

ШИНЭ ЭХ СУРВАЛЖААС ЭХТЭЙ АМЬДРАЛААР АМЬДРАХ НЬ

НЭГДҮГЭЭР ДЭВТЭР:
*ХРИСТ ДОТОР ӨӨРЧЛӨГДСӨН АМЬДРАЛААР
АМЬДРАХ НЬ*

БИЛЛ ЛОВЛЕСС
ХРИСТ БОЛ АМЬДРАЛ ҮЙЛЧЛЭЛ

ЗОХИОГЧИЙН ЭРХИЙН МЭДЭЭЛЭЛ

Copyright © 2010 by Bill Loveless

All rights reserved. This book may not be copied or reprinted for a commercial gain or profit. The use of this material for personal or group study is permitted.

Scripture taken from the Holy Bible, New International Version®, copyright © 1973, 1978, 1984 International Bible Society. Used by permission of Zondervan. All rights reserved.

Scripture taken from the Holy Bible, New Living Translation, copyright © 1996 by Tyndale Charitable Trust. Used by permission of Tyndale House Publishers.

Scripture taken from the New American Standard Bible®, copyright © 1960, 1962, 1963, 1968, 1971, 1972, 1973, 1975, 1977, 1995 by The Lockman Foundation. Used by permission.

Scripture taken from the New King James Version, copyright © 1982 by Thomas Nelson, Inc. Used by permission. All rights reserved.

Scripture quotations marked (GNT) are from the Good News Translation in Today's English Version—Second Edition, copyright ©1992 by American Bible Society. Used by permission.



Christ Is Life Ministries

Website: www.christislifeministries.com

Email: bill@christislifeministries.com

**ШИНЭ ЭХ СУРВАЛЖААС ЭХТЭЙ
АМЬДРАЛААР АМЬДРАХ НЬ**

ГАРЧИГ

НОМЫГ СУДЛАХ АРГАЧЛАЛ.....	4
НЭГДҮГЭЭР ХИЧЭЭЛ	<i>“АМЬТАЙ” болон “АМЬГҮЙ” итгэлийн амьдралын ялгаа.....</i>
ХОЁРДУГААР ХИЧЭЭЛ	<i>Таны дотор амьдардаг Түүний амийг тэтгэхийн тулд Бурханы хийх ажил болон Түүний амиар тэтгэгдэхийн тулд таны хийх ажил.....</i>
ГУРАВДУГААР ХИЧЭЭЛ	<i>Итгэлээр алхах нь – Амь болох Христийг ойлгох нь.....</i>
ДӨРӨВДҮГЭЭР ХИЧЭЭЛ	<i>Бурханы ялалт, эрх чөлөө, эдгэрлийн амлалтыг мэдэх нь.....</i>
ТАВДУГААР ХИЧЭЭЛ	<i>Итгэлийн тулаан.....</i>
ЗУРГААДУГААР ХИЧЭЭЛ	<i>Итгэлээр алхахдаа хүлээх хүлээлт.....</i>

НОМЫГ СУДЛАХ АРГАЧЛАЛ

“Шинэ эх сурвалжаас эхтэй амьдралаар амьдрах нь” гэсэн энэхүү номыг судлахаар сонгосонд талархал илэрхийлье. Таныг эхлэхээс өмнө энэхүү номыг хэрхэн судлах талаар багахан тайлбар хийе. Энэхүү номонд зургаан хичээл байгаа бөгөөд хичээл тус бүр 5 дэд хичээл буюу 5 өдөр уншиж судлах материалтай (Өдөр 1, Өдөр 2...) болно. Та өөрийн баг хамт олонтой долоо хоног тутам нэг уулзалт хичээл хийхээр төлөвлөж байгаа бол 5 өдрийн унших материалтай танилцан хийж гүйцэтгэхэд танд долоон өдөр өгөгдсөн байна гэсэн үг юм. Хичээл тус бүрт холбогдох асуултууд, чимээгүй цаг гарган бодох ишлэлүүд, мөн Бурхантай ярилцах нь гэсэн хэсгүүд байгаа.

Асуултууд:

Асуултууд нь та тухайн өдрийн хичээлийн дагуу уншсан үнэнг өөрийн юу гэж итгэдэг итгэл үнэмшилтэйгээ харьцуулан бодоход зориулагдсан болно. Та ямар нэгэн худал хуурмагт итгэж байгаа бол энэхүү асуултууд нь тэдгээрийг илчлэн харуулах зорилготой юм.

Чимээгүй цаг гарган тунгаан бодох ишлэлүүд:

Бясалгах гэдэг үгийн бусад шашнуудад хэрэглэгддэг утгаас болоод зарим хүмүүс хэрэглэхдээ эргэлздэг. Гэвч энэ нь библийн дагуух үг тул хэрэглэхээс зайлсхийх хэрэггүй бөгөөд гол түлхүүр нь ЮУГ болон ХЭНИЙ ТУХАЙ бясалгаж байна вэ гэдэгт л байгаа юм. Бидний бясалгалын утга учир нь Бурхан болон Бурханы үнэн дээр байх ёстой. Энэ номын хүрээнд бясалгах гэдэг үг нь уншин судалж буй үнэнийхээ талаар тунгаан бодох гэсэн утгаар ашиглаж байгаа болно.

Бурхантай харилцах цаг гаргах нь:

Энэ библи судлалын хамгийн чухал хэсэг нь хичээл болгоны Бурхантай харилцах нь гэсэн хэсгүүд юм. Энэ хэсэгт та уншиж судалсан зүйлийнхээ төлөө ойлголт, илчлэлт, хэрхэн амьдралдаа хэрэгжүүлж болохоо Ариун Сүнснээс асуухад зориулагдсан цаг юм. Таны эндээс шинээр суралцаж буй зүйлс урьд нь таны итгэж явсан ойлголтуудтай зөрчилдөж эхлэхэд Ариун Сүнсний туслалцаа маш чухал (Энэ л үедээ та Бурханы үнэнг эрж хайхгүй бол та өөрийн итгэж буй зарим нэг худал хуурмаг ойлголтуудыг ялган салгаж таних боломжгүй байдаг) Тиймээс энэ цагийг онцгойлон гаргаж Бурхантай ярилцаарай.

Илчлэлт:

Энэ номд илчлэлт гэсэн үг олон удаа давтагдан гарах учир би энд энэхүү үгийг ямар утгатайгаар ашиглаж буйгаа тайлбарлая. Илчлэлт гэдэг нь Бурхан Өөрийн үнэнийг ер бусын аргаар миний амьдралын нөхцөлд тааруулан надад хувьчлан ойлгуулахыг хэлнэ. Илчлэлт таны ухамсар дахь ойлголтыг Бурханы үнэн болох сүнслэг ойлголт уруу шилжүүлж өгдөг.

ТҮЛХҮҮР ҮНЭН

Та энэхүү судлалын туршид дараах суурь үнэнг санаарай.

Та өөрийн итгэж байгаагаас илүү гарч амьдарч чадахгүй. Хэрэв таны итгэж байгаа зүйл худал хуурмаг бол таны амьдрал мөн тийм л байна.

Энэ яагаад чухал вэ гэвэл таны юунд итгэж байгаа тань таны бодол, зан үйл, болон хийх сонголтуудад шууд нөлөөлдөг юм. Тиймээс энэхүү библи судлалын нэг зорилго нь таны худал хуурмаг итгэсэн зүйлүүдийг танд илчлэн харуулах, өөрийн оюун бодлыг шинэчлэх, болон Иохан 8:32 ишлэлийн дагуу чөлөөлүүлэх юм. Энэхүү судлалыг хийж буй таны төлөө “худал хуурмаг үнэмшлээс мөн худал хуурмаг итгэлээс үүдэн гарч буй нөлөөллөөс таныг чөлөөлөх Бурханыг хайгаасай” гэж би залбирах болно.

НЭГДҮГЭЭР ХИЧЭЭЛ

“Амьтай” ба “Амьгүй” итгэлийн амьдралын ялгаа

НЭГ ДЭХ ӨДӨР

Оршил

Та бүхэнтэй хуваалцах энэ зүйлс нь теологийн үнэн төдийгүй миний бодол, мэдрэмж, итгэл, зан чанар, сонголт болгоныг минь байнга өөрчлөн шинэчлэлж байдаг гэдгийг хэлэхийг хүсч байна.

Би хэдэн зуун Христитгэлт хүмүүст үйлчилж Бурхан энэ үнэнээр дамжуулан тэдгээр хүмүүсийг чөлөөлж байгаагийн гэрч нь болсон юм. Та ч гэсэн энэ үнэнийг өөрийн амьдралдаа хүсч байгаа гэдэгт итгэлтэй байна. Сайн мэдээ бол өөрчлөлт, энэ өөрчлөлт нь Христитгэлт хүн бүрт өгсөн Бурханы амлалт юм.

Нэгдүгээр хичээлийн тойм

- “Амьтай” болон “Амьгүй” итгэлийн амьдралын ялгааг ойлгох
- “Амьтай” амьдралын утга учрын тухай Бурханы үнэнг мэдэх
- Бурхан бол эх сурвалж гэдэг нь ямар утгатай болохыг
- Загалмайн ГЭМТЭЙ тал болон АМЬ амьдралтай талын талаар суралцах
- Бурханыг амьдралынхаа эх сурвалж болгосноор хэрхэн Бурхан бидний амьдралыг өөрчилж байгааг ойлгох

“Амьгүй” итгэлийн амьдрал эсвэл “Амьтай” итгэлийн амьдрал

“Амьтай” Христитгэлт амьдрал, “Амьгүй” Христитгэлт амьдралаар амьдрахын ялгааг мэдэх нь хамгийн чухал учраас энэ асуултаар эхний хичээлээ эхлэе. Яагаад? Яагаад гэвэл нэг амьдрал нь таныг Бурханы амласан ялалт, эрх чөлөө, өөрчлөлтөөр дүүрэн амьдрахад хөтлөх бол нөгөө нь ялагдал, эрх чөлөөгүй байдал, ямар ч өөрчлөлтгүй амьдрал руу хөтөлнө. “Амьгүй” итгэлийн амьдрал болон “Амьтай” итгэлийн амьдралын ялгааг тайлбарлахын тулд та бүхэнд өөрийнхөө түүхийг хуваалцая.

Би “Амьгүй” Христитгэлт амьдралаар 30 жил амьдарсан

Би өөрийнхөө түүхийг хуваалцахаасаа өмнө “Амьгүй” Христитгэлт амьдралыг тодорхойлоё.

“Амьгүй” Христитгэлт амьдрал гэдэг нь:

Христитгэлт амьдралаар АМЬДРАХАД, Бурханд болон бусад хүмүүст таалагдаж, хүлээн зөвшөөрөгдөхийн тулд Бурханы туслалцаатайгаар миний ХИЙХ ёстой гэж заалгасан зүйлс

Би 18 настай байхдаа Христитгэгч болсон боловч 22 нас хүртлээ Христтэй хамт алхах талаар нухацтай бодож байгаагүй юм. Яг энэ үед, Христитгэлт амьдарлаар амьдрахын тулд би юуг **хийх** хэрэгтэй вэ? гэж өөрөөсөө асуусан. Яагаад гэвэл миний амьдралын бусад бүх талбар "Эхлээд сур, дараа нь сурсанаа хэрэгжүүл" гэсэн дараалалтай байсан учир би энэ асуултыг өөрөөсөө асуусан юм. Би оюун ухаандаа автоматаар суулгасан “сур дараа нь хий” гэсэн дарааллаар Христитгэлт амьдралаа амьдрах юм байна гэсэн ойлголттой байв.

Христитгэлт амьдралаар амьдрахын тулд би юу хийх хэрэгтэй вэ гэсэн асуултанд олон итгэгчид дараах хариултуудыг өгдөг юм.

1. Библиэс сурсан зүйлсээ өөрийн амьдралдаа хэрэгжүүлэх гэж хичээх хэрэгтэй гэж сурсан
2. Гэм нүгэл үйлдэхээ болихын тулд хичээх ёстой гэж би заалгасан
3. Бурханы өгсөн дүрэм журам, тушаалыг дагах гэж ёстой гэж би заалгасан
4. Бурханы тусламжтайгаар өөрийгөө өөрчлөхийг хичээвэл би чадна гэж заалгасан.
5. Би улам илүү зөвт болохын тулд илүү их хичээх хэрэгтэй
6. Өөрийн махан биеийн зан чанараа илүү Христтэй адил болгохын тулд хичээх
7. Би өөрөө сайн хичээж чадах юм бол эрх чөлөө болон ялалтыг амьдралдаа олж авч чадна.

Бурханы тусламжтайгаар эдгээр зүйлүүдийг л хэрэгжүүлж чадвал Бурханд болон бусдад таалагдсан “амжилттай” Христитгэгч болж чадна гэж би итгэдэг байв. Дээр дурьдсан жишээ тус бүрт “хичээх” гэдэг үг орсон байгааг ажиглаж байна уу?

Асуулт: Христитгэгч амьдралаар амьдрахын тулд дээр дурьдсан жишээнээс аль нэгийг нь хийх хэрэгтэй гэж хэн нэгэн танд хэлж байсан уу?

Маш сайн итгэгч байхын тулд би 30 жилийн турш дээр дурьдсан бүх зүйлсийг хэрэгжүүлэхээр маш шаргуу хичээсэн. Асуудал нь юунд байсан бэ? гэвэл илүү их хичээх тусам улам бүр дордож байв. Бурханы амладаг эрх чөлөө, ялалт, өөрчлөлтийн оронд юу ч өөрчлөгдөхгүй байсан учраас Христтэй хамт алхах нь улам бүр сэтгэлийг минь гонсойлгож байлаа. Хүмүүсийн надад хийхийг зөвлөж байсан зүйлийг хийж чадахгүй байсан учраас улам бүр бүтэлгүйтэж байгаа юм шиг надад санагддаг байв. Дээрээс нь зарим нэг хувийн асуудал дээр нилээн зөрчилтэй байсан юм.

Миний хувийн зөрчил

30 жилийн турш би дотроо хангалтгүй байдал, айдас, уур хилэн, үнэ цэнэгүй байдалтай маш хүчтэй зөрчилдөж байсан юм. Эдгээр зөрчлүүд миний мэдрэмж, сонголтонд яг дарангуйлагч мэт тушааж чадахуйц хүчтэй болсон байв. Үнэнийг хэлэхэд эдгээр зөрчлийн хүлээснээс чөлөөлөгдөхийг хүсч байлаа. Иохан 8:32 ишлэл дээр ийнхүү амласан байв.

"Тэгээд та нар үнэнийг ойлгож, үнэн та нарыг ЧӨЛӨӨЛНӨ..."

Дахин хэлэхэд би Бурханыг тусламжийг аваад өөрөө хангалттай сайн хичээх л юм бол өөрөө өөрийгөө чөлөөлж чадна гэж боддог байв. Улам сайн хичээх тусам айдас, уур хилэн, хангалтгүй, үнэ цэнэгүй байдлын энэ мэдрэмжээс би өөрийгөө хэзээ ч чөлөөлж чадахгүй юм шиг санагддаг болов. Яг үнэндээ байдал улам бүр дордож байсан юм. Эдгээр зөрчлөөс чөлөөлөгдөхийн тулд хэдэн жил хичээсний дараа хийж байгаа зүйлийнхээ юу нь болохгүй байгаад дүгнэлт хийхэд хүрэв.

Миний өөрчлөгдөхийг хүсч байсан хүлээлтүүд, эрх чөлөө, ялалтын амлалт огт биелэхгүй байсан нь 30 жилийн турш аялсан Христитгэлийн амьдралаасаа бууж өгөхөд хүргэсэн юм. Бурхан намайг орхиж би өөрийгөө даагаад ганцаараа үлдсэн юм шиг л санагдаж байв. Би авралд ирэхээс өмнөх үетэйгээ одоогийн байдлаа харьцуулахад улам бүр сэтгэл гутрав. Эцэст нь сэтгэл гутралаасаа болоод амиа хорлох талаар боддог болсон байв.

Энэ бүх жилүүдэд Бурхан надад төлөвлөсөн байсан нөгөө бүрэн дүүрэн, төгс амьдрал нь энэ байсан гэж үү? Би юуг нь буруу хийсэн юм бол? Христитгэлээр амьдрахад минь дутуу /байхгүй/ зүйл байна уу?

Та амьдралдаа ямар нэгэн зүйлийг өөрийнхөөрөө бүтээх гэж оролдож байсан уу? Тийм гэж хариулсан бол надад танаас асуух хэдэн асуулт байна.

- Бурхантай хамт байнга ялалттай байхад тань ямар нэгэн зөрчилтэй асуудал байна уу?
- Байнга унаад байдаг гэм нүгэлтэй талбар дээр та өөрчлөлт ялалтыг авчирмаар байна уу?
- Гэм нүгэлтэй зан чанар, хандлагыг өөрчлөхийг хүсдэг боловч өөрчлөх гэж хичээх тусам юу ч өөрчлөгддөггүй юу?
- Христигтэлт амьдралаар амьдрахад тань ямар нэгэн зүйл дутуу юм шиг санагддаг уу?

Хэрэв та нэг болон нилээн хэдэн асуултанд тийм гэж хариулсан бол та яг над шиг “АМЬГҮЙ” Христигтэлт амьдралаар амьдарч байна. Та “АМЬГҮЙ” Христигтэлт амьдралаар амьдарч байгаа бол та хэзээ ч сэтгэл ханамжтай, тууштай, өөрчлөгдсөн байдлыг мэдрэхгүй. Бид “АМЬГҮЙ” Христигтэлт амьдралаар үргэлжлүүлэн амьдарвал энэ нь зөвхөн

- Улам их цөхрөл
- Улам их бүтэлгүйтэл
- Улам чанга хүлээс
- Улам гүнзгий сэтгэл гутрал
- Улам их дотоод зөрчил
- Ямар ч өөрчлөлтгүй байдлыг бий болгодог.

Та энэ жагсаалтыг хараад энэ бол Бурхан бидэнд төлөвлөсөн амьдрал биш гэдэгтэй санал нийлнэ гэж итгэж байна.

“АМЬГҮЙ” Христигтэлт амьдрал нь

зөвхөн ИЛҮҮ ИХ ялагдал, ИЛҮҮ ЧАНГА хүлээс, ЯМАР Ч өөрчлөлтГҮЙ байдлыг авчирна.

Энэ нь Бурханы төлөвлөсөн амьдрал уу, эсвэл ӨӨР амьдралын зам байгаа юу?

Асуулт: Та “Амьгүй” Христигтэлт амьдралаар амьдарч байна уу? Хэрэв тийм бол одоог хүртэл та өөрийнхөө Христигтэлт амьдралын талаар юу гэж боддог вэ? Цөхөрч байна уу? Ялагдаж байна уу? Бүтэлгүйтэж байна уу? Сэтгэлээр унаж байна уу? Илүү ихийг хүсч байна уу? Ямар нэгэн юм дутуу юм шиг санагдаж байна уу? Улам хичээх хэрэгтэй юу?

Иймээс “Амьгүй ” итгэлийн амьдралын үр дүнг харвал “ Бурхан бидэнд өөрөөр амьдрах амьдрал өгсөн үү?” гэсэн асуулт гарч ирнэ. Сайн мэдээ бол өөр амьдрал байдаг бөгөөд тэр амьдралаар амьдруулахаар Бурхан биднийг дуудсан юм. Үүнийг “АМЬТАЙ” итгэлийн амьдрал гэнэ. “АМЬТАЙ” итгэлийн амьдралын утга учрыг тодруулая.

“АМЬТАЙ” Христигтэлт амьдрал гэж юу вэ?

Есүс болон Паул “АМЬТАЙ” итгэлийн амьдралын талаар юу гэж хэлснийг ойлгох замаар асуултандаа хариулая.



Есүс “АМЬТАЙ” Христигтэлт амьдралын талаар юу хэлсэн бэ?

Есүс хэлэхдээ:

“..... **БИ БОЛ** зам, үнэн, **АМЬ** мөн.....”
Иохан 14:6

“.....**БИ БОЛ** амилалт ба **АМЬ** мөн.... ” Иохан 11:25

Эдгээр хоёр ишлэл дээр Есүс юу гэж хэлсэн бэ? Есүс өөрөө би бол “**АМЬ**” амьдрал гэж хэлсэн нь тодорхой байна. Есүс бол “**АМЬ**” амьдрал гэсэн нь ямар утга учиртай вэ? Олон жил эдгээр ишлэлийг би уншихдаа Есүс зөвхөн **мөнхийн** амьдралын эх сурвалж нь гэж ойлгодог байв. Гэхдээ Есүс энэ хоёр ишлэлээр дамжуулан бидэнд өөр ямар нэгэн юмыг хэлэх гэж байх боломжтой юу? Асуултандаа хариулахын тулд Паул юу гэж хэлсэнийг харъя.

“АМЬТАЙ” Христигэлт амьдралаар амьдрах талаар Паул юу гэж хэлсэн бэ?

Паул Колоссой 3:4 – т

“..... БИДНИЙ амь болох Христ”

гэж хэлэхдээ “АМЬТАЙ” итгэлийн амьдралыг илүү хувийн харилцааны төвшинд Христ гэж ойлгосон байна.

Энэ ишлэлээр дамжуулан Паул юу гэж хэлсэн вэ? Христигэлт амьдрал гэдэг нь Есүс бидэнд мөнхийн амьдралыг өгсөн авралаас илүү агуу гэдгийг Паул хэлсэн. Христ бол яг энэ мөчид, өнөөдөр **таны** амьдарч байгаа амьдрал гэдгийг Паул хэлж байгаа юм. “Паул юуны тухай ярьж байна вэ? Христ бол миний амьдрал гэдэг нь юу гэсэн утгатай вэ? Паулын ярьж байгаа энэ амьдрал Христигэлт амьдралтай холбоотой юу?” гэсэн асуултуудыг та өөрөөсөө асууж болох юм. Филиппой 1:21 бол энэ асуултын хариулт бөгөөд Паул хэлэхдээ:

“.....Миний хувьд амьдрах НЬ Христ.....”

Христийн төлөө амьдарна гэдэг нь Христийн амьдралаар амьдарна гэсэн үг гэж Паул хэлжээ. Есүс болон Паул бидэнд маш гайхалтай үнэнийг илчилсэн байна.

Амьтай Христигэлт амьдрал гэдэг нь нэг ХҮН юм.

Тэр нь Христ өөрөө юм.

Христ өөрөө АМЬТАЙ Христигэлт амьдрал гэж та ойлгож байна уу? Хэсэг хугацаанд бодоод үзье. Хэрэв “АМЬТАЙ” Христигэлт амьдрал нь Хүн юм бол “АМЬТАЙ” Христигэлт амьдрал нь ямар нэгэн хийх ёстой зүйлсийн жагсаалтын хуудас бөглөх, ямар нэгэн дүрэм журам тогтоох гэж оролдох, нүгэл үйлдэхээс зайлсхийх, Бурханы төлөө хамгийн сайнаараа хичээхийн төлөө **биш** гэсэн үг үү? “АМЬТАЙ” Христигэлт амьдрал нь бидний бий болгодог амьдрал биш гэдгийг Есүс болон Паул хэлж байгаа юм. Энэ бол **зөвхөн Христийн** ургуулдаг амьдрал юм.

Христигэлт амьдрал бол “АМЬГҮЙ” итгэлийн амьдрал биш юм. Христигэлт амьдрал бол “АМЬТАЙ” итгэлийн амьдрал юм. Бид нар өөрсдөө “АМЬТАЙ” итгэлийн амьдралаар амьдарч чадахгүй. Зөвхөн Христ чадна. Би та бүхэнтэй хэрхэн “АМЬТАЙ” итгэлийн амьдралаар амьдрах талаар мэдсэн сурсанаа хуваалцаж.

Олон жилийн дараа “АМЬТАЙ” итгэлийн амьдралаар амьдрахын үтгэ үчрыг ойлгосон нь

Миний мэдэж байгаагаар Бурхан 30 жилийн турш Христигэлийн амьдралаар өөрийн хүчээр амьдрах гэсэн хүчин чармайлтыг минь эцсийн зогсоол дээр нь авч ирэх үйл явцыг туулуулсан гэдгийг тухайн цаг үеүдэд ухаараагүй байсан юм. 1998 оны 10-р сарын 04-ны Ням гарагт сүмийн ойролцоох цэцэрлэгт хүрээлэнд сууж байхад нэгэн асуулт толгой дотор минь эргэлдэж эхэлсэн юм. “**Христигэлт амьдралыг**

өөрийнхөө хүч чадал, авьяас чадвараар бүтээх гэж хичээж ханав уу?” гэсэн асуулт байв. Бурханы Ариун Сүнс асуусан гэдэгт би эргэлздэггүй юм. Би Бурханд “Хангалттай. Би өөрөө хийж чадахгүй юм байна” гэж хариулсан. Бурханы цаг төгс байсан учраас Бурхан тэр өдөр цуглаан дээр Ян Томас гэх зочин пастораар дамжуулан “АМЬТАЙ” итгэлийн амьдралын үнэнийг заасан юм. Ян Томасын номлолоо эхлүүлсэн хамгийн эхний үг нь:

Бурхан хэзээ ч ЗӨВХӨН Христ Өөрөө амьдарч чадах “АМЬТАЙ” Христитгэлт амьдралыг өөрөөр чинь гүйцэтгүүлэхээр чиний дотор төлөвлөөгүй

Христитгэлт амьдарлаар амьдрах нь миний **хичээж** амьдрахтай хамааралгүй гэдгийг 30 жилийн хугацаанд анх удаагаа хэлсэн хүн нь Ян Томас пастор байсан юм. Ян Томас пастороор дамжуулан Ариун Сүнс надад чухал үнэн юу вэ гэдгийг хэлж байв.

ЧУХАЛ ҮНЭН:

“АМЬТАЙ” ТӨГС Христитгэлт амьдралаар амьдарсан ЦОРЫН ГАНЦ Хүн байдаг бөгөөд тэр нь Христ ӨӨРӨӨ юм.

Энэ үнэнийг анх сонсоод би гайхаж байсан шиг та бас гайхаж магадгүй юм. Үнэн биш гэж үү? Хэн ч Есүс шиг төгс Христитгэлт амьдралаар амьдарч чадахгүй. Гэтэл яаж бид нар түүнтэй адилхан зүйл хийж чадна гэж бодож зүрхлэнэ вэ. Дараах үнэнийг бодож үзье.

Бид өөрсдийн хүч чадал, авьяас чадвараар хийж чадах ганц зүйл бол Христитгэлт амьдралын “АМЬГҮЙ” ХЭЛБЭР юм.
Зөвхөн Христ “АМЬТАЙ” Христитгэлт амьдралаар амьдарч чадна.

“Хэрэв зөвхөн Христ “АМЬТАЙ” амьдралаар амьдарч чадах юм бол хэрхэн би “АМЬТАЙ” Христитгэлийн амьдралаар амьдарч чадах вэ?” гэсэн асуулт гарч ирнэ. Өнөөдрийн хичээлээр дамжуулан Бурханы Үг хэрхэн энэ асуултанд хариулсаныг үзье.

Асуулт: Христ өөрөө “АМЬТАЙ” Христитгэлийн амьдрал гэсэн дээрхи библийн үнэн таны юу гэж итгэдэгтэй нийлж байна уу? Хэрэв үгүй бол үүнийг хэрхэн өөрчилж болох вэ? Хэрэв “АМЬТАЙ” амьдралаар амьдарч чадах нь зөвхөн Христ бол та хэрхэн Христитгэлийн амьдралаар амьдрах вэ?

Бясалгал: Дээрхи ишлэлүүдийг уншаад “АМЬГҮЙ” эсвэл “АМЬТАЙ” итгэлийн амьдралын алинаар нь амьдарч байгааг илчилж өгөхийг Бурханаас асуугаарай.

Бурхантай харилцах цаг гаргах нь: Хэрэв энэ үнэн танд шинэ ойлголт бол Бурхан уруу очих хэсэг хугацааг гаргаад Бурханаас эдгээр үнэнийг танд бодит болгож өгөхийг гуйн залбираарай. "АМЬТАЙ" итгэлийн амьдралтай байхын тулд Христ ямар утга учиртай болохыг илүү гүн гүнзгий арга замаар илчлэхийг Бурханаас гуйн залбираарай. Хэрэв энэ үнэн Христитгэлт амьдралын талаар таны итгэлтэй зөрчилдөж байвал дөнгөж уншсан зүйл үнэн эсэхийг Бурханаас илчилж өгөхийг асуугаарай. Энэ хэсэгт Христ бол таны амьдрал гэдэг нь ямар утга учиртай болохыг илүү нарийн судалъя.

ХОЁР ДАХЬ ӨДӨР

Христ БОЛ таны амьдрал гэдэг нь ямар утгатай вэ?

Христ бол таны амьдрал гэдэг нь ямар утгатай вэ? гэж та асуух байх. Бурхан үүнийг 1 Коринт 1:30 ишлэлд нэгтгэн дүгнэсэн байна.

“Тэр бол Христ Есүс дотор таны ЭХ СУРВАЛЖ юм” 1 Коринт 1:30 (NRSV)

Уг ишлэлийн эхний хэсгээр дамжуулан Бурхан бидэнд Тэр бол Христ, Христ дотор таны амьдралын ЭХ СУРВАЛЖ байгаа гэдгийг харуулж байгаа юм. “Эх сурвалж” гэдэг үгийг тодорхойлбол “ургуулдаг нэгэн” гэсэн утгатай. Маш олон Христитгэгчид над шиг Бурханы тусламжтай Христитгэлт амьдралаар амьдрахдаа өөрөө өөрсдийнхөө эх сурвалж болдог гэж заалгасан учраас танд энэ үнэн шинэ байж болох юм. Зөвхөн ГАНЦХАН зөв эх сурвалж байдаг ба түүнээс Христитгэлт амьдрал тэтгэгдэнэ.

Бурхан бол ЭХ СУРВАЛЖ, та өөрөө БИШ. Христээс ЭХ СУРВАЛЖТАЙ байх нь Христитгэлт амьдрал юм.

Христитгэлийн амьдралаар амьдрахын тулд Бурхан бол таны ЭХ СУРВАЛЖ гэдгийг илчилсэн хоёр ишлэлийг уншиж үзье.



“Түүний дотор бид амьдарч, хөдөлж, оршин тогтдог.”
Үйлс 17:28

“Учир нь Түүнээс, Түүгээр, Түүнд бүх юм байна....”
Ром 11:36

Христитгэлт амьдралаар амьдрахын тулд Бурхан бол таны ЭХ СУРВАЛЖ гэдгийг илчилсэн Библи дээрх олон ишлэлүүдийн хоёрыг нь ашиглав. Бурхан таны ЭХ СУРВАЛЖ гэдэг нь бодит амьдрал дээр яг ямар утгатай болоход та эргэлзэж байж болох юм. Бурхан таны Эх сурвалж гэдгийг илтгэсэн 4 жишээг харъя.

- Бурхан бол таны хэрэгцээг хангагч Эх сурвалж. Филиппой 4:19
- Бурхан бол таны нүглийг ялан дийлэх хүчийг өгөгч Эх сурвалж. 1 Иохан 3:6
- Бурхан бол Түүний үнэнд итгэх зүрх сэтгэлийг шинэчлэгч Эх сурвалж. Ром 12:2
- Бурхан бол таны амьдралыг бодитоор өөрчлөх ба Түүний амлалт таны амьдралд төгс болох Эх сурвалж нь юм. Филиппой 1:6

Энэ дөрвөөс аль нэгийг нь хэрэгжүүлэхийн тулд та өөрөө эх сурвалж нь болох гэж хичээж байсан уу? Хэрэв тийм бол энэ нь танд хэр үр дүнтэй байсан бэ? Хэрвээ бид бүхэн эдгээр асуултанд шударгаар хариулбал тиймээ энэ нь надад үр дүнгүй байсан гэж хариулах байсан байх. Үнэн юу гэвэл - бид Христитгэлт амьдралынхаа эх сурвалж нь өөрсдөө болох гэж хичээх тусам бүтэлгүйтдэг. Хэрвээ Христтэй хамт алхах үед / бидний амьдралын бүх талбарт/ Бурхан бидний Эх сурвалж болж чадахгүй бол бид нар хэзээ ч Бурханы үнэн болон Түүний амлалтын гэрч болох боломжгүй болно.

**АМЬТАЙ Христитгэлт амьдралаар амьдрах үед ЭХ СУРВАЛЖ болсон Бурхан л
ДАНГААРАА Түүний үнэн болон Түүний амлалтуудыг бидний амьдралд БОДИТОЙ болгож
өгч чадна**

Асуулт: Христитгэлт амьдралаар амьдрахын тулд Бурханы тусламжтайгаар ТА ӨӨРӨӨ эх сурвалж нь байж чадна гэж өнөөдрийг хүртэл итгэж ирсэн үү? Хэрвээ тийм бол, Бурхан бол Эх сурвалж гэдэгт итгэснээр таны Христитгэлийн амьдрал хэрхэн өөрчлөгдөх вэ?

Бясалгал: 1 Коринт 1:30, Үйлс 17:28, Ром 11:36

Бурхантай хамт алхах нь: Эдгээр 3 ишлэлийг бясалган Ариун сүнснээс "АМЬТАЙ" Христитгэлт амьдралаар амьдрахад таны Эх сурвалж болох Бурхан ямар утга учиртай болохыг улам гүнзгий ойлгуулахыг гуйн залбираарай.

Яагаад Бурхан бид нарт өөрсдөө Эх сурвалж болоход тусалдаггүй вэ?



Олон Христитгэлт хүмүүс “Бурхан надад тусална” гэж ярихыг би сонсож байсан. Бид “Өөрөө өөрийгөө өөрчилж өөрийнхөө эх сурвалж нь болоход Бурхан тусална” гэж өөрийн мэдэлгүй ярьдаг. “Бурхан надад өөртөө туслахад тусална”. Бурхан хэзээ ч хүнийг өөрөө өөрийнхөө өөрчлөн шинэчлэгдэх эх сурвалж нь болгоно гэж төлөвлөөгүй учраас ингэж ярих нь буруу сургааль юм. Энэ асуултыг бодоод үзээрэй. “Хэрвээ Бурхан Эх сурвалж нь юм бол яагаад тэр таныг өөрийнхөө эх сурвалж болоход тусална гэж?” Бурхан анхнаас нь л ингээд бүтээчихсэн! Хэрвээ Христитгэлт амьдралаар амьдрахад Тэр таны Эх сурвалж болохгүй л юм бол эцсийн үр дүн нь таны амьдралд бүтэлгүйтэл ихсэж, улам чанга хүлээстэй юм шиг, ямар ч өөрчлөлт байхгүй байна. Бурханы загварчлал ганцхан арга замаар л биелэх боломжтой бөгөөд энэ нь Тэр таны Эх сурвалж болох юм.

Бурхантай хамт алхах нь: Хэрвээ та өнөөдрийг хүртэл Христитгэлт амьдралаар амьдрахын тулд Бурхантай хамтраад өөрөө болгочихно гэж итгэж байсан бол "АМЬТАЙ" Христитгэлт амьдралын Эх сурвалж нь Христ бөгөөд зөвхөн Христ Эх сурвалж нь байж чадна гэдгийг улам гүнзгийгээр танд илчилж өгөхийг гуйн залбираарай.

Итгэлийн амьдрал дахь ХАМГИЙН ТҮГЭЭМЭЛ ХУДАЛ ҮНЭМШИЛ

Бурханы тусламжтайгаар би өөрийн ухамсар, чадварыг ашиглан ӨӨРӨӨ ӨӨРИЙНХӨӨ эх сурвалж байснаар Христитгэлийн амьдралаар амжилттай амьдарч чадна.

Бурхан бидний Эх сурвалж болсон талаар илүү тодорхой ойлголттой болсон бол одоо Христ бол таны амьдрал гэдэг нь ямар утга учиртай болохыг гүнзгийрүүлэн судалъя.

Бурхан бидний Эх сурвалж байх ёстой гэдгийг хэрхэн мэдэх вэ?

Бурхан бол бидний Эх сурвалж гэдэг үнэнийг ойлгохын тулд хүн төрөлхтөнд зориулсан Бурханы бүтээл болон төлөвлөгөөг мэдэх нь чухал юм. Бурхан анхнаасаа хүн төрөлхтөний эх сурвалж нь байхаар төлөвлөсөн байжээ. Энэ хэсэгт доорхи 4 асуултыг авч үзье.

- Уналтаас өмнө Адам болон Евагийн эх сурвалж нь хэн байсан бэ?
- Адам болон Ева нүгэл үйлдэхэд юу болсон бэ?
- Анхны хүн мэндлэхдээ сүнслэг байдал нь ямар байсан бэ?
- Хүний эх сурвалж болохын тулд Бурхан юу хийсэн бэ?

Еден цэцэрлэгт болсон Уналтын өмнөх болон дараах Адам, Евагийн нөхцөл байдлыг ойлгохоос хичээлээ эхлээ.

Уналтаас өмнө Адам болон Евагийн ЭХ СУРВАЛЖ нь хэн байсан бэ?


“ЭЗЭН Бурхан тоос шорооноос хүнийг бүтээж, амин амьсгалыг хамраар нь үлээж оруулахад, хүн амьд оршигч болжээ.” “Эхлэл 2:7

“.....**Миний Бурхан Христ Есүс дотор та нарыг хэрэгтэй бүхнээр тань хангана....**”
Филиппой 4:19

Эхлэл 2:7-д хэлсэнчлэн Бурхан амин амьсгалыг Адам, Евагийн хамраар нь үлээж оруулснаараа хүний эх сурвалж нь болжээ. Өөрөөр хэлбэл, Адам, Евагийн бие махбодийн, сүнсний, сэтгэл санааны бүх хэрэгцээг хангагч ЭХ СУРВАЛЖ нь Бурхан байсан юм. (Филиппой 4:19) Хүн өөрийнхөө хэрэгцээг хангаж чадахгүй зөвхөн Бурхан хангаж чадах учраас анхнаасаа хүний Эх сурвалж нь Бурхан байхаар бүтээгдсэн нь тодорхой боллоо.

Уналтаас өмнө хүний Бурхантай харилцах харилцаа ямар байсныг үзүүлсэн диаграммыг дор үзүүлэв.

УНАЛТААС ӨМНӨ АДАМ, ЕВАГИЙН ХЭРЭГЦЭЭГ ХАНГАГЧ ЭХ СУРВАЛЖ НЬ БУРХАН БАЙСАН ЮМ.




Хэрвээ Бурхан тэдний бүхий л хэрэгцээг хангагч Эх сурвалж нь юм бол Адам, Ева хоёр хэрэгцээгээ хангуулахын тулд Бурханаас БҮРЭН ХАМААРАЛТАЙ байсан гэж дүгнэж болох уу?

"Хамаарал" гэдэг нь Бурхан болон Адам, Евагийн харилцааг тодорхойлох түлхүүр үг юм. Адам, Ева хоёр хэрэгцээгээ олж авахын тулд Бурхантай бүрэн хамааралтай байсан. Бид нар энэ хэсгийг дараах чухал үгнээр дүгнэе.

ЧУХАЛ ҮНЭН:

Адам, Ева хоёр үргэлжлүүлэн Бурханаас ХАМААРАЛТАЙ амьдарсан бол Тэр тэдний бүх хэрэгцээг хангах тэдний ЭХ СУРВАЛЖ нь байх байсан

Бурхан Адам, Ева хоёрт ХАМААРАЛТАЙ байх чөлөөт сонголтыг өгсөн



“Тэгээд ЭЗЭН Бурхан тэр хүнд тушаан ийнхүү өгүүлэв.

-**Чи энэ цэцэрлэгийн аль ч модны жимсийг дураараа идэж болно.**

Харин **чи сайн мууг мэдүүлэгч модны жимснээс огт идэж болохгүй. Чи түүнээс идсэн тэр өдөртөө л зайлиггүй үхнэ!** хэмээн айлдав.” Эхлэл 2:16-17

Эхлэл 2:16-17 ишлэл дээр хэлсэнчлэн Бурхан хүнд хамааралтай эсвэл биеэ даасан байх сонголтыг өгсөн. Цэцэрлэгт байгаа сайн мууг мэдүүлэгч модны жимснээс бусад модны жимсийг идэж болох сонголт байсан юм. Энэ сонголт нь Бурхантай үргэлжлүүлэн хамааралтай байхыг хүсч байгаа эсэхийг шалгасан сорилт байсан юм. Хэрвээ тэд сайн мууг мэдүүлэгч модны жимснээс бусад модны жимсийг идээд Бурхантай хамааралтай байхыг сонгосон бол тэд амьд үлдэх байсан. Гэхдээ тэд сайн мууг мэдүүлэгч модны жимснээс идсэн болохоор тэд үхэх болсон юм.

“Тэгээд тэр модны жимс нь хүнс болоход шимтэй, нүд булаам, мэргэн ухаантай болгочихмоор, шунал хөдөлгөм сайхан харагдсан тул тэр эмэгтэй түүнээс авч иджээ. Тэр бас өөртэйгөө хамт байсан нөхөртөө өгч, тэр ч иджээ.” Эхлэл 3:6

Адам, Ева хоёрын нүгэлтэй, бие даасан байх шийдвэр гаргасан нь **сүнслэг үхлээр** төгссөн гэж Ром 5:12-ын эхний хэсэгт онцолсон байна.

“... **Нэг хүнээр ертөнцөд нүгэл нь ирсний адил нүглээр үхэл нь ирсэн...**” Ром 5:12

Сүнслэг үхэл гэдэг нь ямар утгатай вэ? Сүнслэг үхлийг тодорхойлох хамгийн чухал үг бол “**хагацал**” юм. Грек хэлэнд “хагацал” гэдэг нь “таслах”, “салгах” гэсэн утгатай.

СҮНСЛЭГ ҮХЭЛ гэдэг нь Бурханаас ТАСЛАГДАХ эсвэл САЛГАГДАХ гэсэн утгатай

Энэ тусгаарлалт нь хоёр хэсгээс бүтнэ.

- Бурханы АМИАС САЛАХ

“Тэд өөрсдийнхөө дотор буй харанхуй байдлаас, зүрхнийхээ хатуугаас болж оюун ухаандаа харанхуй болж, **Бурханы амиас салжээ**.” Эфес 4:18

Адам, Ева хоёр Бурханаас тусгаар байхыг сонгон гэм үйлдсэн учраас Бурханы амиас салсан юм. Адам, Ева хоёр бие махбодийн хувьд амьд үлдсэн боловч тэд цаашид Бурханы сүнслэг амьдралаар амьдрах боломжгүй болсон. Эцэст нь тэд сүнсний хувьд үхсэн.

- **ЭХ СУРВАЛЖ болсон Бурханаас САЛАХ**


“Харин та нарын гэм буруу нь та нарыг Бурханаас хагацуулан, та нарын нүглүүд Бурханы нүүрийг та нараас далдалжээ. Тийм учраас Тэр сонсдоггүй” Исаиа 59:2

Өмнө нь хэлсэнчлэн Адам, Ева хоёр тэдний хэрэгцээ болгоныг хангаж чадах Эх сурвалж болсон Бурхантай бүрэн хамааралтай байсан. Тэдний үйлдсэн гэмээс болоод Бурхан биднээс Өөрөө салсан бөгөөд Бурхан хүн бүрийн хэрэгцээ болгоныг хангагч Эх сурвалж нь байхаа больсон.

Хүн ӨӨРИЙНХӨӨ хэрэгцээг хангахын тулд ӨӨРӨӨ эх сурвалж болон ӨӨРӨӨ асуудлаа шийдэн, өөрийнхөө амьдралыг амжилттай болгож ХИЧЭЭХИЙН тулд салсан.

Уналтын дараа хэрхэн хүний нөхцөл байдал өөрчлөгдсөнийг дараах диаграмаар харуулав.

УНАЛТЫН ДАРААХ АДАМ, ЕВА ХОЁРЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ



ГУРАВ ДАХЬ ӨДӨР

Адам, Ева хоёрын сүнслэг үхэл бидэнд дамжин ирсэн нь

Энэ нь танд болон надад Адам, Ева хоёрын сүнслэг үхэл болон салалт нь бие махбодийн хувьд дамжин ирсэн гэсэн утгатай юм.


“Нэг хүнээр ертөнцөд нүгэл нь ирсний адил нүглээр үхэл нь ирсэн. Тиймээс бүгд нүгэл үйлдсэн тул үхэл нь бүх хүнд иржээ. ” Ром 5:12

Ром 5:12 дээр хэлсэнчлэн Адамын нүглээр дамжуулан хүн бүр төрөхдөө сүнсний хувьд үхмэл ажээ. Бид төрсөн тэр цаг мөчөөс эхлэн Адамын сүнслэг үхэл бидэнд дамжин ирсэн юм.

*Адам, Ева хоёр шиг бид төрөхдөө Бурханы АМЬ болон ЭХ СУРВАЛЖ болсон Эзэнээс
салангид төржээ.*

Дараагийн диаграм дээр Адамын Бурханы Амь болон Эх сурвалжаас салсан хагацал бидэнд дамжин ирсэн учраас бид сүнсний хувьд үхмэл болох үнэнг үзүүлсэн байна.

**БИЕ МАХБОДИЙН ХУВЬД ТӨРӨХДӨӨ ХҮН ТӨРӨЛХТӨНД
АДАМЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ ДАМЖИН ИРЭХ НЬ**



Танд Адамын сүнслэг үхэл дамжин ирсэн учраас та Бурханы Амиас болон Эх сурвалжаас САЛСАН. Энэ салалтаас болоод ТА амьдралынхаа эх сурвалж болох гэж ХИЧЭЭХ болсон.

Асуулт: Хэрвээ Бурханы төлөвлөгөө бидний Эх сурвалж болсон Түүнд бүрэн хамааралтай байхад оршиж байгаа юм бол та бид Бурханаас хамаарахгүйгээр биеэ даан өөрсдийн хэрэгцээгээ өөрсдөө хангаад, өөрсдийнхөө асуудлыг өөрсдөө шийдээд, Христитгэгч амьдралаар амжилттай амьдарч чадах уу?

Бясалгал: Христитгэлт амьдралаар амьдрахын тулд Эх сурвалж болсон Бурхантай бүрэн хамааралтай байх нь анхнаасаа Бурханы загварчлал байсан гэсэн үнэн дээр төвлөрөх.

Бурхантай хамт алхах нь: Эзэн таны амьдралын (гэрлэлт, ажил, нөхцөл байдал) Эх сурвалж нь байхын утга учрыг илчлэн харуулж өгөхийг Эзэнээс гуйн залбираарай.

Еден цэцэрлэгт Уналтын дараа алдагдсан ямар зүйлсийг Бурхан шинэчилсэн бэ?

Хэрвээ Бурхан бидэнд үүнээс гарах гарцыг өгөхгүй бол хүн Түүнээс бүр мөсөн сална гэдгийг Бурхан мэдэж байсан. Тийм учраас Бурхан хүнд аврал болон амийг (хүний эх сурвалж Бурхан гэж шинэчлэхийн тулд) өгөхийн тулд дараах хоёр зүйл хэрэгтэй болсон. Загалмайн хоёр тал гэж нэрлэгддэг диаграм ашиглан эдгээр хоёр зүйлийг дүрслэе. Загалмайн нэг тал ГЭМ НҮГЭЛИЙг нөгөө тал нь АМИЙГ дүрсэлсэн. Эхлээд Бурхан бидний гэмийг уучлахын тулд загалмайн ГЭМ НҮГЛИЙН талд юу хийснийг харъя.

Загалмайн ГЭМтэй тал – Христ бидэнд мөнхийн амийг өгөхийн тулд бидний гэмийн төлөө үхсэн.

Христийн сайн мэдээ гэдэг нь хүн төрөлхтөний хүсэн хүлээсэн Аврагч эзэн Есүс бидний гэм нүглийн төлөөсийг төлөхөөр ирсэн тухай юм. Түүний үхлээр бидний гэм нүгэл цагаатгагдан Христэд итгэснээр бид мөнхийн амьдралыг хүлээн авч аврагдах юм.


"Түүний нигүүлслийн баялагаар бидэнд Түүний дотор цусных нь золилт, гэм нүглийн маань төлөөх уучлал бий." Ефес 1:7

"Хүүд итгэдэг нь мөнх амьтай." Иохан 3:36а

Христ бидний гэмийн төлөө үхсэн бөгөөд загалмайн ГЭМтэй талыг төлөөлдөг.

Загалмайн гэмтэй талыг диаграммаар дүрсэлбэл

Загалмайн гэмтэй тал



Христ бидний гэмийн
төлөө үхсэн Ефес 1:7

Зөвлөмж: Хэрвээ та Христийг өөрийн аврагч хэмээн хүлээн авсан эсэхэд эргэлзэж байвал яг одоо авралыг хүлээн авах боломжтой. Уучлал, авралыг хүлээн авсан гэдэгт итгэн дараах залбирлыг даган хэлээрэй. “Эзэн Бурхан минь, Аврагч хэрэгтэй гэмтэй нэгэн билээ би. Миний гэмийн төлөө Та загалмайд цовдлогдсон учир би итгэлээрээ Таныг Аврагч Эзэн хэмээн хүлээн авч байна. Амен”

Загалмайн АМЬ амьдралыг харуулдаг тал – Бурхан өөрийгөө хүний ЭХ СУРВАЛЖ нь болгосон

*Хүнийг аврахын тулд Христ хүний төлөө үхсэн боловч хүн АМЬ, ЭХ СУРВАЛЖ болсон
Бурханаас САЛАНГИД ХЭВЭЭРЭЭ үлдсэн.*

Бурхан хүнийг Түүнээс тусгаарлагдан амьдрахаар бүтээгээгүй учраас Бурхан хүний Эх сурвалж нь байхын тулд Өөрийгөө хүн рүү шинэчлэх гурван зүйлийг өөртөө хийсэн. Эдгээр гурван зүйлийг загалмайн “АМЬ АМЬДРАЛЫГ ХАРУУЛДАГ ТАЛ” гэж нэрлэдэг.

ЗАГАЛМАЙН ХОЁР ТАЛ



Христ бидний гэмийн
төлөө үхсэн Ефес 1:7

Бурханы төгс дүүрнийг бүхлээр нь хүнд
эргүүлэн авч иржээ. Колоссай 2:9,10

Бурхан Өөрийн амь, хүч чадлыг таны
дотор тавьжээ. 1 Иохан 5:12, Үйлс 1:8

Бурхан өөрийгөө тантай нэгдмэл
болгосон. Иохан 14:20

1. Бурхан өөрийн бүрэн дүүрэн, төгс байдлыг бидний дотор бий болгодог

Авралыг хүлээн авах үед та Есүсийг Аврагч Эзэнээр хүлээн авахаас гадна бүх эрх мэдлийн тэргүүн \Эцэг, Хүү, Ариун Сүнс\ - ийг хүлээн авдаг. Энэ нь Колоссай 2:9, 10 дээр гардаг.

“Учир нь Түүн дотор Бурханы төгс дүүрэн нь бүхлээрээ биетээр оршдог. Түүн дотор та нар төгс болгогдсон. Тэр бол бүх удирдлага ба эрх мэдлийн тэргүүн нь мөн” Колоссой 2:9 – 10

Энэ ишлэл бидэнд Христ дотор бүх удирдлага ба эрх мэдлийн тэргүүн байгаа бөгөөд одоо Христ тантай хамт байгаа тул Эцэг, Хүү, Ариун Сүнс ч гэсэн таны дотор байгаа гэдгийг хэлж байна. Үүнээс хойш та Бурханаас тусгаарлагдахгүй болсон. Одоо бүх удирдлага ба эрх мэдлийн ТЭРГҮҮН таны ДОТОР байгаа.

БУРХАН ӨӨРИЙН БҮРЭН ДҮҮРЭН, ТӨГС БАЙДЛЫГ БИДНИЙ ДОТОР БИЙ БОЛГОДОГ



Та Христийн авралыг хүлээн авсан бол одоо Эцэг, Хүү, Ариун Сүнсийг бүхлээр нь өөртөө

АГУУЛЖ байгаа гэдгийг ойлгох нь маш чухал

Асуулт: Та бүх удирдлага ба эрх мэдлийн Тэргүүн тантай хамт байгаа гэдгийг сайн ойлгохгүй байж болох ч энэ үнэнийг бүрэн ойлгох нь таны амьдрал хэрхэн өөрчлөгдөх байх гэж бодож байна вэ?

Бясалгал: Колоссой 2:9- 10. Хэрэв надтай хамт Эцэг, Хүү, Ариун Сүнс байгаа юм бол надад юу дутаж байна вэ? гэсэн асуултанд хариулж үзээрэй.

Бурхантай хамт алхах нь: Таны дотор байгаа Бурханы бүрэн дүүрэн, төгс байдлын мөнхийн утга учрыг илүү их илчилж өгөхийг Бурханаас гуйн залбираарай.

ДӨРӨВ ДЭХ ӨДӨР

2. Одоо таны дотор Бурханы хүч чадал, амь амьдрал бүрэн дүүрнээрээ байгаа.

Та Бурханы бүрэн дүүрэн, төгс байдлыг хүлээн авахаас гадна Түүний Амь амьдрал, хүч чадлыг хүлээн авсан.

А. Христийн амьдрал

Бурхан бидэнд мөнх амь өгсөн бөгөөд энэхүү амь нь Хүүд байна. Хүүтэй хүнд амь бий.

1 Иохан 5:12a

Авралын үед Бурхан бидэнд Христ доторх Амийг өгсөн гэдгийг харж байна. Бид одоо тэрхүү амийг өөрийн болгосон үед илрэх амийн жишээг харья.

Христ амьдралыг өгөгчийн хувьд та ХРИСТИЙН доорх БҮХ зүйлийг агуулдаг гэсэн үг:

Болзолгүй хайр	Ялалт	Үнэ цэнэ	Хүлээн зөвшөөрөл
Итгэл	Эрх чөлөө	Тэвчээр	Хүч чадал
Амар тайван	Итгэмжтэй байдал	Уучлал	Найдвартай
Айдасгүй	Мэргэн ухаантай	Гярхай байдал	Сэтгэл хангалуун
Даруу	Христ-итгэл	Энэрэнгүй	Амралт
Зөвт байдал	Аминч бус	Зориг зүрх	Халуун сэтгэл
Зориг	Баяр хөөр	Нигүүлсэнгүй чанар	Христ захиргаа

Таны амьдралын утга учир болсон Христ нь таныг Христийн амар тайван, хүлээн зөвшөөрөл, баяр баясгалангаар хангах таны ЭХ СУРВАЛЖ юм.

Нэгэнт Христийн амь тантай хамт байгаа тул дээр дурьдсан Христтэй адил зан чанар хэзээд танд боломжтой байгаа гэсэн үг юм. Дөрөвдүгээр хичээлээр бид Христтэй адил зан чанар ба хүний зан чанарын ялгааны талаар илүү сайн суралцана. Жишээлбэл: Христийн хайр, хүний хайр хоёрын ялгаа гэх мэт.

Асуулт: Хэрвээ та дээрх дурьдсан зан чанарууд болох Христийн амар тайван, тэвчээр, ялалт дотор бүрэн амьдардаг байсан бол таны амьдрал хир өөр байх байсан бэ?

Бурхантай хамт алхах нь : Дээрхи Христтэй адил зан чанаруудаас амьдралдаа хэрэгжүүлэхийг хамгийн их хүсч буй нэг юмуу хоёр зан чанарыг сонгон авч Христтэй адил болоход амьдралдаа бодитойгоор хэрэгжүүлэхэд туслахыг Бурханаас гуйгаарай.

Бясалгал: Амиар гэсэн доорхи хүснэгтийн үг дээр бясалгаарай.

Бурхан өөрийн АМИЙН бүрэн дүүрэн, төгс байдлыг таны дотор бий болгосон учраас та бурханы АМИАР амьдрах боломжтой болсон юм.

В.Бурханы хүч чадал

Христийн амийг хүлээн авч авралыг хүлээн авах тухайн мөчид бид Бурханы ер бусын хүчийг бүхлээр нь нэмж хүлээн авдаг.

Ариун Сүнс та нар дээр ирэхэд, та нар хүчийг олж Үйлс 1:8

Хэсэг хугацаанд бодоод үзье. Бүх эрх мэдэл ба удирдлагын Тэргүүн тантай хамт байгаа болохоор Бурханы бүх хүч чадал мөн таны дотор бий болно. Бурханы хүч чадалгүйгээр хүн өөрчлөгдөх боломжгүй гэдгийг Бурхан мэддэг. Тиймээс Тэрээр Өөрийн хүч чадал, бүрэн дүүрэн, төгс байдлыг бидний амьдралыг өөрчлөхийн тулд өгсөн юм. Бидний дотор бий болж байгаа Бурханы хүч чадлын зорилго ба далайцын талаар гуравдугаар хичээлээр дэлгэрэнгүй ярилцах болно.

Бурхан хүнийг Христтэй адил болгож өөрчлөхийн тулд Өөрийнхөө ХҮЧ ЧАДЛЫГ бидэнд өгсөн.

Дараагийн үзүүлэх диаграм бол та Бурханы хүч чадал, амийг тээгч сав суулга гэдгийг харуулахыг зорьсон болно.

БУРХАН ТАНД ӨӨРИЙН АМЬ БОЛОН ХҮЧ ЧАДЛЫГ ӨГСӨН



Асуулт: Бурхан Өөрийнхөө хүч чадлыг бидэнд өгөх нь яагаад тийм чухал байсан бэ? Та өөрийнхөө хүчээр өөрийгөө, хань ижлээ, гэр бүлийнхнийгээ, хамт ажиллагсадаа өөрчлөхийг оролдож байна уу? Энэ нь хир үр дүнтэй байна вэ?

Бясалгал: 1 Иохан 5:12, Үйлс 1:8-ийг бясалгаад яагаад Бурхан бидэнд Өөрийн Хүч чадал болон Амийг өгөх нь чухал байсан гэж бодож байна вэ? гэсэн асуултыг тунгаана уу.

Бурхантай хамт алхах нь: Бурханы Хүч чадлыг улам бүр амьдралдаа мэдрэхийг хүсэн гуйж залбираарай.

3.Бурхан бидэнтэй ХАМТ байхын тулд бидэнд өөрийгөө өгсөн.

Бурхан бидэнтэй хамт байхын тулд бидэнд өөрийгөө өгөөд зогсохгүй Тэр бидэнтэй хамт байсан юм. Тэр биднийг өөртэйгөө НЭГТГЭСЭН. Энэхүү үнэнийг бид доорхи гурван ишлэлээс харж болно.

"Гэвч биднийг гэм нүгэл дотроо үхсэн байхад (Бурхан) Христтэй хамт амьд болгосон юм" Эфес 2:5

"Харин Эзэнтэй нийлсэн хүн (итгэгч) Түүнтэй нэг сүнс (нэгдмэл болсон) байна." 1 Коринт 6:17

***"Би Өөрийн Эцэг дотор, та нар (нэгдмэл) Миний дотор, Би(та нартай нэгдэж) та нарын дотор байхыг та нар тэр өдөр мэдэх болно."** Иохан 14:20 (хаалт доторх нь нэмэлтээр оруулсан)*

Бурхантай хамт байна эсвэл Бурхантай холбогдсон байна гэдэг нь бид Бурханаас дахин ХЭЗЭЭ Ч салахгүй гэсэн утгатай. Нөгөө талаар, хамт байна гэдэг нь аврагдсан өдрөө Бурхантай хамт мөнхийн амьдралд орсон ба та хэзээ ч авралаа алдахгүй гэсэн үг юм. Тийм учраас Еврей номонд Бурхан ийнхүү хэлжээ.

"Би чамайг хэзээ ч орхихгүй. Би чамайг хэзээ ч мартахгүй" Еврей 13:5

Бясалгал: Эфес 2:5, 1 Коринт 6:17, Иохан 14:20 ишлэлийг бясалгаарай. Нэгэнт олсон авралаа алдах боломжтой гэж боддог бол доорх асуултыг тунгаана уу. Хэрвээ Бурхан Өөрийгөө бидэнтэй хамт байлгахын тулд бидэнд өөрийгөө өгсөн юм бол бид өөрсдөө Бурхантай хамт байхаас салах боломжтой гэж үү? гэдэг асуултыг тунгаан бодоорой.

Бурхантай хамт алхах нь: Хэрвээ авралынхаа аюулгүй байдалтай зөрчилдөж байгаа бол Бурхан танд Түүний авралыг алдах эсвэл Бурханаас салгах **юу ч байхгүй** гэдэг үнэнээр ятгахыг Бурханаас гуйн залбираарай.

Бурхан Өөрийнхөө Амь болон хүч чадлыг бидэнд өгсөнөөр ямар үр дүн гарав?

ҮР ДҮН НЬ:

Бурхан Өөрийнхөө АМЬ, ХҮЧ ЧАДЛЫГ бидэнд өгсөнөөр, Бурхан Өөрөө авралд тантай ХАМТ НЭГДСЭНЭЭР ТА амьдралынхаа Эх сурвалж байх шаардлагагүй болсон юм. БУРХАН ӨӨРӨӨ таны ЭХ СУРВАЛЖ болсон ба уг ЭХ СУРВАЛЖ таны амийг тэтгэнэ

ЗАГАЛМАЙН ХОЁР ТАЛ



Христ бидний гэмийн
төлөө үхсэн Ефес 1:7

Бурханы төгс дүүрнийг бүхлээр нь хүнд
эргүүлэн авч иржээ. Колоссай 2:9,10

Бурхан Өөрийн амь, хүч чадлыг таны
дотор тавьжээ. 1 Иохан 5:12, Үйлс 1:8

Бурхан өөрийгөө тантай нэгдмэл
болгосон. Иохан 14:20

Бурхан хүний амьдралын эх сурвалж -
Иохан 14: 6

Сайн мэдээний ГАЙХАМШИГ нь та аврагдаад зогсохгүй Бурхан таны дотор байж таны АМЬ, ЭХ СУРВАЛЖ болсон гэдэгт байгаа юм. Та ДАХИН өөрийнхөө амьдралыг өөрчлөх ЭХ СУРВАЛЖ байх хэрэггүй.

Таны Амь болох Христ гэдэг нь Бурхан Таны ДОТОР Өөрөө амьдрахыг хүсдэг.

Христ бидэнд Өөрийгөө өгсөн учраас ЗӨВХӨН Тэр таны ДОТОР амьдарч чадах ба Түүний АМИАР амьдрахыг биднээс хүсдэг.

Паул үүнийг өөрийнхөө амьдралаар Галат 2:20 дээр баталсан байдаг.

***"Би Христтэй хамт цовдлогдсон. Амьд байгаа нь би биш, харин миний ДОТОР амьдардаг нь Христ юм."* Галат 2:20**

Энэ ишлэл дээр Паул юу гэж хэлсэн байгааг бодож үзье. “Амьд байгаа нь би биш” гэж Паул хэлсэн бөгөөд энэ нь Христитгэлт амьдралаар амьдрахын эх сурвалж нь би өөрөө байж ЧАДАХГҮЙ гэсэн утгатай юм. Уг ишлэлд Паулын итгэмжтэй байдал, оюун ухаан, авъяас чадвар бүхнийг гайхалтайгаар онцолсон байдаг. Паул эдгээр зан чанарууд нь өөрөө өөрийнхөө эх сурвалж болоход шаардлага хангах зүйлс биш гэдгийг бүрэн дүүрэн ойлгож байсан юм. Тиймээс Паул өөрөө Христитгэлт амьдралаар амьдарч чадахгүй гэдгээ хүлээн зөвшөөрөн “ миний дотор амьдардаг Христ” гэж хэлсэн юм.

Таны дотор амьдардаг Христийн амь танд шинэ ойлголт байж болох юм. Христигэлт амьдралаар 30 жилийн турш өөрийнхөө арга замаар амьдрах гэж хичээсний \бүтэлгүйтсэний\ эцэст миний дотор амьдардаг Христ амьдралын минь үндсэн ойлголт болсон юм. Христ миний дотор амьдардаг утга учрыг Эзэн гайхамшигтайгаар илчилж өгсөний үр дүнд зөвхөн Христ л амьдарч чадах тэр амьдралаар би өөрийн хичээл зүтгэлээр амьдарч чадахгүй гэдгийг бүрэн ойлгосон юм.

АМЬТАЙ Христигэлт амьдралаар амьдрах гол ТҮЛХҮҮР нь Христ ӨӨРӨӨ миний дотроос амьдрах юм.

Чухал үнэнийг улам гүн гүнзгийгээр илчлэн харуулж өгөөч хэмээн та Эзэнээс гуйн залбирч байгаа гэж найдаж байна. Цаашдын бүлгүүд дээр Христ бидний дотор Өөрөө амьдрахын утга учрыг бодит амьдрал дээр хэрхэн ойлгох талаар илүү суралцах болно.

Асуулт: Христигэлт амьдрал гэдэг нь Христ таны дотор өөрөө амьдрах тухай гэдгийг та өмнө нь мэддэг байсан уу? Хэрхэн Христигэлт амьдралаар амьдрах талаар таны бодлыг энэ үнэн өөрчилсөн үү?

Бясалгал: Та өөрөө Христигэлт амьдралаар амьдарч чадахгүй гэдэг нь үнэн юм. Зөвхөн таны дотор Христ амьдарч байгаа үед таны амьдрал жинхэнээсээ өөрчлөгдөх болно.

Бурхантай хамт алхах нь: Таны дотор амьдардаг Христийн Амь ямар утгатай болохыг илчлэн харуулахыг Бурханаас асуугаарай.

ТАВ ДАХЬ ӨДӨР

Таны дотор Христ Өөрөө амьдарснаар таны амьдралд Бурхан юу хийхийг хүсдэг вэ?

Таны ДОТОР амьдардаг Түүний амиар амьдрах нь Бурханд ямар харагддаг вэ? гэж та асууж байж магад. Үүнд хариулах нэг хариулт нь Бурхан юу амласанаа таны амьдралд хэрэгжүүлдэг гэдэгт буй. Эдгээр амлалтын заримаас харцгаая.



ЯЛАЛТ – Бурхан танд дэлхийг, гэмийн хүч, махан бие, Сатаныг ялах бодит туршлагыг өгнө.

Харин Эзэн Есүс Христээр маань бидэнд **ялалт** өгдөг Бурханд талархал нь байх болтугай. 1 Коринт 15:57

ЭРХ ЧӨЛӨӨ – Бурхан таныг Хуурмаг итгэл үнэмшил, хэвшмэл гэмийн зуршил, дотоод зөрчлөөс чөлөөлнө.

Христ биднийг эрх чөлөөтэй болгохын тулд **чөлөөлсөн** юм. Иймд бат зогс, дахиж боолчлолын буулганд бүү орогтун. Галат 5:1

ЭДГЭРЭЛ – Бурхан таныг өнгөрсөн болон одоогийн шархнаас чөлөөлнө.

“Эмтэрсэн зүрхтэй хүмүүсийг **анагааж** шархыг нь боож байна.” Дуулал 147:3

ХАНГАМЖ – Бурхан таны бүх хэрэгцээнд хүрнэ.

"Миний Бурхан алдар дахь баялагаар Христ Есүс дотор та нарыг хэрэгтэй бүхнээр чинь хангана."
Филиппой 4:19

ДОТНО БАЙДАЛ – Бурхан таныг Түүнтэй хамт хувийн, дотно харилцаатай байлгахад дагуулан авчирна.

"Тэр Өөрийн хүслийн сайн тааллын дагуу, биднийг Есүс Христээр Өөрийнхөө хөвгүүд болгон үрчлэн авахаар урьдаас тогтоожээ." Ефес 1:5

Эдгээр нь Таны дотор амьдардаг Христ танд зориулан амласан амлалтуудын ердөө л нэг хэсэг нь юм.

<i>Таны дотор амьдардаг Бурхан таны дотор Өөрийнхөө амлалтуудыг ХЭРЭГЖҮҮЛНЭ.</i>

Асуулт: Таны хүсдэг Бурханы амласан эрх чөлөө, ялалт, эдгэрэл, дотно байдлыг өөрийн амьдралдаа мэдэрч байна уу? Хэрвээ үгүй бол Түүний амлалтуудыг мэдэрмээр байна уу?

Бясалгал: Дээр дурьдсан Бурханы амлалтыг бясалгаарай. Эдгээр амлалтаас алийг нь амьдралдаа мэдрэхийг хүсч байна вэ?

Бурхантай хамт алхах нь: Хэрвээ та эдгээр амлалтыг амьдралдаа мэдрэхгүй байгаа бол Бурханаас таны амьдралд эдгээр амлалт бодитоор хэрэгжихэд туслахыг Бурханаас гуйгаарай.

Дахин нэг чухал амлалт: Таны СҮНСЛЭГ хувь тавилангийн биелэл

Итгэгч хүний хувьд танд болон надад сүнслэг хувь тавилан байгаа. Ром 8:29, 2 Коринт 3:18, Галат 4:19 ишлэл дээр Христитгэлт хүний сүнслэг хувь тавиланг тодорхойлсон байна.

"Тэр Өөрийнхөө Хүүг олон ах дүүсийн дунд ууган нь байлгахын тулд, урьдаас мэдсэн хүмүүсээ Тэр бас Түүний дүртэй адил болгохоор урьдаас тогтоосон юм." Ром 8:29

"Харин бид бүгд бүтээлэггүй нүүрээр Эзэний алдрын тусгалыг хардаг. Бид энэхүү Түүний дүрд алдраас алдарт өөрчлөгддөг. Энэ нь Эзэний Сүнсээр болдог." 2 Коринт 3:18

"Хүүхдүүд минь, Христ та нарын дотор дүрээ олтол би төрөх зовлонг дахиж эдэлж байна." Галат 4:19

Эдгээр гурван ишлэл дээр тулгуурлан таны сүнслэг хувь тавилан юу гэдгийг энгийнээр тодорхойлоё.

<i>Таны Сүнслэг Хувь Тавилан гэдэг нь:</i> <i>Та Христтэй АДИЛ болж ӨӨРЧЛӨГДӨХ ба ингэснээр та Христтэй адил БОДОЖ,</i> <i>ИТГЭЖ, СОНГОЖ, ҮЙЛДЭХ болно.</i>

Хэсэг хугацаанд бодоод үзье. Хэрвээ Бурхан таныг өөрчлөөд та Христтэй адил бодож, итгэж, сонгож, үйлдэж эхэлбэл таны амьдралын юу нь өөр байх вэ? Таны бусадтай харилцах харилцаа эсвэл тухайн нөхцөл байдалд хандах хандлага хэрхэн өөрчлөгдөх вэ?

Миний үйлчилж байсан олон Христитгэгчид Христтэй адил болж өөрчлөгддөггүй байсан. Би ч бас 30 жил ямар ч өөрчлөлтийг хэрэгжүүлж чадаагүй учраас би сайн ойлгож байна. Яагаад өөрчлөгдөж чадаагүй вэ гэхээр Христитгэлт амьдралаар амьдрах утга учрыг буруу ойлгосноос болсон юм. Христитгэлт амьдралаар амьдрах үнэн утга учрыг мэдэлгүйгээр, итгэхгүйгээр амьдарч байсан учраас ямар ч том өөрчлөлт гараагүй юм.

Таны дотор Бурханы амь ба хүч чадлын бүрэн дүүрэн, төгс байдал байгаа учраас Христтэй адил бодож, сонгож, итгэж, үйлдэх гайхалтай хүчийг мэдэх боломжтой.

Санамж: Таны дотор амьд буй Христээс тусгаарлагдсанаар ямар ч өөрчлөлтийг хийж чадахгүй. Та өөрийнхөө авъяас чадвараар Христтэй адил болохыг хичээнэ гэсэн үг биш юм.

Асуулт: Христтэй адил бодож, мэдэрч, итгэж, сонгож, үйлдвэл таны амьдрал хэрхэн өөрчлөгдөх вэ?

Бясалгал: Ром 12:2, 2 Коринт 3:18 бясалгаарай. Таны амь болсон Христ таны дотор амьдарсанаар Тэр таны бодол, мэдрэмж, сонголт, үйлдлийг өөрчилнө.

Бурхантай хамт алхах нь: Өөрчлөлтийг хүсч байгаа тэр талбарт өөрчлөлт эхлэхийг Бурханаас гуйгаарай.

Бурхан таны дотор Өөрийн амлалтыг биелүүлэхийн үр дүн нь юу вэ?

Таны дотор амьдардаг амь болсон Христ танд **бялхам амийг** өгөх болно. Иохан 10:10 ишлэл дээр Бурхан ийнхүү амласан байна.

"Би тэднийг амьтай, бялхсан амьтай байлгахын тулд ирсэн юм." Иохан 10:10

Есүс бол бялхам амь гэдгийг та юу гэж бодож байна вэ? Есүс нөхцөл байдлаас үүдэн өөрчлөгдөж байдаг бялхам амийн талаар хэлээгүй гэж би итгэдэг. Есүсийн ярьж байгаа бялхам амь дотоод бялхам амь байх боломжтой юу? Өмнөх хэсэгт жагсааж бичсэн амлалтыг ашиглан бялхам амийн утга учрыг тайлбарлая.

Хэрвээ та:

- Гэм нүгэл, махан бие, дэлхий, Сатаныг ялан дийлж амьдарч байсан бол
- Бүтэлгүйтлээсээ эрх чөлөөг амсаж байсан бол
- Өнгөрсөн, одоогийн шархнаасаа эдгэрч байсан бол
- Хэрэгцээ болгон тань хангагдаж байсан бол
- Христтэй адил бодож, мэдэрч, сонгож, үйлдэхийн тулд өөрчлөгдөж чадаж байсан бол
- Бурхантай хувийн, дотно харилцаатай байсан бол

Та бялхам амьтай байхад анхаарлаа хандуулмаар байна уу?

Та яг над шиг бялхам амьтай байхад анхаарлаа хандуулна гэдэгт итгэлтэй байна.

Бурхан бол таны амь, амь бол БЯЛХАМ юм. Бялхам амийг таны дотор амьдардаг Христ зөвшөөрсөнөөр Түүний амлалт болох ЭРХ ЧӨЛӨӨ, ЯЛАЛТ, ЭДГЭРЭЛ, ӨӨРЧЛӨЛТ, ДОТНО БАЙДЛЫГ та амьдралдаа амсах болно.

Асуулт: Хэн нэгэн танаас та бялхам амьтай амьдралаар амьдарч байна уу гэж асуувал та юу гэж хариулах вэ?

Бид Бурханы төлөө амьдардаг биш Бурхан бидний төлөө амьдардаг

Бидний дотор амьдардаг амь болох Бурханы талаар сурлаа. “АМЫГҮЙ” амьдралаар амьдарсаны үр дүнд би Христитгэлт амьдрал гэдэг нь Бурханы ТӨЛӨӨ амьдарч байна гэж итгэж байсан. Энэ утгаараа сайн мэдээ тараах, дагалдагч бэлтгэх зэргийг хийхэд би Бурханд хэрэгтэй гэж заалгасан юм. Та бас ингэж бодож байсан уу? Зөвхөн Христ амьдарч чадах “АМЬТАЙ” Христитгэлт амьдралыг Бурхан биднээс шаардаагүй. Бурханы ТӨЛӨӨ та ямар нэгэн зүйл хийх эсэх нь таны л шийдвэр. Филиппой 1:6 хэлсэнчлэн Бурхан бол хангагч, бүтээгч бөгөөд Бурхан биднээс ямар нэгэн зүйлийг хүсдэггүй.

"Та нарын дотор сайн үйлийг эхлүүлсэн Тэрээр үүнийгээ Христ Есүсийн өдрийг хүртэл төгс төгөлдөр болгоно гэдэгт би бат итгэж байна." Филиппой 1:6

Бурхан бидний хангагч, бүтээгч учраас бид нар Түүний ТӨЛӨӨ амьдардаггүй ба Бурханаас амьдрахын тулд бид оршин байдаг юм.

ХУДАЛ:

Бид Бурханд ямар нэгэн зүйлийг хийж өгөх ШААРДЛАГАТАЙ учраас бид Бурханы ТӨЛӨӨ амьдардаг.

ҮНЭН:

Бурхан бол ЭХ СУРВАЛЖ ба тэр ЭХ СУРВАЛЖААС амьдрал тэтгэгддэг учраас бид Бурханаас хамааралтай амьдрахын тулд оршин байдаг.

Асуулт: Бурханы ТӨЛӨӨ та хийж өгөх хэрэгтэй ямар нэгэн зүйл байгаа гэдэгт та итгэдэг үү? таны эх сурвалж болсон Бурханаас тэтгэгддэг амьдрал дотор та оршин байдаг гэж бодож байна уу? Бурханаас эсвэл Бурханы төлөө амьдрахын тулд оршин байдгийн аль нэгэнд итгэвэл ялгаа нь юу байх вэ?

Таны дотор амьдарч буй Бурханы ТУЙЛЫН зорилго

Таны дотор амьдарч буй Бурханы туйлын зорилгыг ойлгохын тулд эхлээд хүнд хандсан Түүний зорилгыг ойлгох хэрэгтэй.

"Тэр Өөрийн хүслийн сайн тааллын дагуу, биднийг Есүс Христээр Өөрийнхөө хөвгүүд болгон үрчлэн авахаар урьдаас тогтоожээ." Ефес 1:5

Бурханы ӨӨРЧЛӨГДӨШГҮЙ төлөвлөгөө бол биднийг Түүнтэй хамт ХУВИЙН, ДОТНО харилцаатай байлгахын тулд Өөр дээрээ авчрах юм.

Та Бурхантай харилцаатай байхын тулд бүтээгдсэн. Бурхан бидэнтэй дотно, хувийн харилцаатай байхыг хүсдэг. Тийм учраас Тэр өөрийгөө бидэнтэй салгагдашгүй хамт байлгадаг. Бурхан бидэнтэй харилцаатай

байх албагүй. Гэхдээ Бурхан бидэнтэй харилцаатай байхыг хүсдэг. Бурхан бидэнтэй гүнзгий харилцаатай байхыг хүсч байгаа нь Түүний болзолгүй хайр юм.

*"Түүний өмнө биднийг ариун бөгөөд гэм зэмгүй байлгахын тулд Бурхан ертөнцийн сууриас урьд биднийг Түүний дотор **сонгосончлон, хайраараа...**" Ефес 1:4*

Бурхан биднийг мөнхөд хайрласан гэж Библи дээр хэлсэн. Бурхан таныг төрөхийг тэсэн ядан хүлээж байгаад хайраа бидний зүрхэнд цутгасан. Нэгэн шинжлэх ухааны баримтыг авч үзье. Үр тогтоход генетикийн хослол үүсэх 500 САЯ боломж байдаг ба энэ дотроос Бурхан ТАНЫГ төрүүлэхээр сонгосон. Бурхан Түүний амлалт таны амьдралд биелэлээ олох амийг өгөхөөс гадна тантай харилцаатай байж таныг Түүний агуу хайрыг мэдээсэй гэж хүсдэг.

Бясалгал: Ефес 1:4, Ефес 1:5 бясалгаарай. Бурхан таныг Түүнтэй харилцаатай байлгахын тулд бүтээсэн. Бурхан таныг төрүүлэхээр сонгож авсан ба таны төрөхийг хүлээж байгаад Тэр өөрийн хайрыг таны зүрхэнд цутгахаар хүлээж байсан.

Бурхантай хамт алхах нь: Бурхантай харилцах харилцааны төвшинд зөрчил байгаа бол Тэр өөрийн хязгааргүй, мөнхийн хайраа танд өгсөн гэдгийг хүлээн зөвшөөрөхөд туслахыг гуйгаарай.

Анх удаа эдгээр үнэнийг сонссоноос хойш надад юу тохиолдсон бэ?

1998 оны 10 сарын 04-ний өдөр “АМЪТАЙ” Христитгэлийн талаар үнэнийг сонссоноос хойш шинэ "АМЪТАЙ" Христитгэлт амьдралаар амьдрах аялалаа эхлүүлсэн. Үр дүнд нь Бурхан миний бодол, мэдрэмж, сонголт, үйлдлийг өөрчилж эхэлсэн. Миний дотор амьдардаг Христэд итгэсэнээр хангалтгүй, айдас, уур хилэн, үнэ цэнэгүй байдлын хүлээнээс чөлөөлөгдсөн. Бурхан миний амьдралыг өөрчилсөнөөр Христтэй хамт алхахыг хүсдэг олон итгэгчдэд эдгээр үнэнийг хуваалцахын тулд амжилттай ажиллаж байсан бизнесээ орхин үйлчлэлээ эхлүүлсэн. Таны дотор амьдардаг “АМЪТАЙ” Христитгэлт амьдралаар амьдрах нь танд ямар утга учиртайг илчилж өгөхийг Ариун Сүнснээс би гуйн залбирч байна.

Нэгдүгээр хичээлийн дүгнэлт

- Христ өөрөө амь юм. Иохан 14:6
- Бурхан бол таны дотор амьдардаг амийн Эх сурвалж юм. Үйлс 17:28
- Уналтаас өмнө Бурхан бол Адам, Евагийн эх сурвалж нь байсан. 1 Коринт 1:30
- Адам, Ева гэм үйлдэн Бурханыг дагаагүй учраас сүнсний хувьд тэд үхсэн. Ром 5:12а
- Бурхан бидний гэмийг өршөөсөн ба хүний эх сурвалж болохын тулд Өөрийнхөө амийг бидэнд өгсөн. Ефес 1:7, 1 Иохан 5:12
- Бурханы амь ба хүч чадал бидний амьдралыг өөрчилнө гэж амласан. 2 Коринт 3:18
- Бурхан биднийг өөрчлөх явцдаа уг өөрчлөлтийн эхлүүлэх шалтгаан ба үр дүн нь байдаг. Филиппой 1:6
- Таны өөрчлөлтийн туйлын зорилго нь Бурхантай хувийн, дотно харилцаатай байх юм. Ефес 1:5

"АМЬТАЙ" БОЛОН "АМЬГҮЙ" ИТГЭЛИЙН АМЬДРАЛЫН ЯЛГАА

**Амьгүй итгэлийн амьдрал
(Та өөрөө өөрийнхөө амьдралын ЭХ СУРВАЛЖ)**

Биеэ даасан амьдрал

Христитгэл амьдрал амьдрахдаа Би Христээс тусдаа биеэ даасан амьдралаар амьдарна

Христитгэл амьдрал бол Гүйцэтгэлийн амьдрал

Христитгэл амьдрал нь дагах ёстой хууль журмууд болон бөглөх ёстой хийх зүйлсийн жагсаалт

Христитгэл амьдралын ЭХ СУРВАЛЖ нь та

Бурханы төлөө амьдрах

Бурханаас ямар нэг зүйл (Хайр, хүлээн зөвшөөрөгдөх) авах гэж эсвэл өөрийн хүчээр Бурханд юм хийж өгөх гэж амьдрах

Бурханы тусламжтайгаар өөрөө өөрийгөө өөрчлөх

Ялалт, эрх чөлөө, эдгэрэл, өөрчлөн шинэчлэлтийг Бурханы тусламжтайгаар өөрийнхөө хүч чадлаар хийх

Бурханы багахан тусламж оролцоотойгоор өөрөө өөртэй итгэж амьдрах

Христитгэлт зөвт амьдралыг цогцлоохын тулд Бурханы тусламжтайгаар өөрийн ур чадвар, оюун ухаан, сахилга батанд найдан амьдрах

ҮР ДҮНД НЬ :

Махан биеийн хүсэл, гэм нүгэл, сэтгэл уналт, ялагдал шарх
Христитгэл амьдралаас холдох, эсвэл худлаа төсөөлөлөөсөө болоод өөрөө өөрийнхөөрөө муйхраар зүтгэх
Өөрчлөл шинэчлэлт байхгүй
Өөрөө өөрийгөө болгосон Христитгэл амьдрал
Байнгийн тэмцэл, тогтворгүй байдал

**Амьтай итгэлийн амьдрал
(Христ Таны амьдралын ЭХ СУРВАЛЖ)**

Хамааралтай амьдрал

Христитгэл амьдралаар амьдрахдаа цаг хором тутам Эзэнээс хамааралтай амьдралаар амьдрах
Иохан 15:5

Христитгэл амьдрал бол Христ ӨӨРӨӨ

Христитгэл амьдрал бол Христ ӨӨРӨӨ
Иохан 14:6, Филиппой 1:21

Христитгэл амьдралын ЭХ СУРВАЛЖ нь Бурхан ӨӨРӨӨ Бурханаас эхлэлтэй амьдрах

Амьд байгаа нь би биш, харин миний дотор амьдардаг Христ юм.

Галат 2:20

Бурханы удирдан явуулах өөрчлөлт шинэчлэлт

Түүний үйлдсэнээр та нар Христ Есүс дотор байгаа бөгөөд Тэрээр бидэнд Бурханаас ирсэн мэргэн ухаан, зөвт байдал, ариусал ба золилт мөн.

1 Коринт 1:30

Бурханд итгэж амьдрах

Бурханы итгэлтэй хамт байсанаар Христтэй адил болох өөрчлөлтийн хүч чадал тань руу урсах болно.

1 Иохан 5:12;

Эфес 1:19, 20; Еврэй 11:6

ҮР ДҮНД НЬ:

Эрх чөлөө, ялалт, эдгэрэл - Галат 5:1;
1 Коринт 15:57; Дуулал 147:3
Бурханаас илүү ихээр хамаарах - Иохан 15:5
Бурхантай илүү ойр дотно байх - Филиппой 3:8
Христтэй адил болгон өөрчлөгдөх -
2 Коринт 3:18; Ром 8:29
Бүрэн дүүрэн амьдрал - Иохан 10:10

ХОЁРДУГААР ХИЧЭЭЛ

ТАНЫ ДОТОР АМЬДАРДАГ ТҮҮНИЙ АМИЙГ ТЭТГЭХИЙН ТУЛД БУРХАНЫ ХИЙДЭГ АЖИЛ БОЛОН ТҮҮНИЙ АМИАР ТЭТГЭГДЭХИЙН ТУЛД ТАНЫ ХИЙХ АЖИЛ

НЭГ ДЭХ ӨДӨР

Хоёрдугаар хичээлийн агуулга

- Таны дотор амьдардаг амийг тэтгэхийн тулд Бурханы хийдэг ажил
- Та Бурханы амиар тэтгэгдэхийн тулд таны хийх ажил
- Есүс Эцэгтэйгээ хэрхэн харилцаж амьдарсаныг ойлгох нь
- Бурхантай хамааралтай амьдрахад яагаад зөрчил үүсдэг вэ?
- Яагаад бид Бурханаас салангид биеэ даан амьдарч чадахгүй вэ?
- Итгэл гэдэг үгийг тодорхойлох дөрвөн арга зам
- Итгэлийн талаарх хоёр зүйл
- Яагаад бид итгэлтэйгээ зөрчилддөг вэ?

Оршил

Нэгдүгээр хичээл та бүхэнд Христийн амь болох “АМЬТАЙ” амьдралын үнэн гэж юу болохыг, Тэр бидний дотор Өөрөө амьдрахыг хүсдэг талаар тодорхой ойлгосон гэж найдаж байна. Харин хоёрдугаар хичээл дээр бид таны дотор амьдардаг амь болсон Христэй хамт амьдрахын тулд таны хийх ажил болон Бурханы хийдэг ажлын талаар суралцъя.

Таны дотор амьдрахын тулд Бурхан юуг хийдэг вэ?

Олон Христитгэгчид тэдний дотор амьдардаг амь болсон Бурхантай хамт амьдрахын тулд Бурхан хэрхэн ажилладаг болон бид юуг хийх ёстойг мэддэггүй учраас хамгийн түрүүнд үүнийг ойлгож мэдэхээс энэ удаагийн хичээлээ эхэлье. Тиймээс Бурханы хэрхэн ажилладаг болохыг Библи дээр юу гэж хэлсэнийг хараад дараа нь амь болсон Христ таны дотор амьдрахын тулд бид юу хийх хэрэгтэйг харъя.

Бурхан бол Өөрийн амласан амлалтуудаа Таны амьдралд бодитойгоор биелүүлэхээр энэхүү амлалтыг САНААЧЛАГЧ нь бөгөөд амлалтын ҮНДЭС СУУРЬ ба ТӨГӨЛДӨРШҮҮЛЭГЧ нь юм.

"Та нарын дотор сайн үйлийг эхлүүлсэн Тэрээр үүнийгээ Христ Есүсийн өдрийг хүртэл төгс төгөлдөр болгоно гэдэгт би бат итгэж байна." Филиппой 1:6

Энэ ишлэл дээр Паул юу гэж хэлж байна вэ? Бурхан сайн үйлийг эхлүүлсэн ба үүнийгээ таны дотор төгс төгөлдөр болгохыг хүсч байна гэж хэлсэн байна. Бурхан энэ сайн үйлийг таны дотор загалмайн авралын үед эхлүүлсэн буюу **санаачилсан** юм. Хүн төрөлхтөнийг гэм нүглээс аврахын тулд Эцэг Өөрийн Хүү Есүсийг бидэнд илгээн загалмай дээр цовдлуулсанаар энэ сайн үйлийг төгс төгөлдөр болгосон юм. Гэхдээ Бурхан биднийг авраад зогсохгүй үүнээс ч агуу зүйлийг хийнэ гэж амласан. Филиппой 1:6 ишлэлийн хоёр дахь хэсгээс үүнийг харж болно.

"Та нарын дотор сайн үйлийг эхлүүлсэн Тэрээр үүнийгээ Христ Есүсийн өдрийг хүртэл төгс төгөлдөр болгоно гэдэгт би бат итгэж байна." Филиппой 1:6

Филиппой 1:6 ишлэлийг харвал Бурхан таныг аврах ажлыг эхлүүлээд л дуусаагүй, харин уг авралын сайн үйлээ БҮРЭН ТӨГС БОЛГОНО гэсэн байна.

Бурхан бол САНААЧЛАГЧ нь бөгөөд таны амьдралыг бодитойгоор өөрчилж чадах ҮНДЭС СУУРЬ ба ТӨГӨЛДӨРШҮҮЛЭГЧ нь юм


Бид амьдралдаа өөрөө өөрсдийгөө өөрчилж чадах САНААЧЛАГЧ нь буюу энэ өөрчлөлтийнхөө үндэс суурь ба төгөлдөршүүлэгч нь байж чадна гэсэн буруу ойлголттой байдаг. Нөгөө талаас хэрвээ ямар нэг өөрчлөлт хэрэгтэй бол та өөрөө өөрийгөө Бурханы хэсэг тусламжыг аваад өөрөө өөрчилж чадна гэж ойлгодог. Энэхүү буруу ойлголтоос болоод маш олон Христитгэгчид өөрөө өөрсдийгөө өөрчлөх гэж маш шаргуу хичээдэг эсвэл Христитгэлт амьдралд бууж өгөн орхиж явдаг. Гэтэл Бурхан амлалтаа Өөрөө л бүрэн дүүрэн төгс биелүүлэхийн тулд зөвхөн Бурхан л өөрчлөлтийг бий болгох үндэс суурь ба үр дүн нь байж чадна. Өөрөөр хэлбэл Бурхан бол танд амласан амлалтынхаа Бүтээгч нь юм.

Бурхан таны дотор юуг бүтээхийг хүсдэг вэ? Бурхан дараах зүйлийг таны амьдралд хийхийг хүсдэг.

- Та өөрөө ялан дийлж чадахгүй байгаа гэм нүглийн хүлээснээс таныг **ЧӨЛӨӨЛӨХИЙГ** хүсдэг. Галат 5:1
- Таны өнгөрсөн болон одоогийн шархыг **ЭДГЭЭХИЙГ** хүсдэг. Дуулал 147:3
- Таны хэрэгцээг **ХАНГАХЫГ** хүсдэг. Филиппой 4:19
- Дэлхийлэг, махан биеийн, Сатаны, гэм нүглийг ялах **ЯЛАГЧ** нь байхыг хүсдэг. 1 Коринт 15:57
- Христтэй илүү адил болгон таны амьдралыг **ӨӨРЧЛӨХИЙГ** хүсдэг. 2 Коринт 3:18
- Бурхан өөрөө тантай **ДОТНО** харилцаатай байхыг хүсдэг. Эфес 1:5

Бурхан бидэнд шинэчлэгдсэн бодол санаа, ялалт, эрх чөлөө зэргийг амласан бөгөөд Тэр амлалтаа биелүүлэх үндэс суурь хийгээд төгөлдөршүүлэгч нь болохын тулд бидний зүрх сэтгэл дотроос гадагш бидэнтэй хамт амьдрах бидний амьдрал юм гэдгийг харуулсан диаграм байна.

ЗҮРХ СЭТГЭЛИЙН ДОТРООС ЭХ СУРВАЛЖТАЙ АМЬДРАХ НЬ



Асуулт: Шинэчлэгдсэн бодол санаа, өөрчлөлт, ялалт, хангамж, эрх чөлөө зэргээс та алийг нь амьдралдаа илүү их мэдэрдмээр байна вэ?

Бурхантай хамт алхах нь: Бурханаас эдгээр зүйлс бидний амьдралд биелэлээ олсон байгаасай хэмээн гуйн залбираарай.

Бурхан үнэхээр бидний амьдралыг өөрчлөхийг хүсдэг үү? гэж маш олон Христитгэгчид асуудаг. Бурхан авралаар дамжуулан өөрийн сайн үйлийг таны дотор эхлүүлсэн ба Тэр таны амьдралыг өөрчлөхийг үргэлж хүсдэг гэдгийг Филиппой 1:6 ишлэл дээр харуулсан байна.

*"Та нарын дотор сайн үйлийг эхлүүлсэн Тэрээр үүнийгээ Христ Есүсийн өдрийг хүртэл **төгс** төгөлдөр **болгоно** гэдэгт би бат итгэж байна."* Филиппой 1:6

Олон Христитгэгчдийн амьдралаас харсан бодит үнэн бол өөрчлөхийг хүсэхгүй байгаа нь

Бурхан БИШ бөгөөд

Бурханы өөрчлөлтийг амьдралдаа хүлээн зөвшөөрөхийг ХҮСЭХГҮЙ байгаа нь хүмүүс бид нар өөрсдөө билээ.

Асуулт: Таны амьдрал өөрчлөгдөх эсэх нь таны л гаргах шийдвэр эсвэл сонголтоос хамаарна гэдэгт та итгэж байв уу? Хэрвээ таны амьдралыг өөрчлөх учир шалтгаан ба үр дүн нь Бурхан гэдэгт та итгэвэл таны Христитгэлт амьдрал хэрхэн өөрчлөгдөх вэ?

Бясалгал: Филиппой 1:6 ишлэлийг бясалгаарай. Таны дотор буй Бурхан бол таны амьдралыг бүрмөсөн өөрчлөхийг юунаас ч илүүтэйгээр хүсч байгаа нэгэн гэдгийг нухацтай бодож үзээрэй.

Бурхантай хамт алхах нь: Хэрвээ таны амьдралыг өөрчлөхийг хүсч байгаа эсвэл өөрчлөх боломжтой нэгэн нь Бурхан гэдэгтэй та зөрчилдөж байвал Тэр таны амьдралыг юунаас ч илүүтэйгээр өөрчилж чадах ба өөрчлөхийг хүсч байгаа Нэгэн нь мөн гэж ятгаж өгөхийг Түүнээс гуйн залбираарай.

Таны дотор амьдарч буй Бурханы ажлыг САНААЧЛАГЧ нь болсон БУРХАНГҮЙГЭЭР, өөрчлөлтийг БҮТЭЭГЧ нь болох БУРХАНГҮЙГЭЭР, таны амьдрал ХЭЗЭЭ Ч өөрчлөгдөхгүй.

Усан үзмийн мод -мөчрийн үялдаа нь таны хийх хэрэгтэй ажлыг илэрхийлдэг



Хэдийгээр Бурхан бол таны амьдралыг өөрчлөх үндэс суурь ба төгөлдөршүүлэгч нь мөн боловч таны дотор амьдарч буй амиар тэтгэгдэн амьдрахын тулд та маш чухал үүрэгтэй оролцдог. Та маш чухал үүрэгтэй оролцоно гэдэг нь ямар утгатай болохыг Иохан 15:5 ишлэл дээр тайлбарласан байна.

"Би бол усан үзмийн мод, та нар мөчрүүд. Хэн миний дотор байж, Би мөн түүний дотор байна, тэр их жимс гаргана. Учир нь Надаас ангид та нар юу ч хийж чадахгүй." Иохан 15:5

Бие махбодийн хувьд мөчрүүд нь амьдрахын тулд усан үзмийн модтойгоо бүрэн хамааралтай байхаар бүтээгдсэн шиг сүнсний хувьд мөчрүүд нь амьдрахын тулд сүнсний Усан үзмийн мод болсон Бурхантай

бүрэн хамааралтай байхаар бүтээгдсэн гэж Есүс хэлсэн байна. “Миний дотор байна” гэдэг үг нь “**хамааралтай**” байна гэсэн утгатай юм.

Яг энэ мөчид маш чухал доорх үнэнийг ойлгох хэрэгтэй болно:

ЧУХАЛ ҮНЭН:

Бурхан хүнийг Түүнтэй ХАМААРАЛТАЙ байхаар бүтээсэн.

Түүний БҮТЭЭСЭН зорилго анхнаасаа таныг Түүнтэй хамааралтай байлгахад оршино.

“Бүтээл” гэдэг нь түлхүүр үг юм. Бурхан анхнаасаа Адам, Ева хоёрын хэрэгцээ бүрийг хангахын тулд тэднийг Түүнтэй бүрэн хамааралтай байхаар бүтээсэн гэж эхний хичээл дээр бид бүхэн суралцсан билээ. Бурхан төлөвлөгөөгөө өөрчлөөгүй. Та ч гэсэн Бурхантай **бүрэн** хамааралтай амьдрахын тулд бүтээгдсэн. Бурхан бол бидний Эх сурвалж юм бол Бурхантай хамааралтай байж Түүний Эх сурвалжаас амьдрах нь бидний хийх ёстой ажил биш гэж үү? Тийм учраас амьдрахын тулд мөчир усан үзмийн модтойгоо бүрэн холбоотой байдаг төгс жишээг Есүс ашигласан байна.

Таны дотор амьдардаг амь болсон Христийг таны төлөө Бурхан бүтээсэн юм.

Таны Эх сурвалж болсон Бурхантай БҮРЭН ХАМААРАЛТАЙ амьдрах ХАНДЛАГААР амьдар

Санамж: Иохан 15:5 дээр хэлсэн “гаргах” гэдэг үг нь “боловсруулах” гэсэн утгатай үг биш юм. “Гаргах” гэдэг нь “үргэлжлүүлэн авч явах” гэсэн утгатай юм. Мөчир дангаараа үр жимсийг боловсруулдаггүй. Усан үзмийн мод бол үр жимс боловсруулах эх сурвалж нь бөгөөд мөчир уг үр жимсийг боловсруулагч эх сурвалжаас нь дамжуулж байгаа юм.

ЧУХАЛ САНАА

Та Бурхантай ХАМААРАЛТАЙ БАЙХ ХАНДЛАГААР алхах үед таны Эх сурвалж болсон

Бурхан эрх чөлөө, ялалт, эдгэрлийн амлалтуудыг таны дотор БОЛОВСРУУЛАХ болно.

Христтэй адил болон өөрчлөгдөх СҮНСНИЙ хувь тавиланг Бурхан бүрэн дүүрэн хангах болно.

Асуулт: Та өөрөө үр жимс боловсруулж чадна гэж итгэж ирсэн үү? Хэрвээ та тийм гэж хариулбал таны хийх ажил бол “хамааралтай” байх ба Бурханы хийх ажил бол таны дотор үр жимсийг “боловсруулах” гэдэгт та итгэвэл Христтэй хамт алхах таны хандлага хэрхэн өөрчлөгдөх вэ? Хамааралтай байдал гэдэг нь бидний өнөөгийн соёлын дамжуулдаг ойлголтоос аль хир ялгаатай байна вэ?

Бясалгал: Олон Христтэгчид Иохан 15:5 ишлэлийг Есүсийн хэлсэн өнө мөнхийн үнэ цэнэ агуулсан гүн утга санааг ойлгохгүйгээр түгээмэл ашигладаг билээ. Тиймээс энэ ишлэл дээр цаг гарган сайтар тунгаан бодож бясалгаарай.

Бурхантай хамт алхах нь: Та мөчир – усан үзмийн мод хоёрын хоорондын харилцааг Таны Бурхантай хамааралтай байх сүнслэг ойлголттой уялдуулан гүн гүнзгий мөнхийн утга санааг ойлгуулж өгөхийг Бурханаас гуйн залбираарай.

ХОЁР ДАХЬ ӨДӨР

Хамааралтай байх байдлын талаар сайн ойлгохын тулд Есүс хэрхэн АМЬДАРЧ байсныг харья

Та яг одоо хамаарал гэж юу болох талаар гайхаж байж болох юм. Бурхантай хамааралтай байхыг бүрэн ойлгохын тулд энэ дэлхий дээр Есүс хэрхэн амьдарч байсныг харья. Юуны түрүүнд бид Бурханы мөн чанартай боловч энэхүү эрх мэдлээ хойш тавьсан Есүсийг ойлгох хэрэгтэй. Бид үүнийг Филиппой 2:6,7 дээр харж болно.

"Тэрээр хэдийгээр Бурханы мөн чанараар оришин байсан боловч, Бурхантай тэгш байх явдлыг Өөртөө хадгалах зүйл гэж үзсэнгүй, харин Өөрийгөө хоосолж, боолын дүрийг авч, хүнтэй адил болжээ"
Филиппой 2:6, 7

Энэ нь Есүс дэлхий дээр амьдарч байхдаа Бурханы дүрээр амьдарч байгаагүй гэсэн үг биш юм. Энэ нь Есүс хүний дүрээр амьдрахын тулд Бурхантай тэгш эрх мэдэлтэй байхыг хойш тавьсан гэсэн утгыг илэрхийлж байна. Үүгээрээ Есүс Өөрийн Эцэгтэй хэрхэн харилцаж амьдарсан гэсэн үг вэ?

Есүс Өөрийн Эцэгтэй харилцсан харилцааг тайлбарлах дараах 3 ишлэлийг харья.

"Есүс тэдэнд хандан: Үнэнээр, үнэнээр Би та нарт хэлье. Эцэгийнхээ хийдгийг Хүү нь үзэхгүй бол Хүү Өөрөөсөө юуг ч хийж чадахгүй. Учир нь Эцэг юу хийнэ, Хүү нь бас эдгээр зүйлийг түүнчлэн хийдэг."
Иохан 5:19

"Би Өөрийн санаагаар юуг ч үйлдэж чадахгүй. Би сонссоноороо шүүх бөгөөд Миний шүүлт шударга. Учир нь Би Өөрийнхөө хүслийг бус, харин Намайг Илгээгчийн хүслийг хайдаг." Иохан 5:30

"Тиймээс Есүс [тэдэнд]

-Та нар Хүний Хүүг өргөвөл, "Би байдаг" гэдгийг, мөн Би Өөрийн санаагаар юуг ч хийдэггүй, харин Эцэгийн Надад зааснаар Би эдгээрийг ярьдаг гэдгийг мэдэх болно." Иохан 8:28

Эдгээр гурван ишлэлийн нийтлэг санаа нь Эцэгээс салангид Есүс юу ч хийж чадахгүй гэж хэлсэн байна. Өөрөөр хэлбэл, Есүс энэ дэлхий дээр амьдарч байхдаа хором бүр Түүний Эх сурвалж болсон Эцэгтэйгээ хамааралтай байсан юм. Эх сурвалж болсон Эцэгээсээ Есүс хамааралтай амьдарч байсан гэдэг нь ямар утгатай вэ?

Есүс ӨӨРИЙН амь болон хүч чадлаар юуг ч үйлдээгүй ба харин ЭЦЭГИЙНХЭЭ амь болон хүч чадлаар үйлдсэн юм.



Үүгээр Есүс энэ дэлхий дээр үйлдсэн бүх зүйлсийн Эх сурвалж нь Есүс Өөрөө биш харин Эцэг байсан гэж ойлгож болох уу? Үүний хариулт нь Иохан 14:10 ишлэл дээрээс харагддаг.

"Би Эцэгийн дотор, Эцэг Миний дотор байгаа гэдэгт чи итгэхгүй байна уу? Миний та нарт хэлж байгаа үгсийг Би Өөрийн санаагаар хэлээгүй. Харин Миний дотор оршигч Эцэг Өөрийнхөө ажлуудыг хийж байгаа юм."

Энэ ишлэл бидэнд Эцэгийн **амь** болон **хүч чадлаар** Есүс өвчтэйг нь эдгээж, хараагүйг нь хараа оруулж, Лазарыг үхлээс амилуулсан гэж хэлж байна. Өөрөөр хэлбэл, Есүс Эцэгтэйгээ хамааралтай байсны үр дүнд Эцэг Христээр дамжуулан гайхамшгуудыг бүтээсэн. Есүсийн Эцэгтэйгээ харилцан хамааралтай амьдрал нь мөчир – усан үзмийн мод хоёрын харилцааг харуулсан төгс жишээ юм.

Хэрвээ Есүсийн хамааралтай байдлаар дамжуулан Эцэгийн амь ба хүч чадал Есүсээр дамжин гайхамшгийг бүтээсэн юм бол та Бурхантай хамааралтай байвал яг адил амь ба хүч чадал таны амьдралд ажиллахгүй гэж үү? Энэ нь биднийг дараах асуулт уруу хөтөлнө.

Хүний дүртэй адил болсон Есүс Эх сурвалж болсон Эцэгтэйгээ бүрэн ХАМААРАЛТАЙ амьдарсаны үр дүнд Есүсээр дамжуулан Түүний дотор Эцэг амьдарсан юм бол ТА ХЭРХЭН АМЬДРАХ ХЭРЭГТЭЙ ВЭ?

Чухал ойлголт: Есүс зөвхөн бидний гэмийн төлөө үхээгүй бөгөөд бидэнд хэрхэн амьдрахыг мөн харуулахын тулд ирсэн юм.

Асуулт: Нэгдүгээр хичээл дээр онцолж байсан Бурханы амласан ялалт, эрх чөлөө, эдгэрэл, өөрчлөлтийн амлалтыг эргэн харвал та Бурхантай хамааралтай амьдрахыг сонгосноор Бурхан таны амьдралд юуг бүтээж өгнө гэж итгэж байна вэ?

Бясалгал: Иохан номон дээр дурьдсан ишлэлийг бясалгаарай. Хэрвээ Есүс бидний үлгэр дууриалал болж Эцэгийнхээ амь ба хүч чадалд бүрэн хамааралтай амьдарсан юм бол Бурхан биднээс хэрхэн амьдрахыг хүсдэг хэрэг вэ?

Бурхантай хамт алхах нь: Одоог хүртэл Есүс Өөрийн Эцэгтэй харилцсан харилцааг та өөрийнхөө Бурхантай харилцах харилцаатай адилтган дүгнэж ойлгохгүй байж болох юм. Хэрэв тийм бол Есүс Өөрийн Эцэгтэй харилцсан харилцааг та өөрийн өдөр тутмын амьдрал дээр хэрхэн хэрэгжүүлж амьдрахыг илчилж өгөхийг Бурханаас гуйн залбираарай.

Бурхантай хамааралтай байхын тулд яагаад дотоод зөрчил тэмцэл үүсдэг вэ?

Христ миний дотор Өөрөө амьдрахыг хүлээн зөвшөөрөх шинэ аялалын маань эхлэл Бурхантай бүрэн хамааралтай байхын төлөөх дотоод зөрчил тэмцэлтэй тулгарлаа. Олон Христитгэгчдэд үйлчлэл хийж байхад бид бүгдээрээ Бурханд бүрэн хамааралтай байх тал дээр байнга зөрчилддөг юм байна гэдгийг ойлгосон юм. Яагаад? Яагаад бид бүхэн хамааралтай байхын эсрэг тэмцэл үүсдэг 3 нийтлэг шалтгааныг тайлбарлая.

1. Дэлхий бидэнд БИЕ ДААСАН бай гэж сургадаг

Хамааралтай байхад үүсдэг эхний тэмцэл бол бидний эргэн тойрон амьдарч буй нийгэм бидэнд “бие даасан бай, хувиа хичээсэн бай, өөрийнхөө хүч чадалд итгэ” гэж чангаар тунхагладаг. Биеэ даасан байдлыг уриагаа болгосон дэлхий бидний толгойг эргүүлсэнээс үүдэн бид Бурхантай хамааралтай амьдрахад тэмцэл үүсдэг.

2. Хамааралтай байх нь СУЛ ДОРОЙ БАЙДАЛтай адил гэсэн ойлголтыг дэлхий бидэнд өгдөг



Дэлхий “бие даасан бай” гэж хашгичихаас гадна “хамааралтай” байх нь “сул дорой байдалтай” адил гэсэн ойлголтыг тарааж байдаг. Хэн ч \ялангуяа эрэгтэйчүүд\ сул дорой гэж бусдад ойлгогдохыг хүсдэггүй учир тэд өөрсдөө бие даасан байдал дотроо “хүчтэй” харагдахыг сонгодог. (Жич: Хамаарал = сул дорой байдал гэдэг нь худал ойлголт)

3. Бурхантай хамааралтай байхыг эсэргүүцдэг хүний бүрэлдэхүүн хэсэг: МАХАН БИЕ

Бид аврагдах мөчийг хүртэл Бурханаас тусдаа бие даан амьдарч байсан. Христитгэлт амьдралд хөл тавих үед энэхүү амьдрал нь хамааралтай байх байдал юм гэдгийг ойлгох боловч биднийг үргэлж Бурхантай хамааралтай амьдруулахаас эсэргүүцдэг “махан бие” гэж нэрлэгддэг нэгэн зүйл бидэнд саад болдог. (Ром 7:18 харна уу). Махан бие бол “Би өөрийнхөөрөө амьдарч чадах учраас надад Бурхан хэрэггүй” гэж хэлдэг бидний дотоод хандлага юм.

МАХАН БИЕЭС эхтэй амьдрал нь Бурхантай хамааралтай амьдрахыг ЭСЭРГҮҮЦЭЖ байдаг #1 шалтгаан юм.

Дөрөвдүгээр хичээл дээр бид махан биеийн талаар илүү тодорхой ярилцах болно. Гэхдээ бид Бурхантай хамааралтай амьдрахыг маань ҮРГЭЛЖ эсэргүүцэж байдаг нэг зүйл бидэнд байдаг гэдгийг санаж байх нь маш чухал.

Үнэн бол хүн бие даасан амьдралаар амьдрахаар анхнаасаа бүтээгдээгүй гэдэгт байгаа юм.

Иохан 15:56-г дахин харцгаая. Энэ ишлэлийн төгсгөлд Есүс хэлэхдээ:

"... Учир нь Надаас салангид байвал та нар юу ч хийж чадахгүй..."

Би та бүхнээс нэг асуулт асууя. Мөчир усан үзмийн модноос салгагдах юм бол юу болох вэ? Усан үзмийн модноос хамааралгүй болсон учраас мөчир үхэж эхлэх ба усан үзмийн модноос ямар ч үр жимс ургахгүй. Хэрвээ та сүнслэг Усан үзмийн мод болсон Христээс салж биеэ даан амьдрахаар хичээж эхэлбэл таныг юу хүлээж байна вэ?

“Учир нь Надаас салангид байвал та нар юу ч хийж чадахгүй” гэж Есүс хэлэхдээ юуг илэрхийлдэг бэ? Иохан 15:56 ишлэл олон Христитгэгчдэд асуудал үүсгэдэг. Яагаад? Учир нь хүн Бурханаас салангид олон зүйлийг хийх чадамжтай байдагт оршино. Эхний хичээл дээр ярьж байсанчлан хүн хэрхэн ажил хийхийг, хэрхэн сайн спортын тамирчин болохыг, хэрхэн санхүүгийн асуудлаа зохицуулах зэргийг суралцдаг. Тэгвэл Есүсийн хэлсэн үг ямар утга учиртай вэ?

Бурханаас САЛАНГИД амьдарвал та Бурханы амладаг “АМЬТАЙ” амьдралыг бүтээж ЧАДАХГҮЙ гэж Есүс хэлсэн

Бурхантай хамааралтай байхаас ангид байх нь:

- Гэмийг ялах хүч БАЙХГҮЙ.
- Махан биеийг дийлэх ялалт БАЙХГҮЙ.

- Гэмт зуршлаас чөлөөлөгдсөн чөлөөлөлт БАЙХГҮЙ
- Одоо болон өнгөрсөнөөс авсан шархны эдгэрэл БАЙХГҮЙ
- Таны амьдралд ургуулсан Сүнсний үр жимс БАЙХГҮЙ.
- Таны амьдралыг өөрчилсөн өөрчлөлт БАЙХГҮЙ
- Бурхантай харилцах дотно харилцаа БАЙХГҮЙ.

Та дээрх жагсаалтыг дахин нэг нухацтай уншиж үзээд Бурханаас салангид бие даан амьдрахыг сонговол үр дүнд нь дээрх зүйлс таны амьдралд орж ирэх нь тодорхой гэдгийг ойлгоно.

Бясалгал: Иохан 15:56 ишлэлийг бясалгаад таны харилцаанд тулгамдаад буй шийдэгдээгүй зөрчил, ялахыг хүсч байгаа хэвшмэл гэм нүглийн зуршил, амьдралдаа хийхийг хүссэн өөрчлөлт зэрэгт энэхүү ишлэл хэрхэн хэрэгжүүлэлт болж болох талаар бодоод үзээрэй.

Бурхантай хамт алхах нь: Бурханаас салангид биеэ даан амьдарч байгаа тухайн талбарыг (ажил, гэрлэлт, гэр бүл зэрэг) илчилж харуулахыг Бурханаас гуйн залбираарай. Мөн Бурханы амь болон хүч чадлаас салангид амьдарсанаар та Түүний эрх чөлөө, ялалт, эдгэрэл, өөрчлөлтийг харах боломжгүй гэдэгт Бурхан таныг ятгаж өгөөрэй гэж гуйн залбираарай.

ЧУХАЛ ОЙЛГОЛТ

Та ӨӨРИЙНХӨӨ эрх мэдэл, хүч чадал, авьяас чадвар, сэтгэлийн тэнхээгээр амьдрах нь ЗӨВХӨН Бурхан л бүтээж чадах Христитгэлт амьдралыг бий болгож ЧАДАХГҮЙ-д хамаг асуудал байгаа юм.

ГУРАВ ДАХЬ ӨДӨР

Бурхантай ХАМААРАЛТАЙ БАЙХ = Бурханд итгэх ИТГЭЛ

"Итгэл үгүйгээр таалагдана гэдэг боломжгүй юм." Еврей 11:6

Би Бурханаас хамааралтай байхыг Бурхан **дотор** итгэлээр алхахтай адилтган жишлээ. Хэрвээ та Христитгэгч болоод тодорхой хугацаа өнгөрсөн бол Христитгэлийн амьдралд бидний зүгээс хийх ажил бол итгэл гэдгийг мэдэж байгаа. Гэвч, миний олж илрүүлж буйгаар хүмүүс итгэлийн асуудал дээр нэг бол буруу ойлголттой эсвэл худал итгэл үнэмшилтэй байдаг.

Би үүнийг хэлж буй шалтгаан нь тэд итгэл бол энэ хэмээн итгэн хүлээн авсан зүйл нь тогтвортой эрх чөлөө, ялалт, эдгэрэл, өөрчлөлтийг тэдэнд авчрахгүй байгаад байгаа юм. Иймээс цаашдын энэхүү хичээлээр таны итгэдэг итгэл гэж юу болохыг илүү нарийвчлан харангаа итгэлийн талаарх худал итгэл үнэмшил байгаа бол илчилж өгөхийг Бурханаас гуйгаарай. Нэн тэргүүнд та дараах асуултыг өөрөөсөө асуух байх:

Итгэлийн алхаа бол энэ юм гэж ИТГЭЖ байгаа зүйл маань миний амьдралыг ӨӨРЧИЛЖ байна уу?



Би яагаад хамаарал = итгэл гэж хэлэв? Та бүхэнд нэгэн жишээг харуулья. Таны шүд өвдвөл шүдний эмчид очих хэрэгцээ үүснэ. Та асуудлаа шийдүүлэхийн тулд шүдний эмчтэй бүрэн хамааралтай болно. Өөрөөр хэлбэл, энэхүү хамаарал нь та өөрөө хийж чадахгүй зүйлээ шүдний эмчийн чадварт итгэн даатгах юм. Энэ нь бид бүхэн Бурханд итгэж найдахтай яг адил юм. Итгэл гэдэг нь энгийнээр таны амьдралд гүйцэлдүүлнэ гэж амласан Бурханы амлалт биелэхийн (та өөрөө биелүүлж чадахгүй) тулд Бурхантай хамааралтай байх юм.

Галат 2:20 уншаад Паулын дотор Христ амьдрахын тулд Паул юу хийснийг харъя.

"Би Христтэй хамт цовдлогдсон. Амьд байгаа нь би биш, харин миний дотор Христ амьд байна. Эдүгээ би махан биедээ амьд байгаа нь намайг хайрлаж, миний төлөө Өөрийгөө тушаасан Бурханы Хүүд итгэх итгэлээр амьдарч буй хэрэг юм." Галат 2:20

Паул хэлэхдээ Христ Паулын дотор амьдрахыг хүлээн зөвшөөрөх нь итгэлийн амьдралд түүний хийх хэсэг ба энэ нь итгэлээр юм гэжээ. Өөрөөр хэлбэл, Христ л хийж чадах зүйлийг хийлгэхийн тулд зөвхөн Христээс л бүрэн хамааралтай байх ёстой гэж Паул хэлж байна. Олон Христитгэгчид надаас “Би Христитгэгч амьдралаар хэрхэн амьдрах вэ?” гэж асуудаг. Энэ бол буруу асуулт юм. Үнэн бол Христ л Өөрийнхөө амьдралыг таны дотор амьдарч чадах тул та ингэж асуух хэрэгтэй.

Миний дотор Христ өөрөө амьдрахыг би хэрхэн ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ вэ?

Хариулт нь Христтэй хамааралтай байх буюу Христ дотор итгэлтэй байсанаар. Бид энэ хичээлийг бүрэн дуусгах тэр явцад яагаад маш олон Христитгэгчид итгэлийн талаарх худал итгэл үнэмшлээсээ болж өөрчлөгдөхгүй байгааг харах болно.

Итгэлээр алхсаны үр дүн нь Таны дотор амьдардаг амь болсон Христ Өөрийн амласан амлалт болох бялхам амьдралыг бүтээж өгөх болно.

Итгэл бол Христитгэгчдийн “ХЭРХЭН” гэдгийн учиг юм.

Итгэлээр амьдрах нь Ариун Сүнс таны дотор дараах зүйлүүдийг бүтээж өгөх шижүүрийг нээдэг:

- Гэм нүглээсээ **ЧӨЛӨӨЛӨГДӨХ**
- Махан бие, гэм нүглийн хүч чадал, Сатаныг **ЯЛАН ДИЙЛЭХ**
- Одоо болон өнгөрсөнд авсан шархнаасаа **ЭДГЭРЭХ**
- Христтэй адил болж **ӨӨРЧЛӨГДӨХ**
- Бурхантай **ДОТНО** харилцаатай байх

ИТГЭЛИЙГ тодорхойлох 4 арга зам

Итгэлийн талаар гүнзгий ойлголттой болохын тулд өнгөрсөн жилүүдэд надад тусалж байгаа 4 бодит арга замыг танд танилцуулъя. Энэ арга замууд танд ч гэсэн тусална гэж найдаж байна.

1. **Итгэл бол бидний БОДИТ БАЙДАЛ ба БАТАЛГАА юм.**

"Итгэл бол бидний найдаг зүйлсийн бодит байдал, харагдахгүй зүйлсийн баталгаа мөн."
Еврей 11:1

Еврей 11:1 дээр буй “бодит байдал” гэдэг үгийн зарим утгуудыг Стронгийн Лексикон хэмээх Библийн тайлбар орчуулга дээр оюун санааны тууштай байдал, шийдэмгий байдал, гарцаагүй хэмээн итгэх, хөдлөшгүй итгэн даатгах гэж тайлбарласан байна. "Баталгаа" гэдэг нь эргэлзээгүй баримт гэсэн утга илтгэдэг. Эдгээр бүх үгсийг нэгтгэвэл итгэлийн нэг тодорхойлолт нь дор дурдсанчлан болно:

ИТГЭЛ бол :

Бурхан бол Тэр өөрөө байдаг гэж хэлсэн Тэр Нэгэн мөн ба амласнаа биелүүлэх Бурхан гэдгийн БОДИТ БАЙДАЛ, ГАРЦААГҮЙ ИТГЭЛ, ЭРГЭЛЗЭЭГҮЙ БАЙДАЛ юм.

Хэрэгжүүлэлт: Дээрх тодорхойлолтын хэрэгжүүлэлт нь Иохан 6:37-40 ишлэлийн дагуу "Бурхан Өөрийнхөө тухай хэлсэн нь үнэн бөгөөд надад авралаа алдахгүй гэж амласан учраас би авралаа алдахгүй гэдэгт бүрэн итгэлтэй байна" гэж итгэх юм.

Асуулт: Бурхан Өөрийнхөө тухай хэлсэн зүйлд болон амласан зүйлээ таны амьдралд биелүүлэхийг хүсдэг мөн биелүүлж өгөх чадамжтай гэдэгт итгэх аль хир хэмжээний хөдлөшгүй итгэл ба баталгаа танд байна вэ? Бурханаас бүрэн хамааралтай байж чадахгүй байгаа нь танд хөдлөшгүй итгэл болон баталгаа дутаж байгаагийн илрэл байж болох уу?

Бясалгал: Еврей 11:1 ишлэлийг бясалгаад та бүрэн баталгаатай байж чаддаггүй нөхцөл байдлууд, Бурхан ажиллаж байгаа гэдэгт итгэж чаддаггүй талбаруудаа бодож үзээрэй.

Бурхантай хамт алхах нь: Тэдгээр талбарууддаа, Бурхан бол амласанаа таны амьдралд биелүүлэх, Өөрийнхөө талаар хэлсэн Тэр нэгэн мөн гэдэгт улам ихээр ятгаж, гарцаагүй баталгаатай болгохыг Бурханаас гуйн залбираарай.

2. Итгэл бол ҮНЭМШИЛ ба ХҮЛЭЭЛТ юм.

ИТГЭЛ бол

(Маттью Хенригийн тайлбар орчуулгад тодорхойлсоноор)

Бурхан Христ дотор бидэнд амласан БҮХНЭЭ гүйцэтгэнэ гэж бат ҮНЭМШИЖ ХҮЛЭЭХ нь юм.

Үнэмшил ба хүлээлт гэдэг үгнүүдээс болоод надад энэ тодорхойлолт таалагддаг. Яагаад бид нар хамгийн түрүүнд Бурхан дээр очдог вэ? Учир нь Бурхан бол Өөрийнхөө талаар хэлсэн Тэр Нэгэн мөн ба амласанаа биелүүлнэ гэж тодорхой төвшинд итгэдэг тул бид Бурхан дээр ирдэг. Өөрөөр хэлбэл, бидэнд амласан амлалтаа биелүүлэх Бурханы чадварт тодорхой хэмжээгээр бид үнэмшсэн байдаг.

Гэвч, бидний үл итгэлээс болоод амьдралын туршид биднийг Бурхан үргэлжлүүлэн үнэмшүүлэх хэрэгтэй болдог. “Тэнгэрлэг үнэмшил ” бол бидний өөрчлөлтийн зайлшгүй нэг хэсэг юм. Ром 4:21 ишлэл дээр Абрахам амласан амлалтаа гүйцэлдүүлэх Бурханы хүч чадал болон чадамжинд баттай итгэсэн талаар Паул дурдсан байдаг.

"Бурхан амласнаа биелүүлэх чадвартай гэдэгт бүрэн үнэмшилтэй байлаа." Ром 4:21

Хэрэгжүүлэлт: Дээрх тодорхойлолтын хэрэгжүүлэлт нь "Бурханаас хамааралтай алхах үед Бурхан надад хайртай бөгөөд Тэр миний амьдралыг өөрчилнө гэдэгт намайг улам бүр бат үнэмшилтэй болгох болно" гэж бодох юм.

Асуулт: Таны амьдралыг өөрчлөх Бурханы хүч чадал ба хүсэлд та хир бат итгэлтэй байдаг вэ? Танд илүү Бурханлаг үнэмшил хэрэгтэй юу?

Бясалгал: Ром 4:21, Филиппой 1:20 ишлэлүүдийг бясалгаад энэ асуултыг бодож үзнэ үү. Амьдралын тань аль талбарт Бурханы хайр, зан чанар, амлалтын талаар үнэмшлээ илүү ахиулах хэрэгцээ байна вэ?

Бурхантай хамт алхах нь: Дээрхи бодсон тухайн талбарт Бурхан илүү ихээр үнэмшүүлж өгөхийг гуйн залбираарай.

3. Итгэл бол “БИ ЧАДАХГҮЙ” боловч “БУРХАН ЧАДНА” гэдэгт итгэх юм.

БИ ЧАДАХГҮЙ - Учир нь Надаас салангид байвал та нар юу ч хийж чадахгүй. Иохан 15:56

БУРХАН ЧАДНА - Та нарын дотор сайн үйлийг эхлүүлсэн Тэрээр үүнийгээ Христ Есүсийн өдрийг хүртэл төгс төгөлдөр болгоно гэдэгт би бат итгэж байна. Филиппой 1:6

Бид эхлээд “би чадахгүй” гэдэг цэгт ирэх хэрэгтэй. Учир нь үнэн гэвэл бидний амьдралд ирэх өөрчлөлтийн амлалтаа бий болгох ажлыг зөвхөн “Бурхан чадна”. Бурхан чадна гэдгийг харуулсан өөр нэг ишлэл бол Дуулал 37:5 юм:

*"Өөрийн замыг ЭЗЭНд даатга. Мөн Түүнд итгэж найд. Тэгвэл Тэр **БИЕЛҮҮЛНЭ**." Дуулал 37:5
(Тодруулсан хэсгийг нэмж оруулсан болно)*

ИТГЭЛ бол

Таны амьдралд зөвхөн Бурхан хийж ЧАДАХ зүйлийг та хийж ЧАДАХГҮЙ гэдгээ ойлгож ухаарсанаар Бурхан чадна гэдэгт ИТГЭН НАЙДАХ юм.

Бурхан бидэнд Тэрээр эхлүүлсэн ажлаа дуусгана, дуусгаж чадна гэж Өөрийн үгээр ахин дахин хэлдэг.

Хэрэгжүүлэлт: Энэ тодорхойлолтын хэрэгжүүлэлт нь “Би өөрөө өөрийгөө айдсаас чөлөөлж чадахгүй боловч би итгэлээр алхсанаар Бурхан намайг чөлөөлж чадна (чөлөөлөх болно)” гэх юм.

Асуулт: Та өөрөө хийж чадахгүй гэж мэдэж авсан, харин Бурхан хийнэ гэж амласан 3 зүйл юу вэ?

Бясалгал: Иохан 15:56, Филиппой 1:6 ишлэлүүдийг бясалгаад Христитгэлт амьдралаар амьдрахад хийж чадахгүй боловч хүчээр хийх гэж оролдож байгаа зүйл чинь юу байж болох талаар бодоорой.

Бурхантай хамт алхах нь: Өөрийн тань хийж чадахгүй байгаа зүйлийг Бурхан хийнэ гэж итгэж эхлээрэй.

4. Итгэл бол Бурхантай ХАМТРАХ юм.

"Би Өөрийн санаагаар юуг ч үйлдэж чадахгүй. Би сонссоноороо шүүх бөгөөд Миний шүүлт шударга. Учир нь Би Өөрийнхөө хүслийг бус, харин Намайг Илгээгчийн хүслийг хайдаг."

Иохан 5:30

Итгэл гэдэг нь та Бурхантай хамтрах шийдвэр гаргалаа гэсэн утгатай. Энэ нь зөвхөн Бурхан хийж чадах зүйлийг та өөрөө хийх гэж хичээхээ больж, Бурханы ажлыг цаашид эсэргүүцэхээ болино гэсэн утгатай юм. Хамтын ажиллагаа нь итгэлийн хандлага бөгөөд ингэж хэлдэг: "Эзэн, Та миний дотор Өөрөө амьдарч Өөрийн хүслийн дагуу намайг өөрчлөхөд би өөрийгөө Танд итгэн даатгаж байна."

ИТГЭЛ бол

Бурхан Өөрийн хүслийн дагуу таны амьдралыг өөрчлөхийн тулд та Бурхантай

САЙН ДУРЫН ТҮНШЛЭЛ хийх юм


Хэрэгжүүлэлт: Та хангалтгүй, дутуу байдлын мэдрэмжтэй зөрчилдөж байна гэж төсөөлье. Энэ үед Эзэнтэй хамтрах нь ингэж харагдана: "Эзэн, Тантай хамтрах хүслийг өгч, хангалтгүй дутуу мэт байдлаас чөлөөлөх Таны ажлыг эсэргүүцэхгүй байхад тусалж өгөөрэй гэж гуйн залбирч байна"

Асуулт: Та амьдралынхаа аль талбарт Бурхантай хамтрахгүй эсвэл таны дотор хийж буй Түүний ажлыг эсэргүүцэж байна вэ?

Бясалгал: Иохан 5:30 ишлэлийг бясалгаад намайг чөлөөлж, ялалтыг өгч, хэрэгцээг минь хангана гэж амладаг байхад би амьдралын минь эдгээр талбаруудад хийж буй Бурханы ажлыг яагаад эсэргүүцэж байна вэ? гэж өөрөөсөө асуугаарай.

Бурхантай хамт алхах нь: Таны амьдрал дахь Түүний өөрчлөлтийн ажлыг эсэргүүцэхээ болих хүслийг өгөөч хэмээн Бурханаас гуйгаарай.

Дараах диаграммаар итгэлийн 4 тодорхойлтыг дүгнэн үзүүлэв.



Асуулт: Итгэлийн тодорхойлолтуудаас аль нь таны хувьд илүү амьдралд ойр байна вэ? Яагаад?

Бясалгал: Итгэлийн 4 тодорхойлолтыг бясалгаад итгэлээр алхах хүслийг болон илүү гүнзгий илчлэлтийг өгөхийг Бурханаас гуйн залбираарай.

ДӨРӨВ ДЭХ ӨДӨР

Итгэлтэй холбоотой 3 түлхүүр үнэн

Итгэлийн талаарх хичээлээ дуусгахаас өмнө итгэлийн талаарх 3 түлхүүр үнэнийг нэмж харцгаая.

1. Итгэлийг бий болгох нь таниас хамаарах уу?

Энэ бол бидний хариулах хэрэгтэй түлхүүр асуулт юм. Учир нь Олон Христитгэгчид Христитгэлт амьдралаар амьдрахын тулд итгэлийг бий болгох нь тэднээс өөрсдөөс нь хамаарна гэж итгэдэг. Дээрх асуултын хариулт болгож Иохан 19:30 ишлэлд загалмай дээр Есүсийн хэлсэн сүүлчийн 3 үгийг харцгаая.

"ГҮЙЦЭЛДЛЭЭ."



Христитгэгчийн хувьд Эзэний загалмай дээр хэлсэн сүүлчийн гурван үг танд болон надад мөнхийн ач холбогдолтой. Үүний нэг утга нь Христ бүгдийн төлөө бидний гэм нүглийг нэг удаа, нэг дор шийдсэн гэсэн утгатай. Гэвч бидний Христитгэлийн алхаанд хамааралтай өөр нэг утга байна. Таниас нэг асуултыг асууя. “Аль хэдийн хийгээд дууссан ажил дээр та юуг нэмэх вэ?” Юуг ч биш!

Өөрөөр хэлбэл, Бурхан Өөрийн гүйцээсэн ажил дээр ямар нэг юм нэмээд өгөөч гэж асуугаагүй. Бурханд таниар Өөрт нь зориулж ямар нэг зүйлийг амжилттай хийлгүүлэх хэрэгцээ байхгүй. Колоссай 2:6 дээр хэлсний дагуу таны хийх хэсэг бол энгийнээр ХҮЛЭЭН АВАХ юм:

"Тиймээс та нар Эзэн Христ Есүсийг хүлээн авсан шигээ Түүн дотор алхахдаа,..."

Энэ ишлэл итгэлд хэрхэн хэрэгждэг вэ? Нэгдүгээр хичээл дээр суралцаж байсан Колоссай 2:9,10 ишлэлийг харъя:

"Учир нь Түүн дотор Бурханы төгс дүүрэн нь бүхлээрээ биетээр оршдог. Түүн дотор та нар төгс болгогдсон. Тэр бол бүх удирдлага ба эрх мэдлийн тэргүүн нь мөн." Колоссай 2:9,10

Доор Колоссай 2:9,10 ишлэл дээр үндэслэсэн түлхүүр үнэн байна:

Хэрвээ танд Христ дотор бүрэн дүүрэн байдал өгөгдсөн юм бол энэ нь таны дотор Христ ИТГЭЛИЙН БҮРЭН ДҮҮРЭН байдал байна гэсэн утгатай.

Үүнийг Филиппой 4:19 ишлэлтэй холбож ойлговол:

"Миний Бурхан Өөрийн алдар дахь баялгаар Христ Есүс дотор та нарыг хэрэгтэй бүхнээр тань хангана." Филиппой 4:19

Бурхан бол таны итгэлийг хангах Эх сурвалж нь учраас итгэлийг бий болгох төрүүлэх нь танаас хамаарахгүй. Нэгэнт Христ таны дотор байж та Христийн дотор байгаа тул танд хэрэг болох бүх итгэлийг

та агуулж байгаа. Колоссой 2:6 ишлэлийн дагуу таны хийх хэсэг бол танд аль хэдийнээ бий болсон тэр итгэлийг ХҮЛЭЭН АВАХ нь юм.

САЙН МЭДЭЭ!

Та өөрөө итгэлийг бий болгоно гэж Бурхан ХҮЛЭЭДЭГГҮЙ.
Харин итгэлийн ХАНГАМЖИЙГ ХҮЛЭЭН АВАХЫГ таниас хүлээдэг.

Асуулт: Христитгэлт амьдралаар амьдрахад хэрэгцээтэй итгэлийг бий болгох нь таниас хамаарна гэж итгэсээр байв уу? Итгэлийг өөрийнхөө хүчин чармайлтаар бий болгохын оронд Христ дотор аль хэдийн таных болсон итгэлийг зүгээр л хүлээн авах нь хичнээн хялбар байхсан билээ?

2. Есүс итгэл “багатай” гэж ямар үтгээр хэлсэн бэ?



"Есүс тэдэнд

-Юунд айцгаана вэ, итгэл багатай хүмүүс ээ? гээд Тэр босож, салхи болоод нуурыг зэмлэжээ. Гэтэл нам гүм боллоо. "

Матай 8:26

Энэ ишлэл дээр Есүс - итгэл “багатай” гэж хэлсэн учир нь дагалдагчид итгэлээ бүрэн дүүрэн хэмжээнд нь **ашиглахгүй** байгааг илэрхийлэхийн тулд юм. Яагаад? Пентокостын өдрийг хүртэл Бурханы гурвалыг тэд дотроо бүрнээр нь хүлээн авах боломжгүй байсан тул яг тухайн мөчид дагалдагчдад Христэд буй итгэл бүхлээрээ бий болоогүй байсан юм.

Харин та бол эсрэгээрээ Христийн итгэлийг бүхлээр нь агуулж байгаа тул Христийн амьдралын бүрэн дүүрэн байдал таны дотор байна. Асуулт бол: “Та дотроо байгаа итгэлийн дүүрэн байдлаа улам илүүгээр ашиглах уу эсвэл Есүсийн дагалдагчид шиг итгэл багатай байдлаар амьдрах уу?”

Асуулт нь “Танд хир их итгэл байна вэ?” биш харин

“Христ дотор аль хэдийн таны өмч болсон итгэлийн дүүрэн байдлаа та АШИГЛАЖ байна уу?” гэдэгт байна.

Асуулт: Христ дотор танд хэрэгтэй бүх итгэл тантай хамт байгаа гэдгийг ойлголоо. Энэ нь итгэлийн талаарх таны үзэл бодлыг хэрхэн өөрчлөх вэ?

Бурхантай хамт алхах нь: Танд хэрэгтэй бүх итгэл тантай хамт байгаа бөгөөд аль хэдийн өмчилсөн итгэлийн бүрэн дүүрэн байдлаа ашиглах нь таны хийх ажил гэдгийг улам гүнзгий ойлгуулж өгөхийг Эзэнээс эрэн хайгаарай.

3. Таны амьдрал дахь Бурханы ажил таны итгэлийн нөхцөл байдлаас заавал хамаардаг зүйл БИШ

*"Харин бидний Бурхан тэнгэрт байдаг. **Тэр Өөрийн хүссэн бүхнээ үйлддэг.**" Дуулал 115:3*

Таны амьдрал дахь Бурханы ажил та итгэлээ хэрхэн ашиглаж байгаагаас заавал хамаардаг зүйл **биш**. Бурхан бол хэмжээлшгүй эрхт бөгөөд та итгэлээр алхаж байгаа эсэхээс огт хамаарахгүйгээр таны

амьдралд хүссэн зүйлээ Тэр хийж чадна. Хэдийгээр бид итгэлээр алхаагүй байсан ч Бурхан бидний амьдралд хийх ажлаас зайлсхийдэггүй. (Би үүнийг “нигүүлсэл” гэж нэрлэдэг) Гэсэн хэдий ч өөрийнхөө итгэлээр Бурхантай хамт идэвх санаачлагатайгаар алхсан сүүлийн хэдэн жилийн туршлагыг өмнөх Христитгэлийн 30 жилийн туршлагатайгаа харьцуулбал Бурхан миний амьдралд өөрчлөлтийн үйл явцыг хурдасгасаад байна. Үүнээс санах хэрэгтэй түлхүүр үнэн бол:

Итгэлээр алхах нь Бурхан таны амьдралд хийх өөрчлөлтийн үйл явцыг ХУРДАСГАДАГ.

Итгэл заавал зорилготой байх ёстой



Итгэл олон зорилготой байж болно. Машин бариад явах үедээ та машиныхаа тормосонд итгэдэг, өдөр бүр ажлаа хийдэг оффисын барилгынхаа чанарт итгэдэг эсвэл суудаг сандалдаа итгэдэг. Энэ бол миний яриад байгаа түлхүүр итгэл биш.

Түлхүүр нь таны итгэлийн зорилго юун дээр байна вэ гэдгийг бодох юм. Христитгэгчийн хувьд бидний итгэлийн зорилго нь Есүс байх хэрэгтэй. Бид үүнийг дараах ишлэлүүдээс хардаг:

"Итгэлийг Эхлүүлэгч бөгөөд бүрэн дүүрэн Төгсгөгч болох Есүс уруу хараагаа чиглүүлье."

Еврей 12:2

"Түүний нэрд итгэсэн итгэлийн үндсэн дээр, та нарын харж байгаа энэ хүнийг Есүсийн нэр тэнхээтэй болгосон юм." *Үйлс 3:16*

Бидэнд итгэлийн өөр нэг бай байдаг нь асуудал болдог.

Христитгэлт амьдралаар та тодорхой хугацаанд амьдарч байгаа бол итгэлийн зорилго нь Есүс Христ байх ёстой гэдгийг мэднэ. Олон Христитгэгчдэд үйлчилсний үр дүнд 10, 20, 30 жилээс дээш хугацаагаар Христитгэгч байсан хүмүүс\ тэдний итгэлд өөр төв байдгийг туршлагаараа гэрчилж байна. Тэдний төв бол тэдний өөрсдийнх нь **оюуны потенциал, чадвар, сэтгэлийн тэнхээ** юм. Дараах мэдэгдлийг тунгааж үзээрэй:

Христитгэлт амьдралаар амьдрахын тулд Бурханы тусламжтайгаар өөрөө болгоно гэж итгэдэг бол таны итгэлийн **ЖИНХЭНЭ** төв таны оюуны потенциал, чадвар, сэтгэлийн тэнхээ байх боломжтой юу?



Танд нэгэн жишээг харуулья. Христитгэлт амьдралаар амьдрахын тулд Бурханы тусламжтайгаар өөрөө болгоно гэж та итгэдэг бол Бурханы ялалт, эрх чөлөө, өөрчлөлтийн амлалтыг өөрийнхөө амьдралд бодитоор эдлэхийн тулд өөрийн чадвар, сэтгэлийн тэнхээгээр хичээж зүтгэж олохыг оролдох болно.

Нэг үгээр хэлбэл, эдгээр амлалтуудыг та өөрийнхөө амьдралд бодит болгохын тулд өөртөө итгэж, та өөрийнхөө эх сурвалж болоход Бурханаас туслахыг гуйсан болж байна. Гэвч бидний мэддэг зүйлс үнэн мөн үү? Нэгдүгээр хичээлийн 1 Коринт 1:30 ишлэл дээр бидний дотор амьдардаг амийн Эх сурвалж нь Бурхан ба Тэрээр бидэнд өөрсдийнхөө Эх сурвалж нь болоход тусладаггүй гэж сурсан. Одоо харин би таниас доорх асуултыг илүү хувьчлан асуумаар байна:

*Христитгэлт амьдралаар амьдрахын тулд ӨӨРИЙН хүч чадал, сэтгэлийн тэнхээгээр
ХИЧЭЭЖ байгаа бол та жинхэнэ өөрчлөлтийг мэдэрч байна уу?*

Олон Христитгэгчид яг над шиг Бурханы үнэнийг амьдралдаа “хэрэгжүүлэх” ёстой гэж заалгасан байдаг. Энэ нь нилээн сүнслэг сонсогдож байвч Бурханы үнэнийг аваад амьдралаа өөрийн оюуны потенциал, чадвар, хувийн сахилга бат, сэтгэлийн тэнхээг ашиглан бодит болгохыг хичээх гэсэн оролдлого болж харагддаг. Үүнд асуудал нь амжилттай хэрэгжүүлэх эсэх нь надаас хамаардаг юм бол би яагаад ч амжилттай хэрэгжүүлж чадахгүй тул бүтэлгүйтэх болно.

*Бид Бурханаас БҮРЭН хамааралтай бөгөөд Тэр л Өөрийн үнэний дагуу бидний амьдралд
хэрэгжүүлж өгдөг юм.*

Дараах асуултууд танд итгэлийн алхаа тань хир явж буйг тодорхойлоход тус болж магад.

Таны итгэлийн амьдрал доорх зүйлсийг бүтээж байна уу?

- Гэм нүглийн зуршил болон Сатаныг байнга ялан дийлж байна уу?
- Гэмтэй зан чанараас байнга чөлөөлөгдөж байна уу?
- Одоо болон өнгөрсөн шархны тогтмол эдгэрэл байна уу?
- Христтэй адил болж тогтвортой өөрчлөгдөж байна уу?

Та эдгээр асуулт тус бүрт “тийм” гэж хариулж чадахгүй байвал та итгэлээ Бурханы чадварт тавихын оронд өөрийн чадварт тавьж байх боломжтой юу? Таныг ичгүүртэй, өөрийгөө буруутгасан байдалд оруулахын тулд энэ асуултыг асуугаагүй юм шүү. Энэ асуултуудыг асуусан шалтгаан нь бид Христ дотор итгэлээр алхах үед бид Бурханы бүтээж өгөх байнгын ялалт, эрх чөлөө, эдгэрэл, өөрчлөлтийг амсах болно. Та итгэлээ өөрийн чадвар дээр эсвэл Бурханд тавихад гардаг ялгаатай үр дүнг дараах диаграмаар харуулав.

**Бурханы хэсэг тусламжийг
авч өөрийн эх сурвалжид
итгэн амьдрах амьдрал
= амьгүй, хүчгүй, өөрчлөлтгүй**

**Бурханыг эх
сурвалжаа болгох
амьдрал=
Ялалт, эрх чөлөө,
өөрчлөлт**

СОНГОЛТ

Алхам Алхмаар!

Та ямар сонголт хийх вэ?

Та итгэлээ өөр дээрээ тавьсанаар гарах үр дүн бол таны амьдралд Бурханы хүч чадал ба жинхэнэ өөрчлөлт хэзээ ч бий болохгүй бөгөөд та Христийн амиар амьдрахыг амьдралдаа мэдрэх боломжгүй юм. Харин Бурханыг Эх сурвалжаа болгон итгэлээр амьдрахын үр дүн нь Христийн амь ба хүч чадлаар ирэх хувирашгүй өөрчлөлтийн туршлага юм.

Бурхантай хамт алхах нь: Ариун Сүнснээс та өөрийнхөө итгэлийн төв нь өөрийн чадвар, сэтгэлийн тэнхээн дээр байна уу эсвэл Бурханы чадвар дээр төвлөрч байна уу гэдгийг илчилж өгөхийг гуйгаарай.

Асуулт: Дээрх диаграм дээрх та итгэлийнхээ төв нь өөрөө болсноор гарах үр дүнгээр дамжуулан юут илчилж байна вэ?

Бурхантай хамт алхах нь: Бурханы чадварын эсрэг та өөрийн чадвар дээр итгэлээ тавьж байгааг илрүүлбэл Бурханыг Эх Сурвалжаа болгон хамааралтай алхах хүслийг өгөөч хэмээн гуйгаарай.

ТАВ ДАХЬ ӨДӨР

Бурханд итгэлтэй байхад бид яагаад зөрчилддөг вэ?

"Тэгтэл тэд Түүнээс

-Бид Бурханы ажлуудыг хийхийн тулд юу хийх вэ? гэсэнд Есүс тэдэнд

-Та нар Бурханы илгээсэн Нэгэнд ИТГЭХ нь Түүний ажил мөн гэж хариулав" Иохан 6:28-29

Цааш үргэлжлүүлэхийн өмнө, Бурханд итгэлтэй байхад Христитгэгчдийг зөрчилдүүлдэг 3 шалтгааныг энэ олон жилүүдээс нээн илрүүлснээ хэлэх нь чухал гэж бодлоо

1. Бид “СУРААД дараа нь ХИЙ” гэдэг сэтгэлгээг Христитгэлт амьдралдаа авч ирдэг



Сураад дараа нь хий гэдэг энэ сэтгэлгээ итгэлийн асуудал дээр зөрчил авч ирдэг №1 шалтгаан гэж би итгэдэг. Яагаад? Бид угаасаа л ингэж амьдардаг тул өөрсдийн чадвар дотроо итгэлтэй алхах нь амархан байдаг. Та өөрийнхөө амьдралын тухай бодоод үзээрэй. Өнөөг хүртэл та хэрхэн амьдарч ирэв? Бидний ихэнх нь амьдралын тухай суралцаад сурсанаа амьдралдаа хэрэгжүүлэх гэдэг.

Жишээлбэл, ажлаа яаж хийхийг сураад тэгээд ажлаа хийдэг. Та гольф тоглох, загас барих, ан хийхийг сураад тэгээд хэрэгжүүлдэг. Та хүүхдээ өсгөхийг сураад сурсан зүйлээ хүүхдээ өсгөхөд ашигладаг. Хамгийн гол нь та өөрийн оюун ухаан, чадвараа ашиглан сурсан зүйлээ хийдэг. Бид бүгдээрээ нэг иймэрхүү л амьдарсаар ирсэн. Асуулт нь - Христитгэлт амьдралд “сураад дараа нь хий” гэдэг энэ сэтгэлгээ хэрэгждэг үү?

Христитгэлт амьдралын тухай Бурханы үнэнийг СУРАЛЦААД дараа нь (Бурханы тусламжтай) өөрийн чадвараар Бурханы хэлсэнийг ХИЙНЭ гэж итгэдэг үү?

Үнэн: АМЬТАЙ Христитгэлт амьдралаар амьдрахад “сураад дараа нь хий” гэдэг энэ сэтгэлгээ хэрэгждэггүй. Яагаад? Зөвхөн Ариун Сүнс бидний амьдралд хийхээр амладаг, Ариун Сүнсний хийж чаддаг зүйлийг бид өөрсдийн чадлаар хийж чадахгүй. Филиппой 1:6 ишлэлийг санаж байна уу? Эхний

хичээл дээр суралцсанаар зөвхөн Бурхан ба Түүний хүч чадал бидний сүнслэг өөрчлөлтийг бий болгоно. “Сураад дараа нь хий” гэдэг Христитгэлт амьдралаар амьдрах гэж хичээсэн ч эцэст нь би хөөрхийлөлтэйгээр бүтэлгүйтэж дууссан хэмээн хувийнхаа түүхээс танд хуваалцаж байсан билээ. Асуудал нь энэ арга замаар Бурханы амласан амьд өөрчлөлт хэзээ ч бий болоогүйд байсан юм. Эзэнд бүрэн дүүрэн хамааралтай байдлаар л дамжуулан жинхэнэ өөрчлөлт бий болсон билээ.

2. Сүнслэг өөрчлөлтийн УЧИР ШАЛТГААН ба ҮР ДҮН-гийн нэг хэсэг нь бид өөрсдөө байхыг хүсдэг

Итгэлтэй холбоотой бас нэг асуудал бол сүнслэг өөрчлөлтийн учир шалтгаан ба үр дүнгээ бид өөрсдийн оюун ухаан, чадвар, авьяас билэгтэй хамтатгах боломжгүйд байдаг. Бид өөрсдийн оюун ухаан, чадвар, авьяас билгийг ажил, гэрлэлт, хүүхдээ өсгөх зэрэгт хэрэглэдэгт асуудал нь байгаа юм. Зөвхөн Бурхан бий болгож чадах зүйлийг бид өөрсдөө бүтээж чадахгүй ч бидний төрөлх чанар өөрөө өөрсдийгөө өөрчлөх буюу өөрийн хүчин чармайлтаар Бурханы тусламжтай өөрчлөгдөх гэж хүсч, хичээдэг.

Үнэн: Бид итгэлийн алхаандаа өөрсдөө хийж чадахгүй зүйлсээ бидний дотор Өөрийн хүч чадал, ухамсар, чадвараар хийж өгч чадах Бурханаас хамаарч байна. Иохан 15:56 ишлэлийг санаж байна уу? Бид өөрсдийн чадварыг хойш тавьж Бурханы чадвараас зурах үед ирдэг зөрчлийг дүрсэлдэг. Таны Эх сурвалж болох Бурхан дангаараа таны бодол, мэдрэмж, сонголт, үйлдэлд чухал өөрчлөлтийг авч ирж чадна хэмээн ямар нэгэн хэмжээгээр ятгагдаж байгаа гэж найдаж байна.

Санамж: Энэ нь бид өөрсдийн ухамсар, чадвараа ашиглахгүй гэсэн утгатай биш. Гэвч эдгээр зүйлүүд таны сүнслэг өөрчлөлтөнд ямар ч сайн зүйл өгөхгүй.

3. ХУУЛИЙН ЯГШ БАРИМТЛАЛ нь “Сураад дараа нь хий” гэдэг Христитгэлийг хөхүүлэн дэмждэг

Хэрэв та хууль дүрмийг ягштал баримталдаг сүмд над шиг удаан явсан бол “сураад дараа нь хий” гэсэн Христитгэлт амьдралаар амьдарсан байх магадлалтай. “Хуулийн ягш баримтлал” гэж би юуг илэрхийлнэ вэ? Сүнслэг өөрчлөлтийг бий болгохын тулд өөрийн чадварыг тодорхой дүрэм баримтлахад ашиглан Христитгэлийн амьдралаар амьдрахаар хичээн зүтгэх нь хуулийн ягш баримтлал юм. Хуулийн ягш баримтлал нь сайн Христитгэгч байхын тулд эсвэл Бурханд таалагдахын тулд өөрийн эх сурвалжаар тодорхой стандарт, дүрэм журмыг даган биелүүлэхийг хичээх болно гэсэн буруу итгэл үнэмшилийг сурталчилдаг. Миний хувьд хуулийн ягш баримитлал нь Бурханд таалагдах гэж, өөрөө өөрийгөө чөлөөлөх гэж өөрийнхөө хүч чадалд найдан чармайх байдлыг бий болгосон. Танд энэ танил санагдаж байна уу?

Үнэн: Ямар нэгэн тогтоосон стандарт, хэв журмын хэм хэмжээнд хүрч амьдрах гэж хичээх нь хэзээ ч бодит өөрчлөлтийг бий болгохгүй. Улам шаргуу хичээх эсвэл Бурханы төлөө илүү ихийг хийж өгөх гэж оролдох нь таны хүссэн тэр өөрчлөлтийг авчрахгүй. Энэ нь зөвхөн Христитгэлт амьдралаар амьдрахын тулд улам шаргуу хичээх эсвэл Христитгэлээ орхин бууж өгөх гэсэн үр дүнтэй байх болно. Жинхэнэ эрх чөлөө нь амлагдсан өөрчлөлтийг бий болгох Бурханы хүч чадал, чадварт өөрийн итгэлээ тавих үед ирдэг.

Энэ нь би юу ч хийлгүй ИДЭВХИГҮЙ амьдарна гэсэн үтгатай юу?

"Та нарын итгэл хүмүүсийн мэргэн ухаан дотор бус, харин Бурханы хүч дотор байхын тулд юм. "
1 Коринт 2:5



Тэдний дотор Христ амьдрахын тулд Христ дотор итгэлээр амьдрах тухай ойлгохыг хичээж буй нөхдөөсөө би эдгээр тайлбарыг их сонсдог: "Итгэлээрээ амьдарна гэдэг нь би юу ч хийх ёсгүй гэсэн үг үү?" эсвэл тэд ингэж хэлдэг: "Итгэлийн алхаа маш идэвхигүй байх юм шиг санагдаж байна" эсвэл "Миний үүрэг юу вэ?". Үнэн бол итгэлийн алхаа нь идэвхигүй байдлаас огт өөр зүйл юм.

ТҮЛХҮҮР ҮНЭН бол

Христитгэлт амьдрал бол маш ИДЭВХИТЭЙ боловч тэрхүү ИДЭВХИТЭЙ БАЙДЛЫН (сүнслэг өөрчлөлт) ЭХ СУРВАЛЖ нь БУРХАН юм.

Дээрх үнэнийг ойлгохын тулд Есүсийн амьдрал болон үйлчлэлийг харцгаая. Та Есүсийг идэвхигүй байсан гэж хэлэх үү? Бидний хэн нь ч тэгж хэлэхгүй гэж итгэж байна. Гэвч, Есүсийн хэрхэн амьдарсан талаар бид нар юуг сурсан бэ? Тэр Эцэгээсээ бүрэн ХАМААРАЛТАЙ байсан. Тэрээр хамааралтай алхах үед юу тохиолдсон бэ? Эцэг Есүсээр ДАМЖУУЛАН амьдралыг өөрчлөх Өөрийн Амь ба Хүчийг урсгасан.

Таны дотор Тэр өөрийн амьдралыг амьдрахын тулд алхам тутам Христэд ХАМААРАЛТАЙ байх нь таны үүрэг хариуцлага юм.

Та ингэснээр Бурхан таны бодол, мэдрэмж, сонголт, үйлдлийг бодитойгоор өөрчлөх өөрийн амь ба хүч чадлыг танд асгана.

Бясалгал: Бурханд та идэвхитэйгээр хамааралтай байж, Тэр бол таны дотор бий болж буй ИДЭВХИТЭЙ БАЙДЛЫН (сүнслэг өөрчлөлт) Эх сурвалж юм гэдгийг бясалгаарай.

Бурхантай хамт алхах нь: Эдгээр идэвхигүй байдал, үүрэг хариуцлага, идэвхитэй байдлын талаарх илчлэлтийг өгөхийг Бурханаас гуйн залбираарай.

Хоёрдугаар хичээлийн дүгнэлт

Бурханы өөрчлөлтийн үйл явцад та юуг хийх хэрэгтэй талаарх ойлголтыг энэ хичээл сайн өгсөн гэж найдаж байна. Энэ удаагийн хичээлээс тогтоож авсан гэж найдаж байгаа түлхүүр ойлголтууд бол:

- Христитгэлт амьдралаар амьдрахад таны хийх ажил бол Эх сурвалж болсон Бурханаас хамаарах юм.
- Хамаарал бол ИТГЭЛ гэдэг үгийн өөр нэг утга юм.
- Итгэлийг бий болгох нь таниас хамаарахгүй. Таны ажил бол Христ дотор танд байдаг итгэлийг ХҮЛЭЭН АВАХ юм.
- Таны итгэлийн ЗОРИЛГО нэг бол та ӨӨРИЙНХӨӨ эх сурвалж нь байх эсвэл БУРХАН таны эх сурвалж байхын аль нэг л байдаг.
- “Сураад дараа нь хий” гэсэн сэтгэлгээ, өөрийн авьяас билэг, чадвараа ашиглаж чадахгүй байдал, хуулийг ягш баримтласнаас үүдэлтэй туршлагуудаас болоод бид итгэлийн үнэн мөн чанартай зөрчилддөг.

- Христитгэлт амьдрал бол идэвхигүй байдал биш. Бурхан бол таны амьдралын талбар бүрийг өөрчлөх идэвхитэй байдлын Эх сурвалж юм.
- Христ дотор итгэлээр амьдарсаны үр дүнд бидний бодол санаа, итгэл үнэмшил, зан чанар, сонголт өөрчлөгддөг.

27 – р хуудсан дээр байгаа “АМЬГҮЙ ” болон “АМЬТАЙ ” Христитгэлт амьдралын ялгааг харуулсан диаграмыг дахин хараарай.

ГУРАВДУГААР ХИЧЭЭЛ

Итгэлийн алхааны тухай түлхүүр үнэн Таны Амь болох Христийг ойлгох нь

НЭГ ДЭХ ӨДӨР

Гуравдугаар хичээлийн агуулга

- Та итгэлийн алхам хийх үед таны дотор юу болдог вэ?
- Бурханы хүч чадлаар амьдрахад гарах үр дүн
- Бурханы ер бусын ажлын утга учир
- Итгэл ба мэдрэмж, туршлагыг ялгаж ойлгох нь
- Христэд –бат итгэхийн утга учир
- Бидний амь болох Христийг өдөр тутмын амьдралдаа хэрхэн тавихыг ойлгох нь

Оршил

Өмнөх хичээл танд Бурхантай хамааралтай байх болон Бурханд итгэлээ тавьж сурах талаар тодорхой ойлголт өгсөн гэж найдаж байна. Бурханы гүйцэтгэх өөрчлөлтийн үйл явцад бидний хийх ажил юу болохыг ойлгосон учраас одоо бид итгэлийн алхам хийх үед бидний амьдралд юу тохиолддог болохыг харъя. Энэхүү хичээлийн төгсгөлд өдөр тутмын амьдралдаа бидний амь болох Христээс эхтэй амьдрах нь ямар болохыг харахын тулд суралцсан зүйлээ хэрэгжүүлж эхлэх болно.

Итгэлийн аялал итгэлийн АЛХМААС эхэлдэг

"Хүн оюун ухаандаа өөрийн замыг төлөвлөдөг бол ЭЗЭН түүний алхаа гишгээг чиглүүлдэг." Сургаалт
үгс 16:9

Та гэр бүлээрээ Индонез рүү нүүлээ гэж төсөөлье. Та амьдарч байсан, өөрт танил соёлоос 180 градусаар тэс өөр соёл руу нүүж очиж байна гэсэн үг. Одоо та энэхүү шинэ соёлд хэрхэн амьдрахыг суралцаж эхлэх хэрэгтэй болно. Үүнтэй адил, Бурхан таныг өөрийн чадвараар амьдарч байсан “хувийн” соёлоос тань холдуулж Түүний хязгааргүй чадлаар амьдрах шинэ “сүнслэг” соёл руу таныг хөтлөн авчирч байна. Энэ бас маш хүнд шилжилт юм. Гэвч бид итгэлийн алхам хийвэл Түүний амладаг өөрчлөлт ба бялхам амьдралыг бидэнд бодит болгож өгнө гэж Бурхан амладаг. Тиймээс итгэлийн алхмыг тодорхойлохоос хичээлээ эхэлье:

ИТГЭЛИЙН АЛХАМ

**Энэ нь итгэлээр Бурханы АМЬ, ХҮЧ ЧАДАЛ, Бурхантай өөртэй нь ХОЛБОГДОХ
тэр МӨЧ юм.**



Та Христитгэгч болоод тодорхой хугацаа болсон бол Христитгэлийн алхаа нь итгэлийн алхаа гэж мэддэг болсон гэсэн үг. Гэвч, бидний итгэлийн алхааны талаарх хоёр түлхүүр ойлголтыг би цохон тэмдэглэмээр байна. Нэгдүгээрт, итгэлийн алхам хийхэд юу тохиолддог талаар хамтдаа харахыг хүсч байна. Хоёрдугаарт бидний итгэлийн төвийг хармаар байна.

Итгэлийн алхам хийх мөчид танд юу тохиолддог вэ?

Нэгдүгээр хичээл дээр сурсан Колоссай 2:9,10 ишлэлийн дагуу яг энэ мөчид таны дотор Бурханы амь ба хүч чадал БҮХЛЭЭРЭЭ байдаг гэдэг үнэнийг санаарай.

"Учир нь Түүн дотор Бурханы төгс дүүрэн нь бүхлээрээ биетээр оршдог. Түүн дотор та нар төгс болгогдсон. Тэр бол бүх удирдлага ба эрх мэдлийн тэргүүн нь мөн." Колоссай 2:9, 10

Бурханы амь ба хүч чадал бүхлээрээ нэгэнт таны дотор байдаг тул та итгэлийн алхам хийх үед танд юу тохиолддог вэ?

Та итгэлийн алхам хийх үед таны бодол санаа, итгэл үнэмшил, зан чанарыг өөрчлөхийн тулд таны доторх Бурханы амь ба хүч чадал БҮХЛЭЭРЭЭ НЭЭГДЭЖ ЭХЭЛДЭГ.

Энэ хичээлийн төгсгөлд Бурханы амь бидний дотор чөлөөлөгдөж байгаа талаар дэлгэрэнгүй ярих болно. Харин одоо Бидний дотор Бурханы хүч чадал чөлөөлөгдөхөд юу болдгийг нягтлан харъя. Паул Бурханы хүч чадлыг итгэлтэй хэрхэн холбож буйг харъя.

"Та нарын итгэл хүмүүсийн мэргэн ухаан дотор бус, харин Бурханы хүч дотор байхын тулд юм." 1 Коринт 2:5

"Тиймээс бидний Бурхан та нарыг дуудлагад чинь зохистой гэж тооцон, сайны төлөөх хүсэл бүхнийг ба итгэлийн үйлийг хүчээрээ биелүүлэг хэмээн бид та нарын төлөө үргэлж залбирдаг." 2 Тесалоник 1:11

Та итгэлийн алхам хийхэд Бурхан өөрийн амь ба хүч чадлын талыг л өгдөггүй. Харин таны амьдралын талбар тус бүрийг өөрчлөх Бурханы хүч чадлын бүрэн төгөлдөр байдлыг таны дотор бий болгодог.

Бурханы хүч чадал нь ямар хүч чадал вэ?

"Хүчний давамгайлал нь биднээс биш, харин Бурханых байхын тулд бид энэхүү баялгийг шавар савнуудад тээдэг." 2 Коринт 4:7

Танд болон надад байдаг баялаг бол Бурханы хүч чадлын давамгайлал юм. Энэ нь ямар хүч чадал вэ? Эфес 1:19, 20 ишлэлийг харъя:

"Мөн итгэдэг бидэнд хандсан Түүний хүч чадлын хэмжээлиггүй сүр жавхланг мэдэх болтугай. Энэ хүч нь Түүний чадлын хүчний нөлөө билээ. Тэрээр Христ дотор энэ л хүчээр нөлөөлж, Түүнийг үхэгсдээс амилуулаад тэнгэрт Өөрийн баруун гарт залж,...." Эфес 1:19, 20

Үүнийг тунгаан бод!

Есүсийг үхэгсдээс амилуулсан ЯГ ТЭР хүч чадал ТАНЫ ДОТОР оршин байдаг.

Нэмж хэлэхэд, таны дотор дор дурьдсан Бурханы хүч чадал яг тэр хэвээрээ оршдог:

- Диваажин ба дэлхийг бүтээсэн

- Улаан тэнгисийг хуваасан
- Ертөнцийг тогтоон барьж байгаа

Бурханы хүч чадлаас эхтэй амьдрах нь туйлын чухал юм. Учир нь үүнгүйгээр Бурханы өөрчлөлтийн амлалтыг бид хэзээ ч амсахгүй. Өмнө нь та өөрийн хүч чадал, сэтгэлийн тэнхээгээр гэм нүглийн зуршлаа ялах юм уу эсвэл гэм нүгэл үйлдэхгүй байх гэж хичээж байсан байх. Хэрэв тийм бол энэ нь таны хувьд хир бүтэмжтэй байсан бэ? Үнэн гэвэл жинхэнэ өөрчлөлтийг амсахын тулд Бурханы хүч чадлын оршихуйгаас эхтэй амьдрах хэрэгтэй.

***Таны дотор буй Бурханы хүч чадлаар амьдрах нь таны бодол, итгэл, сонголт, үйлдлийг
ҮНДСЭЭР нь өөрчилнө.***

Асуулт: Энэ хүртэл ярьсан таны дотор оршин буй Бурханы хүч чадлын агуу байдлыг та ойлгож авав уу?

Бясалгал: 2 Коринт 4:7, Эфес 1:19, 20 ишлэлүүдийг бясалгаад таны дотор буй Бурханы хүч чадлын цар хүрээг тунгаан бодоорой.

Бурхантай хамт алхах нь: Бурхан таны дотор байршуулсан тэнгэрлэг хүч чадлаа таныг чөлөөлөхийн тулд ашиглахыг хүсч буйд бат үнэмшүүлэхийг Бурханаас гуйгаарай.

Бурханы хүч чадал таны дотор чөлөөлөгдөхөд тэр хүч чадал юуг хийх чадалтай вэ?

Бурханы хүч чадал бидний дотор юуг гүйцэлдүүлж чадах вэ? Паул үүнийг Эфес 3:20 ишлэл дээр тодорхой хэлдэг:

"Эдүгээ, бидний дотор ажилладаг хүчний дагуу гуйж, бодох бүхнээс минь илүү хэмжээлшгүй бялхлаар үйлдэх чадвартай Түүнд...." Эфес 3:20

Энэ ишлэлийг хэсэг хугацаанд бодоод үзээрэй. "Бидний бодох бүхнээс минь илүү хэмжээлшгүй бялхлаар" Бурханы хүч чадал үйлдэх чадвартай хэмээн Паул маш зоригтой тунхаглажээ. Паулын дотор тэрхүү хүч чадал маш хүчирхэгээр ажиллаж өөрийнх нь хувьд хэзээ ч хэрэгжих боломжгүй мэт тэр өөрчлөлтийн цэгт Паулыг авч ирсэн тул Паул энэхүү үнэнийг чангаар тунхаглаж байна. Хэрвээ Бурханы хүч чадал Паулын амьдралд энэ бүхнийг хийж чадсан юм бол Бурханы хүч чадал таны амьдралд юуг хийж чадна гэж та бодож байна вэ?

Таны ДОТОР буй Бурханы хүч чадал:

- Түүний үнэнд итгүүлэхийн тулд оюун санааг тань ШИНЭЧИЛДЭГ. Ром 12:2
- Таныг гэм нүглийн хүлээсээс ЧӨЛӨӨЛДӨГ. Иохан 8:32
- Таны шархыг ЭДГЭЭДЭГ. Дуулал 147:3
- Махан бие, гэм нүгэл, Сатан, дэлхийг ялан дийлэх ЯЛАЛТЫГ өгдөг. 1 Коринт 15:57
- Таны бодол, мэдрэмж, сонголт, үйлдлийг ӨӨРЧИЛДӨГ. 2 Коринт 3:18
- Өөртэйгөө дотно харилцаатай байлгах газарт таныг АВЧИРНА. Эфес 1:5

Асуулт: Бурханы хүч чадал таны бодол, итгэл, сонголт, үйлдлийг өөрчилсөн гэдгийг хамгийн сүүлд та хэзээ мэдэрсэн бэ? Эдгээр 4 талбарт амсахыг хүсч буй 3 өөрчлөлтөө бичнэ үү.

Бясалгал: Эфес 3:20 ишлэлийг бясалгаад Паултай хамт “бид бодож, асууж чадах бүхнээс ч илүү хэмжээлшгүй бялхам зүйлийг Тэр хийх чадалтай” гэж хэлж чадахын тулд таны амьдралд хийх хэрэгтэй Бурханы өөрчлөлтийн талаар бодож үзнэ үү.

Бурхантай хамт алхах нь: Та амьдралдаа амсаж үзэхийг хүсч буй өөрчлөлтийг Бурханаас гуйгаарай.

Бурханы хүч чадлыг мэдэрч чадахуйц хангалттай итгэлийн алхам хийгээгүйгээс Бурханы хүч чадлын ЦАР ХҮРЭЭГ ИХЭНХ Христитгэгчид үнэн утгаар нь ойлгодоггүй гэдгийг үйлчэлийн энэ он жилүүдэд ойлголоо

"Бурханд "Таны үйлс хичнээн сүрлэг вэ! Таны хүч агуу учраас дайснууд тань Таны өмнө зусардан бялдуучилна." Дуулал 66:3

ХОЁР ДАХЬ ӨДӨР

Та итгэлийн алхам хийх сонголт хийхгүй бол таны дотор буй Бурханы хүч чадал ЯМАР Ч түсгүй гэдгийг санаарай.

Би саяхан шинэ зөөврийн компьютер худалдаж авсан юм. 2 жилийн өмнө худалдан авч байсан хуучин зөөврийн компьютертэй минь харьцуулахад санах ой, хүчин чадал нь харьцангуй өндөр байв. Бусад компьютеруудын л адил интернэт дээрх бүх мэдээлэл рүү нэвтрэх боломжтой байв. Гэвч, би компьютераа асаахгүй л бол бүх хүчин чадал, нэвтрэх боломж нь ямар ч ашиг хэрэглээ байхгүй билээ. Асаах хүртэл энэ компьютер зүгээр л жин дарсан цаас мэт л байна.

Бурханы хүч чадал яг л ийм. Яг одоо та Бурханы бүх хүч чадлыг дотроо агуулж байгаа. Гэвч, Бурханы хүч чадлыг нээж өгөхгүй юм бол танд энэ хүч чадал ямар ч тус нэмэргүй билээ.

Бурханы хүч чадалд ХОЛБОГДОХ арга зам бол ИТГЭЛИЙН АЛХАМ юм.



Танд үүнийг тайлбарлахын тулд дүрсэлж үзүүлье. Таглаатай, дүүрэн цэвэр устай пластик сав байна гэж төсөөлье. Саванд байгаа дүүрэн ус Бурханы гурвал ба Бурханы ХҮЧ ЧАДАЛ тантай хамт байгааг илэрхийлнэ. Авралын үед ус савтайгаа бүхлээрээ таны дотор оржээ гэж төсөөлье (Учир нь авралд ирэх үед та Бурханы амь ба хүч чадлыг өөртөө хүлээн авсан).

Гэвч савны тагийг онгойлгохгүйгээр Бурханы хүч чадлаас зуурч, уух боломжгүй. Та итгэлийн алхам хийснээр Бурхан савны тагийг мулталж таны бодол, итгэл үнэмшил, зан чанарыг өөрчлөх Өөрийн хүч чадлаа цутгадаг.

Намайг шаналгадаг зүйл бол маш олон Христитгэгчид миний туулсан 30 жилийн амьдралтай адилаар амьдарч байна. Тэд өөрсдийг нь өөрчлөх Бурханы хүч чадлыг тээж байгаа боловч Бурханы хүч чадлын цар хүрээг ойлгодоггүй эсвэл Түүний тэр хүч руу хэрхэн нэвтрэхээ мэддэггүй. Үр дүнд нь тэдний амьдрал өөрчлөгдөхгүй хэвээр үлддэг. Тэд ялалтын дунд ялагдал дотор амьдарч байна. Тэднийг чөлөөлөх, эдгээх, өөрчлөх хүч чадал нь өөрсдөд нь ямар ч ашиг хэрэглээгүй байсаар байна. Тэд Бурханы хүч чадлын оронд өөрсдийн ухамсар, чадвар, сэтгэлийн тэнхээгээр Христитгэгч биш хүн шиг амьдардаг.

***Итгэлээр Бурханы хүч чадалд нэвтрэхгүй бол таны амьдралд ямар ч АЧ ХОЛБОГДОЛ
бүхий өөрчлөлт бий БОЛОХГҮЙ.***

Бурханы хүч чадал таны дотор ЕР БУСЫН ажлыг гүйцэтгэх болно.

Бидний амьдрал дахь Бурханы ажилтай холбогдуулан ойлгох хэрэгтэй чухал үг бол "ер бусын" гэдэг үг юм. "Ер бусын" гэдэг үгийг ойлгох хэрэгтэй нэн чухал шалтгаан бол Бурхан таны амьдралд үйлддэг ажил бүр "ер бусын" учраас юм. Тиймээс цааш үргэлжлүүлэхийн өмнө "ер бусын" ажил гэдгийг тодорхойлъё :

"ЕР БУСЫН" АЖИЛ

***Энэ бол бид итгэлээр алхах явцад Бурхан биднээр дамжуулан бидний дотор хийдэг энгийн
хүний санаагаар тайлбарлаж БОЛОМГҮЙ ажил юм.***



Иошуа 6:3-5 ишлэл дээр Иерихогийн ханыг нураасан "ер бусын" ажлын тухай түүхийг харуулья.

"Та нар буюу бүх цэрэг эрс хотыг нэг удаа тойрон алх. Үүнийг зургаан хоног хий. Мөн долоон тахилч хуцын эврээр хийсэн долоон бүрээг авдрын өмнө авч явах ёстой. Долоо дахь өдөр нь та нар хотыг долоон удаа тойрч, тахилч нар бүрээг үлээгтүн. Тэд хуцын эврийг уртаар хүнгэнүүлэхэд, та нар бүрээний дууг сонсохдоо, бүх хүмүүс маш чангаар хаширалдах ёстой. Хотын хана доошоо нуран унаж, хүн бүр чигээрээ дайрагтун гэлээ."

Та энэ ишлэлийг дахин уншиж үзээд өөрийгөө энэ түүхийн нэг хэсэг болгон төсөөлж үзэхийг зөвлөе. Хэрэв танд Иерихо хотын цайзыг 7 хоног тойрон алхаад, 7 дахь өдрөө бүрээ үлээгээд хашгирахад хана нурах болно гэж Бурхан хэлсэн бол та энэ тохиолдолд яах байсан бэ? (Бурхан Еврейчүүдэд нураагч бөмбөгтэй өргөгч цамхаг авч ирээрэй гэж хэлээгүй) Ишлэлийг уншаад мэдэж авснаар тэд хэлснийх нь дагуу хийгээд хотын хана нуран унасан. Тэдний хийх ёстой байсан зүйл нь алхаад, бүрээ үлээгээд, хашхирах байсан гэдэг нь ойлгох хэрэгтэй чухал санаа. Тэд үүнийг итгэлээрээ үйлдсэн. Гэвч, эдгээр үйлдлүүдийн аль нь ч ханыг нураасан хүчин зүйл байгаагүй. Бурханы тогтоосон төгс цагт Түүний хүч чадал дотор Тэр өөрөө ер бусын байдлаар ханыг цохисон юм.

Үүнийг бодоорой: Бурхан яг үүнтэй адил ер бусын ажлыг таны дотор хийхийг хүсдэг байх боломжтой юу? Таныг чөлөөлөхийн тулд танд буй худал итгэл үнэмшил, гэмт зуршил, шарх зэрэг хана хэрмийг бут цохин нураана гэж Бурхан амладаггүй гэж үү? Иймээс таны хийх ажил бол итгэлийн алхам хийж, үүнийг хийх Бурханы ер бусын хүч чадалд итгэл хүлээлгэх нь юм. Еврейчүүд хана нурах үед Түүнээс эмээхүй дор зогссон шиг энэ бүхнийг Тэрээр танд хийж өгөхөд та ч мөн адил эмээхүйг олох юм.

Асуулт: Бурхан таны амьдралд ямар ер бусын ажлыг хийгээсэй гэж та хүсдэг вэ? Таны дотоод зөрчлийн ялалт уу, гэмт зуршлаас чөлөөлөгдөх нь үү, махан биеийн зан чанарын өөрчлөлт үү?

Бясалгал: Иошуа 6:3-5 ишлэлийг бясалгаад энэ асуултыг бодож үзээрэй. "Бурхан Иериход байрлах бодит цайзыг нурааж чаддаг юм бол та итгэлээр алхах үед таны худал итгэл үнэмшил, гэмт зуршил, хүлээсийн ханыг нурааж өгөхгүй гэж үү? "

Бурхантай хамт алхах нь: Итгэлийн алхам хийж эхэл. Тэгээд таны дотор буй тэдгээр хануудыг нурааж эхлэхийг Бурханаас асуугаарай.

Бидний дотор ажилладаг Бурханы ер бусын ажлын тухай юүг ойлгох хэрэгтэй вэ?

Бурханы хүч чадал бол ер бусын гэдгийг ихэнх Христитгэгчид ойлгодог гэж хэлэх нь зүйтэй байх. Гэвч, Бурхан тэдний дотор ер бусын ажлыг хийхийг хүсдэг гэж хувьчлан хэлмэгц тэд энэ ухагдахууныг ойлгох гэж зүдрэх хандлагатай болдог. Бидний дотор Бурханы хүч чадал ажиллах тухайд ер бусын гэдэг нь ямар утгатай вэ? Энэ асуултанд хариулах дараах 2 түлхүүр үнэнийг харъя.

1. Та ихэнх тохиолдолд таны дотор ажиллаж буй Бурханы ер бусын хүч чадлыг МЭДРЭХГҮЙ эсвэл АМСАХГҮЙ БУЙ МЭТ байж болно

Та хэсэгхэн анхаарлаа төвлөрүүлбэл би яг хэлэх гэсэн санаагаа харуулья. Та яг одоо надтай хамт итгэлийн алхам хийгээрэй. “Эзэн, Таны хүч чадал яг энэ мөчид над руу урсан орно гэдэгт би итгэж байна” гэж хэлээрэй. Та үүнийг итгэлээр хэлсэн бол та ямар нэгэн онцгой зүйлийг мэдэрч байна уу? Бурханы хүч чадал тан руу эрчимтэй урсан орж ирж байгааг амсаж байна уу? Та итгэлээр алхаж байлаа ч ихэнх тохиолдолд Бурханы хүч чадлыг мэдрэхгүй байх магадлалтай. Яагаад? Хариултыг нь 2 Коринт 5:7 ишлэлээс харъя.

"Учир нь бид үзэгдэж байгаагаар БУС, харин итгэлээр алхаж байна."



Паул бидэнд уг ишлэлээр дамжуулан итгэлийн алхам тул мэдэрч эсвэл амсах зүйл биш гэдгийг хэлж байна. Дандаа биш ч ихэнх тохиолдолд Бурханы амь ба хүч чадлын алийг нь ч та мэдрэхгүй. Яагаад энэ нь ийм сэтгэл гонсойлгом юм бол? Хүн төрөлхтөн бид таван мэдрэхүйгээр дамжуулан цаг мөч тутам амьдралын аливаа зүйлийг амсаж, мэдэрдэг. Нэгэнт мэдрэхүй ба амсаж туулахуй нь бидний амьдралын салшгүй хэсэг тул итгэлийн алхам хийхэд Бурханы ажлыг мэдэрч эсвэл амсана гэж дүгнэх нь амархан байдаг.

Үнэн бол та итгэлийн алхам хийхэд ИХЭНХ ТОХИОЛДОЛД Бурханы амь, хүч чадал тан руу урсан орж байгааг МЭДРЭХГҮЙ бас АМСАХГҮЙ .

ХУВИЙН ЖИШЭЭ

Итгэлийн аялалаа эхэлсэн тэр үед ааваасаа авсан шархыг эдгээхийг Бурханаас хүсдэг байлаа. Эдгэрэл руу чиглэсэн миний итгэлийн алхам ингэж эхэлсэн - “Эзэн, аавын минь надад ам хэл, сэтгэл хөдлөл, бие махбодийн хүчирхийлэлээр учруулсан шархыг эдгээж өгөөч гэж гуйж байна”. Яг тэр мөчид Бурханы эдгээх хүч чадал бүхлээрээ миний дотор ажиллаж эхэлсэн юм.

Гэсэн хэдий ч би Бурханы эдгэрлийн ямар нэг хүч чадлыг тухайн үедээ амсаж, мэдэрч эхлээгүй байсан. Хэдийгээр би Бурханы хүч чадлыг амсаж мэдрэхгүй байсан ч Бурханы үнэн бидэнд юу гэж хэлдэг вэ? Би мэдэрсэн мэдрээгүйгээс үл хамааран Бурханы хүч чадал надад цутгагдаж байсан юм. Бурханы эдгэрлийн

хүч чадлыг би мэдрэхгүй байсан нь Бурхан намайг эдгээх ажлаа тухайн мөчид хийж байсан гэдэг зайлшгүй үнэнийг өөрчилдөггүй. Итгэлийн алхааны маш чухал түлхүүр үнэн энд гарч байна.

Итгэлийн алхааны ТҮЛХҮҮР бол:

Таны дотор ажиллаж буй Түүний амь ба хүч чадлыг МЭДЭРЧ эсвэл АМСАЖ байгаа эсэхээс үл хамааран итгэлээр алхахад таны дотор Бурхан ажиллаж байгаа гэдэгт ИТГЭ.

Асуулт: Өнгөрсөн хугацаанд итгэлээр алхах гэж хичээсэн боловч та амьдралдаа Бурханы ажлыг мэдрээгүй эсвэл амсаагүйгээсээ болоод сэтгэлээр унаж итгэлээр алхахаа больж байсан уу? Бурхан Өөрийн ажлаа хийж байсан ч Түүний амь ба хүч чадлыг бид амьдралдаа тэр бүр мэдрэхгүй, бодит бус мэт байх боломжтой гэдэг үнэнийг мэдсэн нь итгэлийн алхааг илүү ойлгоход туслав уу?

Бясалгал: Бид итгэлээр алхаж байхад Бурханы хүчийг мэдрэхгүй байсан ч Бурхан ажлаа хийж байгаа гэдэг үнэнийг бясалгаарай.

Бурхантай хамт алхах нь: Та итгэлээр алхаж эхэлмэгц л Бурханы амь ба хүч чадлыг тэр дор нь мэдэрч эсвэл амсаж эхлэхгүй байх боломжтой гэдэг үнэнийг гүнзгий илчлэхийг Бурханаас асуугаарай. Та өөрчлөгдөхийг хүсч байгаа талбарт итгэлийн алхам хийж эхлээрэй. Хэдийгээр та өөрчлөлтийг мэдрэхгүй байгаа ч Бурхан ажлаа хийж байгаа гэдгийг батлахыг Бурханаас гуйн залбираарай.

Энэ үнэнийг МЭДЭЭГҮЙ, энэ үнэнд ИТГЭЭГҮЙ хүмүүс итгэлээр алхахаа

ЗОГСОХ гол шалтгаан болдог.

ГУРАВ ДАХЬ ӨДӨР

2. Таны дотор Бурханы хүч чадал хэрхэн ажиллаж байгааг та мэдэхгүй.



"Өөрийн замыг ЭЗЭНд даатга, Мөн Түүнд итгэж найд. Тэгвэл Тэр биелүүлж өгнө." Дуулал 37:5

Дахин хэлэхэд биднийг өөрчлөх Бурханы хүч чадал бидний дотор хэрхэн ажилладагийг бид мэддэггүй буюу мэдэхгүй. Миний ихэнхдээ ашигладаг нэг үгийг цэрэгт их ашигладаг. "Та зайлшгүй мэдэх-шаардлагатай гэсэн онолоор яваад байна". Та Бурхантай ч яг ингэж харьцаад байна. Бурхан бид нарыг хэрхэн өөрчилж байгаагаа хэлэхгүй байгаагаас хойш бид мэдэх гээд ч хэрэггүй. Бид бүгд аливаа нэг зүйлийг хэрхэн явагддаг зүй тогтлыг заавал мэдэхийг хүсдэг учраас Бурхан юу хийж буйгаа хэлдэггүй нь бидний сэтгэлийг гонсойлгох боломжтой. Гэвч Бурхан хэрхэн ажиллаж буйгаа ихэнхдээ хэлэхгүй л болов уу. Харин тэрээр таныг итгэлээр алхаж байхад тань таны дотор ажиллана л гэж амладаг.

ЕР БУСЫН гэдэг нь Бурхан таны амьдралыг өөрчилж буй ҮЙЛ ЯВЦАА танд ХЭЛЭХГҮЙ

байгаа гэсэн утгыг мөн илтгэдэг юм.

Энэхүү үнэнийг тантай хуваалцахад надад тулгарч буй хамгийн том хүндрэл бол таны амьдралыг өөрчилж байгаа Бурханы үйл явцыг би танд тодорхойлж хэлж чадахгүйд оршино. Бурхан бидэнд өөрийн ажлаа хэрхэн хийдэг талаар танд эсвэл надад ойлгуулаагүй (ба ойлгуулахгүй). Тэрээр таныг Түүн дотор итгэлийн алхам хийхийг хүсдэг бөгөөд итгэлээр Түүний ер бусын ажил таны дотор хийгдэж буйг мэдээсэй хэмээн хүсдэг. Тиймээс л итгэлээр алхах талаар ямар нэг томъёо эсвэл хэв загвар байдаггүй юм. Учир нь таны дотор хийгдэж буй Бурханы ажил бусад хүмүүст хийгддэгтэй огт адилгүй өвөрмөц юм.

Бурханы ажил бол ЕР БУСЫН ажил ба хувь хүний онцлогт нь нийцсэн учраас Христитгэлийн амьдралыг хэв загвар, томъёонд оруулж ЧАДАХГҮЙ.

Энэ асуултыг бодоод үзээрэй: Бидний итгэлийг барьж байгуулахын тулд Бурхан бидэнд хэрхэн ажиллаж буйгаа хэлэхгүй байх боломжтой юу?

Асуулт: Бурхан бидний амьдралд юу хийж байгааг мэдэх хэрэгцээ танд яагаад байгаа гэж боддог вэ? Хэрэв бид мэдэх хэрэгцээтэйгээ зууралдвал ямар сөрөг нөлөө үүсч болох вэ?

Христитгэлт амьдралаар амьдрахын тулд дагах томъёо, хэв загварыг бид яагаад бий болгож чадахгүй талаар сайн ойлголттой болсон уу?

Бясалгал: Дуулал 37:5 ишлэлийг бясалгаад таны амьдралд Бурхан хэрхэн ажлаа хийж байгааг мэдэх гэсэн хүслээс холдуулж өгөхөд туслахыг Бурханаас гуйгаарай.

Бурхантай хамт алхах нь: Өөрчлөгдөхийг хүсч буй талбартаа итгэлийн алхам хийж байхдаа Тэр хэрхэн ажиллаж буйг мэдэхгүй ч амар тайван байх хүслийг өгөхийг Эзэнээс залбираарай.

Энэ нь та өөрчлөлтийг амсахгүй гэсэн үг биш юм шүү.

Та хэдийгээр Бурханы үйл явцыг МЭДРЭХГҮЙ, ШУУД АМСАХГҮЙ байх БОЛОМЖТОЙ ч ЦАГ НЬ БОЛОХОД та өөрийн бодол, итгэл, зан чанаа, сонгох сонголтондоо ӨӨРЧЛӨЛТИЙГ амсах болно.



Бурхан өөрөө амьдрал тань авчрах өөрчлөлтийг мэдрээсэй гэж хүсдэг ба та мэдрэх ч болно. Гэвч тухайн өөрчлөлт бодит биелэлээ олохоос өмнө та Бурханы таны дотор хийдэг ажлыг мэдрэхгүй эсвэл амсахгүй байх боломжтой.

Жишээлбэл, бүтэлгүйтлийн айдсаас чөлөөлөгдөх гэсэн итгэлээр та Бурханыг хайж эхэлжээ. Та итгэлээр алхаснаар Бурханы хүч чадал таныг чөлөөлөхөөр ажиллаж эхлэх боловч чөлөөлөлт явагдаж буй үйл явцыг та мэдрэхгүй байх магадлалтай. Гэсэн хэдий ч, нэг л өдөр Бурханы тогтоосон төгс цагт та бүтэлгүйтлээс айхаа больсоноо харах болно. Түлхүүр нь та хүссэн өөрчлөлтөө амсахын тулд итгэлээр хангалттай хугацаанд алхах ёстой болдог.

Тиймээс итгэлийн алхам хийж байхдаа таны асуух түлхүүр асуулт энд байна:

**Та амьдралдаа өөрчлөлтийг АМСАХЫН тулд
итгэлээр хангалттай удаан хугацаанд алхах уу?**

Өөрчлөгдөхийг хүсч байгаа талбартаа итгэлээрээ алхаж эхэлсэнээс хойш хир удаан хугацааны дараа өөрчлөлт амсахыг бид мэддэггүй (Бурхан бидэнд хэлдэггүй) тул бид амьдралдаа өөрчлөлтийг мэдрэх хүртлээ итгэлээр үргэлжлүүлэн алхсаар л байх ёстой. Энэ хичээлийн явцад бид бүхэн итгэлийн алхаанаас юуг найдаж хүлээх хэрэгтэй талаар илүү ярилцах болно. Та ер бусын өөрчлөлтийг амсах тэр үед юу тохиолддог вэ?

Өөрчлөлт ХРИСТЭД-БАТ ИТГЭЛТЭЙ байдлыг бий болгодог.

"Та нарын дотор сайн үйлийг эхлүүлсэн Тэрээр үүнийгээ Христ Есүсийн өдрийг хүртэл төгс төгөлдөр болгоно гэдэгт би (Христ) бат итгээж байна."
Филиппой 1:6 (Хаалтан доторхыг нэмсэн)

Энд Паул ямар төрлийн итгэлтэй байдлын талаар ярьж байна вэ? Паул өөртөө итгэлтэй байх талаар яриагүй. Үүнээс илүү, Паул Бурханаар-бий болгогддог Христэд-бат итгэлтэй байдлын талаар ярьж байна. Яагаад? Паул Бурханаас эхтэй мөнөөх ер бусын өөрчлөлтийг амьдралдаа мэдэрсэн бөгөөд бат итгэлтэй байдал нь өөрийн чадвар, өөртөө итгэлтэй байдал биш гэдгийг гэрчилж байна. Харин үүнээс ч илүү Бурханы хүч чадал дотор Христэд-бат итгэлтэй байдлыг Паул ярьж байна.

**Та амьдралдаа ер бусын өөрчлөлтийг АМСАЖ эхлэхэд
ХРИСТЭД-БАТ ИТГЭЛТЭЙ байдал үр дүнд нь бий болдог.**

Христитгэгчдийн олонхоос нь Бурханд-бат итгэлтэй байдлыг олж хардаггүйгээ шударгаар хэлье. Учир нь тэдний олонх нь ер бусын өөрчлөлтийг амсахуйц хангалттай урт хугацаанд итгэлээрээ алхаагүй байдаг юм. Тиймээс таныг урамшуулж хэлэхэд та итгэлээр үргэлжлүүлэн хангалттай хугацаанд алхах үед та Христэд-бат итгэлтэй байдлыг амсах бөгөөд нэг л өдөр Паултай адил үгийг хэлэх чадвартай болох юм:

"Эдүгээ, бидний дотор ажилладаг (Бурханы) хүчний дагуу гуйж, бодох бүхнээс минь илүү хэмжээлшгүй бялхлаар үйлдэх чадвартай Түүнд".... Эфес 3:20 (хаалтан доторхыг нэмсэн)

Христэд-бат итгэлтэй байдлыг хөгжүүлэх нь үйл явц юм. Паул "2 Тимот 1:12" дээр уг үйл явцыг илчлэхийн тулд "итгэлтэй болгогдсон" гэдэг үгийг ашигладаг.

"Энэхүү шалтгааны улмаас би мөн зовдог. Гэхдээ би ичдэггүй. Учир нь би хэнд итгэснээ мэддэг. Тэр надад хариуцуулсан зүйлээ тэрхүү өдрийг хүртэл хамгаалах хүчтэй гэдэгт би итгэлтэй болгогдсон."

Бид итгэлээр алхан Бурханы өөрчлөлтийн ажлыг амьдралдаа мэдэрч эхлэхэд Паулын энэ үнэн бидний амьдралд биелэлээ олох болно. Яг Паул шиг бидний амьдралд Бурханы хүсэл ба чадвар оршиж, ажиллаж байгаа гэдэгт бид итгэлтэй болгогдох болно.

**Тиймээс бид амьдралдаа өөрчлөлтийг мэдрэхийн тулд итгэлээр хангалттай удаан
алхаснаар Бурхан доторх бидний ИТГЭЛТЭЙ БАЙДАЛ ӨСӨХ болно.**

Асуулт: Хэрэв та Бурханы хүчирхэг амлалтаас ирэх өөрчлөлтийг амслаа гэж үзвэл энэ нь таны амьдралыг өөрчлөх Бурханы хүсэл ба чадварт бат итгэлтэй байх байдалд ямар нөлөө болох байсан бэ?

Бясалгал: 2 Тимот 1:12 ишлэлийг бясалган таны Бурханд–бат итгэлтэй байдлын суурь хир гүн болохыг илчилж өгөхийг Ариун Сүнснээс гуйн залбираарай.

Бурхантай хамт алхах нь: Таны амьдралыг өөрчлөх Бурханы хүсэл ба чадварт улам илүү гүнзгий итгэж эхлэхийн төлөө Бурханаас гуйн залбираарай. Мөн Бурхан бол юу амласнаа хийдэг, Тэр бол байдаг Нэгэн гэдэг Бурханд – бат итгэлтэй байдлыг агуугаар өгөхийн төлөө гуйгаарай.

Жишээлбэл: “Эзэн, Танд-бат итгэлтэй байдал минь тийм ч их биш байна. Би Танаас миний амьдралыг өөрчлөх Таны чадварт бат итгэлтэй байдлыг барьж байгуулахын тулд миний амьдралыг өөрчлөөч хэмээн гуйн залбирч байна”

ДӨРӨВ ДЭХ ӨДӨР

Таны “АМЬ” болох Христээс эхтэй амьдрах нь

Бид итгэлээр алхаснаар Бурханы хүч чадал бидний дотор нээгддэг гэдэг үнэнийг үзлээ. Нэмж хэлэхэд, бид итгэлийн алхам хийх үед ч мөн бидний дотор Христийн амь чөлөөлөгддөг. Тиймээс энэ хэсэгт бидний амьдралд чөлөөлөгдсөн, бидний амь болсон Христийн талаарх гүнзгий утга учир болон амьдралын бодит хэрэгжүүлэлтийн талаар харуулья.

Нэгдүгээр хичээл дээр уншиж байсан Христ бол амь гэдгийг илчилсэн доорх хоёр ишлэлийг санаж байна уу?

"Бидний амь болох Христ..." Колоссой 3:4

"Би бол зам, үнэн, амь мөн..." Иохан 14:6

Христ бол таны амь гэдэг нь ямар утгатай вэ?

Таны амь болсон Христ гэдэг нь

ЗӨВХӨН Христээр хангагдах боломжтой ЕР БУСЫН, Христийн амьдралын ШИНЖ

ЧАНАРУУД танд нээлттэй байна гэсэн үг.

Христийн амьдралын шинж чанаруудын талаар жишээ өгөх дараах ишлэлийг уншъя.

"Харин Сүнсний (Христийн) үр жимс нь хайр, баяр баясгалан, амар тайван, тэвчээр, энэрэл, сайхан сэтгэл, итгэлтэй байдал, дөлгөөн зан, өөрийгөө захирах байдал нь юм..."

Галат 5:22, 23а (хаалтан доторхыг нэмсэн)

"Тиймээс Бурханаар сонгогдсон, ариун хийгээд хайрлагдсан хүмүүсийнхээ хувьд та нар (Христийн) өрөвч зүрх, энэрэл, даруу байдал, дөлгөөн зан, тэвчээрийг өмс. Ингэхдээ нэг нэгнээ хүлцэж, бие биеэ уучилж, хэрэв хэн нэгэнд чинь нөгөөгийнхөө эсрэг гомдол байвал та нарыг Эзэн уучилсны адил та нар бас

уучил. Энэ бүгдийн дээр (Христийн) хайрыг өмс. Хайр бол эв нэгдлийн төгс холбоос юм." Колоссай 3:12-14 (хаалтан доторхыг нэмсэн)

"Эцэст нь Эзэн дотор ба Түүний чадлын агуу хүч дотор бэхжигтүн." Эфес 6:10

Галат 5:22-23 ишлэл дээр Ариун Сүнсний үр жимсийг, Колоссай 3:12-14 ишлэл дээр бид нар юуг өмсөх хэрэгтэйг (ж- өрөвч зүрх, нинжин сэтгэл, даруу зан г.м), Эфес 6:10 ишлэл дээр "Христ" дотор хүчтэй байхыг дурьдсан нь бүгдээрээ Христийн амьдралын шинж чанаруудын жишээ юм.

Христ таны амь гэдэг нь юу болохыг нэгдүгээр хичээлийн Христийн амьдралын шинж чанаруудаас жагсаан үзүүлсэнийг дахин толилуулъя.

Таны амь болсон Христ БОЛ таны:

Болзолгүй хайр	Ялалт	Үнэ цэнэ	Хүлээн зөвшөөрөл
Итгэл	Эрх чөлөө	Тэвчээр	Ноён нуруутай байдал
Амар тайван	Итгэмжит байдал	Уучлал	Найдвартай
Айх айдасгүй	Мэргэн ухаан	Сайн мууг ялгах чадвар	Чадваржуулагдсан
Даруу байдал	Христ-итгэл	Энэрэнгүй	Амралт
Зөвт байдал	Өгөөмөр	Зориг зүрх	Халуун сэтгэл
Эр зориг	Баяр хөөр	Нигүүлсэнгүй	Христ захиргаа

Хэсэг хугацаанд бодоод үзье: Дээр жагсаасан бүх зан чанарууд Христээр дамжуулан танд тухайн мөч бүрд боломжтой болгогдсон. Тийм учраас цаг гарган дахин нэг нухацтай уншаад үзээрэй.

Христийн амьдралын шинж чанаруудаас та алийг нь илүү ихээр амсахыг хүсдэг вэ?

Христийн амьдралын шинж чанарууд болон хүний шинж чанарын ялгаа нь юу вэ?

Христийн амьдралын шинж чанаруудыг сайн ойлгохын тулд эдгээр шинж чанаруудад **хүнийхтэй** төстэй хэсэг байгаа бөгөөд **сүнслэг** шинж чанарууд ч байдаг гэдгийг ойлгох хэрэгтэй. Хүмүүний хүрээлэлд амар тайван, тэсвэр тэвчээр, аюулгүй байдлыг мэдрэх боломжтой. Тиймээс Христийн амьдралын шинж чанаруудыг хүнийхтэй эсрэгцүүлж харъя.

Хүний шинж чанарууд – Бидний нөхцөл байдал, харилцаанаас хамаарч **ӨӨРЧЛӨГДДӨГ** хүнээс гардаг сэтгэл мэдрэмжүүд.



Жишээлбэл, та өдрийг маш сайхан өнгөрөөлөө гэж төсөөлье. Та **хүний** амар тайван, баяр баясгалан, аюулгүй байдлыг мэдрч байна. Гэвч та гэртээ иртэл танай гэрт хулгай орсон, шугам хагарч гэрт чинь ус алдаад, хоёр настай хүү чинь ааш нь олдохгүй уйлж байлаа.

Энэ үед танд буй хүний амар тайван, баяр баясгалан, аюулгүй байдалд тэр дороо юу тохиолдох вэ? Үтэр түргэн энэ бүх амар тайван замхран алга болно! Хэрэв Христийн амьдралын шинж чанараар амьдарч байвал яг энэ нөхцөл байдал ямархуу харагдах бол?

Би энэ асуултанд хариулахаас өмнө Христийн амьдралын шинж чанарыг тодорхойлье.

ХРИСТИЙН АМЬДРАЛЫН ШИНЖ ЧАНАР – Нөхцөл байдал, харилцаанаас хамааран өөрчлөгдөөд **БАЙДАГГҮЙ** Христээр хангагддаг Христийн амьдралын **ЕР БУСЫН** шинж чанар.

Паул итгэлээр алхсаар зовлонгийн дунд ч агуу баяр хөөртэй байж чаддаг тэр нөхцөл байдалд ирсэн. Бид зовлонд унасан үедээ хүний хувьд баяр баясгаланг мэдэрнэ гэдэг нь бараг л боломжгүй. Тиймээс Паулын амссан баяр хөөр бол хүнээс эхтэй биш юм. Паул зовлон ч хулгайлж үл чадах Христийн амиар ирдэг баяр баясгаланг амсаж байсан ажээ.

Дээрхтэй адил жишээг ашиглан хулгайчтай нүүр тулж, ус алдсан, хүү чинь уйлсан нөхцөлд та уур хилэн, бухимдал, тэвчээргүй байдлыг мэдэрч байна гээд төсөөлцгөөе. Яг энэ мөчид Христийн амьдралын шинж чанарууд болох амар тайван, баяр хөөр, тэвчээрийг итгэлээр өөртөө өмсөх боломжтой. Амьдрал дээр энэ яаж харагдах вэ?



“Эзэн, би хүнд байдаг баяр хөөрөө алдаж, уур хилэн, бухимдал, тэвчээргүй байдлыг мэдэрч эхэлж байна. Яг одоо Бурхан Та Өөрийн хүчээр, Христийн амьдралын амар тайван, баяр хөөр, тэсвэр тэвчээртэй байдлаар энэ мэдрэмжүүдийг сольж өгөөч гэж гуйж байна.”

Яг энэ ухвар мөчид, Ариун Сүнсний хүч чадал таны уур хилэн, бухимдал, тэвчээргүй байдлыг дарж Христ Өөрийн амар тайван, тэвчээрийг тань руу урсгах болно. Тэр даруй та үүнийг мэдрэхгүй байж болох ч та Түүний амар тайван, тэвчээрээс зуурахаа үргэлжлүүлэх үед таны уур хилэн, бухимдал, тэвчээргүй байдал намжих болно.

ХҮНИЙ шинж чанар болон ХРИСТИЙН АМЬДРАЛЫН шинж чанарын гол ялгаа нь харилцаа эсвэл хүнд нөхцөл байдал нь Христийн амьдралын шинж чанарыг амсах байдлыг ХУЛГАЙЛЖ чаддаггүйд оршино.

Асуулт: Та Христээс ирдэг амар тайван, баяр баясгалан, тэсвэр тэвчээр, уучлалаар амьдарч байвал таны амьдралд үүссэн асуудал, зөрчилд энэ бүгд хэрхэн нөлөөлөх вэ?

Бясалгал: Та өөрийн амсахыг хүсдэг Христийн амьдралын шинж чанарыг амьдралдаа амсаж байсан бол таны амьдрал хир их өөр байх байсан бэ?

Бурхантай хамт алхах нь: Итгэлийн алхам хийж эхэл. Христийн амар тайван, баяр баясгалан, уучлалыг мэдрэхийн тулд Бурхан та намайг өөрчилж өгөөрэй гэж залбираарай.

Жишээлбэл: “Эзэн, миний хүсэл бол Таны амар тайван дотор алхах. Та намайг өөрчилнө гэж итгэн даатгаж байна тэгснээр би Таны амар тайвныг амсах болно.”

Өдөр бүр үүсдэг зөрчил, тэмцлийн дунд бидний амь болсон Христээс зуурах нь ямар харагддагийг харцгаая.

ГАДААД болон ДОТООД зөрчлийн дунд таны амь болсон Христээс зуурах нь

Бидний амь болсон Христээс зуурах талаар ярихаас өмнө бидэнд тулгардаг асуудлын талаар зарим нэгэн түлхүүр ойлголтуудаас би тантай хуваалцъя. Үүнд нэгдүгээрт:

Таны амь болсон Христ танд үргэлж ХЭРЭГТЭЙ гэдгийг САНУУЛАХААР Бурхан сөрөг нөхцөл байдал эсвэл хүнд зөрчил тэмцлийг АШИГЛАНА.

Би зөрчилтэй байгаа хувь хүн эсвэл хосуудад зөвлөгөө өгөхдөө ажигласан зүйл бол тэд болж өнгөрсөн зөрчил, тэмцэл буюу зөрчлийн үр дүнд бий болсон өвдөлт дээрээ л төвлөрөөд байдаг. Гэвч, Бурхан зөрчлийг ашиглан тэднийг Бурхантай хамааралтай байлгах руу эргүүлэхийг хүсдэг ба тэгсэнээр тухайн нөхцөл байдал дотроо тэдний амь болсон Христээс зуурах юм. Тухайн нөхцөл байдалд бидний амь болсон Христ хэрэгтэй гэдгийг ойлгохгүйгээр тухайн асуудлыг бид бүхэн өөрсдийн чадвараар шийдэх, эсвэл өнгөрөөх гэж хичээж эхэлдэг. Бидний зөрчлийн тал дээр доорх зүйлийг би ихэнхдээ хуваалцдаг.

Та өөрөө засч ЧАДАХГҮЙ зөрчилд орооцолдохыг Бурхан зөвшөөрөх боломжтой байдаг шалтгаан нь ЗӨВХӨН Бурхан засч чадна гэдгийг ойлгож Түүгээр засуулахын тулд таныг Түүн дээр очуулахыг хүсдэгт байдаг юм.

Асуулт: Нөхцөл байдал, хүмүүстэй харилцах харилцаа, дотоод зөрчилтэй гэх мэт та өөрөө засч чадахгүй ямар байдалтай яг одоо тулгараад байна вэ?

ТАВ ДАХЬ ӨДӨР

“БИ БОЛ БАЙДАГ” Христээс зуурах нь

Бүх зөрчил хэрэгцээг үүсгэдэг. Жишээлбэл, таны зөрчил магадгүй амар тайван, тэсвэр тэвчээр, мэргэн ухаантай байх хэрэгцээг үүсгэнэ. Филиппой 4:19 ишлэлд Паулаар дамжуулан Эзэн хэлдгийг харцгаая.

"Христ Есүс дотор та нарыг хэрэгтэй бүхнээр тань хангана."

Есүс бол бидний хэрэгцээг хангагч гэж Паул хэлж байна. Есүсийн тэр амь хэрэгтэй бүхнээр хангадаг. Иохан 14:6 дээр Есүс хэлэхдээ:

"БИ БОЛ ТЭР зам, үнэн, амь мөн..."

Христ бидний хэрэгцээнд хүрэх тухай яригдахад "БИ БОЛ БАЙДАГ" бидний хэрэгцээ бүрийг хангагч гэж хэлж байна. Миний юу хэлснийг ойлгохын тулд, энэ хичээлийн хамгийн сүүлийн хуудсанд “БИ БОЛ БАЙДАГ” гэсэн гарчигтай хуудсыг хараарай. Сүүлийн хуудсанд жагсаан бичсэний дагуу бидэнд хэрэгтэй болгонд хандан Христ "БИ БОЛ БАЙДАГ" гэж хэлдэг юм. Христийг “БИ БОЛ БАЙДАГ” гэдгийг амьдрал дээр илүү бодитойгоор тусгахын тулд дараах жишээг өгье.

Жишээ 1: Таны хань таныг голж байгааг мэдэрч байна гэж төсөөлье. Энэ тохиолдолд Христийн хүлээн зөвшөөрөл таны хэрэгцээ юм. Есүс “БИ БОЛ БАЙДАГ чиний хүндлэл” гэж хэлдэг. Тиймээс Христийн хүлээн зөвшөөрлөөс зуурах нь ингэж харагдана. Үүнд - “Эзэн, хань намайг голж байгааг би мэдэрч байна. Та миний хүлээн зөвшөөрөл БАЙНА гэдэгт итгэж байна.”

Жишээ 2: Танай компанид хямрал нүүрлэснээс таны ажилд аюул нүүрлэжээ гэж төсөөлье. Та санаа зоволттой байна. Энэ тохиолдолд таны хэрэгцээ бол Христийн амар тайван юм. Есүс “БИ БОЛ БАЙДАГ чиний амар тайван” гэж хэлдэг. Тиймээс Христийн амар тайвнаас зуурах нь ингэж харагдана. Үүнд -

“Эзэн, би ажлаа алдахвий гэж маш их санаа зовж байна. Гэвч Та миний амар тайван БАЙНА гэдэгт итгэж байна.”

Бясалгал: “БИ БОЛ БАЙДАГ” гэдэг Христийн үнэнийг бясалгаарай.

Дасгал: Өнөөдөр танд тулгарч буй гадаад болон дотоод хүчин зүйлээс үүдэлтэй зөрчилд тулгарсан хэрэгцээ тань юу вэ? “БИ БОЛ БАЙДАГ” гэдэг жагсаалтыг хараад таны зөрчилтэй уялдах хэсгийг олоорой.

Бурхантай алхах нь: Таны зөрчилтэй холбоотой хэрэгцээ нь Христ БАЙХЫГ эрж хайгаарай. Зөрчлийн хүнд хөнгөнөөс хамаараад, таны нөхцөл байдалд тохирсон тэр хэрэгцээ нь Христ БАЙХЫН төлөө үргэлжлүүлэн түүнийг эрж хайгаарай.

Бидний амь болсон Христийн тухай дүгнэлт бодрол



Итгэгчид Христээс тэсвэр тэвчээр, амар тайвныг **өгөхийг** гуйн залбирдаг талаар би сонсдог. Энэ нь яг эмийн санчаас эмийн жор бичиж өгөхийг гуйж байгаатай адил юм. Харин бидний дотор Христийн амар тайван, баяр баясгалан бүгд агуулагдаж байдаг болохоор (Колоссай 2:9) бид аль хэдийн эзэмшдэг зүйлээ гуйх шаардлагатай юу? Өөрөөр хэлбэл, Есүс бол бидэнд хэрэгтэй жорыг бичиж өгдөг тэнгэрлэг эмийн санч биш бөгөөд “БИ БОЛ БАЙДАГ” таны хэрэгцээ гэж Есүс хэлж байгаа юм (БИ БОЛ чиний амар тайван г.м). Тиймээс бид Есүсээс амар тайван, баяр баясгалан, мэргэн ухаан “өгөөрэй” гэж гуйх шаардлагагүй. Харин таны амар тайван, баяр баясгалан, мэргэн ухаан нь Есүс **БОЛНО** гэдэгт “итгэх” хэрэгтэй.

Үнэн нь Христ БОЛ таны амь. Христ танд ямар нэгэн зүйлийг түгээж ӨГДӨГГҮЙ. Оронд нь Христ өөрөө ӨӨРИЙГӨӨ таны амьдралд тасралтгүй хангасаар байна.

Тулгамдсан нөхцөл байдлын дүнд таны хэрэгцээнд хүрэгч Христээс зуурах итгэлийн алхам

Ажил, гэрлэлт, ямар нэгэн нөхцөл байдалдаа “БИ БОЛ БАЙДАГ” Христээс зуурах нь ямар харагддаг жишээнүүдийг харцгаая.

Таны ажлын байранд

Жишээ 1: Та маш их стресстэй ажилтай гэж бодъё (хүн бүр л ийм байдаг тийм үү). Нэг өдөр ажил дээрээ ирээд таны амар тайван, Христ доторх амралтыг хулгайлагч стрессийг үүсгэгч эзэн нь та өөрөө болсоноо ойлгожээ. Таны амь болох Христээс зуурах итгэлийн алхам ингэж харагдах нь байна:

Итгэлийн алхам: “Эзэн, би ажлын стресстээ дарлагдаж, стрессээ өөрөө үүсгэгч болсон байна. Та миний амар тайван БАЙНА гэдэгт итгэж байна.”

Түлхүүр Үнэн: Стрессээсээ чөлөөлөгдөхийн тулд итгэлээрээ хэд хэдэн алхам хийх хэрэгтэй бөгөөд ингэснээр та Христийн амар тайвныг эцэст нь мэдэрнэ.

Жишээ 2: Та ажлаасаа халагдаад сэтгэл санаа тогтворгүй, айдастай, цухалддаг болсон байна. Энэ үед танд Христийн зориг, амралт, бат итгэлтэй байдал хэрэгтэй болжээ.

Итгэлийн алхам: “Эзэн, би ажлаасаа халагдчихлаа. Би цухалдаж, санаа зовж байна. Та миний амар тайван **БАЙНА** гэдэгт итгэж байна.”

Дасгал: “БИ БОЛ БАЙДАГ” хуудасны жагсаалтыг дахин хараарай. Таны ажил “БИ БОЛ БАЙДАГ” Христийн ямар хэрэгцээг үүсгэж байна вэ? Тэрхүү хэрэгцээг хангахын тулд “БИ БОЛ БАЙДАГ” Христээс асууж эхлээрэй.

Таны Гэрлэлт

Жишээ 1: Та ханиа Христийн хайраар хайрлахыг хүсдэг гэж бодож байна. (Хэрэв тийм биш бол танд зөвлөгөө хэрэгтэй болсон байна). Та ханьдаа хэрэгцээтэй байгаа Христийн **болзолгүй** хайрыг өөрөөсөө, өөрөө бий болгох боломжгүй гэдгийг мэдэж байгаа. Тиймээс, ханьдаа зориулах Христийн хайраас зуурах итгэлийн алхам доорхтой адил харагдана:

Итгэлийн алхам: “Эзэн, би ханиа Христийн болзолгүй хайраар хайрлаж чадахгүй байна. Би итгэл дотор Христийн болзолгүй хайраар Та надаар ДАМЖУУЛАН ханийг минь хайрлаач гэж **гуйж байна.**”

Санамж: Энэхүү залбирлыг залбирснаар таниар дамжуулан Христийн хайр урсаж эхлэхийг ихэнхдээ мэдрэхгүй байж болох ч итгэлээр та үүнийг мэдэж байгаа. Та санаж явах хэрэгтэй зүйл бол та итгэлээр алхаж байхад Бурхан ер бусын арга замаар таниар дамжуулан ханийг тань хайрлах болно.

Сорилт: Ирэх 30 хоногийн турш бодох бүртээ аль болох олон удаа энэхүү итгэлийн алхмыг хийгээрэй. Тэгээд энэхүү байдал дотор та ханиа харах өнцөгт ямар өөрчлөлт гарч байгаа болон хань тань таныг харах өнцгийн өөрчлөлтүүдийг тэмдэглэл хөтлөн бичээд байгаарай. Таны гэр бүлийн харилцаанд ер бусын өөрчлөлт гарч эхлэхийг та харах болно.

Жишээ 2: Таны хань таны тэвчээрийг шавхах зүйлийг танд хийдэг гэж төсөөлье. Энэ үед та Христийн тэсвэр тэвчээрээс зуурах дараах итгэлийн алхам хийгээрэй.

Итгэлийн алхам: “Эзэн, хань тэвчээрийг минь шалгаад байна. Та хань руугаа хандах тэвчээр минь **БАЙГААЧ** гэж гуйж байна.” **Санамж:** “Есүсээ та надад тэвчээртэй байхад туслаач” гэж энд би хэлэхгүй байгааг анзаарч байна уу. Есүс таныг тэвчээртэй байхад туслахыг хүсдэггүй. ЕСҮС БОЛ таны тэвчээр юм.

Дасгал: Та өөрийн гэрлэлтийн амьдралыг нэг хараад үзнэ үү. Тэгээд таны гэрлэлтийн амьдрал дахь зөрчлийн талбаруудад таны амь болсон Христээс юу нь танд хэрэгтэй байгааг бодож үзээрэй. Итгэлийн алхам хийж “БИ БОЛ БАЙДАГ” Христээс зуурч эхлээрэй. “БИ БОЛ БАЙДАГ” гэсэн хуудас руу дахин нэг очиж жагсаалтыг хараарай.

Өөрийн нөхцөл байдалд хэрэгжүүлэлт хийх нь

Жишээ 1: Та санхүүгийн асуудалд уналаа гэж бодъё. Цаашид яах талаар та санаа зовж түгшүүртэй болно. Санаа зоволт, түгшүүрээ өөрөө захирахын оронд Бурханаар шийдүүлэхийн тулд Түүнтэй хамт итгэлээр алхахыг сонгоорой.

Итгэлийн алхам: “Эзэн, би төлбөрөө яаж төлөх вэ гэж маш их санаа зовж, түгшиж байна. Та намайг хангана гэдэгт итгэх итгэл, амар тайван минь БАЙХЫГ Таниас **гуйж байна. Мөн** би Таны хэмжээлшгүй эрх мэдэлд **итгэж байна.**”

Жишээ 2: Та эмчээс маш хүнд өвчний онош сонссон гэж бодъё. Айдас таныг нөмөрч эхлэх боловч итгэлийн алхам хийх шийдвэр гаргалаа:

Итгэлийн алхам: “Эзэн, энэ байдлаар надад юу тохиолдох бол гэж би үнэхээр их айж байна. Та энэ айдсыг даван туулах миний хүч тэнхээ, эр зориг минь БАЙЖ энэ айдсыг надаас зайлуулна гэдэгт **итгэж байна.**”

Дасгал: Танд тулгарч байгаа сөрөг, тааламжгүй нөхцөл байдлуудаа (санхүү, эрүүл мэнд гэх мэт) хараад тэдгээр нөхцөл байдлын үр дүнд үүссэн хэрэгцээг тодорхойлоорой. Тэдгээр талбарууддаа итгэлийн алхам хийж эхлэн “БИ БОЛ БАЙДАГ” жагсаалтыг та дахин хараарай.

Таны амь болсон Христээс зуурах үед санах хэрэгтэй чухал ойлголтууд:

1. Таны хэрэгтэй зүйлс Христ БАЙХ БОЛНО гэж итгэхэд та яг тэр мөчид Христийн амийн (Түүний амар тайван, хүч чадал, болзолгүй хайр г.м) БҮРЭН ДҮҮРЭН байдлыг хүлээн авдаг.
2. Христ Өөрийн амийг тань руу урсгах нь ЕР БУСЫН үйл явц гэдгийг санаарай.
3. Энэ үйл явц нь ер бусын тул Христэд БАЙДАГ гэж итгэдэг зүйлсийг шууд мэдэрч, амсахгүй (амар тайван, сэтгэл хангалуун байдал, тэвчээр) БАЙХ МАГАДЛАЛТАЙ.
4. Гэвч тухайн мөчид Христ Өөрийн бүрэн дүүрэн амар тайван, тэсвэр тэвчээрээ урсгаж байгаа гэсэн энэ үнэн ӨӨРЧЛӨГДӨХГҮЙ.
5. Бид Христийн амийг асуух тухайн мөчид шууд мэдрэх ЭСЭХЭЭС ҮЛ ХАМААРАН, ИТГЭЛЭЭР Тэр Өөрийн амар тайван, тэсвэр тэвчээрийг хангаж байгааг мэддэг.

Гуравдугаар хичээлийн дүгнэлт

1. Итгэлийн алхам Бурханы хүч чадлыг бидэнд ЧӨЛӨӨЛЖ ӨГДӨГ.
2. Бидний дотор буй энэхүү хүч чадал нь Есүсийг үхлээс АМИЛУУЛСАН яг тэр хүч чадал юм.
3. Бидний дотор чөлөөлөгдсөн яг энэ хүч чадлаар бид оюун санааны шинэчлэл, ялалт, эрх чөлөө, өөрчлөлтийг АМСАЖ эхлэх болно.
4. Бурханы хүч чадал бол ЕР БУСЫН хүч чадал, тиймээс үүгээр хийгддэг өөрчлөлтийг хүний санаагаар тайлбарлах аргагүй.
5. ЕР БУСЫН гэдэг нь бидний дотор буй Бурханы хүч чадлыг тэр бүр МЭДЭРЧ, АМСАХГҮЙ байгаа мэт байх бөгөөд Бурханы хэрхэн ажиллаж байгааг тааварлашгүй байхыг хэлдэг.
6. Хэдийгээр Бурханы хүч чадал ажиллаж байгааг мэдрэхгүй байж болох ч Бурханы өөрчлөлтийн амлалтыг ЭЦСИЙН ЭЦЭСТ бид амсах болно.
7. Бид эдгээр өөрчлөлтийг амсаж эхэлснээр Бурхан бидний дотор Бурханд-бат итгэлтэй байдлыг бий болгодог.
8. Ажил, гэрлэлт, гэр бүлийн янз бүрийн тааламжгүй асуудлуудад алхам тутамдаа ХРИСТТЭЙ-АДИЛ зан чанараас зуурах боломжтой.

“БИ БОЛ БАЙДАГ ба БИ БОЛ чиний амьдрал”

Таны амьдралд хэрэгцээ тулгарах мөчид "БИ БОЛ БАЙДАГ" Христ таны хэрэгцээнд хүрдэг. Та өөрийн хувийн хэрэгцээг хоосон зайнд нөхөөд жагсаалтаас Христ таны хэрэгцээг ХАНГАГЧ байх болно гэдгийг хайж олоорой.

Таны хэрэгцээ _____? Есүс, “БИ БОЛ чиний _____.”

БИ БОЛ чиний хайр – Галат 5:22
БИ БОЛ чиний баяр хөөр – Иохан 15:11
БИ БОЛ чиний чадвар – 2 Коринт 3:5
БИ БОЛ чиний мэргэн ухаан – 1 Коринт 1:30
БИ БОЛ чиний зам – Иохан 14:6
БИ БОЛ чиний үнэн – Иохан 14:6
БИ БОЛ чиний амралт – Матай 11:28
БИ БОЛ чиний оюун санаа – 1 Коринт 2:16
БИ БОЛ чиний хүсэл – Дуулал 73:25
БИ БОЛ чиний бүрэн байдал – Колоссай 2:10
БИ БОЛ чиний ариусгал – 1 Коринт 1:30
БИ БОЛ чиний зорилго – Эфес 1:10
БИ БОЛ чиний мөн чанар – 2 Коринт 5:17
БИ БОЛ чиний аюулгүй байдал – Сур.үгс 1:33
БИ БОЛ чиний сайн сайхан – Галат 5:22
БИ БОЛ чиний итгэлтэй байдал – 2 Коринт 3:4
БИ БОЛ чиний энэрэл – Дуулал 25:6
БИ БОЛ чиний уучлал – Даниел 9:9
БИ БОЛ чиний амжилт – Ром 8:37
БИ БОЛ чиний үл цөхрөл – Еврей 10:36
БИ БОЛ чиний амар тайван – Эфес 2:14
БИ БОЛ чиний тэвчээр - Еврей 12:2
БИ БОЛ чиний итгэл – Ром 15:5
БИ БОЛ чиний хүч тэнхээ – Ром 6:10
БИ БОЛ чиний хэмжээлшгүй – 1 Тимот 6:15
БИ БОЛ чиний дотно байдал – Дуулал 139:3
БИ БОЛ чиний нинжин сэтгэл – Галат5:22
БИ БОЛ чиний даруу зан – Матай 11:29
БИ БОЛ чиний хүлээн зөвшөөрөл – Ром15:7
БИ БОЛ чиний итгэмжтэй байдал – Галат5:22
БИ БОЛ чиний хэрэгцээнд хүрэгч – Галат4:19
БИ БОЛ чиний аврагч – Дуулал 18:2
БИ БОЛ чиний эрх чөлөө – Иохан 8:32
БИ БОЛ чиний ялалт – 1 Коринт 15:57
БИ БОЛ чиний дөлгөөн зан – Галат5:23
БИ БОЛ чиний тэвчээр – Галат5:22
БИ БОЛ чиний эр зориг – Иохан 16:33
БИ БОЛ чиний ялан дийлэгч – Ром8:37
БИ БОЛ чиний ариун байдал – Колоссай 3:12
БИ БОЛ чиний өөрийгөө захирах байдал
2 Тимот 1:7
БИ БОЛ чиний аврал – Дуулал 27:1
БИ БОЛ чиний итгэл – Иеремиа 17:7
БИ БОЛ чиний хөтөч – Дуулал 48:14

БИ БОЛ чиний хоньчин – Дуулал 23:1
БИ БОЛ чиний тайвшруулагч – Иохан 14:16
БИ БОЛ чиний АББА – Галат4:5-6
БИ БОЛ чиний найдвар – Колоссай 1:27
БИ БОЛ чиний амьдрал – Иохан 14:6

ДӨРӨВДҮГЭЭР ХИЧЭЭЛ

Бурханы ялалт, эрх чөлөө, эдгэрлийн амлалтыг хүртэх нь

НЭГ ДЭХ ӨДӨР

Дөрөвдүгээр хичээлийн агуулга

- Өөрчлөлтийн туршлагыг "итгэл гаргах"-аас ялгаж ойлгох нь
- Бидний оюун бодлыг Өөрийн үнэн уруу шинэчлэх Бурханы үйл явц
- Гэмт зуршил, хүлээсэнд ялагдмал байдлаас ялалт, эрх чөлөөг амсах нь
- Өнгөрсөн болон өнөөгийн шархыг эдгээх Бурханы үйл явц

Оршил

Өнөөдрийг хүртэл үзсэн зүйлийнхээ дагуу, та өөрчлөлтийг амсахыг хүсч байгаа амьдралын талбартаа итгэлийн алхам хийж эхэлсэн гэдэгт би итгэж байна. Хэрэв тийм бол тодорхой хэмжээнд таны бодол санаа, мэдрэмж, сонголт өөрчлөгдөж эхэлсэнийг та анзаарч байгаа гэж найдаж байна. Энэ удаагийн хичээлээр итгэлийн алхаа нь бидний амьдралд хэрхэн дараах өөрчлөлтийг бий болгохыг үзэх болно.

- Худал үнэмшлийн эсрэг Бурханы үнэнд итгэхэд оюун бодлоо шинэчлэх. Ром 12:2
- Гэмт зуршил, махан биеийн зан чанарыг ялах ялалт, эрх чөлөөг амсах. 1 Коринт 15:57
- Өнгөрсөн шархны эдгэрэлийг амсах. Дуулал 147:3

“Итгэл гаргах” ба Туршлага

Энэ хичээлийн амин чухал ойлголтуудын нэг нь энэ гэж би хэлмээр байна. Тиймээс унших гэж буй зүйлийнхээ гарчгийг тунгаан бодож, бясалгахад цаг зарцуулна уу.

Та амьдралдаа өөрчлөгдөхийг хүсч байгаа талбартаа итгэлийн алхам хийж эхлэхэд ихэнх тохиолдолд Бурханы амь ба хүч чадлыг мэдрэхгүй эсвэл амсахгүй байх боломжтойг дахин санаарай. Гэхдээ та итгэлээр алхаад тодорхой хугацаа өнгөрсний дараа оюун бодол, итгэл үнэмшил, сонголт, зан чанарын өөрчлөлтийг мэдэрч эхлэх болно. Өөрчлөлтийг бодитоор мэдрэх үе хүртэлх итгэлийн алхааг би “итгэл гаргах” гэж нэрлэдэг. “Итгэл гаргах” гэдэг нь ямар утгатай вэ?

“Итгэл гаргах” гэдэг нь

БОДИТООР өөрчлөлтийг амсах хүртлээ таны дотор Бурхан ажиллаж байгааг мэдрэхгүй байвч Бурхан таны дотор ажиллаж байгаад ҮРГЭЛЖЛҮҮЛЭН итгэхийг хэлдэг.

Итгэлийн алхааны түлхүүр нь оюун бодол, итгэл үнэмшил, сонголт, зан чанарын өөрчлөлтийг амсах хүртлээ та хангалттай удаан хугацаанд үргэлжлүүлэн “итгэл гаргах” юм. Дүрслэн харуулахын тулд нэгэн жишээ үзүүлье.

Та хэн нэгнийг хайрлах гэж зүдэрч байна гэж бодъё. Өнгөрсөн хичээлээр Христийн хайр бүрнээрээ бидэнд бэлэн байдгийг суралцсан билээ. Тиймээс Христийн хайрыг хүлээн авахын тулд итгэлийн алхам хийж эхэл.

Итгэлийн алхам хийх нь нэг иймэрхүү харагдана- “Эзэн, би энэ хүнийг хайрлаж чадахгүй байна. Тиймээс энэ хүнийг хайрлах Таны хайраас би зуурч байна”.

Энэ үйл явцыг дөнгөж эхэлмэгцээ л та Христийн хайрыг мэдрэхгүй байж болно. Гэвч та итгэлээр алхаж байгаа цагт бидний мэддэг үнэн юу билээ? Тэр үнэн бол Христ тэр хүнд зориулах Өөрийн хайрыг таны дотор үргэлжлүүлэн цутгасаар байна. Тухайн мөчид таны дотроос урсах Христийн хайрыг мэдрэхгүй байж болох ч би үүнийг "итгэл"-ээр хайрлах гэж хэлдэг. Хэрэв та үргэлжлүүлэн “итгэл гаргах” юм бол тэр хүнийг хайрлах Христийн хайрыг **мэдэрч** эхлэх тэр цэгт эцэст нь хүрэх л болно. Итгэлээс бодит туршлага руу шилжих нь Сүнсний ер бусын ажил тул цаг орно гэдгийг санаарай. Доор “итгэл”-ээс “бодит туршлага” руу шилжих нь ямар байдгийг зураглан үзүүлжээ.



“ИТГЭЛ”-ЭЭС “БОДИТ ТУРШЛАГА” РУУ ШИЛЖИХ ҮЙЛ ЯВЦ

Хувийн түүх

Бурхан намайг “итгэл”-ээр хайрлахаас “бодит туршлага” болсон хайр руу хэрхэн авч ирсэн талаар хувийн түүхээсээ хуваалцъя. Надад хайрлаж чаддаггүй хамаатны нэг хүн байдаг байлаа. Түүний хажууд байхад тэр хүний зарим зүйлд гараараа цохилт өгч няцаамаар болдог үе ч байв. (Таныг ийм болгодог хүн байдаг уу?). Бурханы үнэнийг бусдад заадаг болсоноос хойш хэсэг хугацааны дараа Эзэн миний зүрх сэтгэлд энэ хүний талаар ийнхүү хэлсэн юм: “Чиний хайргүй хамаатны тухайд чи юу хэлэх вэ? Чи бусдад зааснаа өөрийн хамаатантай харилцах харилцаандаа хэрэгжүүлэх үү?” гэж асуухад миний эхний хариулт “Би тэгж бодохгүй байна.” гэж билээ. Асуудал нь би хамаатнаа хайрлахыг хүсдэггүйд байсан юм. Эзэн дахин надад энэ бодлыг өгөв: “Би чамайг энэ хүнийг хайрлахыг хүсэхгүй байгааг мэдэж байна. Харин чамаар дамжуулан Би энэ хүнийг хайрлах боломжийг чи Надад олгох уу?”. Миний хариулт “Тиймээ, надаар дамжуулан Бурхан Та түүнийг хайрлахыг би зөвшөөрч байна” гэлээ.

Эзэн надаар дамжуулан түүнийг хайрлахыг би Бурханд итгэн даалгаад, итгэлийн алхам болох "итгэл гаргаж" эхэлсэн юм. "Итгэл гаргах" үйл явц маань 18 сар үргэлжлэв. Энэ бүх хугацаанд би нэг ч удаа хамаатандаа хайр хүрэх мэдрэмж төрөөгүй боловч би итгэлээр үргэлжлүүлэн алхсаар байлаа. Энэ явдлын хамгийн сонирхолтой нь 18 сарын хугацаанд тэр хүний надад хандах хандлага хэрхэн өөрчлөгдсөнийг би харсан юм. Тэр надад илүү нээлттэй, элэгсэг болсон байв. Би эдгээр хүмүүсийг хайрлах ямар ч мэдрэмжийг мэдрээгүй байсан болохоор ийм зүйл болоход маш их гайхсан.

18 сарын дараа нэгэн өдөр би хамаатныдаа очихоор явж байтал тэр хүнд хандсан Бурханы болзолгүй хайрыг мэдэрч эхлэв. Миний амьдралд биелэлээ олсон Бурханы ер бусын ажлыг мэдэрсэн гайхалтай өдөр байсан болохоор би энэ өдрийг хэзээ ч мартахгүй. Тэр өдөр би Бурханы өөрчлөлтийн хүч чадлыг гайхаж биширсэн билээ. Энэхүү өөрчлөлт миний болон хамаатнуудын минь Бурханд-бат итгэлтэй байдалд хэрхэн нөлөөлснийг та төсөөлж чадахуу?

Асуулт: Та хайрлаж чадамгүй хэн нэгэн хүн таны амьдралд байдаг уу? Танаар дамжуулан тэр хүнийг Бурхан хайрлахыг та хүлээн зөвшөөрмөөр байна уу? Хэрэв тийм бол та итгэлийн алхам хийж эхлээрэй. Та хангалттай хугацаанд "итгэл гаргасны" дараа та ч мөн адил (над шиг) тэр хүндээ хандсан Христийн хайрыг мэдэрч эхлэх болно. Хэрвээ таниар дамжуулан Бурхан энэ хүнийг хайрлаасай гэж асуухыг хүсэхгүй байвал таны энэхүү хүсэхгүй байдлыг зайлуулж, таниар дамжуулан тэр хүнийг Тэр Өөрөө хайрлах хүсэлтэй болох тэр цэгт авч ирэхийг гуйн залбираарай.

Хангалттай удаан хугацаагаар “итгэл гаргах”-тай зөрчилддөг хоёр шалтгаан

1. Бид ЭГШИН ЗУУРЫН жаргал хөөх соёл дотор амьдардаг



гүйлт биш юм.

Бид "итгэл гаргах" тал дээр зөрчилддөг нэг шалтгаан бол "Би энийг хүсч байна" би "яг одоо" авмаар байна хэмээх “эгшин зуурын” жаргал хөөх соёл дотор амьдардгийн улмаас юм. Би энийг "богино долгионы зуух" соёл гэж нэрлэдэг. Бид итгэлийн алхаандаа яг энэ хандлагаа тээж ирээд өөрчлөлтийг маш хурдан амсаж, хүртэхийг эрмэлздэг. Үнэн гэвэл итгэлийн алхааны ихэнх хэсэг нь аялал болохоос богино зайн

Би танд шударгаар хэлье. **Ихэнх Христитгэгчид Бурханы ер бусын өөрчлөлтийг огт мэдэрдэггүйн №1 шалтгаан энэ гэдэгт би итгэлтэй байдаг.** Тэд өөрчлөлтийг мэдрэхийн тулд хангалттай итгэлийн алхам хийхийг хүсэлгүй маш богино хугацаанд өөрчлөгдөх хүсэлдээ хөтлөгддөг.

Тиймээс л итгэлийн алхаатай холбоотой энэ түлхүүр асуултыг та өөртөө тавих хэрэгтэй болдог:

Өөрчлөлтийг АМСАХЫН тулд та хангалттай урт хугацаанд “ИТГЭЛ ГАРГАХ” уу?

2. Сатан итгэлийн алхааг тань ЗОГСООХ-ын тулд уруу татна

“Итгэл гаргах”-ад үүсдэг хоёр дахь зөрчил бол Сатан танд өөрчлөлт болон чөлөөлөлтийг амсуулахгүй байхыг хүсдэг. Тиймд таныг “итгэл гаргах” үед урам хугалсан, эргэлзээтэй бодлуудыг танд өгч итгэлийн алхааг тань зогсоох гэж уруу татдаг. Учир нь та урам хугарч эсвэл Бурханд эргэлзэх үед ихэвчлэн бууж өгөх төлөвт ордог юм. Бид бүхэн тавдугаар хичээл дээр бидний итгэлийн алхааг бусниулдаг Сатаны оролцоог гүнзгийрүүлэн судлах болно.

Энэ сэдвийн хүрээн дэх дүгнэлт бодол:

“Итгэл гаргах” явцдаа өөрчлөлтийг амсах хүртэл Христийн ТЭСВЭР, ТЭВЧЭЭРЭЭС зуурах хэрэгтэйг санаарай.

Итгэлийн алхмаар явж байхад хэд хэдэн удаа хурдацтай өөрчлөлт огт байхгүй байгаа мэт санагдаж тэвчээр алдан бууж өгөх шахаж байснаа санадаг юм. Яг иймэрхүү сэтгэгдэл төрөх болгонд Христ миний тэсвэр, тэвчээр байхыг би гуйдаг байлаа. Энэ нь хэрхэн харагдаж болох жишээг үзүүлье.

Жишээ: “Эзэн, би итгэлээр нилээн алхаж байгаа боловч ямар нэг өөрчлөлтийг мэдрэхгүй байна. Миний тэвчээр барагдаж байна. Та миний тэсвэр, тэвчээр БАЙХ болно гэдэгт би итгэж байна. Та миний хүслийг хөдөлгөөч. Тэгээд би итгэлийн алхам үргэлжлүүлэн хийх болно.”

Бид өөрчлөлтийг мэдрэх хүртэл хир удаан “итгэл гаргах” ёстойг би та нарт хэлж чаддаг ч болоосой. (Хэрэв Бурхан танд хэлбэл, та надад мэдэгдээрэй). Бид өөрчлөгдөхийг хүлээх зуур Бурхан бидний итгэлийг өсгөж байдаг гэдгийг сурсан билээ. Тиймээс энэ хичээлийн үлдсэн хэсэгт “итгэл гаргах”-аас Бурханы өөрчлөлтийн ажлын "бодит туршлага" руу шилжих зарчмыг хэрэгжүүлээрэй. Бидний худал итгэл үнэмшил, гэмт зуршил, шархыг эдгээж өөрчлөх үнэнүүдийг хэрэгжүүлж эхлэхээс өмнө миний хувийн алхаандаа дахин дахин ашигладаг түлхүүр "итгэл"-ийн үгийг харцгаая.

ХОЁР ДАХЬ ӨДӨР

Өөрчлөлтийн үйл явцын түлхүүр "ИТГЭЛ"-ийн үг: ИТГЭН ДААТГАХ



"Тэр зүхэгдэж байхдаа, хариуд нь зүхээгүй. Тэр зовон тарчилж байхдаа заналхийлээгүй, харин шударгаар шүүдэг Нэгэнд Өөрийгөө даатгасаар байлаа."

1 Петр 2:23

Та Христитгэгч хүн бол “итгэл”-ийн үгнүүд болох итгэн найдах, гуйн хүсэх гэх мэт үгсийг мэддэг гэсэн үг. Бидэнд “**итгэн даатгах**” гэдэг бас нэг хамгийн идэвхитэй итгэлийн үг байдаг билээ. Итгэн даатгах гэдэг энэ үг нь ямар утгатай вэ?

ИТГЭН ДААТГАХ

Зуурч байгаа хэн нэгэн эсвэл ямар нэг зүйлээ найдвартай хадгалуулахын

тулд Бурханд өргөн барих

Бурхан хэзээ ч эзэмш гэж өгөөгүй харилцааны зөрчил, ярвигтай нөхцөл байдлуудаас зуурсаар байдаг нь олон Христитгэгчдийн асуудал болдог билээ. Эдгээр нь байнгын толгойны өвчин, зовлон, өвдөлтийг бий болгодог. Бурхан таны зөрчлийг өөрөөр чинь шийдүүлэхийг зорьдоггүй. Бурхан танд үүссэн зөрчил, тэмцэл, нөхцөл байдал бүрийг Өөрт нь итгэн даалгаасай хэмээн хүсдэг юм. Яагаад? Учир нь таны зөрчлийг зохицуулж чадах цорын ганц Нэгэн бол Бурхан юм.

Үүнийг тодруулахын тулд би энэ жишээг олон ашигладаг. Би очих дуртай нэг Мексик ресторан байдаг юм. Тэд хоол авчирч өгөхдөө өөрсдөө бээлий өмссөн байдаг ба тогоо халуун гэж надад сануулдаг байлаа. Нэгэн өдөр, би шаазан аяга халуун гэдгийг мартаад бариад авсан юм. Өвдөлт тэр дороо мэдрэгдэлгүй яахав. Энэхүү халуун шаазан таны өдөр тутамдаа туулдаг гадаад ба дотоод зөрчил гэж төсөөлье. Хэрэв та шаазангаас зуураад байвал яах вэ? Тэгвэл та өвдөлтийг үргэлжлүүлэн мэдрээд л байх бөгөөд үүнээс үүдсэн зовлон зүдгүүр үүснэ. Миний хэлэх гээд буй санаа бол та асуудлаа энэхүү халуун шаазантай зүйрлэх хэрэгтэй. Бурхан таныг үүнээсээ зуураад байхыг чинь хүсдэггүй. Харин Бурхан таныг асуудлаа Өөрт нь итгэн даатгаж Түүгээр шийдүүлэхийг чинь хүсдэг.

Үнэн нь та гадаад ба дотоод зөрчилтэй асуудлынхаа шийдвэрлэгч нь байхаар БҮТЭЭГДЭЭГҮЙ. Бурхан эдгээр бүх асуудал нэг бүрээ Түүнд ИТГЭН ДААТГАДАГ байлгахыг зорьдог юм.

Бурхан таныг өөрчлөхийн тулд таниас худал итгэл үнэмил, гэмт зуршил, шархаа Түүнд итгэн даатгахыг чинь хүсдэг талаар үлдсэн хичээлээр ярилцах болно. Иймээс Бурханы амласан өөрчлөлтийн төлөөх итгэлийн алхмын тухайд “итгэн даатгах” гэдэг үгийг хэрэгжүүлэхэд суралцах болно.

Бурханы амладаг өөрчлөлтийг амсахын төлөөх итгэлийн алхам ямар харагддаг вэ?

Доорх Бурханы хүч чадлыг амсахын төлөөх итгэлийн алхам хэрхэн хийхийг энэ удаагийн болон дараагийн хичээлээс сурах болно. Бурханы хүч чадал нь:

- Худал итгэл үнэмшлээс илүү үнэнд итгэх итгэл рүү **ШИНЭЧИЛДЭГ**. Ром 12:2
- Гэмт зуршил, махан биеийн зан чанарыг ялах **ЯЛАЛТ**, **ЭРХ ЧӨЛӨӨГ** өгдөг. 1 Коринт 15:57, Иохан 8:32
- Таны шархыг **ЭДГЭЭДЭГ**. Дуулал 147:3

Итгэлийн алхам болон Бурханы амлалтыг ойлгох Түлхүүр Үнэн

Бурханы амлалт руу хүрэх итгэлийн алхааг хэрэгжүүлж эхлэхийн өмнө бидний сурч буй амлалт болон итгэлийн алхааны талаарх түлхүүр үнэнийг ойлгох нь чухал юм. Эдгээрийг би цаашид хэд хэдэн удаа давтан хэлэх болно.

1. Итгэлийн алхаа бол **ҮЙЛ ЯВЦ** гэдгийг ойлгох нь хамгийн чухал. Энэ бол аялал болохоос богино зайн гүйлт биш.
2. Үүний улмаас таны бодол санаа, мэдрэмж, сонголт, үйлдэл өөрчлөгдөхийг мэдэрч эхлэхээс өмнө та **НИЛЭЭН ХЭДЭН УДАА** итгэлийн алхам хийх хэрэгтэй болж магад.
3. Та итгэлийн алхам хийж эхэлмэгц Бурханы хүч чадал тан руу урсан ирж буйг шууд **АМСАЖ** эсвэл **МЭДРЭХ**-гүй байж болохыг санаарай.
4. Таны амьдралыг өөрчлөх Түүнийг **ХҮЛЭЭСНЭЭР** Бурхан танд итгэлийг заадаг юм.
5. Та итгэлийн алхам хийхгүй бол Бурханы өөрчлөлтийн амлалтыг **ХЭЗЭЭ Ч** амсахгүй.

Итгэлийн алхаа ба оюун бодолдоо ШИНЭЧЛЭГДЭХ нь



"Энэ үеийн явдалд бүү нийцэгтүн. Харин зүрх сэтгэлээ шинэчилснээр өөрчлөгдөж..."
Ром 12:2

Христитгэлийн амьдралд бид бүгд худал итгэл үнэмшилтэй зөрчилдөж байдаг. Бурханы тухай, бусдын тухай, гэрлэлт болон Христитгэлийн амьдралын тухай гэх мэтчилэн цөөхөн хэдээс нь дурьдахад л бид бүгдээрээ эдгээр зүйлсийн талаар худал итгэл үнэмшлийг тээчихсэн явж байдаг. (Энэ хичээлийн төгсгөлд байгаа худал итгэл үнэмшлийг жагсаан бичсэнийг үзнэ үү) Эдгээр худал итгэл үнэмшил нь гэмт зан чанар, эргэлзээ, үл итгэлийг бий болгодог төдийгүй итгэлийн алхааг хүртэл зогсооход хүргэж чадна. Тэгвэл худал итгэл үнэмшлийг тодорхойлъё.

ХУДАЛ ИТГЭЛ ҮНЭМШИЛ гэдэг нь

Бурханы үнэнтэй нийцэхгүй ЭСРЭГЦЭЖ байгаа аливаа итгэл үнэмшлийг хэлнэ.

“Та итгэж байгаа зүйлийнхээ хил хязгаараас давж амьдарч чадахгүй. Та худал хуурмагт итгэвэл яг тэр зүйлийнхээ дагуу л амьдрах болно” гэж би өмнө нь хэлж байсныг санаарай. Хэрвээ бид Бурханаар бодол санаагаа үнэн руу шинэчлүүлэхийг зөвшөөрөхгүй бол бид худал хуурмагийн хүлээсэнд байсаар байх болно. Энэ хүлээс биднийг худал бодол, буруу сонголт, махан биеийн зан чанар дотор үргэлжлүүлэн хазаарласаар байна. Гэтэл таны оюун бодлыг шинэчлэх Бурханы зорилго бол худал итгэл үнэмшлийг тань Түүний үнэнээр сольж чөлөөлөх нь юм. Тэрээр үүнийг биелүүлж өгсний үр дүнд таны бодол, сонголт, махан биеийн зан чанар өөрчлөгддөг.

Тиймд Ром 12:2 ишлэлийн дагуу оюун бодол дотроо шинэчлэгдсэн байх амлалт нь өөрчлөлт ба итгэлийн алхаанд маш чухал үүрэгтэй болно. Бид цааш үргэлжлүүлэхээс өмнө дараах түлхүүр үнэнийг ойлгох хэрэгтэй.

ТҮЛХҮҮР ҮНЭН

ТА оюун бодлоо Бурханы үнэн руу өөрийн чадлаар ШИНЭЧИЛЖ чадахгүй.

ЗӨВХӨН БУРХАН шинэчлэл ба өөрчлөлтийг гүйцэтгэж чадна

Олон Христитгэгчид өөрсдийнхөө бодол санааг өөрсдөө шинэчилж чадна гэж ойлгодог. Бодит үнэн бол зөвхөн Бурхан л үүнийг хийж чадна. ЕСҮС Иохан 15:5 ишлэл дээр иш татан хэлснээр “Учир нь Надаас салангид байвал та нар юу ч хийж чадахгүй.”. Тиймээс худал итгэл үнэмшлийг харуулсан жишээнүүдээс таны оюун бодлыг шинэчлэх Бурханы хүч чадалд холбогдохын тулд ямар итгэлийн алхам хийж болохыг харцгаая.

Жишээ 1: Өнөөг хүртэл Христитгэлт амьдралаар амьдрахад Бурханы хэсэг тусламжыг аваад өөрөө болгочихно гэж буруу ойлгосон байна гэж төсөөлье. Галат 2:20 ишлэлийн дагуу таны дотор буй Христ л Христитгэлт амьдралыг амьдарч чадна гэдэг үнэнийг ойлголоо. Энэ үнэн рүү оюун бодол тань шинэчлэгдэхийн тулд Бурхантай итгэлээр холбогдож та чадна.

Итгэлийн алхам: “Эзэн, би Таны тусламжтай Христитгэлт амьдралаар амьдарч чадна гэсэн худал хуурмагт итгэжээ. Үнэн гэвэл би тэгж чадахгүй. Тиймээс Бурхан, танд эдгээр худал ойлголтыг **итгэн даатгаж байна**. Зөвхөн Та л Христитгэлт амьдралыг надаар дамжуулан миний дотор амьдарч чадна гэдэг үнэн руу миний оюун бодлыг шинэчилж **өгөхийг гуйн залбирч байна**. ”

Жишээ 2: Таныг гэм нүгэл үйлдэх эсвэл бүтэлгүйтэх үед Бурхан таныг буруутгаж эсвэл шүүдэг гэсэн худал итгэл үнэмшилд та итгэдэг гэж төсөөлье. Ром 8:1 ишлэл дээр хэлсэн үнэн бол өнгөрсөн, одоо, ирээдүйн бүх гэм нүгэл уучлагдсан учраас Бурханаас ирэх ямар ч ял буруутгал байхгүй гэсэн байна. Тэр бүх гэм нүгэл загалмай дээр цовдлогдсон Христийн үхлээр төлөгдсөн бөгөөд цаашид Бурхан дахин санахааргүй уучилсан юм.

Итгэлийн алхам: “Эзэн, би гэм нүгэл үйлдэх эсвэл бүтэлгүйтэх үед Та намайг шийтгэнэ гэдэг худал итгэл үнэмшилд итгэсэн байна. Би таны өмнө энэ гэмээ улайж, гэмшиж байна. Танд худал итгэл үнэмшлээ **итгэн даатгаж байна**. Би гэм нүгэл хийх үед Бурхан та намайг буруутгаж, ялладаггүй гэдэг үнэн руу миний оюун бодлыг шинэчилж өгнө гэдэгт итгэж байна.”

Чухал санамж: Та гэм нүгэл үйлдвэл гэмээ улайж гэмших шаардлагатай. Гэмээ улайх гэдэг нь та Бурханы өмнө үйлдсэн гэмээ хүлээн зөвшөөрөх бөгөөд гэмших гэдэг нь хийсэн зүйлийнхээ төлөө харамсаж, гэмээсээ эргэж Бурхан дээр дахин эргэж ирэхийг хэлдэг.

Жишээ 3: Хань тань таныг болзолгүй хүлээн зөвшөөрөх ёстой гэсэн худал итгэл үнэмшилд та итгэдэг байжээ. Зөвхөн тодорхой нөхцөл нь сэтгэлд нийцсэн үед л бид бие биенээ хүлээн зөвшөөрөх хандлагатай байдаг учраас бид өөрсдийн мэдлээр үүнийг гүйцэлдүүлж чадахгүй. Тиймээс бидний болзолгүй хүлээн зөвшөөрөл нь зөвхөн Христээс ирдэг юм.

Итгэлийн алхам: "Эзэн, миний хань намайг болзолгүйгээр хүлээн зөвшөөрөх нь түүнээс хамаарна гэсэн худал итгэл үнэмшилд би итгэжээ. Би энэ худал итгэл үнэмшилээ танд итгэн даатгаж байна. Энэ болзолгүй хүлээн зөвшөөрлийн хэрэгцээг Та л хангаж чадна гэдэг үнэн руу миний оюун бодлыг шинэчилж өгөөч"

Дасгал: Энэ хичээлийн төгсгөлд жагсаан бичсэн "Худал итгэл үнэмшил" хэсгийг хараарай. Таны оюун бодолд шинэчлэгдэх шаардлагатай худал итгэл үнэмшилүүдийг сонгоорой. Аль эсвэл Бурхан таныг чөлөөлөхийг хүсч буй худал итгэл үнэмшилүүдээс илчилж өгөхийг гуйгаарай. Тэгээд таны оюун бодлыг шинэчлэх Түүн рүү итгэлийн алхам хийгээрэй. Та доорх жишээг ашиглаж болно.

Жишээ: "Эзэн, би ---- худал хуурмагт итгэж байжээ. Энэ худал хуурмагийг Танд итгэн даатгаж байна. Та миний оюун бодлыг шинэчилж, энэ худал хуурмагийг таны үнэнээр сольж өгөхийг гуйн залбирч байна."

Таны оюун бодлыг үнэн рүү шинэчлэхийг Бурханаас эрэн хайх явцдаа таны бодол, итгэл үнэмшил, сонголтонд Түүний хийж буй өөрчлөлтүүдийг илчилж харуулахыг Түүнээс асуугаарай.

Итгэлийн алхаа ба оюун бодолдоо шинэчлэгдэх талаар: ЧУХАЛ ҮНЭН

1. Таны оюун бодол шинэчлэгдэх нь ҮЙЛ ЯВЦ гэдгийг санаарай. Энэ үйл явц нэг өдрийн дотор болчихдог зүйл биш юм.
2. Та хэтэрхий удаан хугацаагаар тээсэн учраас зарим худал итгэл үнэмшил үнэнээс ХҮЧТЭЙ мэт болчихдог.
3. Тиймээс таны бодол, зан чанарт өөрчлөлт ирэх хүртэл итгэлээр алхахад ТОДОРХОЙ ХУГАЦАА шаарддаг.
4. Та зарим худал итгэл үнэмшилээ өөрөө ч мэддэггүй байж болох тул худал итгэл үнэмшлийг ИЛЧИЛЖ өгөхийг Бурханаас гуйн залбираарай.
5. Таны оюун бодлыг өөрчлөх Бурханыг эрэн хайнгаа таны бодол, сонголт, зан байдлын ӨӨРЧЛӨЛТИЙГ илчилж үзүүлэхийг Бурханаас гуйн залбираарай.

ГУРАВ ДАХЬ ӨДӨР

Махан биеийн зан чанар, хүлээсийг ялах ЯЛАЛТ ба ЭРХ ЧӨЛӨӨГ амсах итгэлийн алхаа

"Бурханаар төрсөн бүхэн ертөнцийг ялдаг. Ертөнцийг дийлсэн ялалт нь бидний итгэл болой."



1 Иохан 5:4

Бидэнд бүгдэд нь ялж, чөлөөлөгдөхийг хүсдэг махан биеийн зан чанар, гэмт зуршил байдаг. Гэвч, бид өөрсдийн хүч, чадвараар уг ялалт, эрх чөлөөг олж авах гэдэг хандлагатай байдаг. Дээр бичсэн Иохан номын ишлэл дээр бидний хүч тэнхээ, нөөц чадамж, сэтгэлийн тэнхээ уг ялалтыг авчирдаг гэж хэлээгүй байгаа нь сонирхолтой биш байна гэж үү? Ялалт итгэлээр дамжуулж ирдэг. Христ бол бидний ялалт, эрх чөлөө ба итгэлээр Түүнд найдсанаар Тэр бидний гэмт зуршил, махан биеийн зан чанарыг ялах ялалтыг бий болгож өгдөг. Бурханы өгдөг ялалт, эрх чөлөөний үйл явцыг ярилцахаас өмнө махан бие, махан биеийн зан чанар, хүлээс зэрэг үгнүүдийн утгыг харцгаая.

МАХАН БИЕ гэж юу вэ?

Ром 7-р бүлэг дээр Паул өөрийн махан биеийг тайлбарлажээ.

"Учир нь Хууль бол сүнслэг гэдгийг бид мэддэг. Харин би махан биетэй бөгөөд нүглийн боолчлолд худалдагдсан." Ром 7:14

"Учир нь миний дотор буюу миний махан биед ямар ч сайн зүйл байдаггүйг би мэддэг. Учир нь хүсэл нь миний дотор байвч, харин сайныг хийх нь үгүй." Ром 7:18

Махан биеийг бид хэрхэн тодорхойлох вэ?

“Махан Бие” гэдэг үгийн Библийн утга нь Эх сурвалж болсон Бурханаас САЛАНГИД, БИЕ ДААН амьдралынхаа эх сурвалж нь ӨӨРӨӨ болж амьдрах гэсэн хүний ХҮСЛИЙГ хэлдэг.

Аврагдахаасаа өмнө бид асуудлыг шийдэх, амьдралыг туулах, амжилт олох зэрэгт өөртөө л (махан бие) найдахаас өөр замгүй байсан билээ. Бид Эх Сурвалж болсон Бурханаас салангид өөрийн эх сурвалжаар (боловсрол, оюуны потенциал, хувь чанар, гадаад дүр төрх, авъяас чадвар, чадамж, нөөц бололцоо, хувийн сахилга бат, өөрийн тэнхээ) амьдарч явсан. Ингэж амьдарсны үр дүнд бид өөрсдөө амьдралынхаа эх сурвалж БАЙХ хүслээ өөгшүүлдэг байлаа.

Бурхан биднийг 2 зорилготойгоор аварсан. Нэгдүгээрт, Бурхан биднийг гэм нүглээс аврахыг хүссэн. Хоёрдугаарт, Библи дээр тодорхойлсон “махан бие” гэгч өөрсдөөс минь аврахын тулд Бурхан бидэнд Өөрийн амь ба хүч чадлыг өгсөн. Би "хувийн-амьдрал" гэдэг зүйлийг "Энэ бол МИНИЙ л тухай" гэх хандлага гэж нэрлэдэг.

(Санамж: Бурхан хүн тус бүрт оюуны потенциал, авъяас чадвар, чадамжийг өгсөн гэдгийг онцлох хэрэгтэй гэж бодлоо. Гэхдээ Түүнээс **хамаарахгүй** авъяас чадвар, чадамжаараа амьдрах зорилгын төлөө Бурхан тэдгээрийг өгөөгүй юм.)

Махан биеэсээ эхтэй амьдрах нь Бурханаас хамааралгүй амьдрах хүслийг ҮРГЭЛЖ төрүүлдэг. Бид Бурханаас хамааралтай байхаар БҮТЭЭГДСЭН-ээс хойш махан биеэс эхтэй амьдрахыг СОНГОВОЛ Бурханы амлалтыг амьдралдаа хэзээ ч хүртэхгүй.

Би таниас хоёр асуулт асууя. “Дотоод, гадаад асуудлууд, амьдралын тань талбарт үүсч байгаа зөрчлүүдийг шийдвэрлэхийн тулд та Түүний өгсөн авъяас чадвар, чадамж, сэтгэлийн тэнхээ зэргийг Бурханы оролцоогүйгээр ашиглаж байх боломжтой юу?” “Христитгэлт амьдралыг та өөрийн хүчин чармайлтаар авч явах гэж хичээж байна уу?” Хэрэв тийм бол өөр нэг асуулт асууя:

ЭНЭ БҮХЭН ЧИНЬ ТЭГЭЭД ХИР ҮР ДҮНТЭЙ БАЙНА ВЭ?

Бурхан амьдралд ЗАГВАРЧИЛСАН бүхэн Түүнээс ХАМААРАЛТАЙ амьдраагүй цагт ХЭЗЭЭ Ч горимондоо байхгүй юм.

Махан биеийн шинж чанар

Махан биеийн талаар сайн ойлголт өгөхийн тулд махан биеийнхээ шинж чанарыг судалцгаа.



“Махан бие” бол бие даах гэсэн **хандлага** ба ингэж хэлдэг:

- Би удирдлагыг гартаа байлгаж чадна
- Би хэрэгцээндээ хүрч чадна
- Би бүх асуудлыг зохицуулж, шийдэж чадна
- Би гэрлэлт, ажил, санхүү гэх мэт нөхцөл байдал тус бүрийг өөрийнхөөрөө зохицуулж чадна.
- Би амжилттай байж чадна
- Би өөрөө өөрийнхөө бурхан нь байж чадна.

Махан биеийн дотор амьдрах ХҮСЭЛ нь өөрөө маш хүчтэй тул махан биеийн хүсэл биднийг үргэлж Бурханаас САЛАНГИД амьдруулж, "БИ ЧАДНА" гэхэд хүргэдэг

Махан биеэс эхтэй амьдрал махан биеийн авирыг бий болгодог.

Махан биеэс эхтэй амьдралын үр дүн бол МАХАН БИЕИЙН АВИР

"Эдүгээ **махан биеийн үйлс** нь илэрхий юм. Эдгээр нь завхайрал, бузар байдал, тачаангуй байдал, шүтээн шүтэх, ид шид, дайсагнал, маргаан, хардалт, уур хилэн, өрсөлдөөн, хагарал, тэрс үзэл санаа, атаархал, архидалт, утга учиргүй наргиж цэнгэх **зэрэг нь юм..**"

Галат 5:19 – 21а

Махан биеэс эхтэй амьдрахын өөр нэг сөрөг үр дүн бий. Галат 5:19 – 21 дээр жагсаасанчлан энэ нь **махан биеийн хандлага, махан биеийн авир** гэх мэт "махан биеийн үйлс"-ийг л ургуулдаг.

МАХАН БИЕИЙН АВИР нь

Бурханаас САЛАНГИД амьдарсаны үр дүнд илэрдэг аливаа ааш авир юм.

Махан биеийн авир, хандлагууд бол худал итгэл үнэмшлийн бялхал юм. Тэдгээр нь хоёр үндсэн хэлбэрээр илэрдэг: **эерэг** махан бие ба **сөрөг** махан бие. Эерэг ба сөрөг махан биеийн жишээг дор үзүүлэв.



бол “би өөрөө” юм.

Сөрөг махан биеийн жишээ: Уур хилэн, сэтгэл ханамжгүй байдал, уучлахгүй байх, атаархал, айдас, санаа зоволт

Эерэг махан биеийн жишээ: Өөртөө-итгэлтэй байдал, өөрийн хүч чадалд хэт итгэх, өөртөө-сэтгэл ханасан шинжтэй, амжилт, өөрийн гэсэн хүчирхэг үзэл бодол

Санамж: Эерэг махан бие нь илүү сэтгэл татам харагддаг тул танихад маш хэцүү боловч үүнийг махан биеийн зан авир биш гэж ойлгож болохгүй. Эерэг махан биеийг тодорхойлогч түлхүүр үг

Дасгал: Энэ хичээлийн хамгийн сүүлийн хуудсанд байгаа махан биеийн зан авирын жагсаалтыг уншаад танд хамгийн танил таван махан биеийн авирыг бичээрэй.

ДӨРӨВ ДЭХ ӨДӨР

Махан биеийн зан авираар амьдарсаны ҮР ДҮН юү вэ?

Махан биеийн зан авираа даган амьдрахыг сонговол Библи бидэнд эцэст нь ямар үр дүнд хүрч болохыг Ром 8:6 дээр хэлсэн байна. Эцсийн үр дүн нь **үхэл юм**.

"Махан биеийн бодол санаа бол ҮХЭЛ, Сүнсний бодол санаа бол амь ба амар тайван болой."
Ром 8:6

Үхлийг “гэм нүглийн үр дүнд бий болсон оюун санааны эмгэг” гэж Стронгийн Лексикон тайлбар орчуулга дээр тодорхойлсон байна. Хэрвээ та махан биеийн зан авир, хандлагаар үргэлжлүүлэн амьдарсаар байвал зайлшгүй үр дүн нь таны оюун санаа “эмгэг”-тэй болох болно.

Оюун санааны "эмгэг"-ийг тодорхойлсон зарим жишээг дор харуулав.

Буруутгал	Уур хилэн	Айдас	Аюултай байдал
Уйтгар гуниг	Сэтгэл ханамжгүй	Гологдмол	Үл уучлал
өөрийгөө өрөвдөх	Ял зэмлэл	Ичгүүр	Хорсол зэвүүцэл
Үнэцэнэгүй	Түгшүүр	Бухимдал	Бүтэлгүйтэл
Стресс	Гэм буруутай	Санаа зовнил	Сэтгэл гутрал

Асуулт: Та эдгээр жагсаалтыг уншаад танд оюун санааны эмгэгийн шинж тэмдэг байна гэж бодож байна уу?

Би махан биеийн зан авиртаа автаж, нэг хэсэгтээ тийм хэвээр амьдрахыг "төөрсөн хүүгийн гахайн оромж" руу орлоо гэж нэрлэдэг. Бие даан амьдрахаар шийдээд явсан боловч гахайн оромжинд очдог төөрсөн хүүг санаж байна уу? Бид махан бие рүүгээ эргэхэд яг ийм зүйл болдог. Ингэхдээ бид төөрсөн хүү шаварт "хөрвөөдөг" шиг махан биеийн балчигт унадаг. 2 Петр 2:22 ишлэл дээр энэ үнэнийг онцолжээ.



"Тэдний хувьд **"Нохой бөөлжсөө долоодог, гахайг угаасны дараа шаварт буцаж хөлбөрдөг"** хэмээх үнэн сургаалт үгийн дагуу тохиолдсон аж." 2 Петр 2:22

Нохой бөөлжсөө долоодог эсвэл гахай шавартаа буцаж хөлбөрдөг гэдэг нь махан биеийн зан авираар амьдрахын тод зураглал юм. Энэ нь ийм бохир зүйл юм бол бид яагаад байнга махан биеэсээ зууралддаг вэ? Учир нь бид энэ байдалдаа дасал болсон байдаг. Бид бүр махан биеийн эмгэгтэйгээ эвлэрчихсэн, үүнээсээ салж амар тайвны бүсээсээ гарах дургүй болсон байдаг. Энэ нь танд асуудал мэт санагдаж байна уу? Тийм байгаасай гэж найдаж байна.

Бурхан таныг махан биеийн зан авираас чөлөөлөхийг хүсдэг. Түүний хүч чадал дотор итгэлээр алхах нь шавхайндаа хөлбөрсөн байдлаас гарах цорын ганц АРГА ЗАМ юм.

Одоо хүлээс гэдэг нь ямар утгатай болохыг харцгаая.

ХҮЛЭЭС – махан биеийн бодол, итгэл, үйлдлийн өөгшмөл, давтамжтай зүришл

Бид бүгд махан биеийн зан авир гаргадаг ба тэдгээр зан авирууд бидний амьдралыг их бага хэмжээгээр атгачихсан байдаг. Биднийг маш хүчтэй атгагч тэдгээр зан авируудыг би "хүлээс" гэж нэрлээд байгаа юм. Хүлээсийг би дараах байдлаар тодорхойлдог.

ХҮЛЭЭС:

Та чөлөөлөгдөнө гэж огт итгэдэггүй, таныг хүчтэй атгасан махан биеийн зан авирууд

Хүлээсийн тодорхой жишээнүүдээс дурдвал - порнограф, замбараагүй идэлт, мансууруулах бодисын хэрэглээ. Угжирсан айдас, сэтгэл түгшил, бардам зан, өөртөө итгэлтэй байдал, уур хилэн бас л хүлээсийн жишээ. Эдгээр хүлээсээс чөлөөлөгдөхтэй холбоотой Бурханы үнэнийг харцгаая.

Бурханы эрх чөлөөний амлалт

Махан биеийн зан авир болон хүлээсээс чөлөөлнө гэж Бурхан амласаныг Иохан 8:32 ишлэлээс уншъя.



"Тэгээд та нар үнэнийг ойлгож, үнэн та нарыг чөлөөлнө"

Энэ ишлэл дээр хэлж байгаа "ойлгох" гэдэг үг нь оюун ухааны мэдлэг биш. "Ойлгоно" гэдэг нь Библийн үнэнийг Ариун Сүнс хувьчлан илчлэхийг хэлнэ. Үүнийг бас бодоод үзээрэй. Иохан 14:6 ишлэл дээр Есүс "Би бол зам, үнэн, амь мөн." гэж хэлжээ. Ариун Сүнс бидэнд Түүний Үгийн илчлэлтийг өгөхөд бид итгэлийн алхам хийж, үнэн болсон Христ биднийг чөлөөлнө.

Биднийг чөлөөлөх Бурханы ХҮЧ ЧАДАЛ, Христийн ЭРХ ЧӨЛӨӨНӨӨС зуурч итгэлийн алхам хийх үед бид хүссэн эрх чөлөөгөө ЭЦЭСТ НЬ амсах болно.

Сайхан мэдээ гэвэл таныг чөлөөлөх Бурханы хүч чадлаас давсан хүчтэй хүлээс гэж байхгүй. Миний хүлээс болсон порнограф, сэтгэл түгшил, айдас, шүүмжлэлтэй ханддаг хандлагаас Бурхан намайг чөлөөлсөн учраас би үүнийг хүчтэй гэрчилж чадна. Бурхан таны амьдралд яг адил зүйлийг үйлдэх болно. Махан биеийн зан авир ба хүлээсээс чөлөөлөгдөхийн тулд хийх итгэлийн алхмын жишээг харцгаая.

Махан биеийн зан авир ба хүлээсээс чөлөөлөгдөх итгэлийн алхам

Жишээ 1: Таныг гэнэт огцом уурладаг хүн гэж бодъё. Бурхан таныг энэ уур хилэнгээс чөлөөлнө гэж амласан. Таныг чөлөөлөх Бурханы хүч чадлыг авч ирэх итгэлийн алхам хэрхэн харагдах бол?

Итгэлийн алхам: “Эзэн, би уураа барьж чаддаггүй. Махан биеийн байдал болсон уур хилэнг Танд даатгаж байна. Та намайг уур хилэнгээс чөлөөлнө гэдэгт итгэж байна. Миний уурлан хилэнгэх хүслийг надаас зайлуулж өгөөрэй.”

Чухал ойлголт: Таны уур хилэнгийн хэмжээ, хир гүнээс хамааран таны чөлөөлөгдөх хугацаа харилцан адилгүй байна. Та маш их ууртай нэгэн бол үүнээс чөлөөлөгдөхийн тулд илүү их хугацаа шаардлагатай болно.

Хүлээсийн талаар жишээг дор харуулсан ба хүлээсээс чөлөөлөгдөх итгэлийн алхам ямар байхыг харцгаая.

Жишээ 2: Таныг порнограф үздэг донтон гэж бодъё. Үүнээс чөлөөлөгдөхийн тулд хэрхэн итгэлийн алхам хийх вэ?

Итгэлийн алхам: “Эзэн, би өөрөө өөрийгөө порнограф үзэхээс чөлөөлж чадахгүй, хүчгүй сул дорой нэгэн. Та өөрийн хүч чадлаараа намайг энэ хүлээсээс чөлөөлж эхлэхийг гуйн залбирч байна.”

Санамж: Та хэд хэдэн удаа итгэлийн алхам хийхийг оролдсон боловч та ямар ч бодит эрх чөлөөг мэдрээгүй байж болох юм. /Хэдийгээр бид Бурханы хүч чадлыг хором мөч тутам мэдрээгүй ч гэсэн таны итгэлээр дамжуулан Бурханы хүч чадал таны дотор ажиллаж байгаа гэдгийг санаарай./ Энэ үеийн итгэлийн алхам ийм байж болох юм.

Итгэлийн алхам: “Эзэн, би хэд хэдэн удаа итгэлийн алхам хийх гэж оролдлоо. Порнограф үзэхээс чөлөөлөгдөхгүй байна. Цаашид итгэлээрээ алхсаар байх хүч чадал, тэсвэр тэвчээр минь Бурхан Та БАЙХЫГ гуйн залбирч байна.”

Энэхүү үйл явцын хажуугаар өөр нэгэн итгэлийн алхам хийх жишээ нь:

Итгэлийн алхам: “Эзэн, хэдийгээр Таны хүч чадал миний дотор ажиллаж байгаа гэдгийг мэдрэхгүй байгаа ч гэсэн Та намайг порнограф үзэхээс чөлөөлөхийн тулд ажиллаж байгаад итгүүлээч.”

Итгэлээрээ үргэлжлүүлэн алхсаар байвал, та нэг л өдөр өөрийгөө порнограф үзэхээ больсоноо мэдэх болно. Гэвч бууж өгөн үүнийг дахин хийх тохиолдол ч үүсч болно. Олон удаагийн ялагдал таны ялалтын хэмжээг тодорхойлох тул бүү шантар. Ялагдсан үедээ өөрийгөө битгий буруутгаарай. Ийм зүйл тохиолдож болно. Энэ тухай бид дараагийн хичээл дээр тодорхой ярилцах болно. Амжилт, ялалттай байж байгаад ялагдсан үед дараах итгэлийн алхмыг хийгээрэй.

Итгэлийн алхам: “Эзэн, Та намайг чөлөөлж эхэлж байгаад баярлалаа. Хэдийгээр би ялагдаж дахин порнограф үзсэн ч би Таны өмнө гэмшиж байна. Эрх чөлөөг мэдрэх хүртэл явах итгэлийн алхам бол аялал бөгөөд бүрэн чөлөөлөгдөх хүртэл тодорхой хугацаа шаардлагатай гэдгийг дахин дахин сануулж өгөөрэй.”

Итгэлийн алхаа ба Христийн эрх чөлөөг мэдрэх талаар чухал үнэн

1. Гэмт зуршил, махан биеийн зан авирын хир ГҮН ГҮНЗГИЙ болох нь эрх чөлөөг мэдэрч эхлэх хүртэл хир хугацаа орохыг зарим талаар харуулдаг.
2. Итгэлийн алхам хийж байх явцдаа та гэмт зуршил, махан биеийн зан авиртаа олон удаа ялагдаж байгааг харах болно. Маш түргэн хугацаанд та чөлөөлөгдөж ЧАДАХГҮЙ тул ингэх нь асуудал биш шүү. Гэм үйлдсэн мөчид Бурханы өмнө ГЭМШЭЭД цаашид үргэлжлүүлэн итгэлээр алхаарай.
3. Бодит үнэн бол эрх чөлөө нь туршлага болтол маш олон удаа ялагдах болно. Та итгэлээр үргэлжлүүлэн алхсаар байвал ЗААВАЛ Христийн эрх чөлөөг мэдрэх болно.
4. Сүнсээрээ СОНОР СЭРЭМЖТЭЙ байж Бурхан хэрхэн таныг чөлөөлж байгааг илчилж өгөхийг Бурханаас гуйн залбираарай.

Угжирсан айдсаас чөлөөлөгдсөн хувийн түүх

40 гаруй жил би их айдастай амьдардаг байсан ба эрх чөлөөг мэдрэхийн тулд би хэд хэдэн удаа итгэлийн алхам хийсэн. Бурхан бол миний амар тайван гэдэг үнэнийг мэдэх мэдлэгээс энэ үнэнд зайлшгүй итгэх итгэл руу би шилжлээ. Тэгээд маш аажуухан миний айдас алга болж эхэлсэн юм. Энэ үйл явцын дунд маш олон удаа би түгшүүрт нөмрүүлж байлаа. Тэдгээр мөчүүдэд би түгшсэнийхээ төлөө улайн гэмшиж, итгэлээр алхахаа үргэлжлүүлсээр байв.

Бурхан бол миний амар тайван, хэмжээлшгүй удирдагч, Түүний гарт бүх зүйл байгаа гэдэгт итгүүлэх тусам би угжирсан айдастайгаа үргэлжлүүлэн амьдрах шаардлагагүй гэдгээ ойлгосон. Гэхдээ энэ нь зарим нэг нөхцөл байдалд айж түгшдэггүй гэсэн үг биш юм. Харин байнгын угжирсан айдсын нөхцөл байдал, хандлагаасаа чөлөөлөгдсөн гэсэн үг юм. Энэ бол аялал байсан бөгөөд өнөөдөр мэдэрч буй эрх чөлөө минь итгэлээр үргэлжлүүлэн алхсаны үнэ цэнийг бий болгосон юм.

Дасгал: Та чөлөөлөгдөхийг хүсч байгаа хүлээс, махан биеийн зан байдлаасаа 3-ыг бичнэ үү.

Бурхантай хамт алхах нь: Итгэлийн алхам хийж эхлэн Бурханаас чөлөөлж өгөхийг гуйн залбираарай. Бууж өгсөн үедээ эсвэл Бурхан таны дотор ажиллахгүй байгаа мэт санагдах үедээ Бурхан та миний хүч чадал, тэсвэр, тэвчээр минь болооч гэж гуйн залбираарай. Таныг чөлөөлж байгаагаас үүдэлтэй жижигхэн өөрчлөлтөнд хүртэл сэргэг байлгахыг гуйн залбираарай.

ШАРХНЫ эдгэрлийг амсах итгэлийн алхам

"Тэр эмтэрсэн зүрхтэй хүмүүсийг анагааж, Тэдний шархыг боодог." Дуулал 147:3

"Учир нь Би чамайг тэнхрүүлэн сэргээнэ, Чамайг шархнаас чинь эдгээнэ" Иеремиа 30:17



Олон Христитгэгчид ямар нэг хэмжээгээр гомдож шархалсан байдлаас болж шаналж байдаг. Шарх үүсгэсэн шалтгаан нь янз бүр байдаг.

- **Хүчирхийлэл** – бие махбодийн, үгэн, сэтгэлзүйн, бэлгийн
- **Шок** – гэр бүл салалт, үхэл хагацал, ганцаардал гэх мэт
- **Осол** – өвчин зовлон, гэмтэж бэртэх гэх мэт

Ямар нэгэн шархлуулам үйл явдал болсон болохоор шарх үүсдэггүйд гол асуудал байдаг. Ямар нэгэн таагүй үйл явдлын нөлөөгөөр **худал итгэл үнэмшил** бий болох нь шарх үүсгэдэг юм.

Нэгэн жишээг авч үзье. Аавдаа хүчирхийлүүлсэн нэгэн эмэгтэйг би дагалдуулдаг байв. Хүчирхийллээс болоод энэ эмэгтэй өөрийгөө бузар, үнэ цэнэгүй гэж боддог болжээ. Энэ эмэгтэй Христитгэгч залуутай учирч гэрлэсэн байна. Гэрлэсэн залуу нь маш бурханлаг нөхөр байсан ба түүнийг хайр халамжаар дутаагаагүй боловч бузарлагдсан, үнэ цэнэгүй гэдэг худал итгэл үнэмшлээсээ болоод тэр эмэгтэй хэзээ ч бэлгийн таашаалыг мэдэрч үзээгүй байв. Эцэст нь түүнийг хүрээлсэн худал итгэл үнэмшлээс эмэгтэй хэзээ ч эдгэрээгүй учраас гэрлэлт нь нурсан юм.

***Бурхан таны шархтай холбоотой худал хуурмагаас ЧӨЛӨӨЛЖ, ОЮУН БОДЛЫГ тань
Өөрийн үнэн руу шинэчилснээр таны шархыг эдгээнэ гэж амладаг.***

Бурхан хэрхэн эдгээдэг болохыг харъя. Ямар нэгэн шархлуулам үйл явдалд гол шалтгаан нь байдаггүй гэдгийг санаарай. Тухайн шархлуулам үйл явдлаас үүдсэн худал итгэл үнэмшил бий болох нь л асуудал юм.

ТАВ ДАХЬ ӨДӨР

Шархны эдгэрэлтэй холбоотой итгэлийн алхам

Жишээ 1: Бага байхаасаа ээж аавдаа гологдсон, хүлээн зөвшөөрөгддөггүй гэж итгэж өсчээ гэж бодъё. Энэхүү шархнаас эдгэрэх Бурханы хүч чадлаас зуурах итгэлийн алхам хэрхэн харагдахыг доор харуулсан болно.

Итгэлийн алхам: “Эзэн, би хүүхэд байхдаа үгээр дайрч доромжлуулсан ба миний зүрх сэтгэл маш их шархалсан. Үүнээс болоод би гологдсон, хаягдсан хүүхэд гэж итгэх болсон. Бурхан танд энэ зүрх сэтгэлийн шархыг **даатгаж байна**. Та миний зүрх сэтгэлийг болзолгүйгээр хүлээн зөвшөөрдөг, цаашид би бол хаягдсан хүүхэд гэж итгэхгүй байх талаар Таны үнэнээр миний зүрх сэтгэлийг шинэчилж өгөхийг итгэлээрээ гуйн залбирч байна.”

Жишээ 2: Таныг хүчирхийлэгч ханиас сэтгэлийн шархтай салсан байна гэж төсөөлье.

Итгэлийн алхам: “Эзэн, миний бүтэлгүй гэрлэлт, салалтаас болоод би өөрийгөө үнэ цэнэгүй гэж бодох болсон. Та миний эдгэрэл БАЙНА гэж **итгэж байна**. Би үнэ цэнээ зөвхөн таны дотроос олно гэдгийг үргэлжлүүлэн ятгаж өгөөрэй ”

Санамж: Та шархтай удаан явсан бол Бурханы эдгэрлийг мэдрэхийн тулд тодорхой хугацаа шаардлагатай. Таныг шархлуулж байгаа нөхцөл байдал дунд яг одоо байгаа бол энэ нөхцөл байдал дунд Бурханаас та миний хамгаалалт, хүч чадал минь болохыг илүү итгэлээр санаачлагатай гуйн залбираарай.

Бурхантай хамт алхах нь: Та өнгөрсөнд шархалж байсан туршлага байгаа юу? Тийм бол таны шархыг тойрсон худал итгэл үнэмшлийг Бурханы үнэнээр шинэчлэхийн тулд итгэлээр алхаж эхлээрэй.

Чухал ойлголт: Зүрх сэтгэлийн шархтай холбоотой худал итгэл үнэмшлээ та мэдэхгүй байж болох ч Бурхан мэдэж байгаа. Тийм учраас Бурхан таны зүрх сэтгэлийг шинэчилж чөлөөлөхийн тулд Бурхан дээр очоорой.

Шарх ба үл уучлал

Таныг хэн нэгэн хүн гомдоосон бол шархалсан зүрх сэтгэл, уучлахгүй байдал хоёр атгасан гар шиг нэгдэн таныг хүлж байдаг. Хир гүнзгий шархалсанаас хамаарч хийсэн зүйлийнх нь төлөө тэднийг уучлахгүй байж болно гэсэн худал ойлголттой болох магадлалтай байдаг. Гэвч, энэ нь худал бөгөөд Таныг шархлуулсан тэр хүнийг уучлах Христийн уучлал танд бэлэн байж байдаг. Бидний асуудал бол та тэр хүнийг уучлахыг хүсдэггүйд оршино. Бид нар Библи дээр уучлах ёстой гэдгийг мэддэг боловч бид тэр хүнийг уучлахыг хүсдэггүй. Би 48 жилийн турш аавыгаа уучлахыг хүсээгүй учраас би ямар байдгийг нь мэднэ. Гэхдээ Бурхан Өөрийн ер бусын арга замаар намайг үл уучлалаас уучлал руу хөтөлсөн юм. Бурхан намайг хэрхэн эдгээснийг тантай хуваалцъя.

Аавруугаа хандсан үл уучлалын бодит жишээ

Миний аавын үг хэл, бие, сэтгэлзүйн хүчирхийллээс авсан гүнзгий шархнаас болоод би ууртай, хорссон, уучлахыг хүсдэггүй хүн болсон юм. Эзэн намайг уучлахыг хүсэхгүй байгааг тодорхой мэдэж байсан. Гэвч, Бурхан миний бодлоор дамжуулан надад ингэж хэлэв, “Аавыгаа уучлахыг хүсэхгүй байгааг чинь Би мэдэж байна. Чамаар дамжуулан Би чиний аавыг уучлахыг чи Надад зөвшөөрөх үү?”. Яг энэ үед би аавыгаа уучлахыг хүсэхгүй байсан ч надаар дамжуулан Бурхан аавыг минь уучлахыг зөвшөөрсөн юм. Энэ итгэлийн алхам нэг иймэрхүү байсан:

Итгэлийн алхам: “Эзэн, намайг шархлуулсан, хүчирхийлсэн аавыгаа би уучилж чадахгүй байна. Надаар дамжуулан миний аавыг уучлах миний уучлал БАЙХ-ыг би Таниас **гуйж байна**. Та намайг уучлахыг хүсэхгүй байдлаас уучлахыг хүсэх байдал руу хөтлөн дагуулна гэдэгт би итгэж байна.”

18 сарын турш, аавыгаа уучлахын тулд санаачлагатайгаар Бурханыг итгэлээрээ хайсны үр дүнд Бурхан миний хандлагыг өөрчилж эхэлсэн. Бурхан ер бусын байдлаар 18 сарын эцэст миний хүслийг өөрчилж, надаас аавыгаа уучлахыг зөвшөөрч байна уу? гэж Бурхан асуусан юм. Тэр үед би “тийм” гэж хариулсан. Аавыгаа уучлахыг үргэлжлүүлэн хүссэнээр Бурхан миний уур хилэн, хорслыг Өөрийн хайраар сольсон. Би аавыгаа уучлаад зогсохгүй Ариун Сүнс миний зүрх сэтгэлийг өөрчилснөөр одоо би аавыгаа хайрлаж чадах болсон. Намайг шархлуулсан аавыгаа би хэзээ ч уучилж чадахгүй гэж боддог байсан болохоор би үүнийг Бурхан миний амьдралд бүтээсэн Бурханы хамгийн гайхалтай ер бусын ажлын нэг гэж боддог. Таны зүрх хир гүнзгий шархалснаас үл хамаарч Бурхан яг адил эдгэрлийг бүтээж чадна:

ТҮЛХҮҮР ҮНЭН

Бурхан уучлахыг хүсэхгүй байдлаас уучлахыг хүсдэг байдал руу хөтлөх болно.

Санамж: Уучлалын талаар санах санамж байна. Бурхан ч, би ч аавынхаа хүчирхийлэлд тоомжиргүй хандсан хэрэг биш юм. Энэ бол маш бодитой, шархлам зүйл байсан. Гэвч, Ром 8:28 ишлэл дээр Бурхан бүх зүйлийг бидний сайн сайхны төлөө эргүүлдэг гэсэн байдаг. Бурхан миний хүслийг уучлал руу хөтлөн дагуулсан нь Бурханы хийсэн тэнгэрлэг ажил байсан. Миний авсан шархнаас үлдсэн зарим нөлөөлөл одоог хүртэл үлдсэн байдаг ч гэсэн худал хуурмагийн хүрээллээс ихэнхийг нь Бурхан чөлөөлсөн.

Бурхантай хамт алхах нь: Уучилж чадахгүй гэж боддог нэг хүний тухай бодоорой. Танаар дамжуулан Бурхан тэр хүнийг уучилна гэдэгт та итгэхийг хүсч байна уу? Би хэрхэн итгэлийн алхам хийсэн шиг та итгэлийн алхам хийгээд таниар дамжуулан Бурхан уучилж өгөхийг гуйн залбираарай. Бурхан таны хүслийг өөрчилж чадна гэдэгт итгэснээр та уучлах зүрх сэтгэлтэй болох болно.

ДҮГНЭЛТ БОДРОЛ

Ул уучлал таны доторх Христийн амийн урсгалыг ТАСЛАН ЗОГСООДОГ.

Итгэлийн алхаа ба шархны эдгэрэлтэй холбоотой чухал үнэн

1. Шархлахад шархлуулам үйл явдал нөлөөлдөггүй гэдгийг санаарай. Харин уг үйл явдлаас үүдсэн ХУДАЛ ИТГЭЛ ҮНЭМШИЛ шархлуулдаг юм.
2. Удаан хугацааны шархыг засах “хурдан” арга БАЙХГҮЙ. Олон жилийн турш тээсэн шархыг эдгээхэд удаан хугацаа шаардлагатай байх боломжтой.
3. Эдгэрлийн үйл явц дунд Христийг тэсвэр тэвчээр тань байхаар ЗУУРАХ хэрэгтэй болно.
4. Уучлахыг хүсэхгүй байдлаас уучлалыг хүсэх байдал хүртэл Бурхан таныг хөтөлж удирдахад ХУГАЦАА авах боломжтой. Ялангуяа удаан хугацаанд үл уучлал дунд амьдарсан бол шүү дээ.
5. Бурхан таны зүрх сэтгэлийг шинэчлэх үед та Түүний эдгэрлийг МЭДЭРЧ эхэлнэ.

Итгэлээр алхаж эхлэх эхний үеүдэд САНААЧЛАГАТАЙ байх шаардлагатай болно

Итгэлээр алхаж эхлэхдээ итгэлийн алхам хийх тал дээр САНААЧЛАГАТАЙ байгаарай.

Энэ санааг ойлгомжтой болгохын тулд Матай 7:8 ишлэлийг уншъя.

"эрж хайдаг хүн олно..."

“Эрж хайдаг” гэдэг үг үргэлжилж байгаа цаг дээр хэлэгдсэн байна. Өөрөөр хэлбэл, Есүс энэ ишлэл дээр хэлсэн санаа бол эрж хайх нь байнгын, санаачлагатай байдал юм гэж байна. Би итгэлийн алхам хийж эхэлж байх тэр үедээ зориудаар санаачлагатай хандаж байсан билээ.

Үүнийг би өөрийн жишээг ашиглан тайлбарлая. Тантай хуваалцаж байгаа эдгээр үнэнийг анх сураад Эзэнээр өөрчлүүлэхийг хүссэн зүйл бол миний махан биеийн зан байдал болох шүүмжлэлтэй, өөнтөгч байдал байлаа. Тиймээс энэ зангаа тавихын тулд би санах болгондоо санаачлагатай Эзэнээс асуудаг

болсон. Өөрөөр хэлбэл “санаачлагатай” байх нь асуудалтай талбарыг өөрчлөхийн тулд Бурханыг эрж хайхыг шийдвэртэйгээр хүсэх явдал юм.

Үүнийг анх удаа машины жолоо барьж сурч байгаатай адилтгаж болно. Энэ үед жолоогоо барих, тормос гишгэх, баруун зүүн тийш эргэж сурахад анхаарлаа маш сайн төвлөрүүлж санаачлагатай байх хэрэгтэй байдаг. Бүх зүйлийг алдаагүй хийхийн тулд байнга бодох шаардлагатай болно. Үргэлжлүүлэн байнга хийсээр нэг л өдөр аяндаа дадал зуршил болох болно. Итгэлээр алхаж дөнгөж эхлэх үед Бурхан яг ийм зүйлийг таны дотор хийхийг хүсдэг. Таны амьдралыг өөрчлөх Түүнийг эрэн хайдаг "ариун зуршил"-ыг таны дотор хөгжүүлэхийг Тэр хүсдэг.

Амь болсон Христийг эрж хайх, зүрх сэтгэлийн шинэчлэлийг эрж хайх, эрх чөлөө ялалтыг эрж хайх, эдгэрлийг хайхын алинд ч ялгаагүй Түүнээс зуурах "ариун зуршил", цуцалтгүй хандлагыг хөгжүүлэх тал дээр санаачлагатай байх нь их чухал.

Итгэлийн алхааны тухай дүгнэлт үнэн

- Итгэлийн алхаагаар дамжуулан **итгэлээр амьдрахыг суралцдаг.**
- Итгэлийн алхмаар дамжуулан итгэлээр амьдрах нь улам илүү бодит болж, итгэл нь мэдрэмж, туршлагаас ч илүү бодит болдог.
- Итгэл дотор алхах тусам **аливаа нөхцөл байдлыг Бурханы нүдээр** харж эхлэх ба үүний үр дүнд Бурханы зорилгыг илүү ойлгох болно.
- Итгэл дотор удаан алхах тусам Бурханы удирдлага, хэмжээлшгүй эрх мэдэлд итгэх итгэл улам томордог тул та амьдралдаа цаашид юу тохиолдохыг таамаглах **боломжгүй байсан ч амар тайван болно.**
- **Тэвчээртэйгээр** итгэлийн алхааг туулбал таны бодол, итгэл, сонголт, үйлдлийг өөрчлөх Бурханы ер бусын ажлыг мэдрэх болно.
- Итгэлээр алхах тусам таны Бурхантай харилцах харилцаа гүнзгийрч та Бурханы оршихуйг улам хүсэн тэмүүлж, таны төлөөх Бурханы зорилго, төлөвлөгөө, хүсэлтэй нийцэн алхах болно.

Дүгнэлт

1. Бурхан танд ялалт, эрх чөлөө, эдгэрлийг тэр дор нь өгч чадна. Гэхдээ эдгээрийг та амьдралдаа мэдрэхээс ӨМНӨ нилээн УРТ ХУГАЦААНЫ үйл явцыг туулах хэрэгтэй ч болж болох юм.
2. Та мэдэрч, амсаж байгаа эсэхээс үл хамааран итгэлээр Бурхан таныг чөлөөлж, ялалт өгч, эдгээж, амьдралыг тань өөрчлөхөөр АЖИЛЛАЖ БАЙГАА гэдгийг хүлээж аваарай.
3. Бурханы товлосон цагийг хүлээхэд таны тэвчээр барагдаж магадгүй. Тэвчээр алдах болгонд Бурханаас таны ТЭСВЭР, ТЭВЧЭЭР болж өгөхийг гуйн залбираарай.
4. Өдөр тутам таны амьдралд ажиллаж буй Бурханы ажилд сүнсээрээ СОНОР СЭРГЭГ бай. Өөрчлөлтүүд бага багаар, эсвэл багц багцаар бий болох болно. Бурханы ажиллаж байгаа өөрчлөлтөнд сонор сэргэг байлгахыг гуйн залбираарай.

ХУДАЛ ИТГЭЛ ҮНЭМШИЛ

Бурханы талаарх худал итгэл үнэмшил

Бурхан **бол** ... гэдэгт би итгэдэг:

Өнгөрсөн үед хэцүү асуудалтай үед Бурхан.... юм шиг санагддаг байсан:

Ууртай	Шүүмжлэмтгий	Хайрладаггүй
Хүйтэн хөндий	Буруутгадаг	Бэлэн биш
ялгаагүй	Шийтгэдэг	Хүсэлгүй
Удирддаггүй	Хайхрамжгүй	Энэрэлгүй

Бусдын талаар худал итгэл үнэмшил

Бусдыг уучлахгүй байх эрх надад бий.

Миний хэрэгцээнд бусад хүмүүс хүрэх ёстой.

Бусад намайг болзолгүй хайрлах ёстой.

Бусдаар хүлээн зөвшөөрүүлэхийн тулд бусад

хүмүүсийг би хүлээн зөвшөөрөх ёстой.

Бусдын санаа бодол миний үнэ цэнийг тодорхойлдог.

Надаар хүлээн зөвшөөрүүлэхийн тулд миний стандартад бусад хүмүүс нийцэх ёстой.

Христ итгэлт амьдралын талаарх худал итгэл үнэмшил

1. Би Бурханы төлөө ажиллах ёстой:
 - a. Бурханы хайрыг хүртэхийн тулд
 - b. Бурханаас аз жаргал олохын тулд
 - c. Бурханаар хүлээн зөвшөөрөгдөхийн тулд
 - d. Бурханы ял шийтгэлээс мултрахын тулд
 - e. Өөрөө өөрийгөө сайнаар мэдрэхийн тулд
 - f. Бусдын тааллыг олохын тулд
2. Би Бурханы тусламжтайгаар өөрийн ухамсар, чадвараа ашиглах нь миний үүрэг:
 - a. Бурханы тушаалыг дагахын тулд
 - b. Амьдралдаа Бурханы амлалтыг бодит болгохын тулд
 - c. Өөрөө өөрийгөө өөрчлөхийн тулд
 - d. Аз жаргалтай байхын тулд
 - e. Амжилттай байхын тулд

МАХАН БИЕЙН ААШ АВИР

Өөр дээрээ төвлөрсөн:

Хэт өөрийгөө хянах
Өөрийгөө өрөвдөх
Сэтгэлээр унах
Өөрийгөө хүчлэх
Хохирогчын сэтгэлгээ
Бусдын анхаарлыг татахын тулд
өөрийнхөө зовлонд хэт анхаарал
төвлөрүүлэх
Бусдын амжилт, аз жаргалд
атаархах

Өөрийгөө тусгаарлах:

Бүрэг
Ганцаараа байхыг эрхэмлэх
Бусдаас зугтамхай
Дуугаа хураах
Харьцаж боломгүй
Хариу үйлдэлгүй
Харилцахаас татгалзах

Зугтамхай(өвдөлт\дарамт):

Хар тамхи, архийг хэтрүүлэн
хэрэглэх
Завгүй байх
Зурагт, Компьютер, Порнограф
Их унтах, их идэх
Ажил, карьер
Хичээл сургууль
Кино Секс
Шашин шүтлэг

Санаа зовнил их (аймхай):

Айж мэгдэх
Амар тайван бус байх
Айж хөших
Хардаж сэрдэх
Эерэг бус
Муу муухайг зөгнөх

Хөтөч болох зүйл хайх:

Одон орон,
Зурхай судлал
Үзмэрч

Хувийн сахилга бат: Бусдыг

болон өөрийгөө гүйцэтгэлээр
дүгнэх
Төгс болохыг хичээх

Бүтэлгүйтэхгүйн тулд шаргуу
хичээх

Алдаа хийхээс айх
Хууль дүрэм баримтлагч
Номын зааврыг дагах
Хийх ёстой гэж зүтгэх
Бусдад/өөртөө шалгуур тавих
Бодит байдалд нийцэхгүй
Стандарт тогтоох

Шунах/Улайрах:

Амжилт
Нэр алдар / байр суурь
Материаллаг зүйлс
Бусдын бодолд анхаарах
Гадаад төрх
Өнгөрсөнөөс авсан шарх
Бүтэц, дэг журам, хууль

Түрэмгий/Дарангуйлагч:

Дарангуйлагч болох
Шаардангуй болох
Хэтэрхий захирангуй болох
Бусдад өөрийгөө өгдөггүй

Удирдлагыг гартаа авах:

Сүрдүүлэх
Шалтаг тоочих
Дайрч давшлах
Худлаа амлах
Идэвхигүй байх
Хоолноос гарах (анарокси)

Энэрэл, халамж дутах:

Өөрийгөө хамгаалах

Өөрийгөө зөвтгөх:

Шалтаг тоочих
Алдаагаа нуун дарагдуулах
Өөрийгөө зөвтгөх
Өөрийгөө асуудалгүйд тооцох
Бусдыг буруутгах
Хариуцлагаас зайлсхийх
Уучлал гуйдаггүй
Буруугаа хүлээдэггүй
Тусламж гуйдаггүй
Талархалгүй
Бусдыг дорд үзэх - Би л зөв
ярьдаг, хэлдэг гэх мэт

Шүүмжлэгч:

Бусдаас өө сэв хайх
Өчүүхэн зүйлд ач холбогдол
өгөх
Тэвчээргүй болох
Гомдоллох

Өөртөө бат итгэлтэй:

Бурхан эсвэл бусдад итгэхийн
оронд өөртөө л итгэх
Бардам, пээдгэр
Сагсуу онгироо болох
Хувиа хичээх
Сэхүүн болох
Хөөрүү болох

Мэдрэмжгүй:

Өрөвдөх сэтгэлгүй болох
Бусдыг анхаарахаа болих
Анзааргагүй

Маадгар/хэнэггүй:

Яасан ч яахав
Бүх юм зүгээр ш дээ

Гутранги үзэл:

Итгэлгүй, сөрөг
Хэт хардамхай
Итгэлгүй
Юу ч таалдаггүй
Юунд ч ханамжгүй

Өсөрхүү

Нөхөрсөг бус
Амархан уурлах
Бусдыг үзэн ядах
Бусдыг егөөдөх
Бие махбодийн хүчирхийлэл
Үгээр дайрч доромжлох

Атаа жөтөө санах:

Сэтгэл санаа тогтворгүй
Хорсол тээх
Бусдыг уучлахгүй байх
Бусдаас өшөө авах гэж оролдох
Өөрийгөө эсвэл бусдыг шийтгэх

Зүй бус тэмцэл:

Хов жив хөөцөлдөх
Асуудлыг буруу тайлагнах
Алтан хошуу хүргэх
Янаглан хорлох
Жинхэнэ мэдрэмжээ нуух
Мартамхай загнах
Харилцахаас зайлсхийх
Хоцрох
Хойшлуулах

Өөрийгөө дорд үзэх:

Би бол асуудлын эзэн
Хэт уучлал гуймтгай
Өөртөө хатуу хандах
Амжилтад таатай бус
Хайр халамж, магтаал, уучлалыг
хүлээж авахад бэрхшээлтэй байх
Бусдыг уучилж чадахгүй байх

Бусдыг сорих:

Эрх мэдлийг эсэргүүцэх
Уян хатан бус
Оюун санаа нь хаалттай
Санал үл нийлэх
Юмыг хэт хүндрүүлэх
Цэцэрхүү
Зөрүүд
Үндэслэлгүй

Бодит байдлыг үгүйсгэх:

Үүссэн асуудлыг үл тоох
Тэгж байгаад болно гэж бодох
Буруу, муу зүйлийг үгүйсгэх
Хийсвэр
Өөрийгөө/өрөөлийг хуурах

Өөртөө/өрөөлд худал хэлэх
Дэгсдүүлэх/Давслах
Гол санаагаа нуухаар тоглох

Дүр эсгэх:

Юу бодож байгаагаа нуух
Бусдад таалагдахаар оролдох
Бусдын анхаарлыг татах
Маяглах
Дүр эсгэх
Өөртөө бусдыг ойртуулдаггүй

Санаачлагагүй болох:

Амархан бууж өгөх
Боломжийг ашиглахгүй байх
Хэн нэгэн зааварлахыг хүлээх
Хувирамтгай болох
Шийдэмгий бус
Бүтэлгүйтлээс зугтах
Хойшлууламтгай
Хариуцлагагүй болох
Залхуу болох

Түгшүүртэй болох:

Амгалан бус
Тайван бус болох
Тэвчээргүй
Хямрамтгай

Сэтгэл хөдлөлөө бөөцийлсөн:

Дотнослоос зайлсхийх
Санал бодол, мэдрэмжээ
хуваалцахад хүндрэлтэй
Сэтгэл хөдлөлөө нуух
Явцуу, зожиг

Мэдрэмжээрээ амьдрах:

Мэдэрч байгаадаа итгэх
Шүүмжлэлд эмзэг хандах
Хэтэрхий мэдрэг
Наалинхай
Айдас, уур, эргэлзээ, аюулгүй
байдлаар удирдуулах
Автоматаар гологдсон мэдрэмж
тээх

Бусдыг зугаацуулагч

Хүн бүрийг аз жаргалтай болгох
гэж хичээх
Зөрчлөөс зайлсхийх
Бусад хүмүүсийн бодож байгаа
зүйлтэй өөрийнхөө бодол санааг
нийцүүлэх гэж хичээх
“Үгүй” гэж хэлэхэд хэцүү байх
Бусдын урмыг хугалахаас айх

Аврагч болох

Хэт хамгааламтгай
Хэт их хариуцлага үүрэх
Бусдын хэрэгт хэтэрхий оролцох
Хэтэрхий их ярих
Бага сонсох
Бусдын өмнөөс шийдэх

Хэт чухал:

Хэт задлан шинжлэмтгий
Хөгжилтэй биш
Баяр хөөргүй

ТАВДУГААР ХИЧЭЭЛ

Итгэлийн тулаан

НЭГ ДЭХ ӨДӨР

Тавдугаар хичээлийн агуулга

- Итгэлийн тулаан гэж юу вэ?
- Итгэлийн тулааны талаарх үнэн
- Тулаанд тулалдах дайснууд
- Махан бие, гэм нүглийн хүч чадал, Сатан\муу сүнсийг ялан дийлэх тулаан
- Итгэлийн тулаан ба таны бодлын амьдрал

Оршил

Итгэлийн алхмыг санаачилж эхлэнгүүт итгэлийн алхмыг эсэргүүцдэг эсэргүүцэлтэй нүүр тулдаг. Хэрвээ та итгэлийн алхам хийгээд эхэлчихсэн бол та миний юу ярьж байгааг ойлгож байгаа байх. Та гадаад болон дотоод дайснуудыхаа эсрэг явж эхлэхэд таныг итгэлээр алхах замаас зайлуулах гэж тэд эсэргүүцэж эхэлдэг. Энэ тулаанд нүүр тулах дайснуудын талаар, итгэлийн тулаанд дайснуудаа ялахын тулд хэрхэн Бурхантай хамт алхах талаар энэ хичээл дээр суралцах болно.

Итгэлийн тулаан гэж юу вэ?

“Итгэлийн сайн тэмцлээр тэмц” 1 Тимот 6:12

Итгэлийн тулааныг тодорхойлъё.

ИТГЭЛИЙН ТУЛААН гэдэг нь:

Итгэлийн алхам хийхэд дайснаас ирдэг ЭСЭРГҮҮЦЛИЙГ хэлнэ.



Итгэлийн алхам анх хийхэд эсэргүүцэлтэй тулгарна. Би танаас дараах хоёр асуултыг асууя.

- Итгэлийн тулаан болж байгааг та мэдэж байна уу?
- Та тулалдахад бэлэн байна уу?

Олон Христитгэгчид тэдний эсрэг маш хүчтэй тулаан явагдаж байгаа гэдгийг ойлгодоггүй болохыг би олж мэдсэн юм. Петр энэ тулааныг 1 Петр 2:11 ишлэл дээр батлан хэлсэн байна.

*"Хайрт хүмүүс ээ, сэтгэлийн чинь эсрэг **дайн** хийдэг махан биеийн хүсэл тачаалуудыг цээрлэхийг харь хүмүүс болон түр хугацаагаар байгч та нараас би гуйя."* 1 Петр 2:11

Тулаан болж байгаа гэдгийг бид хамгийн түрүүнд мэдэх ёстой. Хэрвээ бид тулаан байдаг гэдгийг мэдэхгүй бол тулаан байдаггүй юм шиг амьдрах болно. Нэмж хэлэхэд бид нар хэрхэн тулалдахаа мэддэг хирнээ итгэлийн тулаанд тулалдахгүй бол 1 Тимот 6:12 ишлэл дээр хэлсэн гурван үр дүн бий болно.

1. *Бурханаас, итгэлээр алхаанаасаа БУУЖ ӨГНӨ*
2. *Бид өөрсдөө амьдралынхаа эх сурвалж нь болж ХУУЧИН БАЙДАЛДАА БУЦАЖ ОЧНО*
3. *ЯМАР Ч өөрчлөлт бий болохгүй*

Ийм учраас бид нар итгэлийн тулаанд хэрхэн дайснаа ялан дийлэх талаар ойлгох ёстой. Итгэлийн тулааны талаар хэд хэдэн үнэнг суралцай.

Итгэлийн тулааны талаарх үнэн

№1 - Та энэ тулаанд тулалдаж чадахгүй



"Учир нь та нарын төлөө дайсантай чинь байлдахаар, та нарыг аврахаар та нартай хамт явагч нь чиний Бурхан ЭЗЭН юм" гэж хэл." Дэд хууль 20:4

Бурханаас салангид байвал та энэ тулааны эсрэг тулалдаж **чадахгүй** гэдэг нь үнэн юм. Яагаад? Таны нүүр тулж байгаа дайсны хүч чадал таны хүч чадал, сэтгэлийн тэнхээтэй харьцуулахад хэтэрхий хүчтэй учраас та ганцаараа энэ тулааныг үргэлжлүүлж чадахгүй. Бурханы хүч чадлаас салангид байхыг сонгох болгонд та итгэлийн тулаанд ялагдах болно. Сайн мэдээ гэвэл тантай нүүр тулж байгаа дайсан тус бүрийн эсрэг Бурхан таны ТӨЛӨӨ тулалдана гэж амласан.

Бурхан ХЭЗЭЭ Ч таныг Түүнээс салангид ялж ЧАДАХГҮЙ тулаанд тулалдуулахаар зориогүй юм.

№2 – Итгэлийн тулаанд оролцох таны үүрэг

"ЭЗЭН та нарын төлөө байлдана. Та нар тэмцэлдэхээ боль! гэж хэлэв." Гэтлэл 14:14

Бурханы таны төлөө тулалдах нь тодорхой боловч та энэ тулаанд гүйцэтгэх маш чухал үүрэг бий. Энэ нь: "Хөдлөшгүй тайван байх". Эхэндээ идэвхигүй, ямар ч үүрэг хариуцлагагүй мэт сонсогдох боловч итгэлийн тулаанд Бурханд итгэн тулааныг үргэлжлүүлэхэд "хөдлөшгүй тайван байх" гэдэг нь маш идэвхитэй үг.

"Хөдлөшгүй тайван байх" гэдэг нь итгэлийн алхмыг үргэлжлүүлэхийн тулд дайсныг Бурханы хүч чадал ялан дийлж чадна гэдэгт итгэн даатгаж амрахыг хэлнэ. Дуулал 46:10 ишлэл дээр бичсэн яг адил үнэнийг харж болно: "Тэмцэлдэхээ больж, намайг Бурхан гэдгийг мэд." Миний дайснуудыг ялах ЯЛАГЧ нь болох Бурханы хүч чадалд итгэвэл Бурхан миний төлөө дайтаж би амралтыг мэдэрч чадах юм.

Таны итгэл - итгэлийн алхмын эсрэг зогсогч дайсныг устгах Бурханы хүч чадлыг ИДЭВХЖҮҮЛДЭГ

№3 – Бурханы үгийг итгэлийн тулаанд ялах арга болгон ашиглах нь


"Гашиудлаас болж сэтгэл минь уйлдаг. Өөрийн үгийн дагуу намайг хүчжүүлээч." Дуулал 119:28

"Тэгээд та нар үнэнийг ойлгож, үнэн та нарыг чөлөөлнө гэсэнд" Иохан 8:32

Итгэлийн тулаанаар тулалдах хамгийн чухал үүрэг бол Бурханы үнэн болон Бурхантай хамт алхахад оршино. Иохан 8:32 ишлэл дээр хэлсэн “ойлгох” гэдэг үг нь мэдлэгээс илүүгээр “итгэх” гэсэн утгатай байдаг. Иохан 14:6 ишлэлийн дагуу Христ өөрөө бидний үнэн. Иймээс та Бурханы үнэнд итгэн Бурхантай итгэлээрээ хамт алхсанаар таны итгэлийн алхамд саад учруулж байгаа дайснуудыг Бурхан Өөрийн үнэнээр устган таныг Тэр чөлөөлөх юм.

Итгэлийн алхмын талаарх зурган жишээ


Дараах диаграм дээр зүүн талын хэсэг итгэлийн алхам хийхээс өмнөх нөхцөл байдлыг үзүүлсэн байна. Эхэндээ бид махан биеийн хүслийн дагуу амьдарч, маш олон шийдвэрлэгдээгүй зөрчил, гэм нүглийн хүлээс дунд амьдардаг байв. Баруун талд бидний мэдрэхийг хүсдэг Бурханы амласан өөрчлөлтийг үзүүлжээ. Гүүрний дунд хэсэгт итгэл байна. Энэ диаграмыг бид энэ хичээлд их ашиглах болно.



Итгэлийн дайснууд гэж хэнийг хэлэх вэ?

Итгэлээр алхаж эхлэхэд бид бүхэн гадаад ба дотоод зөрчил, саад бэрхшээлтэй тулгарах болно. Махан бие, гэм нүглийн хүч чадал, Сатан ба муу сүнснүүд гэсэн гурван үндсэн дайснуудын эсрэг итгэлийн тулаанд тулалдах болно. “Бузар” гурвал гэж эдгээр дайснуудыг нэрлэе.

“БУЗАР” ГУРВАЛ



Эдгээр гурвалаас гадна бас нэгэн хүчтэй дайсан бол бидний өөрсдийн бодлын амьдрал юм. Итгэлээр алхаж эхлэхэд эдгээр дөрвөн дайснуудын эсрэг тулалдах шаардлагатай болдог.



Итгэлийн тулаанд орж ялахын тулд Бурхантай хэрхэн алхах хэрэгтэйг харцгаая. Мөн дайснаа нэг бүрчлэн харцгаая.

ЧУХАЛ ҮНЭН

Таны хүч чадал, авъяас чадвар, сэтгэлийн тэнхээ дайснуудын чинь ХҮЧТЭЙ харьцуулагдах БОЛОМЖГҮЙ. Бурханаас салангид тэднийг ялах гэж оролдох нь ҮРГЭЛЖ ялагдлыг бий болгоно.


ХОЁР ДАХЬ ӨДӨР

Дайсан №1 – МАХАН БИЕ

Өнгөрсөн хичээл дээр бид махан бие ба түүний зан байдлыг ойлгосон гэдэгт итгэлтэй байна. Энэ удаагийн хичээл дээр бид итгэлийн алхмыг махан бие хэрхэн эсэргүүцдэг болохыг суралцана.

Таны махан бие ҮРГЭЛЖ таны итгэлийн алхааг эсэргүүцэх болно

Махан бие ҮРГЭЛЖ таны итгэлийн алхааг эсэргүүцэх болно. Галат 5:17



"Учир нь махан бие Сүнсний эсрэг хүсдэг, Сүнс махан биеийн эсрэг хүсдэг юм. Яагаад гэвэл хүссэн юмсыг чинь хийлгэхгүйн тулд махан бие ба Сүнс нь нэг нэгнээ эсэргүүцдэг ажээ." Галат 5:17

Амьдралынхаа үлдсэн хугацаанд та бид бүгдээрээ махан бие ба түүний хүслийн эсрэг зөрчилдөх болно. Муу мэдээ гэвэл махан биеийн байдал бидний биеэ даасан амьдралд “төрөлхийн” байдаг учраас амархан махан биеийн байдалдаа буцаж ирдэг. Өөрөөр хэлбэл, бид махан биедээ амьдарч дасал болсон учраас уг байдалдаа буцаж ирэх нь маш амархан. Харин одоо Христитгэгч болсны хувьд бидэнд өөр сонголт байдаг. Бидний дотор Бурханы хүч чадлын дүүрэн байдал байдаг тул Бурхантай хамааралтай амьдралаар амьдрахыг сонгож чаддаг. (Бурханы хүч чадал ҮРГЭЛЖ махан биеийг захиран дийлдэг.)

Христитгэгч бүрт өгөгдсөн ЭХЛЭЛИЙН цэг бол МАХАН БИЕ юм.

Итгэлийн алхмыг эсэргүүцдэг махан биеийн хэд хэдэн жишээг дор үзүүлэв. Махан бие танаас хүсдэг:

- Өөрийгөө өөрчлөхийн тулд өөрийн хүч чадлаа ашиглахыг
- Бурханы хүч чадал таныг өөрчилж чадна гэдэгт эргэлзээ төрүүлэхийг
- “махан биеийн байдалд буцаж” ирүүлэхийг
- Гэм нүглийн хүч чадал ба Сатан уруу татахыг

Асуулт: Ром 7:15 ишлэлийг баясалгаад танд ямар нэгэн зүйлийг хийхийг хүсдэг боловч хийж чадахгүй байгаа зүйлүүд байдаг уу? Та өөрийнхөө хүч тэнхээг ашиглан тэдгээр зүйлийг хийхийг эсвэл хийхгүй байх гэж оролдож үзсэн үү? Энэ бүхэн бүтэмжтэй байна уу?

Итгэлийн тулаан ба Махан бие

Итгэлийн тулаан ба махан биетэй холбоотой дараах гурван зүйлийг Бурхан танд гүйцэлдүүлж өгөхийг хүсдэг.

1. Таны махан бие итгэлийн алхмыг эсэргүүцэж байвал ИЛГАРГАХ

Бидний төрөлхийн зан чанар бол махан бие учраас бидний дотор хийгдэж буй Бурханы ажлыг махан бие эсэргүүцэж байгааг харж чаддаггүй. Бурхан юу хийхийг хүсдэг вэ гэхээр махан биеийн эсэргүүцлийг ил

гаргахыг хүсдэг. Дараах ишлэл дээр Давид өөрийнхөө махан биеийн хүслийг Бурханд хэрхэн ил гаргасныг харъя.

"Өө, Бурхан, намайг судлан, миний зүрхийг мэдээч. Намайг шалгаж, миний бодлуудыг мэдээч. Миний дотор ямар нэгэн хөнөөлт үйл буй эсэхийг харж, Мөнхийн зам уруу намайг залаач." Дуулал 139:23 – 24

Итгэлийн алхам: “Эзэн, миний дотор хийгдэж буй Таны ажлыг миний махан бие хэрхэн эсэргүүцэж байгааг ил гарган харуулж өгөхийг гуйж байна.”

2. Махан бие чинь үхсэнийг харуулах

"Би юу үйлдэж байгаагаа өөрөө ч ойлгодоггүй. Учир нь би хийх хүсэлтэй зүйлээ хийдэггүй, харин үзэн яддаг зүйлээ хийж байна." Ром 7:15

Махан бие бол нэг зүйлийн хоёр тал юм. Нэгдүгээрт, бид махан биеэсээ салж явахыг хүсдэггүй. Хоёрдугаарт, биднийг хүлж байгаа махан биеийн хүлээсээс бид өөрөө өөрсдийгөө чөлөөлөх хүч чадал байхгүй. Бурханы чөлөөлөлтийг махан биедээ зөвшөөрөх хүсэлтэй болохын тулд Бурхан бидний махан биеийн “үхэл”-ийг илчилж өгөх шаардлагатай болдог. (Махан биеийн үхэл гэдэг нь оюун санааны эмгэг бөгөөд бидний дотор Бурханы өөрчлөлтийн ажлыг махан бие эсэргүүцсэний үр дүнд үүсдэг)

Махан биеийн үхлийг харуулах нь таны дотор буй махан биеийн эсэргүүцлийг Ариун Сүнс танд ЭМГЭГ гэдгийг энгийнээр илчилж байгаа хэрэг юм.



Махан биеэс болоод зовлон дунд амьдарч байгаа маш олон Христитгэгчид байдаг боловч тэдгээр хүмүүсийн ихэнх нь махан биеийн зовлон дунд амьдарч байгаагаа мэддэггүй. Тийм учраас бид нар Бурханаас бидний зовлонтой байдлыг илчилж өгөхийг гуйн залбирч байгаа юм. Өөрөөр хэлбэл, 2 Петр 2:22 ишлэл дээр хэлсэнчлэн бид бөөлжөөд, бөөлжсөн бөөлжсөө буцаж долоож түүн дотроо хөлбөрдөг нохой шиг үргэлжлүүлэн амьдрахыг хүсч байна гэсэн үг юм. Бурхан таныг уур хилэнгээс тань чөлөөлөхийг хүсч байгаа хүслийг таны махан бие эсэргүүцэж байгаа жишээг авч үзье. Бурханы хийх зүйл бол таны уур хилэнгийн “үхэл”-ийг Бурхан илчлэн, энэ уур хилэн таны хань, хүүхдүүд, хамтран ажиллагсад, найз нөхдөд байнгын зөрчил хэрхэн үүсгэдэг талаар харуулах юм. Таны уур уцаарын бий болгож буй "бөөлжис"-ийг Тэр арчин зүлгэснээр та уур хилэнгээсээ хэрхэн өөрийгөө эргэж буйг олж харах юм.

3. Махан бие-ДЭЭ үхсэн байдал дотор алхах хүслийг өгөх

Махан биеийн үхлийг бид нэгэнт харж чадвал махан биеэс холдож Бурхантай хамааралтай алхаж эхлэх болно. 2 Коринт 4:11 ишлэлийг харъя.



"Амьд байгаа бид Есүсийн төлөө үхэлд байнга тушаагддаг. Ингэвэл Есүсийн амь мөн бидний үхлийн махан бие дотор илэрхийлэгдэх болно."

2 Коринт 4:11

Паул энэ ишлэл дээр Бурхан бидэнд үргэлж махан биеийн үхлийг илчилж, бид махан биедээ үхсэн байдал дотор алхах талаар ярьж байна. Махан биедээ үхсэн байдал дотор алхана гэдэг нь махан биеийнхээ эсэргүүцлийн үүсгэж буй зовлонг ойлгож, бидний дотор ажиллаж буй Бурханы өөрчлөлтийг үргэлжлүүлэхийн тулд Бурхан дээр эргэн очихыг хэлнэ. Махан биедээ үхмэл байдал дотор алхана гэдэг нь махан биеэ загалмай дээр цовдолж байгаатай адил хэрэг болдог.

Махан бие-ДЭЭ үхмэл байдал дотор алхах нь нөгөө талаас махан биеийг ЯЛАН дийлэх ялалт дотор алхаж буй хэрэг болдог.

Бурхантай хамт алхах нь: Таны амьдралд хийгдэж буй Бурханы ажлыг эсэргүүцэж байгаа махан биеийн ямар талбарууд байгааг Бурхан ил гарган харуулахыг гуйгаарай. Махан биеийн үхэл ба зовлонг Бурхан илчлэн харуулж өгөхийг гуйгаад итгэлээр үргэлжлүүлэн алхах хүслийг Бурхан дахин өгнө гэдэгт итгээрэй.

ГУРАВ ДАХЬ ӨДӨР

Махан биеийг ялан дийлж ялалтыг мэдрэхийн тулд Бурханы хүчтэй нэгдэх нь хэрхэн харагдах жишээ:

Махан биеийг ялах ялалтыг мэдрэхийн тулд:

1. Таны мэдэрч байгаа махан биеийн эсэргүүцлийг Бурхан үргэлжлүүлэн ИЛ ГАРГАЖ өгөхийг гуйн залбирах
2. Танд болон таны эргэн тойронд байгаа хүмүүст нөлөөлж байгаа махан биеийн “үхлийг” ИЛЧИЛЖ өгөхийг Бурханаас гуйн залбирах
3. Бурханы хүч чадал дотор таныг алхахаас холдуулж байгаа махан биеийн зан байдлыг “үхүүлэх” ХҮСЭЛ-ийг Бурхан танд өгөхийг гуйн залбираарай.

Одоо махан биеийн зан авираа ялан дийлэхийн тулд Бурхантай хамт итгэлээр алхах жишээг авч үзэцгээе.

Жишээ №1: Өнгөрсөн хугацаанд таныг гомдоосон хүнийг уучлахын тулд та Бурхантай хамт алхаж байна гэж бодъё. Хэд хэдэн удаа итгэлийн алхам хийсний дараа та тэр хүнтэй уулзахаар болов. Таны махан бие таны итгэлийн алхмыг эсэргүүцэж уурлаж гомдон, уучлахгүй байхыг оролдох болно. Махан биеийг ялан дийлэхийн тулд бид Бурхантай хэрхэн хамт алхах вэ?

Итгэлийн тулаан: “Эзэн, тэр нэг хүнийг харахаар миний уур хүрч эхэлдэг. Миний уур хилэнг үхүүлэх хүч чадал минь Та болооч гэж гуйж байна. Уур хилэнгээс холдох хүслийг надад өгөөрэй.”

Жишээ №2: Та ханиа голдог гэж бодъё. Үүнийг болихын тулд Бурхан таны оюун бодлыг шинэчилснээр ханиа болзолгүй хүлээн зөвшөөрөхийн төлөө залбирч байна гэж бодъё. Та итгэлийн алхам хийж эхлэхэд

та түүнийг ахин голж эхлэхүйц үгнүүдийг ханиасаа сонсож эхэлнэ. Яг энэ үед итгэлийн тулаан эхэлдэг. Бурханы таны төлөө итгэлийн тулааныг хийж өгөхийн тулд та Бурхантай хэрхэн хамт алхах вэ?

Итгэлийн тулаан: “Эзэн, би ханиа голоод байна. Миний болон ханийн минь дотор миний голох сэтгэлийн учруулж буй үхлийг та илчилж өгөхийг Танаас гуйн залбирч байна. Махан биеийн мэдрэмжийг ялан дийлэх, энэ хүндлэхгүй хандаж байгаа байдлаас холдуулах хүчийг Та надад өгөөрэй.

Махан биеийг ялан дийлэхийн тулд Бурхантай хамт алхах тухай дүгнэлт бодол

1. Махан биеийн эсэргүүцлийг ялан дийлэхийн тулд та Бурханыг САНААЧЛАГАТАЙГААР хайхгүй бол та цаг үргэлж ялагдах болно.
2. Та амьдралынхаа тодорхой талбарт ялалт, эрх чөлөө, эдгэрлийг хайж эхлэхэд махан биеийн эсэргүүцэл улам ХҮЧТЭЙ болно.
3. Махан биеийг ялан дийлэхийн тулд Бурхантай хамт алхах тусам цагийн аясаар махан биеийн эсэргүүцэл улам БАГАСАХ болно.

ЧУХАЛ ҮНЭН:

Та итгэлээр алхаж байхдаа маш олон удаа махан биеийн хүсэлдээ захирагдах болно. Яг тэр үед Бурхан таны махан биеийн ҮХМЭЛ чанарыг ил гаргахыг хүсдэг ба түүнээс үүдэн та махан биедээ үхсэн байдлаар алхах болно.

Бурхантай хамт алхах нь: Та амьдралынхаа ямар нэг талбарт ялалт ба эдгэрлийг Бурханаас хайж байхдаа итгэлийн алхааны эсрэг махан биеийн эсэргүүцлийг мэдэрч байвал таны махан биеийн эсэргүүцлийг ялан дийлэх Бурхантай хамт алхаарай.

Дайсан №2 – Гэм нүглийн хүч чадал

"Хэрэв би өөрийн хүсдэггүй зүйлээ хийж байгаа бол цаашид би биш, харин миний дотор оршин байгч нүгэл нь үүнийг үйлддэг."
Ром 7:20

Гэм нүглийн хүч чадал гэж юуг хэлэх вэ?

ГЭМ НҮГЛИЙН ХҮЧ ЧАДАЛ гэдэг нь:

Бурханаас хамааралгүй биеэ даан амьдрахыг ХҮСЧ байгаа ДОТООД хүчийг хэлнэ.

Таны дотор оршин буй гэм нүглийн хүч чадал үргэлж таныг Бурханы хүч чадлын эсрэг өөрийн хүч чадал, оюуны потенциалиа ашиглан амьдарч чадна гэж уруу татдаг. **Гэм нүглийн хүч чадал таны сэтгэлийн тэнхээтэй харьцуулшгүй их тул таны хүч чадал гэмийг ялж чадахгүй гэсэн үг юм.** Иймээс та итгэлээрээ Бурхантай хамт алхахгүй бол үргэлж гэм нүглийн хүч чадлыг улам нэмэгдүүлсээр байх болно.



Гэм нүглийн хүч чадлын талаарх бас нэг үнэн бол та махан бие ба махан биеийн байдалтайгаа “хамтын ажиллагаатай” байна гэсэн үг юм. Махан бие ба гэм нүгэл хоорондоо хэрхэн хамтарч ажилладаг болохыг та очих дуртай ресторандаа хоол идэж байгаагаар төлөөлүүлэн дүрсэлье. Зөөгч таны дуртай бүх амттаныг танд авчирч өглөө. Та өөрийгөө хянаж чадахгүй амттаныг улам их идэж байв.

Яг энэ жишээн дээр зөөгч бол гэм нүглийн хүч чадал, амттан таны махан биеийн зан байдал болж байгаа юм. Хэрвээ та Бурхантай хамт алхахгүй бол та үргэлж гэм нүглийн хүч чадалд ялагдан махан биеийн зан байдлыг сонгох болно. Одоо гэм нүглийн хүч чадал хэрхэн ажилладаг болох мөн гэм нүглийг ялан дийлэхийн тулд хэрхэн Бурхантай хамт алхах талаарх жишээ харья.

Гэм нүглийн хүч чадлыг ялан дийлэхийн тулд Бурхантай хэрхэн хамт алхах талаар жишээгээр үзүүлэв

Жишээ № 1: Өнөөдөр ажил дээрээ очлоо. Уг нь маш шаргуу хичээнгүйлэн ажилласан учраас та тушаал дэвших ёстой байтал таны оронд өөр нэгэн хүн тушаал дэвшсэнийг олж мэдэв. Яг энэ үед махан биеийн зан байдал болох уур хилэн, өс хонзон зэргээр та гэм нүглийн хүчийг улам нэмэгдүүлэх болно. Энэ тохиолдолд та сонголт хийх шаардлагатай болж байна. Та гэм нүгэлд хүч чадал өгөх эсвэл гэм нүглийг ялан дийлэхийн тулд Бурхантай хамт алхах гэсэн хоёр сонголт танд байна.

Итгэлийн тулаан: “Эзэн, би тушаал дэвших эрхтэй гэдгээ мэднэ. Уур хүрч байна. Би уураа Танд **итгэн даатгаж байна**. Миний дотор байгаа гэм нүглийг ялах хүч чадлыг Та надад өгөөрэй. Мөн эдгээр махан биеийн зан байдлаас холдуулж өгөхийг гуйн залбирч байна.”

Жишээ № 2: Таны найз бусадтай нийлж таныг муулж байгааг та олж мэдэв. Энэхүү мэдээг сонсох үед та найзаасаа зайгаа барих махан биеийн зан авир оргилж эхлэнэ. Хэрвээ та гэм нүглийн хүч чадалд бууж өгвөл таны махан бие тэр хүнийг үл хүндэтгэж эхэлнэ.

Итгэлийн тулаан: “Эзэн, миний дотор оршин байгаа гэм нүглийн хүч чадлыг ялан дийлэхийг Бурхан танаас гуйн залбирч байна. Тэгсэнээр миний найз намайг хүндэтгээгүй шиг махан биеийн зан байдлаар би хариугаа авахгүй байх болно.”

Дасгал: Та зөрчилтэй байгаа махан биеийн зан байдлаа дор бичээрэй. Гэм нүглийн хүч чадлыг улам нэмэгдүүлдэг тэр махан биеийн зан байдлыг бодож үзээрэй.

Бурхантай хамт алхах нь: Гэм нүглийн хүч чадлыг ялан дийлэхийн тулд махан биеийн зан байдлаас холдуулж өгөхийг Бурханаас гуйн залбираарай.

Гэм нүглийг ялан дийлэх ялалтын алхам

1. Итгэлийн алхам анх хийж эхлэхэд гэм нүглийн хүч чадал танаас ХҮЧТЭЙ байх болно. Та өөрийгөө гэм нүглийн хүч чадлын эсрэг хийсэн тулаанд ялагдсан гэдгээ мэдэх болно.
2. Гэм нүглийн хүч чадал танаас хүчтэй гэдгээр өөрийнхөө зоригийг БИТГИЙ мохоогоорой. Гэм үйлдсэн бол Бурханы өмнө гэмшээд итгэлээрээ үргэлжлүүлэн алхаарай.

3. Бурхантай хамт үргэлжлүүлэн алхсаар байвал гэм нүглийн хүч чадал улам бүр БАГАСАЖ та тийм ч амархан гэм нүглийн хүч чадалд бууж өгөхгүй болсоноо мэдэх болно.

ГЭМ НҮГЛИЙН ХҮЧ ЧАДАЛ

Таныг махан биеийн зан байдал руу ҮРГЭЛЖ уур татаж үргэлжлүүлэн саад бэрхшээл учруулах болно.

Дайсан №3 – Сатан\ Муу сүнсний хүч

"Учир нь бидний тэмцэл бол махан бие ба цусны эсрэг биш, харин захирагчид, эрх мэдэл, энэхүү харанхуй ертөнцийн хүчнүүд, тэнгэр дэх бузар муугийн сүнслэг хүчний эсрэг билээ." Эфес 6:12

Би анх цуглаанд явж эхэлж байх үедээ Сатан болон муу сүнсний тухай нэг их ярьдаггүй байсан юм. Бид муу сүнсний талаар нэг их яриад байдаггүй шүү дээ. Гэхдээ өнгөрсөн жилүүдэд, Сатан болон муу сүнснүүд үнэхээр бодитой оршин байдаг ба БАЙНГА биднийг сорьж байдаг гэдгийг олж мэдсэн юм. Сатаны байнгын стратеги бол:

Итгэлийн алхмыг тань ХУЛГАЙЛАХ, АЛЖ, СҮЙТГЭХ байдаг

"Хулгайч зөвхөн хулгайлан, алж, сүйтгэхээр ирдэг." Иохан 10:10a

Сатан болон муу сүнсний талаар гүнзгийрүүлэн ярихгүй боловч итгэлээр алхахад дайснууд хэрхэн эсэргүүцдэг болохыг мэдэх нь чухал. Христитгэгчдийг Сатан онилсон байдаг.

Тэр доорх зүйлсийг хүсдэг:



1. Таны амь болсон Христээс таныг холдуулахыг Сатан хүсдэг
2. Таны дотор оршин буй Христийн амиар амьдрах нь ямар утга учиртай болохыг ойлгоход саад болдог
3. Таны амьдрал өөрчлөгдөхийн тулд Эх сурвалж болсон Бурхантай итгэлээр алхахаас холдуулахыг хүсдэг

Сатан Бурханы үнэнийг мэддэг ба Христитгэгчид өөрчлөгдөхөд ямар үр дүн үүсч болохыг ч мэддэг. Тийм учраас Сатан болон муу сүнснүүд Бурханы үнэнийг мэдэх, Бурханы үнэнд итгэх, Бурханы үнэнээр чөлөөлөгдөхөөс бүх хүчээрээ таныг холдуулахыг хичээдэг.

Сатаныг сүрдүүлэх ХАМГИЙН АГУУ сүрдүүлэг бол Бурханы үнэн!

Бурханы үнэнд ИТГЭН ИТГЭЛЭЭР АЛХАХ нь Сатаныг сүрдүүлэх хамгийн агуу сүрдүүлэг болдог.

Иймээс Сатан болон муу сүнснүүдийн зорилго бол биднийг Бурхантай хамт итгэлээр алхахаас холдуулж худал итгэл үнэмшил, махан биеийн зан авир, гэм нүглийн хүчний хүлээс дунд үргэлжлүүлэн амьдруулахыг хүсдэг. Сатан биднийг худал хуурмагт итгүүлсэнээр Бурханы амладаг өөрчлөлттэй, бүрэн

дүүрэн амьдралыг хэзээ ч мэдрэхгүй гэдгийг мэддэг. Бидний бодлоор дамжуулан хамгийн түрүүнд Сатан ажлаа хийдэг.

Христитгэгчдийн эсрэг үйлддэг Сатаны\муу сүнсний стратеги бол худал, хуурмаг, уруу татсан, ялласан, махан биеийн БОДЛЫГ бидний оюун санаанд ОРУУЛАХ юм.

Матай 16:21-23 ишлэл дээр гардаг Петр ба Есүсийн хооронд болсон үйл явдлаар дамжуулан Сатан\муу сүнснүүдэд хүч чадал байдаг гэдгийг бид мэднэ. Петр Есүсд хандан Есүс хэзээ ч загалмай дээр цовдлогдохгүй гэж хэлж байсан. Есүс хариуд нь “Сатанаа миний араас зайл” гэж хэлдэг. Петрийн оюун санаанд Сатан хуурамч ойлголтыг өгсөн гэдгийг мэдсэн учраас Есүс Сатантай шууд ярилцсан. Одоо биднийг итгэлийн алхмаас холдуулахын тулд дайсан юу хийдгийг харъя.

ДӨРӨВ ДЭХ ӨДӨР

Сатан\муу сүнсийг ялан дийлэхийн түлд Бурханы хүч чадалтай хэрхэн хамт алхах вэ?



Жишээ №1: Санхүүгийн хувьд асуудалтай байна гэж бодъё. Таны сүнсний хувьд Бурхан таныг санхүүгээр хангана гэдэгт итгэж байсан ч таны санхүүгийн нөхцөл байдал ерөөсөө өөрчлөгдсөнгүй. “Би Бурханд энэ асуудлыг шийдэхэд 1 долоо хоногийн хугацаа өгсөн байхад Бурхан одоог хүртэл шийдэж чадаагүй л байна. Бурхан миний энэ асуудалд анхаарал хандуулахгүй байгаа учраас энэ асуудлаас гарахын тулд би Бурханаас салангид ямар нэгэн зүйл өөрийнхөөрөө хийсэн нь дээр бололтой” гэсэн бодлыг Сатан\муу сүнс бидэнд өгдөг.

Санамж: Сатан\муу сүнс бидэнд эдгээр бодлыг суулгахад бидний оюун санаанд энэ нь байнга төлөөний үгийн нэгдүгээр хэлбэр болох би, намайг, би өөрөө гэх мэт хэлбэрээр ирдэг бөгөөд энэ нь өөрийн дуу хоолой мэт сонсогддог.

Хэрвээ эдгээр бодлын захирагч нь та өөрөө болвол дайсны эсрэг стратеги таны дотор маш амархан хэрэгжиж та махан биеийн эх сурвалж руу амжилттай эргэн очих болно. Үүний оронд та итгэлийн тулаанд Сатан\муу сүнсийг ялахын тулд Бурхантай хамт алхахыг сонгох боломжтой.

Итгэлийн тулаан: “Эзэн, дайснууд Таны хүч чадал миний санхүүгийн асуудлыг шийдэж өгч чадахгүй гэж итгүүлэн уруу татахыг оролдож байна. Энэ уруу татлагыг Таны хүч чадал ялна гэдэгт би итгэж байна. Танд миний асуудлыг шийдвэрлэх шийдэл байгаа ба Та эдгээр асуудлыг шийдэхийн тулд удирдаж байгаа гэдгийг үргэлжлүүлэн сануулаарай.”

Жишээ №2: Уур таныг байнга ялан дийлдэг. Би уураа хянаж чадахгүй болсон үед Сатан\муу сүнснүүд бидэнд ингэж хэлдэг “би өөрийгөө Христитгэгч гэдэг. Гэтэл миний ямар их ууртайг хардаа. Би өөрийгөө буруутгаж байна. Би хэзээ ч үүнийг ялан дийлж чадахгүй бололтой.”

Бурханы үнэн бидэнд Ром 8:1 ишлэл дээр юу хэлсэнийг харъя. “Тиймд эдүгээ Христ Есүс дотор байгаа хүмүүст ямар ч ял байхгүй.” Бурхан биднийг буруутгахгүй, яллахгүй учраас Сатан\муу сүнсний ятгаж байгаа буруутгалын оюун санааг хүлээн авч өөрийгөө буруутгах шаардлагагүй.

Итгэлийн тулаан: “Эзэн, Ром 8:1 ишлэл дээр хэлсэн үнэний дагуу надад ямар ч ял байхгүй. Таны хүч чадал намайг буруутгаж байгаа бодлыг ялан дийлнэ гэдэгт итгэж байна. Мөн Та буруутгаж байгаа бодлыг бодохгүй байхыг үргэлжлүүлэн ятгаж өгөөрэй.”

Асуулт: Сөрөг, худал, өөрийгөө буруутгасан бодол таны дотор ахин дахин бодогддог уу? Таны бодол санаанд эдгээр бодлыг Сатан эсвэл муу сүнснүүд танд өгсөн байх боломжтой юу?

Бурхантай хамт алхах нь: Бурхан энэ бодлыг юунаас эхлэлтэй, юунаас болоод би ингэж бодох болсоныг надад илчилж харуулаарай. Эдгээр бодолд хүлэгдсэн, эзэмшигч нь болсон намайг Бурхан та Өөрийн хүч чадлаар ялан дийлж өгөөрэй.

Сатан\муу сүнснэй тэмцээж итгэлийн алхам хийхдээ санах хэрэгтэй үнэнүүд

1. Сатаны хамгийн сайн ашигладаг стратеги бол ХУУРАН МЭХЛЭХ. Тэр бидний оюун санаанд бидний бодлыг ашиглан худал, хуурмаг бодлыг оруулж мэхлэхийг хүсдэг.
2. Итгэлийн алхамын эхэн үед таны зөв бурууг ялган харах чадвар сул байгаагаас болоод Сатан\муу сүнсний сөрөг бодол санаанууд таны бодол санааг ҮРГЭЛЖЛҮҮЛЭН эзэлсээр байх болно.
3. Итгэлээр үргэлжлүүлэн алхсаар байвал таны САЙН МУУГ ЯЛГАХ ЧАДВАР САЙЖИРЧ та өөрийн бодол санааг мэдэрч эхэлдэг.

Дайсан №4 – Таны бодлын амьдрал

"Яагаад гэвэл махан биеийн бодол санаа бол Бурханы эсрэг дайсагнал юм. Учир нь энэ нь Бурханы хуульд захирагддаггүй бөгөөд тэгж чадах ч үгүй." Ром 8:7

Итгэлийн алхамд нөлөөлдөг хамгийн том саад бэрхшээл бол таны бодол санаа юм. Дээр дурьдсан олон жишээнүүдийг харвал таныг хуурч мэхэлсэн бодол санааг Сатан\муу сүнс өгдөг. Дахин хэлэхэд таны оюун санаа худал, хуурмаг, итгэмжгүй, буруутгасан бодлыг бий болгох боломжтой. Эдгээр бодлыг үргэлжлүүлэн тунгаасаар байвал Сатан таны оюун санааг энэ байдалд хүлсээр байх болно. Таныг итгэлээр алхахад саад болж итгэлээс холдуулдаг бодлыг харъя.

Айдастай бодол санаа

*"Учир нь Бурхан бидэнд айдсын сүнсийг **бүс**, харин хүч, хайр ба биеэ захирахын сүнсийг өгсөн."*
2 Тимот 1:7



Итгэлээр алхахад хамгийн их нөлөөлдөг саад тогтор бол айдас юм. Яагаад? Айдас маш амархан биднийг хүлж хөдөлж чадахгүй болгодог ба итгэлийн алхмаас маш амархан холдуулж чаддаг. Эдгээр бодлыг ялан дийлэхийн тулд хэрхэн Бурхантай хамт алхах вэ? Итгэлээр алхахад тулгардаг айдсыг дараах жишээгээр тайлбарлая.

1. ТОДОРХОЙГҮЙ байдлын айдас

“Итгэлийн алхам хийвэл дараа нь юу тохиолдох бол?” гэсэн асуултыг маш олон Христитгэгчид асуудаг. Итгэлийн алхам хийхэд дараа нь яг юу тохиолдохыг бид мэдэхгүй тул энэ нь үндэслэлтэй айдас юм. Энэхүү тодорхойгүй байдлын айдас нь биднийг итгэлийн анхны алхам хийлгэхээс зайлсхийлгэдэг. Энэ айдсын эх сурвалж нь итгэлийн алхам хийсний дараах үйл явдлыг бид хянаж чадахгүйд байгаа юм.

Үнэн: Үнэн гэвэл бид итгэлийн алхам хийхэд юу болохыг Бурхан мэдэж байгаа. Бурханы дүр төрх ба Түүний амлалтанд итгэх итгэлээр өсөх тусам итгэлээр алхахад цаашид юу болох бол гэсэн айдас багасч эхэлдэг. Бид итгэлийн алхам хийхгүй бол Бурханы дүр төрх ба хүч чадалд итгэх бидний итгэл хэзээ ч өсөхгүй “нэг газраа” байсаар байх болно.

Итгэлийн тулаан: “Эээн, цаашид надад юу тохиолдохыг мэдэхгүй байгаа болохоор итгэлийн алхам хийхээс айж байна. Та бүхнийг удирдаж бүхнийг миний төлөө хамгийн сайнаар үйлддэг болохоор надад айх айдас байхгүй гэдгийг илчилж өгөөрэй. Энэ айдсыг надаас зайлуулж итгэлээр алхах хүслийг надад өгөөрэй.”

2. БҮТЭЛГҮЙТЛЭЭС айх айдас

“Итгэлийн алхам хийсэн чинь юу ч тохиолдохгүй, Бурхан хариулахгүй бол яанаа?” гэдэг асуултыг надаас их асуудаг. Бүтэлгүйтэхээс айх нь итгэлээр алхахад саад болдог бас нэг айдас юм. Бурхан бүтэлгүйтэж магадгүй эсвэл би бүтэлгүйтэж магадгүй гэдгээс болоод бид нар итгэлийн алхам хийдэггүй.



Үнэн: Үнэн гэвэл та итгэлийн алхам хийхээ БОЛИХГҮЙ л бол Бурхан бүтэлгүйтэхгүй. Тиймээ, махан биеийн зан байдал руугаа та маш олон удаа эргэж очих боловч үүнийг бүтэлгүйтэл гэж бодох хэрэггүй. Махан биеийн зан байдалдаа эргэж очих нь өөрчлөлтийн үйл явцын нэг хэсэг ба энэ нь таныг бүтэлгүйтүүлэхгүй. Таны хүсч байгаа өөрчлөлтийг бий болгогч нь ТА өөрөө биш учраас та итгэлээр алхвал бүтэлгүйтэхгүй.

Итгэлийн тулаан: “Эээн, хэрвээ би итгэлээр алхаж эхэлбэл бүтэлгүйтэх вий гэж айж байна. Эээн, би Танд айдсаа **итгэн даатгаж байна**. Хэрвээ би үргэлжлүүлэн итгэлээр алхсаар байвал бүтэлгүйтэхгүй гэдгийг ятгаж өгөөрэй гэж **гуйж байна**.”

Итгэлийн тулаан: “Эээн, би махан биеийн зан байдал руугаа эргэн очиж байгаад Таны өмнө гэмшиж байна. Та үүнийг бүтэлгүйтэл гэж харахгүй байгаа гэдгийг дахин сануулж өгөөрэй. Таны хүч чадал дотор үргэлжлүүлэн урагшаа алхах хүслийг надад өгөөрэй.”

3. ӨВДӨЖ эсвэл ШАНАЛАХААС айх айдас

“Бурхан намайг зовоож эсвэл өвтгөж магадгүй учраас би итгэлийн алхам хиймээргүй байна.” гэж олон Христитгэгчид хэлдэг.

Үнэн: Үнэн гэвэл бид зовлон, шаналалаар дүүрэн дэлхий дээр амьдарч байгаа. Өнөөдөр та зовж шаналаагүй байж болно. Гэхдээ та итгэлийн алхам хийсэн ч, хийгээгүй ч та хэзээ нэг өдөр зовж шаналах л болно. Үнэн гэвэл Бурхан зовлон шаналалыг бий болгогч нь биш учраас итгэлийн алхам таныг өвтгөж зовоохгүй. Бурхан юу гэж амласан бэ гэхээр хэрвээ та итгэлээр алхвал таныг зовлонгоос чөлөөлөх эсвэл зовлон дундуур алхаж явах үед таны хандлагыг өөрчилнө гэж амласан.

Итгэлийн тулаан: “Эзэн, хэрвээ би итгэлээр алхвал зовж шаналах вий гэхээс айж байна. Зовлон, шаналал бол энэ дэлхийн нэг хэсэг гэдэгт намайг **ятгаарай**. Би зовж шаналан зовлон дундуур алхах явцад Бурхан та миний амьдралыг өөрчилнө гэдэгт **итгэж байна**. Зовж шаналах болгонд Бурхан та надад хором мөч бүр улам хэрэгтэй гэдгээ харуулаарай.”

Бурхантай хамт алхах нь: Итгэлийн алхам хийхэд нөлөөлж байгаа ямар айдастай та нүүр тулж байна вэ? Түүний амар тайван, итгэлээр энэ айдсыг ялан дийлэх хүчийг өгөөрэй хэмээн Бурханаас гуйгаад итгэлээр алхаж эхлээрэй.

Айдсынхаа ЭЗЭМШИГЧ нь та өөрөө болвол, айдас таны итгэлийг ХУЛГАЙЛАХ болно.

Өөрийгөө буруутгах бодол



Сатан\муу сүнснүүд бидний оюун санаанд биднийг буруутгах бодлыг өгдгийг бид мэдсэн билээ. Сатаны туслалцаагүйгээр ч бид өөрсдийгөө буруутгаж чаддаг. Олон жилийн турш дагалдагч бэлтгэх явцад олон Христитгэгчид өөрийн хийсэн гэмийг Бурханы өмнө ирээд гэмшихийн оронд өөрсдийгөө буруутгахад их хугацааг зарцуулдаг болохыг олж мэдсэн юм. Энэ ч бас миний амьдралд бодитой байсан.

Үнэн: Христ загалмай дээр цовлогдохдоо бидний гэм нүглийг Христ өөртөө үүрсэн гэдэгт итгэхгүй байгаагаас эсвэл мэдээгүйгээс өөрийгөө буруутгах буруутгал бий болдог. Бидэнд ямар ч ял өгөхгүйн тулд Есүс бидний төлөө юу хийсэн бэ? Ром 8:1 ишлэлийг санаарай.

*"Тиймд эдүгээ **Христ Есүс дотор** байгаа хүмүүст **ямар ч ял байхгүй**."*

*Христээр дамжуулан буруутгал **БОЛГОНООС** та чөлөөлөгдсөн учраас та цаашид өөрийгөө буруутгах шаардлагагүй.*

Хэлэх нь хийхээсээ амархан. Өөрийгөө буруутгах буруутгалын эсрэг тулалдахын тулд Бурханы хүч чадлыг хэрхэн ашиглахыг харъя.

Жишээ: Өөрийгөө буруутгасан бодлыг амьдралынхаа нэг талбарт үргэлжлүүлэн авчирсаар байна. Эдгээр бодолтой тэмцэхийн тулд Бурхантай хамтрахаар шийдсэн гэж бодъё.

Итгэлийн тулаан: “Эзэн, би өөрийгөө буруутгах бодлыг эзэмшигч нь болсон байна. Би Танд эдгээр буруутгасан бодлыг **итгэн даатгаж байна**. Та намайг өөрийгөө буруутгасан бодлоос чөлөөлж өгөөрэй. Та намайг яллахгүй гэдэг үнэнээр миний зүрх сэтгэлийг шинэчилж өгөөрэй.”


Бурхантай хамт алхах нь: Өөрийгөө буруутгасан бодлоос болоод та өмнө нь бүтэлгүйтэж байсан уу? Эдгээр буруутгасан бодлыг Бурхан ялаад Ром 8:1 ишлэлийн үнэнээр таны зүрхийг шинэчилж өгөхийг гуйн залбираарай.

ТАВ ДАХЬ ӨДӨР

Итгэлгүй бодол

"хүүгийн эцэг тэр дороо хаширч

-Би итгэж байна. Итгэлгүй байгаад минь туслаач гэсэнд..." Марк 9:24



"Итгэлгүй учир тэд орж чадаагүйг бид мэднэ." Еврей 3:19

Еврей 3:19 ишлэл дээр Еврейчүүдэд “амлагдсан газар” байсан боловч итгэлгүйгээс болоод тэд орох боломжгүй болдог. Бурханы хангамж дүүрэн, хамгаалагдсан газар нутаг байсан боловч тэд “орж чадаагүй”. Яагаад? “Аварга” том биетэй цэргүүдийг Бурханы амлалтаас илүү хүчтэй гэж Еврейчүүд харсан. Биднийг итгэлээс холдуулж, өөрчлөлтийн мэдрүүлдэггүй хамгийн гол "аварга" зүйл бол **ИТГЭЛГҮЙ** байдал юм. Яагаад?

Итгэлгүй байдал биднийг худал итгэл үнэмшилд ТҮГЖИЖ, махан биеийн зан байдал, хандлагаар биднийг ХҮЛЖ байдаг.

Бид бүгдээрээ “**ИТГЭЛГҮЙ ИТГЭГЧИД**” гэж би хэлнэ. Энэ нь юу гэсэн утгатай вэ гэхээр бид Христийн авралд итгэсэн боловч Бурхан болон Бурханы үнэнд итгэдэггүй маш олон зүйлүүд байдаг. Үнэнийг “мэдэх” (оюун санааны мэдлэг) болон үнэнд “итгэх” (өөрчлөлт руу хөтөлж байгаа хувь хүний илчлэлт) гэсэн хоёр ойлголтын хооронд ялгаа байгааг санаарай. Итгэлийн алхмыг эхлүүлэхэд итгэлгүй байдлын талаар хэд хэдэн асуудлууд байдаг боловч хоёр асуудал дээр бид итгэлгүй байдаг.

№ 1 – Бурханы ХЭН гэдэгт итгэдэггүй.

№ 2 – Бурхан бидний амьдралд ЮУ хийж чадах вэ? гэдэгт итгэдэггүй

Итгэлгүй байдалтай холбоотой бодол бидний оюун санаанд ирэхэд бид Бурхантай хамт алхаж эдгээр бодолтой заавал тулалдах ёстой.

Жишээ: Таны амьдралд Бурхан үнэхээр ажлаа хийхийг хүсч байгаа боловч та үүнд итгэж чадахгүй байна гэж төсөөлье.


Итгэлийн тулаан: “Эзэн, Та миний амьдралыг өөрчилнө гэдэгт би итгэхгүй зөрчилдөж байна. Бурхан Та энэ бодлыг ялаад Та миний амьдралыг юу юунаас ч илүүтэйгээр өөрчлөхийг хүсч байгаа гэдэг үнэнээр миний бодол санааг шинэчилж өгөөрэй.”

Итгэлийн тулаан: “Эзэн, намайг хүлж байгаа гэм нүглийн хүлээсээс Та намайг чөлөөлж чадна гэдэгт би итгэхгүй байна. Би Танд итгэлгүй байдлыг даатгаад чөлөөлөгдөхийн тулд тодорхой хугацаагаар итгэлээр алхах хэрэгтэй гэдэгт ятгаж өгөхийг гуйж байна.”

Бурхантай хамт алхах нь: Итгэлгүй байгаа нэг талбарыг сонгоорой. Итгэлгүй байдлаас итгэлтэй байдал руу Бурхан таныг хөдөлгөж өгөхийг Бурханаас гуйн залбираарай.

ИТГЭЛГҮЙ байгаа аль ч талбар таныг итгэлээр алхахаа БОЛЬСОН үр дүнд авчрах болно.

Эргэлзээтэй бодол



"ЭЗЭН Бурханы бүтээсэн аливаа хээрийн зэрлэг амьтдын дотроос могой хамгийн илүү зальтай байжээ. Тэр могой -Та нарт энэ цэцэрлэгт байгаа бүх модны жимснээс идэж болохгүй гэж **Бурхан үнэхээр хэлсэн үү?** хэмээн эмэгтэйдээ асуужээ." Эхлэл 3:1

"Харин тэр ямар ч **эргэлзээгүйгээр итгэлээрээ гүйг**. Учир нь **эргэлзгүч** нэгэн нь салхиар туугдан давалгаалах **тэнгисийн долгио мэт ажээ.**" Иаков 1:6

Итгэлийг үгүй хийдэг хамгийн эхний шалтгаан бол эргэлзээ юм. Еден цэцэрлэгт Еваг сорих Сатаны эхний тактик нь эргэлзээ байсан. Ева Бурханд эргэлзэнэ гэдгийг мэдэж байсан ба Еваг Бурханы эсрэг биеэ даасан шийдвэр гаргаж гэм нүгэл рүү уруу татаж чадна гэдгээ Сатан мэдэж байсан. Эргэлзээ бид нарыг үргэлж итгэлээс холдуулдаг.

Бурханы хайр, хүч чадал, чөлөөлөлтийн талаар эргэлзээг олон Христитгэгчдээс би сонсдог. Христитгэгчид эргэлзэж амьдарч байвал тэд итгэлээр алхахгүй байна гэсэн үг юм. Эргэлзээ бодлоос эхэлдэг.

Жишээ: Хэд хэдэн талбарт та итгэлээрээ алхаж байгаа боловч одоохондоо ямар ч өөрчлөлтийг хараагүй байна. Та эргэлзэж эхлэхэд таны бодол санаа өөрчлөгдөж эхэлнэ.

Итгэлийн тулаан: “Эзэн, би ямар ч өөрчлөлтийг харахгүй байгаа учраас Бурхан та миний амьдралд ажиллаж байгаа эсэхэд эргэлзэж байна. Та энэ бодлыг ялан дийлнэ гэдэгт итгэж байна. Та миний тэсвэр, тэвчээр минь болж өгөхийг гуйж байна.”

Бурхантай хамт алхах нь: Бурханы хүсэл эсвэл хүч чадал өөрчилж чадна гэдэгт эргэлзэж байгаа ямар талбар танд байна вэ? Миний эргэлзээг арилгаж оронд нь Та өөрийнхөө итгэлээр дүүргэж өгөхийг гуйж байна. Эргэлзээн дунд Бурхан та миний тэвчээр минь БОЛООРОЙ.

Эргэлзээн дунд амьдрахад итгэлээр алхах ямар ч боломж байхгүй

Итгэлийн тулааны талаарх дүгнэлт үнэн

Энэ удаагийн хичээлийг итгэлийн тулааны талаарх үнэнийг хуваалцаад дуусгахыг хүсч байна.

1. **Заримдаа итгэлийн тулааныг үргэлжлүүлсээр байх шаардлагатай**

Итгэлийн тулаан хийх хугацаа янз бүр байдаг. Зарим саад бэрхшээл таныг маш амархан Бурхантай хамт энэ тулаанд тулалдахаас холдуулж чадна. Гэхдээ зарим тохиолдолд бид итгэлийн тулааныг илүү удаан хугацаагаар үргэлжлүүлэх шаардлагатай болдог.

Замбараагүй иддэг, архи, порнографид донтсон байна гэж төсөөлье. Та үргэлжлүүлэн донтсоор байвал танд ямар ч саад бэрхшээл тулгарахгүй. Махан биеийн хүсэл танд донтолтыг бий болгодог. Сатан эсвэл муу сүнснүүд үргэлжлүүлэн таныг уруу татна. Чөлөөлөгдөхийн тулд Бурхантай хамт тулалдахаар шийдэхэд энэ тулаан удаан, хэцүү байх болно. Иймээс эдгээр саад бэрхшээлд амархан бууж өгөхгүйн тулд Бурхантай үргэлжлүүлэн хамт тулалдах шаардлагатай.

2. Та Тулаанд бүүж өгөхөөр үрүү татагдана

"ЭЗЭН, хэдий болтол юм бэ? Та намайг үүрд мартаж юм уу? Хэдий болтол Та надаас нүүрээ нуух юм бэ? Би хэдий болтол сэтгэлтэйгээ ярьж, Бүхий л өдөржин зүрхээрээ зовох юм бэ? Хэдий болтол дайснууд минь миний дээр өргөмжлөгдөх вэ?" Дуулал 13: 1-2



Дуулал 13 – р бүлэг дээр гарсан Давид шиг ийм мэдрэмжийг өмнө нь та мэдрч байсан уу? Зөрчилдөж байгааг та харахгүй байна гэж үү? Ялангуяа хэзээ ч дуусахгүй мэт хэцүү нөхцөл байдалд байхдаа итгэлийн тулаанд олон удаа бууж өгмөөр санагдах нь ойлгомжтой. Яг энэ үед Бурхантай хамт алхаж таны төлөө Бурханы хүч чадлаар тулалдах тэсвэр тэвчээртэй байх хэрэгтэй.

"Учир нь эрт үед бичигдсэн аливаа зүйлс нь биднийг сургахын тулд бичигдсэн юм. Ингэснээр Судруудын тэвчээр болон урамшуулалтаар дамжуулан бидэнд найдвар байх юм. Тэвчээр ба урамшууллыг өгөгч Бурхан нь Христ Есүсийн дагуу та нарыг нэг бодол санаатай байлган соёрхох болтугай." Ром 15: 4 – 5

Та өөрөө өөртөө тэсвэр тэвчээрийг хангаж чадахгүй гэдгийг мэдэх хэрэгтэй. Зөвхөн Бурхан чадна. Иймээс Бурханаас энэ тулааныг үргэлжлүүлэх тэсвэр тэвчээр нь болохыг гуйгаарай.

"Харин бид харахгүй байгаа зүйлдээ найдал түүнийгээ тэвчээртэйгээр хүлээдэг." Ром 8: 25

Ром 8:25 ишлэл дээр Бурхан амласанаа хийнэ гэдэг “найдар” бидэнд байх юм бол бид итгэлийн тулаан эсвэл итгэлээр алхахдаа тэвчээртэй байна. Бид эрх чөлөө, ялалт, эдгэрэл зэргийг мэдрэх үед итгэлийн алхамаа үргэлжлүүлсээр байх Христэд –бат итгэлтэй байдал бий болох ба энэ Христэд –бат итгэлтэй байдал биднийг итгэлийн тулаанд үргэлжлүүлэн тулалдахад тусалдаг.

ЧУХАЛ ОЙЛГОЛТ

Итгэлийн тулаанд ТЭВЧЭЭРТЭЙ тулалдахад та Бурханы төгс хүчээр өөрчлөгдөх ба таны ХРИСТ – ИТГЭЛ өсч, итгэлийн дахин өөр нэг алхам хийхийг ХҮСЭХ болно.



3. Хэрвээ тулаанд бууж өгвөл ямар үр дүн хүлээж байгааг санаарай.

"Тэдний хувьд "Нохой бөөлжсөө долоодог, гахайг угаасны дараа шаварт буцаж хөлбөрдөг" хэмээх үнэн сургаалт үгийн дагуу тохиолдсон аж." 2 Петр 2:22

Үнэн гэвэл бид тулаанд бууж өгвөл махан биеийн эх сурвалж руу буцаж очих болно. Амьдралаа өөрчлөхийн тулд, асуудлаа шийдэхийн тулд, хэрэгцээгээ хангахын тулд өөрийн хүч чадалдаа эрдсэн “төөрсөн хүү” – гийн түүхийг саная.

Бид бууж өгөхийг сонговол хуучин байсан байдалдаа эсвэл түүнээс дор байдалд буцаж очих болно.


ЧУХАЛ ҮНЭН:

Итгэлийн тулаанд Бурхантай хамт тулалдахгүй бол та тулаанд ялагдах болно. Гэхдээ та Бурхантай хамт итгэлийн тулааныг үргэлжлүүлсээр байвал итгэлийн алхамд саад болж байгаа бүх бэрхшээлийг ялах ЯЛАЛТЫГ хүртэх болно.

Дүгнэлт

Итгэлийн тулааны утга учир болон итгэлийн алхмаас биднийг холдуулах гэж оролддог дайснуудын талаар та бүхэн сайн ойлгосон гэдэгт итгэж байна. Та тулаанд ялж эрх чөлөө, ялалт, эдгэрэл, өөрчлөлтийг хүртэх болно гэдэгт итгэлтэй байна. Таныг итгэлийн тулаандаа үргэлжлүүлэн тулалдсаар байхыг Паулын хэлсэний дагуу зоригжуулмаар байна.

Би сайн тэмцлээр тэмцсэн. Би замаа дуусгасан, итгэлээ сахисан. 2 Тимот 2:7



ЗУРГААДУГААР ХИЧЭЭЛ

Итгэлийн алхаанаас хүлээх хүлээлтүүд Итгэлийн алхааны талаарх дүгнэлт үнэнүүд

НЭГ ДЭХ ӨДӨР

Зургаадугаар хичээлийн агүүлга

Хамгийн сүүлийн хичээл дээр бид бүхэн итгэлийн алхаанаас юуг найдаж хүлээх хэрэгтэй талаар таньж мэдье. Дараах хүлээлтийг бид бүхэн ярилцах болно.

Итгэлийн алхааны талаарх хүлээлтүүд

- Тогтвортой итгэлээр алхсаар байх
- Бүтэлгүйтлийн туршлага
- Мэдрэмжийн эсрэг итгэл
- Бурханы товлосон цаг
- Өвдөлт, цөхрөл
- Бурхан юу хийж байгааг ойлгож мэдэх
- Зөрчилгүй байдалд хүрэх

Оршил

Итгэлээр алхсаны үр дүн нь юу байх талаарх хүлээлт танд үүсэх нь ойлгомжтой. Гэвч бидэнд бодит болон бодит биш хүлээлт байдаг. Энэ удаагийн хичээлээр бид хамгийн их тохиолддог 7 бодит биш хүлээлтийг үзнэ. Би энэ бодит биш хүлээлтийг үнэнтэй харьцуулна. Тийнхүү итгэлийн алхааны талаарх бодит үнэнг хуваалцаад энэхүү хичээлээ дуусгах болно.

Хүлээлт №1: Та Бурханы дотор үргэлж итгэлээр түүшитай алхахыг сонгох болно

Бодит биш хүлээлт: Бурхан дотор байнга итгэлээр алхахыг сонгох болно.

Үнэн (Бодит хүлээлт): Итгэлийн алхмын эхэн үед, аливаа асуудлыг өөрөө шийдвэрлэх, хариултыг



нь олох, өөрийнхөө амьдралыг өөрийн чадлаар босгон байгуулахын тулд махан биеэ эх сурвалж болгох сонголтыг та маш олон удаа хийх болно. Гэвч та итгэлээр үргэлжлүүлэн алхсаар байвал та өөрийгөө махан бие рүү буцаж очих нь бага багаар цөөрч байгааг мэдэх болно.

Энэ бол таныг сарниулах хамгийн аюултай бодит биш хүлээлт. Итгэлийн алхмын эхэн үед асуудлаа шийдэх эсвэл асуудлаа зохицуулахын тулд махан биеийн эх сурвалж руугаа та олон удаа буцаж очих болно. Яагаад? Хамгийн гол нь махан бие бол бидний төрөлх байдал учраас тэр юм. Энэ нь ямар утгатай вэ гэвэл бид махан биеэрээ амьдрахдаа дасал болчихсон байдаг гэсэн үг юм. Бурханаас тусгаарлагдмал өөрийн хүч, авъяас чадвар, ухамсрыг ашиглахыг хүсэх нь бидний төрөлх хандлага юм.

Нэмж хэлэхэд, итгэлээр алхаж эхлэхэд бидэнд “сул дорой”, Есүсийн онцолж хэлдэг “бага” итгэл байдаг. "Сул дорой" итгэл бол Бурхан хэн болох, Бурхан юу хийж чаддаг/чадах талаарх итгэлийн төвшнийг илтгэдэг. "Сул дорой" итгэл нь "хүчтэй" махан биетэй салшгүй холбоотой. Эхэндээ таны махан бие таныг хүлсэн байх боловч итгэлээ үргэлжлүүлэн дасгалжуулсаар байвал таны итгэл махан биеэс чинь илүү хүчирхэгжсээр байх болно.

Мөн та Бурхан дотор итгэлээр алхахыг сурах явцдаа Бурханы амь, хүч чадлыг амьдралдаа мэдрэхээс гадна амьдралд үүссэн асуудлыг өөрөө шийдэх хүч, авьяас чадвар танд байхгүй гэдэг үнэнийг ойлгох болно. Ариун Сүнс махан биеийн үйлсийг тань илчилж өгвөл та Бурхан дээр очиж гэмшээд Түүн руу эргээрэй. Та итгэлээ дасгалжуулсаар байвал махан бие руугаа буцаж очих нь багасах болно.

САНАМЖ:

Үнэн бол та ОЛОН удаа өөрийн махан биеийн эх сурвалж уруу эргэнэ. Гэвч ДАРААГИЙН УДАА та махан биеийн байдлаа гэмшиж таны Эх сурвалж болсон Бурхан дээр эргэн очиж чадна гэдгээ санаарай.

Бурхантай хамт алхах нь: Амьдралынхаа аль нэг талбарт Бурханы өөрчлөлтийг эрэн хайж байхдаа ямар амархан Бурханаас холдож махан биеийн байдалдаа эргэн очиж байгааг анзаарсан уу? Хэрвээ тийм бол та Бурханаас итгэлээр алхах хүслийг үргэлжлүүлэн өгөхийг гуйн залбираарай.

Хүлээлт №2 – Бүтэлгүйтэл бол сонголт БИШ!

Бодит биш хүлээлт: Итгэлийн алхам хийхэд бүтэлгүйтэхийг би тэвчихгүй. Хэрэв тэгвэл би бүтэлгүйтсэнийхээ төлөө өөрийгөө буруутгаж, бүтэлгүй амьтан гэдэгтээ итгэх болно.

Үнэн (Бодит хүлээлт): Итгэлээр алхах явцдаа та нилээн олон удаа бүтэлгүйтэж болно. Гэхдээ энэ нь таныг бүтэлгүй амьтан болгож өөрийгөө буруутгах буруутгал болох ёсгүй.

ҮНЭН:

Бурхан таныг бүтэлгүйтнэ гэдгийг МЭДДЭГ!



Библи дээр Бурханы агуу зарц нар ч гэсэн олон удаа бүтэлгүйтсэн боловч Бурхан тэднийг үнэхээр агуугаар ашигласан байдаг. Бид бүтэлгүйтэх боломжтой, бүтэлгүйтэх болно гэдгийг Давидаас суралцаж болно. Гэвч Бурхан Давидын талаар юу гэж хэлсэн бэ? Давид бол Бурханы тааллыг олсон нэгэн байсан гэж хэлдэг. Тиймээс олон удаа унахад бэлэн сэтгэлтэй бай. (Эх сурвалж болсон махан биеийн байдалдаа буцаж очихыг бүтэлгүйтэл гээд нэрлэхихье.) Бурхан бидний итгэлгүй байдал, махан бие, гэм нүгэл, Сатаны хүч чадлыг мэддэг учраас Бурхан таныг бүтэлгүйтнэ гэдгийг урьдаас мэддэг.

Олон удаа бүтэлгүйтлээ ч энэ нь таныг бүтэлгүй амьтан гэж өөрийгөө буруутгах шалтгаан болох шаардлагагүй. Яагаад? Ром 8:37 ишлэл дээр Бурханы нүдэнд та бол бүтэлгүй амьтан биш харин Христ дотор “ялагчаас ч илүү” гэж хэлжээ. Бүтэлгүйтэх болгондоо Бурханд гэмшээд дараагийн удаа Түүнд итгэж найдна гэдгээ тунхаглаарай.

Санах ёстой бас нэгэн чухал ойлголт бол бидний бүтэлгүйтэл гэж хардаг зүйлийг Бурхан бүтэлгүйтэл гэж хардаггүй. Харин махан биеийн байдалдаа буцаж очиж байгааг тань махан биеийн үхмэл чанарыг харуулах “боломж” гэж хардаг ба та Бурхан дээр эргэн очих хэрэгцээг тань харуулдаг. Бүтэлгүйтэх үедээ Эзэн танд ийнхүү хэлж байгааг сонсоно гэж найдаж байна:

"Эцэж туйлдсан, хүнд дарамт үүрсэн хүмүүс ээ, бүгд Над уруу ир. Би та нарыг амраа."

Матай 11:28

Чухал Үнэн:

Хир олон удаа бүтэлгүйтэх нь хамаагүй. Бүтэлгүйтэх нь тодорхой. Харин Бурхан таны бүтэлгүйтлийг махан биеийн үхмэл чанарыг харуулах БОЛОМЖ болгон ашигладаг ба та Бурхантай хором мөч бүхэнд хамааралтай байх ХЭРЭГЦЭЭГ харуулдаг.

Бясалгал: Та махан биеийн байдалдаа буцаж очихыг Бурхан бүтэлгүйтэл гэж хардаггүй нь үнэн гэдгийг бясалгаарай.

Бурхантай хамт алхах нь: Итгэлийн алхамдаа бүтэлгүйтсэн гэж бодож байвал та бүтэлгүйтээгүй болохыг ятгаж өгөхийг Бурханаас гуйн залбираарай. Харин үүнийг махан биеийнхээ үхмэл чанарыг харах боломж гэж харан Бурхан дээр буцаж очоорой.

Хүлээлт №3 – Та өөрчлөлтийг амсаж, мэдэртэ

"Учир нь бид үзэгдэж байгаагаар бүс, харин итгэлээр алхаж байна." 2 Коринт 5:7

Бодит биш хүлээлт: Итгэлийн алхам хийх эсвэл итгэлээр алхаж эхлэхэд таны амьдралд Бурхан ажиллаж байгааг амсаж мэдрэх болно.

Үнэн (Бодит хүлээлт): Итгэлийн алхмын ихэнх хэсэгт Бурханы хийсэн өөрчлөлт нэгэнт бий болж гүйцтэл тухайн үйл явцыг мэдрэхгүй байх болно. Тухайн өөрчлөлтийн үйл явцыг мэдрэхээс илүү та “итгэл гаргах” шаардлагатай болно.



Итгэлээр алхахдаа хүлээх хүлээлт нь бидний хамгийн том зөрчил байдаг болохоор үүнийг илүү дэлгэрэнгүй ярилцъя. Бид амьдралын хором мөч бүрийг таван мэдрэхүйгээрээ мэдрдэг учраас энэ хүлээлт нь үнэхээр том саад болдог. Гэтэл итгэлээр амьдарч эхлэхэд бидний амьдралд Бурхан ажиллаж байгааг мэдрэх боломжгүй байх үе байдаг.

Бурханы ажлыг судсаар тарьдаг дуслын шингэнтэй харьцуулж үзье. Та эмнэлэгт судсаараа антибиотик тариулж байна хэмээн төсөөлье. Эм дусал дуслар биед орж байвч антибиотикийн нөлөөг эхэндээ шууд мэдрдэггүй. Гэвч эмчийн хэлсэн итгэл төрүүлэм амлалт, зааврын дагуу энэ эм эдгээнэ гэсэн итгэл танд төрсний улмаас тариулдаг. Эцэст нь эдгэрэл ирэх үед танд хэр их нөлөөлсөнийг мэдрдэг.

Үүнтэй яг адилхан итгэлээр алхаж эхлэхэд Бурханы ажил хийгдэж байгааг мэдэрдэггүй боловч итгэлээр алхах явцдаа Бурхан амласанаа биелүүлдэг гэдгийг та мэдэх болно. Хэрвээ та итгэлээрээ хангалттай удаан алхвал эрх чөлөө, ялалт, эдгэрэл, өөрчлөлт, дотно байдал дотор Бурханы ажлын үр нөлөөг мэдэрч эхлэх болно. Гагцхүү түлхүүр нь Бурханы амлалт биелэлээ олох хүртэл “Сүнслэг дусал”-ыг хангалттай удаан итгэлээр хийлгэх нь чухал юм.

Хүмүүс бид нар амьдралыг мэдэрч туулдаг. Гэхдээ итгэлээр алхах тухайд Бурханы өөрчлөлтийн ажлыг МЭДРЭХГҮЙ байх боломжтой.

Бурхантай хамт алхах нь: Итгэлээр алхахдаа эргэлзэж урам хугарч байвал Бурхан танд итгэлийн алхам бол үйл явц гэдгийг дахин сануулж өгөхийг гуйн залбираарай. Хэдийгээр та Бурханы ажлыг мэдрэхгүй байсан ч Бурхан таны дотор ажиллаж байгаа гэдэгт итгэх агуу итгэлээр дүүргэж өгөхийг гуйгаарай.

ХОЁР ДАХЬ ӨДӨР

Хүлээлт №4 – Бурханы товлосон цаг ба таны төлөвлөгөөт цаг

Бодит биш хүлээлт: Би итгэлээр алхаж эхлэхэд өөрчлөлтийг хүсч байгаа миний цаг хугацаанд Бурхан нийцүүлэх болно.

Үнэн (Бодит хүлээлт): Таны амьдралд Бурхан хүслээ биелүүлэх төгс цагаа товлосон байдаг бөгөөд тэрхүү цагаа Бурхан хэлэх **албагүй**.



Та яадгийг мэдэхгүй ч би лав аливаа зүйлийг удаан хүлээдэггүй хандлагатай хүн. Машинаа асаах түлхүүр минь надад байвал машинаа асаамагц тэр дороо асч, машинаа “асаасан” л бол хаазаа тултал нь гишгэхэд машин хурдална гэдэг хүлээлттэй байдаг.

Та яадаг вэ? Харамсалтай нь ихэнх тохиолдолд Бурхан ингэж ажилладаггүй. Итгэлийн алхмаар алхаж байхад та Бурханаас эрх чөлөө, ялалт, эдгэрлийг маш хурдан авахыг хүсдэг. Гэвч та удалгүй Бурханы товлосон цаг болон таны төлөвлөгөөт цаг хоёр ялгаатай болохыг олж мэдэх болно.

Өөрчлөлтийг хүсч байгаа талбарт та Бурхантай хэсэг хугацаанд үргэлжлүүлэн хамт алхсан боловч юу ч өөрчлөгдөөгүй байна гээд бодоод үзье. Бурхан өөрчлөлтийг хийхүйц хангалттай цагийг би зарцуулсан гэж бид дүгнэх гээд байдаг. Бурхан таны төлөвлөгөөт цагийн дагуу ажиллахгүй байвал итгэлийн алхамаа бууж өгөөд Бурханд бухимдах хандлагатай болдог. Гэвч эдгээр хандлагуудын аль нь ч таны хүссэн өөрчлөлтийг танд авч ирэхгүй. Та хүссэн өөрчлөлтөө амсахын тулд итгэлийн алхмыг хангалттай хугацаанд үргэлжлүүлсээр байх нь л гол түлхүүр юм шүү. Та Бурханы товлосон цаг хугацаанд сэтгэл хангалуун биш байвал үүнийг санаарай.

Хэдийгээр Бурхан таны төлөө хангалттай хурдан ажиллахгүй байгаа мэт боловч БУРХАН АЖИЛЛАЖ байгаа гэдгийг сана!

"Тэнгэрийн доорх бүх юмс цаг хугацаатай бөгөөд бүх юм тогтоогдсон цаг мөчтэй ажээ." Номлогчийн үгс 3:1

Бурханаас бид асуудаг нэг асуулт бол **“Яагаад энэ өөрчлөлт бий болохын тулд ийм удаан хугацаа шаардлагатай байгаа юм бэ?”**. Бидний мэдэх ёстой нэг зүйл бол бидний амьдралын зарим талбар бусадтай харьцуулахад “хурдан” өөрчлөгддөг. Яагаад? Нөгөө талаас бидний амьдралын зарим нэг талбар бусадтай харьцуулахад удаан өөрчлөгддөг нь дараах шалтгаантай холбоотой байх магадлалтай юм:

- Олон жилийн турш худал итгэл үнэмшилтэй байснаас та худал хуурмагтаа хэтэрхий хүлэгдсэн байж болно
- Хүлээс эсвэл донтолт таныг маш удаан хүлснээс болоод одоо ч таниас салахгүй зууралддаг.
- Шарх хэт гүн явцтай удаан байснаас болоод эдгэрлийн процесс удаан явагдаж болно.
- Махан бие тань хэт хүчирхэг тул зарим нэг талбарт бусадтай харьцуулахад Бурханы ажлыг илүү хүчтэй эсэргүүцэж байж болох юм.
- Үл итгэл, эргэлзээ, айдас таныг Бурханы өөрчлөлтийн ажлаас холдуулж, хойшлуулдаг байж болно.

Итгэлийн алхам хийхэд бидний хамгийн түрүүнд асуух түлхүүр асуулт бол:

Та амьдралдаа өөрчлөлтийг мэдрэхгүйгээр хир удаан үргэлжлүүлэн Бурханд итгэж чадах вэ?

Асуулт: Хэрвээ Бурхан таны төлөвлөсөн цаг хугацаатай нийцүүлж ажиллахгүй байвал та ямар зүйл хийхээр уруу татагддагаа бичнэ үү.

Бурхантай хамт алхах нь: Ямар нэг талбарт хэсэг хугацаанд итгэлээр алхсаар ирсэн боловч ямар ч өөрчлөлт бий болохгүй байгаа бол та өөрчлөлтийг мэдрэх хүртэл Бурхан таны тэсвэр тэвчээр болохыг гуйн залбираарай.

САНАМЖ:

Бурхан таны амьдралд ажиллаж байгаа нь харагдаж, мэдрэгдэхгүй байвч үргэлжлүүлэн итгэхийг итгэл гэнэ. Биднийг хүлээлгэснээр Бурхан бидэнд зааж буй гол зүйл бол итгэл юм

Хүлээлт №5 – Ямар ч өвдөлт, зовлон шаналал байхгүй байх болно

"Учир нь Христийн зовлонгууд бидэнд арвин байдгийн адил түүнчлэн бидний тайвирил ч мөн Христээр дамжуулан арвин байдаг." 2 Коринт 1:5

"Хайртай хүмүүс минь, та нарыг сорихын тулд дунд чинь ирдэг галт сорилтод ямар нэгэн хачирхалтай юм та нарт тохиолдсон мэт бүү гайх. Харин та нар Христийн зовлонгуудыг хуваалцдагтаа баярла. Ингэснээр мөн Христийн алдар илчлэгдэхэд та нар баяр хөөртэйгөөр баярлах юм." 1 Петр 4:12 – 13

Бодит биш хүлээлт: Итгэлийн алхамд би өөрийнхөө үүргийг гүйцэтгэвэл Бурхан намайг өвдөлт, зовлон шаналал, зөрчлөөс хамгаална.

Үнэн (Бодит хүлээлт): Өвдөлт, зовлон шаналал, зөрчил амьдралд байх боловч Бурхан таны амьдралын талбар тус бүрийн хэрэгцээг хангаж зовлон шаналалаар дамжуулан хийж буй “ариун үйлээ” Бурхан төгс цагт нь илчлэн харуулах болно.



Би өвдөж, шаналж, зөрчилдөхийг хүсдэггүй (цаашид ч хүсэхгүй). Та ч мөн адил байх. Гэхдээ Бурхан хэзээ ч итгэлийн алхам өвдөлтгүй, зовлон шаналалгүй байна гэж амлаагүй. Яагаад? Бид гэм нүгэлтэй дэлхий дээр амьдарч байгаа учраас бид ямар нэг хэмжээгээр зовлон шаналалыг амсах л болно.

Дараах 3 төрлийн хүмүүс байдаг: Шаналж зовсон, шаналж зовж байгаа, шаналж зовох. Эрт орой хэзээ нэгэн цагт энэ 3 төрлийн аль нэгэнд бид харьяалагдах болно. Гэвч зовлон шаналал дундуур итгэлээрээ алхаж чаддаг итгэгчдийг Бурхан хэрэгтэй бүхнээр нь хангана (Филиппой 4:19), итгэлээр дамжуулан ариун сайныг үйлдэнэ (Ром 8:28), Бурхантай улам ойр байлгахын тулд итгэлийг нь ашиглах болно (Иохан 15:5) гэж амласан.

"Бурханыг хайрладаг, Түүний зорилгын дагуу дуудагдсан хүмүүст тохиолддог бүхий л зүйл эцэстээ тэдний сайн сайхны төлөө байдаг гэдгийг бид мэднэ." Ром 8:28

Би өөрийн итгэлийн алхаагаар дамжуулан олж мэдсэн зүйл бол:

Надад тохиолдсон зовлон, шаналал дунд ХАМГИЙН АГУУ өөрчлөлтүүд бий болсон.

Би өвдөлт, зовлонд дуртайдаа үүнийг бичээгүй. Бурхан миний амьдралд ажилласан тэр хугацааг эргээд харахад өвдөж шаналсан мөчүүдэд миний амьдралд “ариун сайн үйл” намайг өөрчилж байсан юм. Би үүнийг өөрийн хувийн түүхээр тайлбарлая.

Би бол хэзээ ч бүрэн эдгэрэхгүй архаг хууч өвчтэй хүн. Эрүүл мэндийн нөхцөл байдлаас болоод би Бурханд энэ “өргөс”-ийг зайлуулж өгөхийг гуйн залбирдаг байлаа. Би итгэлээр үнэн зүрхнээсээ алхаж эхлэхдээ Бурхан өвдөлтийг алга болгож өгөх байх гэж таамаглаж байв. Гэвч яг одоо үүнийг бичиж байхдаа ч би өвчиндөө шаналсан хэвээрээ байна. Харин өнөөдөр миний өргөс ариун сайн үйлсийг бий болгосон гэдгийг ойлгоод байна. Үүнээс цөөн хэдийг нь нэрлэхэд л Түүнд хамааралтай байх, итгэл үнэмшил, тэвчээртэй байдал зэрэг нь болно. Цаашид би Бурханаас энэ өвчнийг алга болгож өгөөч хэмээн гуйн залбирахаа больсон. Харин ч эсрэгээр нь би “өргөс”-өө хүлээн зөвшөөрдөг болсноор Бурханд улам ихээр хамааралтай болж Паулын хэлсэнчлэн “бидний асууж, бодож чадахаас илүүтэйгээр” өөрчлөгдөж эхэлсэн.

Шаналал дундуур алхаж байхдаа би амархан зугтаах, өвчин намдаах эм уух, эсвэл үгүйсгэх гэж оролддог байв. Гэвч Бурханаас өөр зугтах газар надад байхгүй гэдгийг ойлгосон юм. Бурхан бол таны зовлон шаналал дундах тайвшрал, тэвчээр, найдвар болж чадах цорын Ганц Нэгэн. Таныг итгэлээр алхаж байхад ямар ч өвдөлтгүй байх болно хэмээн би амлаж чаддаг ч байсан болоосой. Гэвч би бат Христэд – итгэлтэйгээр итгэлийн алхааны зовлонгийн үр дагавар нь ариун сайхан зорилго байдаг гэж хэлмээр байна.

“АРИУН САЙН” нь

Зовлонгийн дундах Түүний өршөөл, нигүүлслийг ИЛЧИЛЖ, таны амьдралыг өөрчлөн, Түүнтэй АГУУ ХАМААРАЛТАЙ байлгахын тулд Бурхан таны зовлон, гуниг бүрийг ашиглах болно.

Санамж: Та махан биеийн байдалдаа үргэлжлүүлэн алхахыг сонговол Бурхан зовлон шаналалыг ашиглан сахилгажуулж Түүн рүү эргүүлэх арга болгон ашиглах болно.

Бурхантай хамт алхах нь: Амьдралынхаа аль талбарт дуусашгүй зөрчил, шаналалыг илүү их мэдэрч байна вэ? Энэ шаналалаар дамжуулан Бурханд улам илүү хамааралтай болоход авчирч өгөхийг гуйн залбираарай. Мөн Бурхан таны төлөө “ариун сайн үйлсийг” хийж байгаа гэдгийг илчлэн харуулахыг гуйн залбираарай. Хэрвээ өвдөлт эдгэхгүй бол та Бурханаас таны хандлагыг өөрчилж өгөхийг гуйн залбираарай.

ГУРАВ ДАХЬ ӨДӨР

Хүлээлт №6 – Өөрчлөлтийн үйл явцад Бурхан яг юуг хийж байгааг ойлгох болно

"Учир нь Миний бодол санаанууд бол та нарын бодол санаа биш. Миний зам нь та нарын замаас өөр" гэж ЭЗЭН айлдаж байна. Тэнгэр нь газраас өндөр байдаг шиг, Миний зам та нарын замаас, Миний бодол та нарын бодлоос өндөр билээ. Исаиа 55:8-9

"Бүх юмыг Тэр тухайн цагт нь сайн сайхнаар бүтээсэн бөгөөд хэдийгээр хүн Бурханы үйлдсэн ажлыг эхнээс эцсийг нь хүртэл ойлгохгүй ч гэсэн Тэр тэдний зүрхэнд үүрд мөнхийг байгуулсан билээ."
Номлогчийн үгс 3:11



Бодит биш хүлээлт: Бурхан юуг яагаад миний амьдралд хийж байгааг би ойлгох болно.

Үнэн (Бодит хүлээлт): Таны амьдралд Бурхан юуг, яагаад хийж байгааг та нилээд олон удаа ойлгохгүй байх болно. Эцэст нь таны сүнсний хувь тавилан Христтэй адил болж өөрчлөгдөхийн тулд Бурхан энэ бүхнийг хийдгийг ухамсарлана. Таны амьдралд юуг яагаад хийж байгаа болон хийхгүй байгааг мэдэх хэрэгтэй эсэхийг шийдэх Нэгэн нь Бурхан гэдгийг санаарай. Бурхан таны амьдралд хийж байгаагаа хэлэх ЭСВЭЛ хэлэхгүй байхад үргэлж зорилго байдаг.

Паул 2 Коринт 4:8 ишлэл дээр ийнхүү хэлсэн байна.

*"Бид бүх талаараа зовдог боловч няцардаггүй. **Сандардаг боловч цөхөрдөггүй.**"*

Бид бүгдээрээ Паултай адил болж чадна гэдэгт би итгэдэг. Бурхан аливаа зүйлийг хийхэд эсвэл хийхгүй байгааг би самгарддаг гэдгээ анзаардаг. Бид аялалынхаа дунд нэгэн цагт Бурханы ажлыг хараад сандарч гайхна гэдэг нь үнэн.

Гайхаж сандрах нь биднийг Бурханд улам илүү хамааралтай болгодог учраас гайхаж сандрах нь Бурханы төлөвлөгөөний нэг хэсэг юм. Миний сандралаар дамжуулан Бурхан надад Түүний юу хийж байгааг би мэдэх шаардлагагүй гэдгийг заадаг. Бурхан эхнээс нь төгсгөл хүртэл нь юу болохыг мэдэж байгаа болохоор Бурхан надаас бас таниас хүсдэг зүйл нь Түүнд итгэн юуг яагаад гэж мэдэхийг оролдохоо болих нь юм (Бид юуг? яагаад? гэдгийг мэдэхийг хүсдэг шалтгаан нь би нөхцөл байдлыг хяналтандаа байлгахыг хүсдэгтэй холбоотой байж болох уу?).

Бурхан юуг, яагаад хийж байгаагаа сайн МЭДЭЖ БАЙГАА ба Бурханы хяналтанд бүх зүйл байгаа учраас та өөрийнхөө сандрал дунд АМРАХ боломжтой



Бидний байнга асуудаг өөр нэг асуулт бол ЯАГААД? Яагаад ийм юм надад тохиолдож байгаа юм бол, яагаад ийм юм надад тохиолдохгүй байна? Яагаад Бурхан та зогсоохгүй байна эсвэл яагаад үүнийг хийхгүй байна? Бид “яагаад” гэдэг асуултандаа хариулт авахыг хүсдэг ч гэсэн эдгээр олон яагаад гэдэг асуултанд бид төдийлөн хариулт авч чаддаггүй. Учир нь ингэж байхдаа Бурхан бол Бурхан гэдгийг бид мартдаг. Бурхан хүсвэл яагаад энэ бүхэн тохиолдож байгааг илчлэн харуулах болно. Бидний амьдралд юуг, яагаад Бурхан үйлдэж байгааг бидэнд хэлэх эсэхийг шийдэх тусгай эрх мэдэл нь Бурханд оршино.

Хэрэв та тархины мэс засалд орох шаардлагатай болбол мэс засалчид итгэн унтуулах тариа хийлгэн тархины мэс заслын хагалгаанд ордог бол бидэнд юу, яагаад хэрэгтэйг нарийн тодорхой мэддэг “тэнгэрлэг Мэс засалч” болсон Эзэнд итгэж чадахгүй гэж үү? Бид Бурханд итгэхийг суралцсанаар Тэр бүхнийг мэддэг бөгөөд бидний мөнхийн ашиг тусын төлөө юм гэсэн үнэн дотор амарна.

Энэ нь хангалттай хариулт өгч чадахгүй боловч маш тодорхой дүгнэлтийг хэлье:


Бурхан ЮУГ ЯАГААД хийж байгаагаа хэлэх хэрэгтэй гэж шийдвэл танд хэлэх болно. Үүнээс бусдаар таны үүрэг бол Тэр ЮУГ ЯАГААД хийдгээ мэдэж байгаад итгэн үүн дотроо амрах нь юм.
ИТГЭЛ = АМРАЛТ

Бурхантай хамт алхах нь: Бурхан юуг яагаад үйлдэж байгааг ойлгохгүй байх үе таны амьдралд байдаг уу? Хэрвээ Бурхан танд хэлэхийг сонгохгүй л бол та мэдэх шаардлагагүй гэдэгт Бурхан ятгаж өгөхийг гуйгаарай. Амар тайван хандлагаар үлдсэн асуудлаа Бурханд даатган үлдээх хандлагыг танд өгөхийг Бурханаас гуйн залбираарай.

Хүлээлт №7 – ДОТООД зөрчил дүүсах цэгт бид хүрэх болно

Бодит биш хүлээлт: Ямар ч дотоод зөрчилгүй цэгт миний итгэлийн алхам намайг авчрах болно.

Үнэн (Бодит хүлээлт): Та Есүстэй нүүр тулж уулзах хүртэл таны дотор дотоод зөрчил үргэлжилсээр байх болно. Гэвч таны дотор оршин буй Христ таны одоо зөрчилдөж байгаа гадаад болон дотоод зөрчлийг бүгдийг нь ялан дийлсэн гэдгийг санаарай. Бурхан дотор итгэлээр алхсаар байхад дотоод зөрчлөөр дамжуулан та ялалт, чөлөөлөлт, өөрчлөлтийг улам илүү мэдрэх болно.



Олон Христитгэгчид бид итгэлээр алхсаар байвал ахиад хэзээ ч зөрчилдөхгүй цэгт хүрнэ гэсэн худал ойлголттой байдаг. Би ч гэсэн энэ нь үнэн гэж танд хэлмээр байвч харамсалтай нь бид мөнхийн улсад очих хүртэл зөрчилдсөөр л байх болно. Махан бие, гэм нүглийн хүлээс, махан биеийн зан байдалтай зөрчилдөх дотоод зөрчил насан туршид үргэлжлэх болно.

Таныг сэтгэлээр унахаас өмнө, махан биеийг ялах гайхалтай ялалт, үргэлжилсэн гэмт зуршлаас чөлөөлөх эрх чөлөөг мэдрэх боломжтой гэж баталъя. Мөн таны шарх эдгэрэх боломжтой. Нэмж хэлэхэд, Христ дотор үргэлжлүүлэн алхсаар байвал махан биеийн зан байдлаас Христтэй адил зан чанартай болох бодит өөрчлөлтийг Бурхан үйлдэх болно. Эфес 3:20 ишлэл дээр Паул хэлсэнчлэн бид тийм газарт хүрэх боломжтой:

"Эдүгээ, бидний дотор ажилладаг хүчний дагуу гуйж, бодох бүхнээс минь илүү хэмжээлшгүй бялхлаар үйлдэх чадвартай Түүнд" – Эфес 3:20

Сайн мэдээ гэвэл та тэвчээртэйгээр итгэлээр алхах үед:

Бурхан таныг БҮХ оюун ухаанаас дээгүүрх АМАР ТАЙВАН (Филиппой 4:7), ҮГЭЭР ИЛЭРХИЙЛЭМГҮЙ БАЯР ХӨӨР (1 Петр 1:8)-ийг амсах газруудаар таныг дагуулан явах болно.

Бурхантай хамт алхах нь: Бурханы амладаг эрх чөлөө, ялалт, эдгэрэл, өөрчлөлтийг мэдрэнэ гэсэн итгэл өгөхийг Бурханаас гуйн залбираарай.

Дүгнэлт

Найзуудаа! Би эдгээр бүх худал хүлээлтүүдийг хүлээдэг байсан бөгөөд олон удаа махан биеийн байдалдаа буцаж очсон. Гэхдээ “төөрсөн хүүгийн оромжинд” очих бүртээ юу ч дээрдэхгүй байгааг ойлгосон билээ(Буцах тусам дордож байсан шүү). Надад байсан ганц сонголт бол Эзэн дээр эргэн очиж итгэлээр үргэлжлүүлэн алхах байсан юм. Би одоог хүртэл “бөөлжсөндөө буцаж очдог” боловч махан биеийн байдлыг маш хурдан үхүүлж чаддаг болсноо хараад итгэлээр үргэлжлүүлэн алхсаар байгаа.

ДӨРӨВ ДЭХЬ ӨДӨР

Итгэлийн алхам хийхэд анхаарах үнэнүүд

Үнэн №1 – Итгэлийн алхам улам бүр БОДИТОЙ болно

Бид өмнөх хичээлүүдэд итгэлийн алхам хийхдээ санаачлагатай байх ёстойг суралцсан. Итгэлээр хэрхэн амьдрах талаар та суралцах үед өөр соёлтой, гадны улсад очсон байгаатай адил гэж ярьж байсан даа. Энэ бол өмнө нь огт хийж байгаагүй аялал хийхтэй адил гэдгийг одоо ойлгож байгаа гэдэгт би итгэж байна. Энэ аялал бол хэцүү. Та эсэргүүцэлтэй тулгарах боловч өөрчлөлтийн шагналыг хүртэх нь энэхүү аялал

хийхийн үнэ цэнэ. Сайн мэдээ бол та итгэлээр удаан хугацаагаар алхах тусам итгэлээр алхахад амархан болно.

Жишээ болгож би хэрхэн механик хөдөлгүүртэй машин барьж сурсанаар төлөөлүүлэн тайлбарлая. Би араагаа шилжүүлэхийн тулд тормос болон консоо яаж ажиллуулахыг мэддэг боловч хэзээ ч барьж үзэж байгаагүй юм. Анх удаа машинаа бариад эхний 3 метр газар яваад машиныхаа хөдөлгүүрийг эвдэж билээ. Дараагийн удаа 6 метр газар яваад эвдчихлээ. Машинаа удаан барих тусам амархан дадлагажиж конс болон араагаа төвөггүй сольж чаддаг болсон байв. Христитгэлийн алхаа үүнтэй яг адилхан. Эхэндээ итгэлээр алхахын тулд та санаачлагатай байх хэрэгтэй. Та хэд хэдэн удаа махан бие руугаа эргэн буцаж, сүнсний "араа"-гаа гэмтээх болно. Гэвч нэг л өдөр та амьсгал авах тэнхээтэй болж итгэлээр алхахад дадлагажсан байх болно.

Цаашид та өөрийгөө:

- **Аль болох цөөн удаа махан биеийн байдалдаа буцаж очиж байгааг мэдэх болно**
- **Махан биеийн "төөрсөн хүүгийн оромжинд" бага цаг зардаг болсноо мэднэ**
- **Махан биеэ хурдан үхүүлж Бурхан дээр эргэж очих болно**
- **Итгэлээр улам их алхахыг хүснэ**

Бурхантай хамт алхах нь: Итгэлийн алхмаар алхахдаа өөрийгөө цөхөрсөн байгааг олж мэдсэн бол таны итгэлийн алхам “сүнсний хувьд” хэвшсэн зүйл болох хүртэл Эзэнээс тэсвэр тэвчээрийг гуйн залбираарай.

Үнэн №2 – Таны өөрчлөлт бол насан туршид үргэлжлэх МЭС ЗАСЛЫН үйл явц



"Амьд байгаа бид Есүсийн төлөө үхэлд байнга тушаагддаг. Ингэвэл Есүсийн амь мөн бидний үхлийн махан бие дотор илэрхийлэгдэх болно." 2 Коринт 4:11

Христэд итгэсэн мөчөөс эхлэн Бурхан таны амьдралыг өөрчлөх насан туршийн мэс заслын үйл явцыг эхлүүлдэг. Бурхан махан биеийн байдал, худал хуурмаг итгэл үнэмшлээс таныг холдуулах үйл явцыг эхлүүлдэг. Гэхдээ энэ үйл явцад ямар ч өвчний эсрэг мэдээгүйжүүлэлт байхгүй. Тиймээс заримдаа та мэс заслын ширээнээс үсэрч буугаад махан биеийн байдалдаа буцаж очихыг хүсэх болно. Харин Бурхан танд хайртай тул мэс заслын үйл явцыг үргэлжлүүлэхээр цуцалтгүй таныг эргүүлэн авч ирэх болно.

Ариун Сүнс таны мэс заслын үйл явц хэрхэн явагдахыг гаргууд сайн мэддэг. Ариун Сүнс таны өөрчлөлтийн үйл явцын дараагийн үе шатанд юу хэрэгтэйг тодорхой мэддэг. Та үргэлжлүүлэн итгэлээр алхсаар байвал Бурханы амладаг эрх чөлөө, ялалт, эдгэрлийг мэдэрч мэс заслын ширээн дээр улам удаан хугацаагаар үлдэх сонголтыг хийх болно. Мөн Бурхан юу хийхээ мэдэж байгаа, Түүний хайр таны төлөө ажиллаж байгаа гэдэгт та улам их итгэх болно.

Бурханы тэнгэрлэг мэс заслын ажил ИХЭНХДЭЭ мэдээ алдуулагчгүй явагддаг.

Гэвч, мэс заслын ширээн дээр ҮЛДЭЖ Бурханы ажлыг хийлгэ.


Бурхантай хамт алхах нь: Мэс заслын ширээнээс буулгахад хүргэж магадгүй ямар сүнсний мэс засал танд явагдаж байна вэ? Энэ талбар дээр Бурхан өөрийн мэс заслыг бүрэн дүүрэн дуусгахын тулд мэс заслын ширээн дээр үлдэх хүслийг Бурханаас гуйн залбираарай.

Үнэн №3 – Та өсөлтийн үйл явцыг ХЭМЖИХ гэж оролдоно. Бүү тэг!

Бид нэвт шингэсэн “гүйцэтгэлийн” хэмжүүртэй байдгаа мэддэггүй. Бид амьдралынхаа талбар бүрийг бусадтай эсвэл ямар нэг тогтсон хэм хэмжүүртэй харьцуулах гэж оролддог. Итгэлийн алхам хийх явцдаа та өөрийн сүнслэг алхмын өсөлтийг бусадтай харьцуулж хэмжих гэж оролдоно. Битгий тэгээрэй. Үүнд хоёр талт шалтгаан байна:

1. Та өөрийнхөө сүнслэг өсөлтийг хэмжиж чадахгүй. Зөвхөн Бурхан чадна.
2. Хүн тус бүрийн аялал тухайн хүндээ тохирсон онцлогтой байдаг. Тиймээс та өөрийнхийгөө бусадтай харьцуулах ямар нэгэн хэмжүүр байхгүй

Харамсалтай нь итгэлийн алхам хийж эхлэхэд та өөрийнхөө итгэлийн алхмыг бусадтай харьцуулж хэмжих гэсэн уруу татлагад өртөх болно. Үүний үр дүнд таны төлөвлөсөн цаг хугацаанд өсөхгүй байгаагаас болоод та өөрийгөө буруутгах эсвэл бусадтай харьцуулахад хурдан өсч байвал бардамнах болно. Удахгүй та харьцуулан хэмжих нь махан биеийн байдал болох буруутгал эсвэл бардам байдал уруу аваачиж байгааг ойлгох болно. Тиймээс сүнслэг өсөлтөө хэмжихээ больж, аялалдаа сэтгэл дүүрэн алх.



Та өсөлтийн үйл явцыг хэмжих боломжгүй ч сүнслэг аялал тань усан онгоцоор явж байгаатай адил хэмээн бод. Усан онгоц эргээс хөдөлж та усан онгоцны урд тавцан дээр зогсоод явахад хир хол аялсанаа хэлж чадахгүй. Харин усан онгоцны арын тавцан дээр очвол та эргээс хир холдсоноо төвөггүй

мэдэж болно. Тийнхүү итгэлээр алхахдаа хаанаас эхэлсэнээ эргэн нэг харвал та өөрчлөлтийн замаар хир хол аялсанаа харж эхэлнэ. Боомтоос таныг Бурхан ямар хол аялуулсаныг хараад та алмайрах болно.

Санамж: Нэг л мэдэхэд та эргэж хараад Бурхан таныг хаана авчирсан байгааг мэдэх боломжтой болох болно.

Бурхантай хамт алхах нь: Та сүнсний өсөлтөө хэмжих гэж тэсэн ядаж байсан уу? Тийм бол та өөрөө сүнснийхээ өсөлтийг хэзээ ч хэмжих боломжгүй гэдэгт Бурхан ятгаж өгөхийг гуйн залбираарай. Итгэлээр алхаж байхдаа та усан онгоцныхоо арын тавцанд очоод эргэж хараарай. Та өөрчлөлтийн аялалаар хир хол аялсанаа харах болно.

Үнэн №4 – Итгэлээр үргэлжлүүлэн алхах тусам Бурхан таны амьдралд юу хийж байгааг СҮНСЛЭГ нүдээр харж эхэлнэ.



"Бид үзэгдэх юмсыг бус, харин үл үзэгдэх юмсыг хардаг. Учир нь үзэгдэх юмс бол түр зуурынх, харин үл үзэгдэх юмс бол мөнх билээ." 2 Коринт 4:18

Хараагүй хүн “би сохор байсан боловч одоо би харж чадна” гэж хэлсэн байдаг (Иохан 9:25). Итгэлээр алхаж эхлэхэд бид яг хараагүй хүнтэй адил байдаг. Бид таван мэдрэхүйгээрээ л хараад байдаг. Нүдний шилээр дамжуулан бидний хараа тодордогтой адил итгэлээр алхах тусам Бурханы өгсөн “сүнслэг” нүдний шилээр бид амьдралдаа юу болж байгааг харж итгэлээр үргэлжлүүлэн алхаж чаддаг. “Сүнслэг” нүдний шилээр бидний харж чадах зүйлүүд юу вэ?

Өвдөлт, зөрчлийн дунд ч “ариун сайн” байдал бий болж байгааг харж эхэлдэг. Бид Бурханы зорилгыг илүү тод харж, хэрхэн Бурхан бидний сүнслэг байдлыг бүрэн дүүрэн өөрчилж байгааг харж эхэлдэг. Бурханы хүч чадал дотор алхаж байхад бидний дайснууд ямар ч хүч чадалгүй болохыг хардаг. Бидний нөхцөл байдал бүгд үгүй гэж хэлсэн ч гэсэн Бурхан биднийг хайрласаар байдгийг хардаг.

Миний ашигладаг өөр нэг зүйрлэл бол Бурханы харах өнцөг болох 9000 метрийн өндрөөс өөрийнхөө амьдралыг харах. Итгэлийн алхмын эхэн үед бидний итгэл газрын төвшинтэй ижил төвшинд байдаг. Гэхдээ таны итгэл өсөх тусам та улам өндрөөс харж эхлэх ба Бурхан юуг яагаад таны амьдралд хийж байгааг ойлгох болно. 9000 метрийн өндрөөс таны амьдралд юу болж байгааг харахад илүү тодорхой байх болно.

Бидний төрөлх хүн хардаггүй зүйлсийг харуулах сүнслэг ХАРААГ Бурхан бидэнд өгнө.

Дасгал: 9000 метрийн өндрөөс харах шаардлагатай ямар асуудал танд байна вэ? Танд тулгарч байгаа асуудлын бодит байдлаас илүү Бурханы бүх үнэн бодитой гэж харуулахыг Бурханаас гуйгаарай.

Үнэн №5 – Маргаашийн өөрчлөлтийн төлөө итгэлийн алхмыг холбож болохгүй

Маргааш болох өөрчлөлтийг итгэлийн алхамтай хооронд нь холбож болохгүй гэдгийг ойлгох хэрэгтэй. Бид “сүнслэг” цэгүүдээ хооронд нь холбохоос гадна бидний амьдралд болж байгаа бүх зүйлийг хооронд нь холбож ойлгохыг хүсдэгээс болж зөрчил үүсдэг. Бидний үүрэг бол Бурханд итгэх ба үлдсэнийг нь Түүнд даатгаж үлдээх юм. Итгэлийн аялалаар аялахад бидний үүрэг бол Бурхан хэрхэн тэдгээр цэгүүдийг хооронд нь холбохыг мэддэг болохоор бид Бурханд итгэж сурах нь чухал.

ТАВ ДАХЬ ӨДӨР

Үнэн №6 – Таны Христэд-бат итгэх итгэл өсөх тусам таны итгэлийн алхаа улам хүчтэй болдог

"Бидэнд Христээр дамжуулан Бурханд хандах тийм бат итгэл байдаг." 2 Коринт 3:4

Нилээд олон Христитгэгчид “Христэд –бат итгэл”-гүй амьдардаг гэж өмнө нь хэлж байсан. Учир нь гэвэл бидний маш цөөхөн нь итгэлийн алхмыг хангалттай удаан хугацаагаар үргэлжлүүлж Бурханы биднийг чөлөөлөн, бодол санааг шинэчлэнэ гэсэн үнэнг амьдралдаа мэдэрсэн байдагт байгаа юм. Гэвч та итгэлээр үргэлжлүүлэн алхсаар байвал таны сүнслэг алхаа яг уулан дээрээс өнхөрч байгаа цасан бөмбөлөгтэй адил болдог. Таны Христэд-бат итгэл өсөх тусам сүнсний хүч улам нэмэгдэж Бурханы өөрчлөлтийг мэдрэхийг улам их хүсэх болно.

СОРИЛТ:

**Бурханы хүч чадал дотор ХРИСТЭД–БАТ ИТГЭЛТЭЙ байдлыг бий болгохын тулд
ЕР БУСЫН өөрчлөлтийг мэдрэх нилээн олон удаагийн итгэлийн алхам хийх шаардлагатай
ба Түүний хүсэл таны амьдралыг өөрчлөх болно.**

Үнэн № 7 - Өөрчлөлт шинэчлэлт бага багаар өсөн нэмэгдэж бий болдог

Өөрчлөлтийн үйл явц бага багаар өсөн нэмэгддэг юм бол би өөрчлөлт болж байгаа эсэхийг яаж мэдэх вэ?
Ром 15:8 ишлэл дээр Паул бидэнд Бурхан амласанаа биелүүлнэ гэдгийг баталж байна.

*"Учир нь би хэлнэ. Эцгүүдэд өгсөн амлалтуудыг **батлахын** тулд Бурханы үнэний төлөө Христ хөвч
хөндүүлэгсдийн зарц болсон."* Ром 15:8

Бурхан бидний амьдралд ажиллаж байгааг бид итгэлээрээ мэддэг. Үүнийг Бурхан таны бодол, сонголт, зан чанар, мэдрэмжээр батлахыг хүсдэг. Тиймээс таны амьдралд Бурханы ажил хийгдэж байгааг батлах баталгааг дор харуулав.

1. Худал хуурмагт итгэхээс илүү Бурханы үнэний талаар бодож, таны зүрх сэтгэл итгэж эхлэх болно.
2. Өөрийн бодол, мэдрэмжээс илүү Бурханы үнэнд тулгуурлан сонголт хийж эхлэх болно. Бурханы үнэнээр таны зүрх сэтгэл шинэчлэгдэн Бурхантай улам ойр алхах хүслийг өгөх болно.
3. Хандлага, зан байдалд тань ер бусын өөрчлөлт бий болж эхэлнэ
4. Шархны эдгэрлийг мэдрэх болно.
5. Хүлээс, ялагдлыг мэдэрч байсан талбартаа та эрх чөлөө, ялалтыг мэдэрч эхэлнэ.
6. Бурхан доторх итгэл улам өсч урьдын байдал руу буцах хүсэл буурах болно
7. Бурханыг хайх хүсэл улам өсч байгааг мэдэх болно.
8. Бурхан таны амьдралд юу хийснийг болон Бурхан хэн гэдэгт улам итгэлтэй болж байгаагаа мэдэх болно.

Та амьдралдаа эдгээрийг мэдэрч эхлэхэд Бурханд итгэх итгэл тань улам өсөх ба таны итгэлээр алхах хүсэл болон хүчийг улам нэмэгдүүлэх болно.

Үнэн №8 – Таны сүнслэг аялал цаг хором бүр хийх сонголтоос бүрдэж эхэлнэ

**Та амьдралынхаа үлдсэн хором мөч БҮРТ итгэлээ БУРХАН дээр тавих уу эсвэл ӨӨР
ДЭЭРЭЭ тавих уу гэсэн сонголттой нүүр тулах болно**



Та итгэлээ өөр дээрээ тавьбал дараах үр дүн бий болно

- Ялалт үгүй
- Эрх чөлөө үгүй
- Эдгэрэл үгүй
- Өөрчлөлт үгүй
- Баяр баясгалан үгүй
- Дотно байдал үгүй

Та итгэлээ Бурхан дээр тавьбал дараах үр дүн бий болно

- Ялалт
- Эрх чөлөө
- Эдгэрэл
- Өөрчлөлт
- Баяр баясгалан
- Дотно байдал

Аялалын явцад та дараах нөхцөл байдалд олон удаа очих болно гэдгийг санаарай

- Бурханы хүч чадалд эргэлзэх эсвэл өөрөө амьдралаа өөрчлөхийг хүсэх
- Бурханд уурлаж уцаарлах, цөхрөх
- Өөрийгөө буруутгах
- Бууж өгөхийг хүсэх

Харамсалтай нь олон Христитгэгчид итгэлээр алхахаа больж бууж өгдөг. Тэдгээр хүмүүс амьдралыг өөрчилж чадах Нэгэнээс холдож байгаа нь хамгийн харамсалтай. Бид Бурханаас холдоход үлддэг ганц сонголт нь амьдралаа өөрийн хүчээр “аргалах” юм. Би “аргалах” гэдгийг амьдралдаа үүссэн асуудлыг засч залруулахын тулд өөрийн хүчээр өвдөлтөө намдаах эсвэл үгүйсгэх, нуухыг оролдож байгааг хэлнэ. Та бууж өгмөөр санагдвал:

ДАХИН НЭГ итгэлийн алхам хийгээрэй

Таны дотор “буцаад ир” гэдэг үг сонсогдож байвал дахин нэг итгэлийн алхам хийгээрэй. Бурханаас хариултыг нь шаардахад хариулахгүй бол дахин нэг итгэлийн алхам хийгээрэй. Тэсвэрлэж чадахаасаа илүү өвдөж байсан ч дахин нэг алхам хийгээрэй. Айж сандарсан, эргэлзсэн, яахаа мэдэхгүй байсан ч дахин нэг итгэлийн алхам хийгээрэй. Хэрвээ та ингэж чадвал Бурхан танд амласан амлалтыг улам ихээр мэдрэх болно. Ром 5:17 ишлэл дээр “илүү ихийг” гэдэг хэсэг бичигдсэн байна.

*"Учир нь хэрэв ганц хүний алдаа зөрчлөөс болж ганц хүнээр дамжуулан үхэл нь ноёрхсон бол, **илүү их** нигүүлслийн баялгийг болон зөвт байдлын бэлгийн бялхалыг хүлээн авагсад нь **Есүс Христ гэгч ганц Хүнээр дамжуулан амь дотор ноёрхоно.**"*

Амьдралыг ХААНЧЛАХ нь Христээс, Христээр, Христийн амиар бий болдог

Та Иохан 6:66 ишлэлтэй адил итгэгч болох уу? Иохан 6:68 ишлэлтэй адил итгэгч болох уу?

Иохан 6:66 ишлэл дээр зүйрлэсэн итгэгчийг Иохан 6:68 ишлэл дээр зүйрлэсэн итгэгчтэй харьцуулж тайлбарлан энэ удаагийн хичээлээ дуусгахыг хүсч байна.

"Үүнээс болж Түүний дагалдагчдаас олон хүн зайлан явж, цаашид Түүнтэй хамт явсангүй. Тэгээд

Есүс арван хоёртоо

- Та нар бас явахыг хүсэж байна уу? гэхэд,

Симон Петр Түүнд

*-Эээн, бид хэн уруу явах юм бэ? **Мөнх амийн үгс Танд байна.**"*

Иохан 6: 66 – 68

Иохан 6 : 66 ишлэл дээр дүрсэлсэн итгэгч гэж хэнийг хэлэх вэ?

"Үүнээс болж Түүний дагалдагчдаас олон хүн зайлан явж, цаашид Түүнтэй хамт явсангүй."

Харамсалтай нь олон Христитгэгчид Христээс холдож өөрөө өөрсдийнхөө эх сурвалж болдог. Эдгээр Христитгэгчдийг би “Иохан 6:66” дээр дүрсэлсэн Христитгэгчид гэнэ. “Иохан 6:66” дээр дүрсэлсэн Христитгэгчид болоход юу нөлөөлдөг вэ?

- Амь болсон Христийн үнэнийг мэдээгүйгээс Христээр удирдуулан амьдрахын оронд өөрсдийн махан биеийн байдалдаа буцаж очдог.
- Христ дотор хэрхэн итгэлээр алхахаа мэдээгүйгээс Бурханы багахан туслалцаатайгаар өөрсдийн хүч чадлаар итгэлийн алхмаа үргэлжлүүлдэг.
- Христ дотор итгэлээр алхсан боловч өөрчлөлтийг мэдрэх хүртэл хангалттай хугацаагаар алхаагүйгээс болж бууж өгөн өөрсдөө эх сурвалж болсон амьдрал руугаа эргэдэг.

Итгэлийн алхмаас үр дүн гарахгүй байна гэж бууж өгөн өөрсдөө ЭХ СУРВАЛЖ болсон байдалдаа эргэж очиж байгаа тэдгээр хүмүүсийг Иохан 6:66 дээр дүрсэлсэн Христитгэгчид гэнэ.

Иохан 6 : 68 ишлэл дээр дүрсэлсэн Христитгэгч гэж хэнийг хэлэх вэ?

"-Симон Петр Түүнд

-Эзэн, бид хэн уруу явах юм бэ? Мөнх амийн үгс Танд байна."

Петр болон бусад дагалдагчдын хийснийг нэгтгэн дүгнэвэл:

Есүс бол Христитгэлт амьдралаар амьдрах цорын ганц ЗАМ мөн.

“Би бол зам....” Иохан 14:6

Дагалдагчид Есүстэй хамааралтай байхаас өөр ямар ч зам байхгүй гэдгийг ойлгосон байсан. Христ дотор хангалттай удаан итгэлээр алхсанаар цорын ганц Эх сурвалж болох Христээс тэтгэгдэн амьдрана гэдэгт тэд итгэсэн.

Иохан 6 : 68 ишлэл дээр дүрсэлсэн итгэгчид бол

- Тэдний амь болсон Христ бол Христитгэлт амьдралын үнэн гэдгийг МЭДДЭГ
- Христ дотор итгэлээр алхдаг.
- Байнгын сүнслэг өөрчлөлтийг МЭДЭРДЭГ.
- ӨӨР ХЭН Ч өөрчилж чадахгүй боловч зөвхөн Христ өөрчилж чадна.

Иохан 6:68 ишлэл дээр дүрсэлсэн Христитгэгч бол тэдний хүсч байгаа бүх зүйл Есүс гэдгийг ойлгох өөрчлөлтийг мэдэрсэн нэгнийг хэлнэ. Тэдний хувьд Есүс бол БҮХ ЗҮЙЛ юм.

Христитгэлт амьдралаар амьдрах цорын ганц зам нь Христ өөрөө юм гэдгийг ойлгож ухаарах тодорхой цэгт бид аялалаараа хүрдэг гэдэг нь маш чухал ойлголт юм.

Филиппой 3:8 ишлэл дээр Паул ийнхүү хэлсэн байна.

"Тэр ч байтугай, би өөрийн Эзэн Христ Есүсийг таньж мэдэхийн давуу агуу байдлын төлөө бүх юмсыг гарз хохирол болгон үздэг. Би Түүний төлөө бүх юмсын гарз хохирлыг амсаж, тэдгээрийг хог гэж үздэг нь Христийг олохын тулд бөгөөд..."

Иохан 6:68 ишлэл дээр дүрсэлсэн Христитгэгчид болон Иохан 6:66 ишлэл дээр дүрсэлсэн Христитгэгчдийн ялгааг маш тодорхой харуулсан гэдэгт итгэж байна. Петр болон Паул нь Христ бол ЗАМ гэдэгт ятгагдсан шиг та мөн ийм дүгнэлтэнд хүрэх цэгт Бурхан таныг аваачих болтугай гэж би залбирч байна.

Урмын үг

Миний номыг судалсан танд баярлалаа. Ариун Сүнс эдгээр үнэн, илчлэлт, өөрчлөлтийг таны амьдралд авчирсаар байна гэдэгт би итгэж байна. Паулын Филиппой 3:14 ишлэл дээр хэлсэн үгээр би таны төлөө залбирмаар байна.

“УРАГШИЛ”

Таны төлөө залбирах миний залбирал бол итгэлийн алхам дахин дахин хийгээрэй. Үргэлж урагшил, битгий бууж өг, махан биеийн байдалдаа БИТГИЙ эргэн оч. Таны дотор орших хайраар дүүрэн Бурханы гайхалтай ер бусын ажлыг мэдрэхийн тулд урагшил. Филиппой 1:21 ишлэл дээр Паул хэлсэн газар хүрэх хүртэл урагшил.

“Миний хувьд амьдрах нь Христ”